1.2.6	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	100	56.6	339.4	192.4	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 11 булгийн эхийг хашиж хамгааллаа. 2021 онд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал болон төсөл хөтөлбөрийн зардлаар Зэвэг, хадран загасны жарамгай-500000 хүдэр-8, тарвага-80 орчим тоо толгойг сэргээн нутагшуулсан байна. Ховор, нэн ховор амьтдын тогтвор суурьшилтай байдлыг хангах, амьдрах орчныг сайжруулах зорилгоор Тариат, Хангай сумдын УТХГН-ийн нийт 8 цэгт биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлээ. Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг "Иргэн бүр хашаандаа мод таръя" уриан доор зохион байгуулж аймгийн хэмжээнд 25990 ширхэг мод, бут, сөөг тарьж арчилгаа, усалгааг технологийн дагуу хийлээ. Нийт тэрлэсэн мод, бут сөөгийн амьдралт үр дүн 85-аас дээш хувьтай байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө болон иргэд, нөхөрлөлийг хамтран аймгийн хэмжээнд 5.7 га талбайд ойн зурвас байгууллаа. 2021 онд ойн нөхөн сэргээлтийн ажлыг 180 га талбайд гүйцэтгүүлээ. Орон нутгийн төсвийн хөрөнгө, аж ахуй нэгжийн хөрөнгөөр Чулуут, Өндөр-Улаан, Тариат, Цэнхэр сумын ойн хөнөөлт шавжийн тархалттай 4300 га талбайд тэмцлийн ажлыг ойн мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж ойн хөвийн өсөлт хөгжилтийг хангаж ажиллалаа. Байгалийн өвөрмөц тогтоц, ховор амьтан, ургамал бүхий газрын унаган төрхийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор Хайрхан, Эрдэнэмандал, Батцэнгэл сумдын зарим хэсгийг хамарсан Бөхөн шарын нурууны 58167 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хэмжээг 0.1 хувиар нэмэгдүүлээ.
1.2.7	Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ /Халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал сүргийн тоо	100	98	671.1	66.2	Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээнд 1477.0 мянган мал хамруулахаас 1447.4 мянган толгой мал, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 8133.6 мянган толгой мал, амьтан хамруулахаас 7756.8 мянган толгой мал, амьтан хамруулсан байна. Шүлхий өвчний тандалт шинжилгээг 12 сумын 30 өрхийн 480 дээжид, бот малын млязан өвчний тандалт шинжилгээг 12 сумын 29 өрхийн 356 дээжд, брүцеллээ өвчний вакцинуулалтын дараах тандалт шинжилгээг санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон Хангай, Жаргалант сумын малд хийхэд вакцинуулалтын үр дүн 85 хувьтай гарсан байна.
	Шаардлагатай сум багт нийлүүлсэн мал угаалгын ванны тоо					2021 онд энэ арга хэмжээ төлөвлөгдөөгүй.
	Сум дундын малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын лаборатори байгуулах					2021 онд энэ арга хэмжээ төлөвлөгдөөгүй.
1.2.8	Замын сан	100	46	377.5	173.7	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн 220 урт метр төмөр бетон гүүр, 63 км хатуу хучилттай авто замын барилгын ажил 41,16 хувийн гүйцэтгэлтэй, Хархорин-Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Өгийнуур- Батцэнгэл-Ихтамир чиглэлийн А27 дугаартай мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто зам хүртэлх ажлын эхлэл 72 хувийн гүйцэтгэлтэй, Өндөр-Улаан сумын Бэлх багас төв хүртэлх 7 км хатуу хучилттай авто зам барих ажил 46 хувийн гүйцэтгэлтэй, Хайрхан сумын Хануйн голын төмөр бетон гүүрийн барилга угсралтын ажил, Өгийнуур сумын Орхон голын модон гүүрийн ажил 30 хувийн гүйцэтгэлтэй тус тус он дамжин хэрэгжиж байна. Цэнхэр сумын "Цэнхэрийн халуун рашаан" орох сайжруулсан шороон зам, Эрдэнэмандал сумын Хануйн голын 90.9 урт метр төмөр бетон гүүрийн барилга угсралтын ажил бүрэн дуусаж Улсын комисст хүлээлгэн өглөө. Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 17 төсөл арга хэмжээний гүйцэтгэл 90 хувьтай байна.
1.2.9	Жолоочийн даатгалын сангийн үйл ажиллагаа					2021 онд энэ арга хэмжээ төлөвлөгдөөгүй.
1.2.10	Нийтлэг үйлчилгээний алба					2021 онд энэ арга хэмжээ төлөвлөгдөөгүй.
1.2.11	Хот тохижуулах газар	100	100	500.0	498.0	Орон нутгийн Хөгжлийн сангаас санхүүжсэн 59, 667 .2 мянган төгрөгөөр нийтийн эзэмшлийн гудамж талбайн 1500 гаруй гэрэлтүүлгийн төлбөр, засвар үйлчилгээний зардалд зарцуулагдсан болно.Сумын орон нутгийн төсвөөс 721.047.5 мянган төгрөгийн санхүүжилтийг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан бөгөөд 2021 онд 36 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна.Үйлчилгээний ажилчдын үр чадварын нэмэгдэл цалинг шийдвэрлэж өгч ажилласан нь ажилчдын ажилдаа хандах хандлага сайжирч ажилчдын нийгмийн асуудалд маш том түлхэц болсон.
1.2.11.1	Хот тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаа					2021 онд нийтийн эзэмшлийн гудамж талбайд байрлах 162 ш авто замын тэмдгийг , төв замын 4 хэсэгт цагаан зурвас тэмдэглэгээг тодруулан будаж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаа. Цэцэрлэг садны хайс хамгаалалт, замын хашлагийг эвдэрч гэмтээсэн тухай бүрд нь засварлан хэвийн байдалд оруулан гагнах цутгах ажлыг хийсэн. Нийтийн эзэмшлийн алаг чулуун замууд нь үерийн усаар сэтэрч эвдэрсэн 9 газарт буцааж засварлах усны цорго хэлбэрийн цутгалт хийж дахин үерт автахаргүй болгон янзаллаа. Орон сууцны гадна стандартын том 8 ш хогийн савыг хийж төв зам дагуу хийж 15 ш хогийн савыг дахин засварлан өнгө будгийг сэргээн засварлалаа. Аймгийн төвийн нийтийн эзэмшлийн авто болон явган замууд, цэцэрлэг саад, голын гольдролыг цэвэрлэдэг 10 үйлчлэгч, хог хаягдлыг тээвэрлэн зайлуулах 7 жолооч 8 ачигч, засвар үйлчилгээний гагнуурчин, засварчин, анчин,цахилгаанчин, мэргэжилтнүүд гэх 11 ажилчин бүгд 36 орон тоотой иргэдийн цэвэр орчныг бүрдүүлэх ая тухыг хангах өнгө үзэмжийн нэмэгдүүлэхээр цалинжиж ажиллаж байна.
1.2.11.2	Гудамжны гэрэлтүүлэг, цэвэрлэгээ					Архангай аймгийн төвийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн 1110 шон бүхий 2 толгойт гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл, гэрэлт гудамжны гэрэлтүүлэг, гэрэлт цахмийг өвөл зуны хуваарийн дагуу байгалийн цагтай уялдуулан 74 300.0 мянган төгрөгийн зардал гарсан байна. Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн толгойг засвар,мөн 100 ш гэрэлтүүлгийн шинэ толгойг 80ш ногоон гэрлийг шинэчилж тавихаар тэдний кабель солих, бусад гэрэлтүүлэгт цагийн механизм, соронзон пускатель, том жижиг дорсоль засварлах зэрэг урсгал засварын ажилд 15 850.0 мянган төгрөг зарцуулсан. Нийтийн эзэмшлийн бүх гэрэлтүүлгийн шонгуудад дугаарлалт хийсэн Бүх нийтийн хог цэвэрлэгээг аймгийн төвийн хэмжээнд 2 удаа зохион байгуулж 200 гаруй ААН, албан газрын ажилчин албан хаагчидтай эзэнгүй гэгдэх журамдаг үүссэн хог, голын гольдролыг цэвэрлэж нийт 36 машин хог буюу 324 м3 хогийг цэвэрлэлээ.
1.2.11.3	Ногоон байгууламжийн үйл ажиллагаа					Аймгийн төвийн гудамж талбай, цэцэрлэгт сад, орон сууцны орчны талбайд тариалсан ногоон байгууламжийг хэлбэржүүлэх цэвэрлэгээний огтлолыг 2021 оны 5-р сард, зам дагуух модыг хортон шавжаас хамгаалах /шохойдох/ ажлыг 6-р сард хийж тус тус хийж гүйцэтгэсэн. Өвлийн хүлэмжид тариалсан 2500 цэцгийн сулгачыг 2021 оны 06-р сард холбооны үлзвэр, цэцгийн савнуудад тарьж үргүүлсэн.
1.2.11.4	Хог хаягдлын тээвэрлэлт, устгах, дарах үйлчилгээ					Аймгийн хог хаягдлын зохиистой менежментийг бий болгон, үүний үр дүнд иргэдийн хог хаягдлын талаарх ойлголт, мэдлэг сайжирч, зөв дадал, хандлага төлөвшиж, хог хаягдлыг цуглуулах, зайлуулж, устгах, дахин ашиглах дэд бүтцийг бий болж, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор "Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр" ийг иргэд олон нийтийн санал, орон нутгийн онцлогт тохируулан боловсруулж, батлууллаа. Орон нутгийн төсвийн 336 сая төгрөгөөр хог хаягдлын цэгийн га талбайг Ихтамир сум 60 га талбайг 6 га, Өндөр-Улаан сум 3 га талбайг 1 га, Цэнхэр сум 4 га талбайг 2 га, Жаргалант сум 12 га талбайг 7 га болон багасгаж, хашаалж хог хаягдлыг цэгийн талбайг 63 гектараар /га/ бууруулсан байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/	
1	1.2.12	Аймгийн орон нутгийн өмчийн газар	100	100	160.3	160.0	2021 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 3.5 тэрбум төгрөгийн 13 төсөл арга хэмжээ, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 1.7 тэрбум төгрөгийн 16 төсөл арга хэмжээ, төсөл болон сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 0.8 тэрбум төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, бусад байгууллагын болон сумдын хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлэн зохион байгуулах 3.7 тэрбум төгрөгийн 8 төсөл арга хэмжээ, нийт 9.9 тэрбум төгрөгийн 41 төсөл арга хэмжээний худалдан авалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулсан. Орон нутгийн өмчийн газар нь нийт 9.9 тэрбум төгрөгийн 41 төсөл арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулсан. Үүнд: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 3.5 тэрбум төгрөгийн 13 төсөл арга хэмжээ, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 1.7 тэрбум төгрөгийн 16 төсөл арга хэмжээ, төсөл болон сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 0.8 тэрбум төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, бусад байгууллагын болон сумдын хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлэн зохион байгуулах 3.7 тэрбум төгрөгийн 8 төсөл арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулж байгаагаас тендерийг нээж гэрээ байгуулах эрх олгосон болон хүчингүй болсон 27 төсөл арга хэмжээний үр дүнг Сангийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 132 дугаар тушаалаар батлагдсан "Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдоод ил болгох журам"-ын дагуу 36 удаа ил болгосон байна.
	1.2.13	Орон нутгийн ахмад настанд үйлчлэх кабинет төв					2021 онд энэ арга хэмжээ төлөвлөгдөөгүй.
	1.2.14	Байгаль орчны газар	100	95.2	591.6	563.5	Байгаль орчин аялал жуулчлалын салбарын 21 зорилтын 38 арга хэмжээнээс 25 арга хэмжээ үр дүнтэй буюу 100%, 3 арга хэмжээ гол үр дүн нь гарч эхэлж байгаа буюу 90%, 1 арга хэмжээ гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70%, 1 арга хэмжээ бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50%, 8 арга хэмжээ хэрэгжээгүй 0%, нийт 38 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 83.4 хувь байна. Усны тоо бүртгэлийн аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Тус тооллогоор нийт 2822 уст цэг бүртгэгдсэнээс 781, нуур 205, булаг 691, рашаан 45, удаг 1100, сэргэсэн булаг 14, гол 4, нуур 3, ширгэсэн булаг 12, гол 18, нуур 8 тоологдлоо. Мөн ус ашиглагч иргэн аж ахуй нэгж байгууллагын судалгааг шинэчлэн гаргалаа. Аймгийн хэмжээнд ус ашиглагч 379 аж ахуй нэгж, рашаан ашиглагч 19 аж ахуй нэгж тоологдсон байна. Тамир хүүхдийн зуслан Олон улсын хүүхдийн зуслан болгох ахлын зураг төслийг боловсруулах АРАОНОГ/202112001 дугаартай тендер зарлагдаж, "Гобитравэл" ХХК гүйцэтгэгчээр шалгарч, 93 сая 700 мянган төгрөгөөр гэрээ байгуулж, гүйцэтгэлээ.
	1.2.15	Сум дундын ойн анги	100	100	75.8	75.8	Аймгийн Засаг даргын 2021 оны 02 сарын 02 ны өдрийн А/63 тоот захирамжаар Цэнхэр, Ихтамир, Эрдэнмандал сумдад сум дундын ойн ангиуд, Байгаль орчин аялал жуулчлалын газрын дэргэд Ойн нэгжийг байгууллаа. Ойн нэгж, сум дундын ойн ангиудын бүтэц, орон тоо, хариуцан ажиллах ойн сангийн талбайг тодорхой болгож улсын бүртгэлд бүртгүүлэн хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж, ойн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Булган, Ихтамир, Цэнхэр сумдын мод үржүүлгийн газарт нийт 700 ширхэг улиас тарьж усалж, арчлан улиасны мөчир бэлтгэх эх ургамлын талбай бий болгон ажиллалаа. Шилмүүст модны үр аймгийн хэмжээнд ургаагүй, навчит мод, сөөгийн үр болох шар хуягсны 30 кг, хайлаасны 70 кг үрийг түүж, үрийн нөөцийг бий болголоо
	1.2.16	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	100	100	5,547.9	4,485.7	Аймгийн орон нутгийн хөгжлийн санд 3910.0 сая төгрөг, сумдын орон нутгийн хөгжлийн санд 4465.4 сая төгрөгийг зарцуулахаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор баталсан. Гүйцэтгэлээр аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 2,100.0 сая төгрөг, сумдын орон нутгийн хөгжлийн сангаас 1,843.4 сая төгрөгийг зарцуулж гүйцэтгэл 80.9 хувьтай байна. Аймгийн орон нутгийн хөгжлийн сан нийт 46 төсөл арга хэмжээнд 3910.0 сая төгрөг батлагдсан.
	1.2.17	Аймгийн халамжийн сан	100	100	108.0	108.0	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг магадлан итгэмжлэгдсэн 6 төрийн бус байгууллага, 4 иргэн гэрээлэн гүйцэтгэж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар зөвлөгөө өгөх, сэргээн засах, гэрлийн асрамж халамжийн үйлчилгээнд зорилтот бүлгийн 167 иргэн, ахмад настны зөвлөгөө өгөх, өдрийн үйлчилгээнд зорилтот бүлгийн 39 ахмад настан хамрагдсан. Нийгмийн зорилтот бүлэгт халамжийн үйлчилгээний хүрээнд Нийгмийн халамжийн сангаас 2021 оны жилийн эцсийн байдлаар 39521 иргэн хамрагдаж 17.2 тэрбум төгрөг зарцуулсан. Хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдахаар хүсэлт гаргасан шинээр төрсөн 418 хүүхдийг тэтгэмжид хамруулсан.
	1.2.18	Санхүүгийн хяналт, аудитын алба	100	99%	149.7	148.5	2021 оны байдлаар Шилэн дансны нэгдсэн санд тайлан мэдээг 175 байгууллагаас 172 байгууллага илгээж, хэрэгжилт 98.3 хувьтай, мэдээлэл байршуулалт 97 хувьтай байгаа бөгөөд аудит, хяналт шалгалт хийсэн байгууллагуудад Шилэн дансны нэгдсэн цахим хуудсан дахь мэдээлэл, байгууллагын төсөв хөрөнгийн зарцуулалтыг ажилтан, албан хаагчид болон иргэд олон нийтэд нээлттэй ил тод, шилэн байдлаар танилцуулж ажиллах чиглэлээр зөвлөмж өгсөн. 2021 оны Шилэн дансны нэгдсэн санд улирлын тайлан мэдээг 175 байгууллагаас 172 байгууллага илгээж, хэрэгжилт 98.3 хувьтай байна. 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 69 байгууллагад аудит, хяналт шалгалт хийхээр тусгагдсаны дагуу төлөвлөгөөт 69, төлөвлөгөөт бус 14 байгууллагад хийж, нийт 83 байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулсны зэрэгцээ цаашид анхаарах асуудлаар зөвлөмж бэлтгэн харилцагч байгууллагын төсөв захирагч нарт хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллалаа. Аудит, хяналт шалгалтаар 1529.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, улсын байцаагчийн 67 актаар 218.3 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, тайлант хугацаанд 12.5 сая төгрөг, урд оны төлбөрийн үлдэгдлээс 5.0 сая төгрөг нийт 14.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг барагдуулж, биелэлт 85.8 хувь байна. Улсын байцаагчийн 34 албан шаардлагаар 1311.0 сая төгрөгийн зөрчлийн арилгуулах хугацаатай үүрэг өгч, биелэлт 95%-тай байна. Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжийн хүрээнд аймгийн Газрын төлбөрийн ногдуулалт, төлөлийн байдалд хийсэн хяналт шалгалтаар 70.7 сая төгрөгийн зөрчилд 17.6 нөхөн төлбөрийн акт, 53.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, биелэлт 73.1 хувь, Татварын хэлтсийн үйл ажиллагаанд аудит, хяналт шалгалтаар хийж 104.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, биелэлт 100 хувьтай байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
1.2.19	Соёлын үйлчилгээ	100	95.2	3,013.1	2,870.5	Соёл, урлагийн чиглэлийн 8 зорилтын 30 арга хэмжээнээс 13 арга хэмжээ үр дүнтэй буюу 100%, 5 арга хэмжээ гол үр дүн нь гарч эхэлж байгаа буюу 90%, 9 арга хэмжээ гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70%, 2 арга хэмжээ бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50%, 1 арга хэмжээ хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа буюу 30%, нийт 30 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 83.6 хувь байна. Ихтамир, Хангай, Тариат, Хайрхан, Эрдэнэмандал, Батцэнгэл, Хотонт сумын соёлын төвүүд БСУГ-тай хамтран цахим орчинд цар тахлын үед ард иргэдэд зөрөг хандлага төлөвшүүлэхэд соёл, урлагийнхан түүчээлэн хувь нэмрээ оруулах уриатай соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 12 хүний бичлэгийг Архангай аймгийн соёлын төвүүдийн нэгдсэн групп дээр байршуулж ард иргэдэд хүргэж 2000 гаруй хүн үзсэн. "Сүлд-2021" ардын болон нийтийн дууны цахим уралдаанд БСУГ, Хотонт, Батцэнгэл, Эрдэнэмандал, Өлзийт, Хайрхан, Цахир, Чулуут сумдын соёлын төвүүд хамтран ардын авьяастан 10 хүн амжилттай оролцуулж 2-р шатны шалгаруулалтад тэнцсэн. Тариат сумын соёлын төвөөс уран нугараач А.Пүрэвдулам, үндэсний бөхийн уламжлагч зан үйл, арга мэхийг өвлөн уламжлагч Д.Нарангарал, хадны бичээс зургийг сонирхогч С.Лхагвадогдогвоо нарын тухай нэвтрүүлгийг тус тус бэлтгэн Малчин ТВ болон цахимаар иргэдэд сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа. Шинээр Чулуут-2, Өндөр-Улаан-5 нийт 7 өвлөн уламжлагчийг бүртгэсэн. Архангай аймгийн хэмжээнд нийт 358 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг бүртгэн баримтжуулж музей дээр бүртгэл мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна. "Үндэсний бичиг үсгийг байр-2021" арга хэмжээг 5 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд "Зөв сайхан бичигтэн", "Турган уншлага", "Уран бичлэг"-ийн уралдааныг 3 насны ангиллаар зохион байгуулж, уралдааны төрөлд давхардсан тоогоор 186 оролцогч хамрагдлаа. Энэ жилийн арга хэмжээг анх удаа цахимаар зохион байгуулснаараа онцлог байв. Уралдааны ангилал тус бүрд 3 байр, нийт 29 байр шалгаруулж, "Уран бичлэг"-ийн уралдаанд амжилттай оролцон шалгарсан оролцогчдын бүтээлүүдээр өргөмжлөл хийн хадгалуулж, 2.4 сая төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.
1.2.20	Нийтийн биеийн тамир	100	92.8	332.2	308.4	Биеийн тамир, спортын чиглэлийн 5 зорилтын хүрээнд 12 арга хэмжээнээс 7 арга хэмжээ үр дүнтэй буюу 100%, 2 арга хэмжээ гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70%, хэрэгжээгүй 3 арга хэмжээ, нийт 12 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 76.3 хувь байна. ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын эрүүл мэнд, биеийн дархлаа, бие бялдрын үзүүлэлтийн түвшнийг орон нутагт түүврийн аргаар тодорхойлох үзүүлсэн амжилтаар мэдээллийн бааз бүрдүүлэн бие бялдрын сорилын стандарт боловсруулахад жишиг суурь үзүүлэлт болгох зорилгоор Эрдэнэбулган сумын 1-5 дугаар сургуулиудад "Ахлах ангийн сурагчдын сорилго" арга хэмжээг зохион байгуулав. Тус арга хэмжээг түүврийн аргаар хэт ядралт, ачаалал, бөөгнөрөл үүсгэгчгүйгээр хөнгөн атлетийн ойрын зайн 60м, 100м гүйлт, гурвын харайлт, уртын харайлт, 4х100м-ийн буухиа гүйлт гэсэн 5 төрлөөр 10, 11, 12-р ангийн эрэгтэй, эмэгтэй 960 сурагчийг хамруулав. БТСУХ-оос зохион байгуулсан "Эрүүл мэндийн цахим гүйлт 2021" арга хэмжээг "Архангайн гүйлчид 2021" нэрийн доор 2021 оны 03-р дугаар сард зохион байгуулж, оролцогчид STRAVA олон улсын гүйлтийн аппликейшнийг ухаалаг гар утас, ухаалаг бүлгэн цагаандаа татаж суулгаад "Arkhangai running 2021" багт дэлхийн өнцөг булан бүрээс гүйж оролцов. Мөн Архангайн гүйлчид 2021 фэйсбүүк групп хаяг нээж, гүйлтэд оролцогчид өдөр өдрийн гүйсэн замаа оруулж, мэдээ мэдээлэл хүргэж, бусдыгаа бүсээс 4-р байр, улсын хэмжээнд 17-р дугаар байр, Хангайн бүсээс эрэгтэй төрөлд М.Батпүрэв 3-р байр эзэлсэн амжилттай оролцлоо. Ард иргэдийг биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, бие бялдраа чийрэгжүүлэх, биеийн дархлааг дэмжихэд уриалсан "Дасгал хийцгээе" аяныг зохион байгуулсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шатрын тэмцээн, дасгал хөдөлгөөн хийцгээе зураг, шүлгийн уралдаан, селфи зэрэг цахим уралдаан, сургалтыг сарын аяны хүрээнд амжилттай зохион байгуулав. "Цахим гимнастрада" арга хэмжээнд 12 байгууллага, МУБИС, ерөнхий боловсролын 4 сургуулийн 165 гаруй оролцогчид аэробик, бүжиг, ажлын байрны дасгал хөдөлгөөн, иогийн дасгал зэрэг төрлүүдээр оролцож байна.
1.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			56,147.2	53,905.4	
1.3.1	Сургуулийн өмнөх боловсрол /Хамран сургалтын хувь	100	100	11,510.4	11,445.1	2020-2021 оны хичээлийн жилд 2 настай 68, 3 настай 1778, 4 настай 1934, 5 настай 2041, 6 настай 3 нийт 5824 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан. Энэ хичээлийн жилд үндсэн сургалтад 4618 хувилбарт сургалтад 1206 хүүхэд нийтдээ 5824 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна. Үүнээс танхимын сургалтад 3978, зайны сургалтад 1846 хүүхэд хамрагдсан. Ковидын улмаас 2, 3 настай хүүхдийг үндсэн сургалтад хамруулаагүй болно. 4 настай хүүхдийн 91.0, 5 настай хүүхдийн 96.0 хувийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж байна. 2021-2022 хичээлийн жилд 5 настай хүүхэд үндсэн сургалтад 1877, хувилбарт сургалтад 164 нийтдээ 2041 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж, сургуулийн өмнөх боловсролд 5 настай хүүхдийн хамрагдалт 96.0 хувьд хүрч өмнөх хичээлийн жилээс 2 хувиар нэмэгдсэн байна. Архангай аймагт 6 хүүхэд харах үйлчилгээний төв ажилладаг. Цэнхэр суманд-15, Төвшүүлэх суманд-15, Тариат суманд-10, Өлзийт суманд-10, Эрдэнэбулган-1-д-10, Эрдэнэбулган-2-д-15 хүүхэд нийт 75 хүүхэд хамрагдсан.2021 оны 01 сарын 28-нд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтад 3 хүүхэд харах үйлчилгээний төвийн 6 хүүхэд харагч хамрагдан "Хөгжлийг дэмжих арга зүй" номтой болсон.
1.3.2	Ерөнхий боловсрол	100	99	27,945.4	27,814.4	Боловсролын чиглэлийн 23 зорилтын 54 арга хэмжээнээс 27 арга хэмжээ үр дүнтэй буюу 100%, 6 арга хэмжээ гол үр дүн нь гарч эхэлж байгаа буюу 90%, 10 арга хэмжээ гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70%, 1 арга хэмжээ бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50%, 5 арга хэмжээ хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа буюу 30%, 5 арга хэмжээ хэрэгжээгүй 0%, нийт 54 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 76.6 хувь байна. Суурь боловсролын хамран сургалт 92.8 хувь, бага боловсролын хамран сургалт 93.5хувь, 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь 83.2 хувь байна
1.3.4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	100	99	9,326.8	9,239.1	Эрүүл мэндийн чиглэлийн 17 зорилтын 64 арга хэмжээнээс 33 арга хэмжээ үр дүнтэй буюу 100%, 3 арга хэмжээ гол үр дүн нь гарч эхэлж байгаа буюу 90%, 4 арга хэмжээ гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70%, 3 арга хэмжээ бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50%, 6 арга хэмжээ хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа буюу 30%, 15 арга хэмжээ хэрэгжээгүй 0%, нийт 64 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 67.4 хувь байна. Артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдавал зохих иргэдийн 53.9 хувь, чихрийн шижингийн үзлэгт хамрагдавал зохих иргэдийн 48.6 хувь, хөхний өмнөгийн үзлэгт хамрагдавал зохих иргэдийн 59.1 хувь, умайн хүүзний эсийн шинжилгээнд хамрагдавал зохих иргэдийн 44.0 хувь нь хамрагдаж, артерийн гипертензитай 346, чихрийн шижинтэй 11, хөхний өмөнтэй 1 тохиолдлыг илрүүлж хяналтад авсан. Хүн амд шүдний тусламж үйлчилгээг аймгийн Нэгдсэн эмнэлэгт 1, сумын Эрүүл мэндийн төв 2, нийт 3 шүдний кабинетаар тусламж үйлчилгээг үзүүлж байсан бол 2021 онд 2 сумын Эрүүл мэндийн төв шүдний кабинет байгуулагдаж эхэлснээр хүн амд үзүүлэх амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх хүртээмж нэмэгдсэн байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
2.2.9	Асрамжийн үйлчилгээ Асрамжийн хэвийн үйл ажиллагааг хангаж, асруулагчдын амьдрах орчин, үйлчилгээний чанарыг сайжруулна	Асрамжийн хэвийн үйл ажиллагааг хангаж, асруулагчдын амьдрах орчин, үйлчилгээний чанарыг сайжруулна	100%	124.6	124.6	Асрамжийн хэвийн үйл ажиллагааг хангаж, асруулагчдын амьдрах орчин, үйлчилгээний чанарыг сайжруулалт хийж ажилласан. Аймгийн асрамжийн газрын барилга нь Турк улсын "ТИКА" төслийн хүрээнд баригдахаар санхүүжилт нь шийдвэрлэгдсэн.
2.2.10	Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ	Хууль тогтоомжийн хүрээнд, хугацаандаа хийгдсэн байх	95%	168.4	168.4	Хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэний Лонда усний мэргэжил олгох сургалтын төвтэй хамтран усний мэргэжил олгох сургалтад хамруулж мэргэжил эзэмшүүлвэл. Ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.Олон нийтийн оролцонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийн санхүүжилтэд орон нутгийн төсвөөс 168.4 сая төгрөг олгосон болно
2.2.11	Санхүүгийн хяналт, дотоод аудитын үйл ажиллагаа	Хяналт, шалгалт, дүгнэлт үндэслэлтэй хийгдсэн байх		125.0	125.0	Батлагдсан төсвийн хүрээнд гаргаж, зарим нэгэн хэмнэгдэх боломжтой зардлыг зарцуулахгүй байх талаар арга хэмжээ авч хяналт тавьж ажиллаж байна. Хамналттай зардлуудыг хүрэлцэхгүй байгаа бусад зардалд шилжүүлэх тухай байгууллагуудын хүсэлтийг судлан шаардлагатай зардлуудын төсвийн зохицуулалт хийж өгсөн. Хэмнэлтийн горимыг чанд сахин, үргүй зардлыг багасган ажиллаж байна
2.2.12	Мал эмнэлгийн үйлчилгээ	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулах, малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга бүрэн хамруулах.	97%	486.9	486.9	Засгийн газрын 225 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх цусан халдварт, дотрын халдварт хордлого, дуут хавдар, тугалын их балнад, колибактериоз өвчнүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 711,21 мян.толгой мал хамруулахаар төлөвлөснөөс, 10 дугаар сарын мэдээгээр 681938 толгой мал хамрагдаж, гүйцэтгэл 95,8 хувьтай байна.Энэ онд Булган, Дэлүүн суманд малын гоц халдварт шүлхий өвчин гарч нийт 136 толгой мал үүнээс 126 үхэр 10 хонь,амаа/ мал өвчилсөн ба хооронд бус байхгүй. Харин малын өвчлөл өнгөрсөн оноос буурсан үзүүлэлттэй байна.Малын эмч нарын урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсөнд орон нутгийн төсвөөс 149.8 сая төгрөг, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 337.1 сая төгрөгийг РНХсангаас тус тус санхүүжүүлсэн болно
2.2.13	Соёлын өв /орон нутгийн музей/ийн үйлчилгээ	Музей танин мэдэхүй, сурталчилгааны төв болгон хөгжүүлж	98.0%	224.3	224.3	2021 онд КОВИД-19 халдварт цар тахлын улмаас музейн үйл ажиллагааг, ард иргэдэд цахимаар сурталчлан таниулж байна. Үүнд: Цагаан сар, Наурызын баяр, Олон улсын музейн өдөр, Эх үүрсийн баярын өдрүүдэд сэдэвчилсэн тур үзэсгэлэнг цахимаар зохион байгуулан ажилласан. Мөн Музейн үйл ажиллагааг орчин үеийн технологийн тусламжтайгаар бүрэн бүтэн бичлэг хийлгэж, цахимаар сурталчлан ажилласан. "Соёлын яам, нийслэлийн тэргүүний 1 дүгээр сургуультай" хамтран "Орон нутгийн музейн цахим аялал"-д Баян-Өлгий аймгийн музейг танилцуулж, аймгаас төрөн гарсан Хөдөлмөрийн баатруудыг цахимаар цуврал болгон танилцуулсан. Энэ арга хэмжээнд нийт 200 гаруй хүхэд оролцсон. Олон улсын музейн өдрөөр "Музейн ирээдүй, Сэргээе, Шинээр төсөөлө" сэдвээр радио төлөвлөснөөс Эсэв бичигийн уралдаан зарлаж, дүгнэн урамшуулсан. Дорнод, Хөвсгөл аймгийн музейнүүдтэй хамтран "Монголын сайхан орон-Музейн цахим аялал"-ыг амжилттай зохион байгуулж Дорнод аймгийн 13 сумын Ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангийн 100 сурагч музейн цахим аялалд хамрагдсан. Соёлын яамнаас уриалж буй "Цахим орчинд соёл түгээе Би хариуцлагатай иргэн" урианд нэгдэж, "Ардын язгуур урлагийг түгээцгээе" хорол тоглоом тоглох журам, Үүшүүр тоглоом, үүшүүр тоглоом тоглох журам, "Бүргэдээр ан авлах өв соёл", "4 шагайны тоглоом" зэрэг танин мэдэхүйн арга хэмжээг явуулсан.
2.2.14	Орон нутаг дахь номын сангийн үйлчилгээ	Зөөврийн номын сангийн үйлчилгээг нэмэгдүүлж, ард иргэдэд хүрч үйлчилнэ	100.0%	253.0	253.0	Байгууллагуудыг номын булантай болгох ажлын хүрээнд номын сангаас актлагдсан хуучин номуудаас уран зохиолын номуудыг шилж авч Өлгий сумын ЗДТГ, Хот тохижуулах алба,ОБГазар, ШШТГ, НДХэлтэс, Татварын Хэлтэс, Цагдаагийн Газар, Музей, ГХБХБГазар, ОНОНРадио, Гаалийн газар, БОАЖГазар, МАНУТХГ, ХХУГазар зэрэг байгууллагуудад номын булан байгуулан ажилласан. Шинээр бүрдүүлсэн ном хэвлэлийг ЦВБ-4U программны цахим каталогт бүртгэж, нийт 494 ширхэг карт шинээр бичиж, 400 ширхэг хэвлэн холбогдох каталогуудад байрлуулсан.
2.2.15	Тайзны урлаг /Театр чуулга/	Уран бүтээлийн нэр төрлийг олшруулж чанартай уран бүтээлээр ард иргэдэд үйлчилнэ.	100.0%	1,108.8	1,108.8	Ковид-19 цар тахлын нөлөөллөөс болж тогтмол үйл ажиллагаа явуулж чадаагүй ч зайн хэлбэрээр урлагийн үйл ажиллагааг сурталчлан таниулж олны хүртээл болгож ирсэн .
2.2.16	Биеийн Тамир спортын газар	Улс, олон улс, тив дэлхийн тэмцээнд баг тамирчдыг зохион байгуулалттай оролцуулах тамирчдын амжилтыг өсгөх, медалийн тоог нэмэгдүүлэх	Нийтийн биеийн тамирын талаарх иргэдийн мэдлэг, хандлага нэмэгдсэн байна.	211.6	211.6	Иргэдэд үйлчлэх спортын талбай, барилга байгууламжийг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. 2021 онд Ногооннуур суманд спорт цогцолбор баригдаж, ажлын явц 70%-тай байна. Мөн Өлгий сумын төвд хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний хомсдолос сэргийлэх зорилгоор 3х3 сагсан бөмбөгийн стандарт талбайг ХААН банкны төвөөс санхүүжүүлэн барьж, ашиглалтад оруулсан.Өлгий суманд Хөвд голын эрээр дугуйн, гүйлтийн зам барих судалгааны ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, төлөвлөгөө гарган ажиллаж байна. Өлгий сумын Засаг дарга зураг төсөв хийх компанитай гэрээ байгуулахаар болсон. Түүнчлэн 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Булган суманд сургуулийн спорт заал 1 600.0 сая, Баяннуур суманд сургуулийн 1 620.0 сая төгрөгийн өртөгтэй бүтээн байгуулалтын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн.
2.2.17	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	Байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах	Хэвийн үйл ажиллагаагаар хангагдсан	4,302.8	4,302.8	Орон нутгийн төсвөөс байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардлыг санхүүжүүлэн ажилласан болно
2.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			67,213.6	66,926.8	
2.3.1	Сургуулийн өмнөх боловсрол	Бага насны хүүхдийг асран хамгаалах, хөгжүүлэх	95.0%	15,962.4	15,962.4	Тайлант онд аймгийн хэмжээнд нийт 53 цэцэрлэг үйл ажиллагааг хэвийн явуулсан болно Мэдлэг, ур чадвартай, сайн туршлагаас суралцаж ямагт түгээн дэлгэрүүлдэг, ажлын байран дээрээ тасралтгүй хөгждөг, манлайлан үлгэрлэдэг, хүүхдийг хайрлаж хүндэлдэг, эс зүйг эрхэмлэн дээдэлдэг, хариуцлагатай, зөв хандлагатай багшийг төлөвшүүлэх зорилгоор "СӨБ-ийн багшийн хөгжил" дэд хөтөлбөрийг боловсруулан Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, аймгийн ИТХ-ын ээлжит хуралдаанаар оруулан батлуулахаар төслийг бэлэн болгосон
2.3.2	Ерөнхий боловсрол	Бага, суурь, бүрэн дунд боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	98.0%	41,772.3	41,485.5	Нийт 44 сургуульд 24500 хүүхэд суралцсан ба тайлант онд төсвөөс авах санхүүжилтээ бүрэн авч үйл ажиллагааг хэвийн явуулсан болно. Мэдлэг, ур чадвартай, сайн туршлагаас суралцаж ямагт түгээн дэлгэрүүлдэг, ажлын байран дээрээ тасралтгүй хөгждөг, манлайлан үлгэрлэдэг, хүүхдийг хайрлаж хүндэлдэг, эс зүйг эрхэмлэн дээдэлдэг, хариуцлагатай, зөв хандлагатай багшийг төлөвшүүлэх зорилгоор "СӨБ-ийн багшийн хөгжил" дэд хөтөлбөрийг боловсруулан Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, аймгийн ИТХ-ын ээлжит хуралдаанаар оруулан батлуулахаар төслийг бэлэн болгосон
2.3.3	Дүйцсэн хөтөлбөрөөр албан бус боловсрол олгох үйлчилгээ	Насанд хүрэгчдийн бичиг үсэг үл мэдэх байдлыг 35% бууруулах	100.0%			2020-2021 оны хичээлийн жилд Боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар нийт 367 суралцагч хамрагдсанаас Суурь боловсролд 135, 9-р анги төгссөн 50, Бүрэн дунд боловсролд 210, 12-р анги төгссөн 55 суралцагч байна. Тэгш хамран сургалт" хөгжлийн бэрхшээлтэй 46 байна. 2021-2022 оны шинэ хичээлийн жилд сургууль завсардсан Боловсрол нөхөн олгох сургалтад нийт 302 суралцагч хамрагдсанаас бага боловсролд 50 суралцагч, суурь боловсролд 53 суралцагч, бүрэн дунд боловсролд 199 суралцагч байна. Харин Бичиг үсгийн боловсролд 20 суралцагч хамрагдсанаас шинээр бичиг үсэг тайлагдсан 31, өмнөх түвшингээ ахиулсан 102, анхан шат 63, дунд шат 52, гүнзгий шат 35, дараах шат 56 суралцагчдад Насан туршийн боловсролын төвөөс бичиг үсгийн боловсрол олгосон. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад боловсрол нөхөн олгох хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоо буурсан сайн үзүүлэлтэй байна. Насан туршийн боловсролын төвд нийт 3 хүн ажилладаг ба тайлант оны үйл ажиллагааны зардалд 48.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон болно.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	2.3.4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	"Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх	Эх, хүүхдийн эндэгдэл гараагүй	8,812.6	8,812.6	Аймаг, сумдын яаралтай тусламжийн үйлчилгээг сайжруулахын тулд Цэнгэл, Буянт сумын эрүүл мэндийн төвд, Ногоонуур сумын Чихтэйн болон Улаанхус сумын Хөх Хөтөл багийн их эмчийн салбарт фургон машин, аймгийн Нэгдсэн эмнэлэгт яаралтай тусламжийн бүрэн тоноглолтой фургон, Хантар маркийн 2, нийт 6 түргэн тусламжийн машинаар хангагдаж түргэн тусламжийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, 4 их эмч, 8 сувилгаж 24 цагаар яаралтай тусламжийг үзүүлсэн эрмэлгийн яаралтай тусламж авах үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн ажиллаж байна. Аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт яаралтай тусламж үзүүлэх /олон үзүүлэлттэй/ монитор, төрөхийн ор, нярайн фото гэрийн эмчилгээний дулаан ширээ, нярайн шарпалт эмчлэх аппарат, хүүхдийн даралтын аппарат, пульсоксиметр, амьсгал тоологч, эх хүүхдийн жин хэмжигч, өндөр хэмжигч, тариурын автомат шахуурга зэрэг /66.235.000 төгрөгийн тоног төхөөрөмж төслөөр нийлүүлэгдэж тусламж үйлчилгээнд ашигласнаар эх, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж дээшилсэн.
	2.3.5	Газрын харилцаа, кадастр	төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах	100%	437.8	437.8	Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь газрын харилцаатай холбоотой 17 төрлийн төрийн үйлчилгээг 100% цахимд шилжүүлэх арга хэмжээ авч, тоног төхөөрөмжөөр ханган, иргэдэд цахимаар үйлчилгээ үзүүлж байна. Мөн тус газрын 29 мэргэжилтэн тоон гарын үсэг ашиглаж байна. Тухайлбал, Газрын төлбөр, татварын ногдуулалтыг Татварын удирдлагын нэгдсэн системд илгээх, уг системээс газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээллийг хүлээн авах ажил бүрэн хийгдсэн. 2021 онд татварын системээр дамжуулан нийт 5847 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын эзэмшил, ашиглалтад байгаа газарт нэхэмжлэл үүсгэж, 186.4 сая төгрөгийн төлбөр оногдуулан Татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн.
	2.3.6	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ /хамрагдалт/	төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах	97%	228.5	228.5	2021 оны төсөвт Хүүхдийн хөгжил, хамгааллын ордны барилгыг баруулахад зориулж улсын төсвөөс 1 тэрбум 930 сая төгрөгийг тусгаж өгсөн. Үүний дагуу барилгын ажлын захиалагчаас төндөр зарлагдаж "Монстрэй Эра" ХХК шалгарч барилгын ажлыг эхлүүлээд байна. Тэр бүлийн хөгжлийг дэмжих" аймгийн дэд хөтөлбөрийг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас судалгааны үндсэн дээр боловсруулан Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, аймгийн ИТХ-ын ээлжит хуралдаанаар оруулан батлуулахаар төслийг бэлэн болгосон. Авыяаслаг хүүхдүүдийг урамшуулах, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг олон нийтэд алдаршуулах зорилгоор цахимаар "Аз жаргалтай хүүхэд нас" бүжгийн уралдаан, "Уран жиргээ" уран уншлагын уралдаануудыг тус тус зохион байгуулж, 140 хүүхдийг хамруулсан. Улс үндэстний хүүхэд, өсвөр үеийнхний урам зорилгийг сэргээх, урлагаар дамжуулан сайн сайханд тэмүүлэх, өөртөө итгэх итгэлийг бадраахад нэмэр болохуйц, орчин үеийн хэлбэр, агуулгаар "Мөнгөн хараацай" Олон улсын хүүхдийн урлагийн наадамд аймгийн уран бүтээлч хүүхдүүдийг оролцох боломжоор ханган ажилласан.
3	БАЯНХОНГОР				96,047.2	89,196.8	
	3.1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа			2,686.7	2,641.0	
	3.1.1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа	Хурлын хуралдааныг 2-с доошгүй, Тэргүүлэгчдийн хуралдааныг 7, хороод тус бүрийн хурлыг 2 удаа хуралдуулж шийдвэр гаргана.	Орон нутгийн хэмжээнд баримтлах бодлого чиглэл, хөтөлбөр төлөвлөгөөг батлан гаргаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.	2,503.73	2,458	Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллага болох аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүнийг чөлөөт цагт байнгын тасралтгүй үйл ажиллагааг явуулдаг Тэргүүлэгчид нь 2021 онд аймаг орон нутгийн хэмжээнд баримтлах бодлого чиглэл, хөтөлбөр төлөвлөгөөг батлан гаргаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдаан 5 удаа хуралдаж, 27 тогтоолыг батлан хэрэгжүүлж байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 22 удаа хуралдаж, 135 тогтоолыг батлан хэрэгжүүлж байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 7 хороотойгоор ажилласан бөгөөд хороод нийт 15 удаа хуралдаж, 53 асуудлыг хэлэлцэж, 25 санал дүгнэлт гарган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид саналаа дүгнэлтээ оруулж хэлэлцүүлсэн.
	3.1.2	ГХУСА33-ийн үйл ажиллагаа	Аймгийн ГХУСА33-ийн ажлыг нэгдсэн төлөвлөгөөг баталж биелэлтийг хангуулах	9 бүлэг, тусгай арга хэмжээний хүрээнд 41 заалтыг төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн.	180.0	180.0	Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хуралдааныг 2021 онд 4 удаа зохион байгуулж, Баянцагаан, Бөмбөгөр, Эрдэнэцогт, Баянхонгор сумдын болон цагдаагийн газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын сонголт, мэдээллийг 2021 оны хагас жил, 3-р улирлын байдлаар хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өглөө
	3.1.3	ЦАУЗБСК-ийн үйл ажиллагаа	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийн дурсгалыг хүндэтгэх, тэдний үр хүүхэд, ач зээ нарт хуульд заасан дэмжлэг үзүүлэх	Улс төрийн хэлмэгдэгчдийн дурсгал мөнхжүүлэх, 10 иргэнд дэмжлэг үзүүлэх	3.0	3.0	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай" хуульд 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр орсон зарим өөрчлөлтүүдийн дагуу хэлмэгдсэн иргэдийн төрсөн болон үрчилж авсан хүүхдүүдээс материалын бүрдэл хангагдаж "Зууны мэдээ" сонинд зарлуулан, Баянхонгор аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр гарсан 4 иргэнд 2021 онд 121 сая төгрөгийн нөхөх олговрыг олгуулаад байна. Шүүхийн шийдвэр нь гараад санхүүжилт хүлээгдэж буй 6 иргэний 361.0 сая төгрөгийн нөхөх олговор 2022 онд олгогдохоор шийдвэрлэгдээд байна. Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас жил бүр "Улс төрийн хэрэгт хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх өдөр"-ийг тохиолдуулан улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн үр хүүхэд, ач зээ нараас дэмжлэг хүсэж өргөдөл ирүүлсэн, хуулийн дагуу одоогоор нөхөх олговор нь шийдвэрлэгдээгүй /материалаа ирүүлсэн/ иргэдэд нэг удаагийн мөнгөн тусламж үзүүлээ.
	3.2	Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			32,499.5	27,538.5	
	3.2.1	Иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон төрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах	Монгол Улсын хууль, УИХ, Засгийн газар, тогтоолыг орон нутагт хэрэгжүүлэн ажилласан.	12,635.0	8,228.3	Монгол Улсын хууль, УИХ, Засгийн газар, тогтоолыг орон нутагт хэрэгжүүлэн ажилласан. Аймгийн ИТХ-аас Засаг даргад даалган гаргасан 71 тогтоолыг хяналтад авч хэрэгжилтийг ханган, явц үр дүнг тайлагнан 2021 оны жилийн эцсийн хэрэгжилт 93 хувьтай.
	3.2.2	Орон нутгийн засаг захиргааны стратегийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа	Засаг даргын харьяа агентлаг, сумдын ЗДТГ-уудыг бодлого, удирдлагаар хангах.	Орон нутгийн бодлого үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар гэрээ байгуулан, гэрээг бүтэн жилээр дүгнэн ажилласан.	15,542.9	15,063.2	Аймгийн Засаг дарга эрхлэх хүрээний асуудлын 22 агентлагуудтай орон нутгийн бодлого үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар гүйцэтгэлийн төлөвлөгөөг хагас бүтэн жилээр дүгнэн ажилласан. 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 80-аас дээш хувьтай хэрэгжсэн. Мөн 20 сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан гэрээг хагас бүтэн жилээр дүгнэн хэрэгжилт, явц үр дүнг тооцон ажилласан.
	3.2.3	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ	7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн	163.1	163.1	2021 онд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал 163100.0 төгрөгийн 7 ажил арга хэмжээнд зарцуулахаас усны нөөц, зураглал хийж, бохирдлоос хамгаалах, мэдээллийн сан бүрдүүлэхэд 3 ажилын 32.0 сая төгрөг 100 хувийн биелэлттэй орчны бохирдол бууруулах бодлогын хүрээнд хөг хяагдлын менежментийн төлөвлөгөө боловсруулахад 40 сая төгрөгийн ажил 100%, Биологийн төрөл зүйлийг хамгаалах бодлогын хүрээнд 10 сая төгрөгийн ажил зэрлэг амьтдыг хамгаалах био техникийн ажил 100%, ойн менежментийн төлөвлөгөө боловсруулахад 10.0 сая төгрөгийн ажил 100% тус тус хийгдсэн. Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах, ногоон байгууламж нэмэгдүүлэхэд төлөвлөсөн 71.1 сая төгрөгийн ажил 2022.01.06-нд 90%ийн гүйцэтгэлтэй хийгдэж үлдэгдэл 30%ийн санхүүжилтийг олгоогүй болно.
	3.2.4	Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ	20 суманд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан	709.3	695.0	20 сумын мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг 46 аж ахуй нэгжид 533.500.0 төгрөгийн санхүүжилт олгосон.
	3.2.5	Замын сан	Замын сангийн хөрөнгө оруулалтаар 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Замын сангийн хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэгжүүлсэн.	947.7	904.4	Замын сангийн хөрөнгө оруулалтаар 10 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. 1 ажил төндөр шалгаруулалтыг зарласан компани шалгараагүй байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	3.2.6	Хот тохижуулах газар	төлөвлөгөөг хэрэгжүүлэх	төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан			<p>"Баянхонгор-тохижилт үйлчилгээ" ОНТҮГ-ын 18 зам талбайн үйлчлэгч Баянхонгор аймгийн нийтийн эзэмшлийн 96370.9 м2 авто зам , 21349.8 м2 явган зам, 9705.3 м2 хайс хамгаалалт, 78339.1 м2 парк цэцэрлэгт хүрээлэн, эрдэнэмандал хайрханы шат ,зогсоолын талбай зэрэг нийт 218632.5 м2 талбайн халтиргаа гулгааг арилгаж , цэвэрлэгээ үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэж байна. Мөн шинээр нэмэгдсэн 71400 м2 17500м 2 авто замын цэвэрлэгээг тогтмолжуулан ажиллаж байна.</p>
			Нийтийн эзэмшлийн 138439,5 м ² талбайд цэвэрлэгээ үйлчилгээ хийнэ.	100%			<p>"Баянхонгор-тохижилт үйлчилгээ" орон нутгийн өмчит аж ахуйн төсөвт үйлдвэрийн газрын 27 зам талбайн үйлчлэгч Баянхонгор аймгийн нийтийн эзэмшлийн нийт 590,057,12м² зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэж байна. Үүнээс: Авто зам 197993,4м² Явган зам 50245,1м² Хайс хамгаалалт, 78339,1 м² Тусгаарлах зурвас:13749,5м² Дугуйн зам 776,3м² Мазаалай парк 4397,57м² Гурван бүс цогцолбор 24600м² Жаргалант парк 248,270,10м² Эрдэнэмандал хайрханы авто зогсоол 1564м² Шат 2144,8м² Төв талбай 10150,95м² Гон Гандан дэдлин хийд 10858,34м² Хэлмэгдэгсдийн саад 3569,15м² Ахмадын саад 4941м² Хуучин биржийн авто зогсоол 1016,75м² Мазаалай паркийн зүүн талын зогсоол 4397,57м² зэрэг зам талбайн халтиргаа гулгаа, цэвэрлэгээ үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэж байна. Мөн баганат талбай, парк цэцэрлэгт хүрээлэнгүүд болон Түйн голын хөвөөнд зохион байгуулагдсан тэмцээн уралдааны үеэр нийтийн цэвэрлэгээ үйлчилгээ болон бусад ажлуудыг цаг тухай бүр хийж хэрэгжүүлж ажилласан.</p>
			Мазаалай, Гурван бүс, Ахмадын цэцэрлэгт хүрээлэн, Гандангийн өмнөх талбай, ногоон байгууламжийн хайс, Автобусны буудал, замын бродир будах, Эрдэнэмандал хайрханы өнгө үзэмжийг сэргээж, засварлана	100%	910.2	906.8	<p>Мазаалай паркийн засварын ажил хийгдэж сүүдрэвч, сандал, шат, хөшөө зэргийн өнгө үзэмжийг сайжруулж будаж шинэчлэх, усан оргилуурын засварын ажлыг бүрэн хийж ашиглалтад орууллаа. Мөн тус паркийн хашаа будах ажлыг хийж гүйцэтгэлээ. Гурван бүс цогцолборын хөшөө, усан оргилуурын бүрэн бүтэн байдлыг хангаж, засварлах ажлыг хийж гүйцэтгэж эхэлсэн зэрэгцээ тойрсон хашаа бүрэн будаж өнгө үзэмжийг сэргээгээд байна. Ахмадын цэцэрлэгт хүрээлэнд байрлах усан оргилуурыг шинээр хийх ажлын хүрээнд тохижилт үйлчилгээ техникийн албаны ажилчид нь усан оргилуурыг шинэчлэн бетон шал цутгах, плита наах, шинээр усан оргилуурын холболтуудыг гагнах, солих мөн гэрэлтүүлэг цахилгааны холболтууд хийх усан хангамж усаа сэлгэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өглөө. Төв гандангийн өмнөх талбайд байрлах сандал сүүдрэвч зэргийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллахын зэрэгцээ хайс хамгаалалтын эвдэрсэн хэсгийг нөхөж хаалга хийн ажилласан. Баянхонгор-Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-аар нь шинээр ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн газруудад болон хайс хамгаалалт шаардлагатай бүхий л газруудад хайс хамгаалалтыг тогтмол хийж ингэснээр тарьж ургуулж буй мод бутыг хамгаалж, хотын төвийн өнгө үзэмжийг нэмэгдүүлж эмх цэгцтэй тав тухтай орчныг бүрдүүлж байгаа юм. 2021 онд Дунд захын уулзвараас хуучин биржийн уулзвар хүртэл 1900 м2 талбайн хайс хамгаалалтыг, өөрийн байгууллагын өмнөх талбайд 98 метр хайс хамгаалалтыг шинээр хийлээ. Баянхонгор-Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-аар нь аюулгүйн тойргийн уулзвараас онцгой байдлын газрын уулзвар хүртэлх нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хайс, хамгаалалтын өнгө үзэмжийг сэргээн будаж засварлах унасан шон солих, эвдэрсэн хайс гагнах, төв замын тусгаарлах зурвас болон бусад газруудын 4800 метр хуучин төмөр утсыг шинээр трос утсаар солих ажлуудыг хийж гүйцэтгэлээ.</p>
	3.2.6.1	Хот тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаа	Усалгааны системийн хэвийн ажиллагааг хангах, нэмэгдүүлэх	100%			<p>Баянхонгор-Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-аар нь 2021 онд төв замын болон бусад нийтийн эзэмшлийн талбай, замын тусгаарлах зурвасын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх усалгааны системийг засварлах, шинээр хийж ажилд онцгойлон анхаарч ажиллаж ирлээ. Энэ ажлын хүрээнд 2021 оны 05 сарын 15-ны дотор төв усалгааны системийн засварыг бүрэн хийж Мэргэжлийн хяналтын арын гүнийн худгийн насос, кабель, Гурван бүс цогцолбор доторх гүний худгийн насосыг мөн төв усалгааны системийн дэмжих насос, усалгааны шланг, холбох хэрэгслүүд, насад зэргийг шинээр сольж усалгааг жигдрүүлэн ажилласан байна. Дунд захын урьд зэрэг газруудад гүнийг худаг гаргуулаад байна. Гандангийн өмнөх талбайд 95,5 м өргөнтэй 98,5м урттай 9406 м2 талбай, Гандангийн өмнөх талбайгаас Эмэнлэгийн арын уулзвар хүртэлх замын зорчих хэсгийн баруун зүүн талаар нийт урт нь 930 метрийн урттай 2 метрийн өргөнтэй 1860 м2 газарт, Эмэнлэгийн арын гэрлэн дохиотой уулзвараас Аймгийн ЗДТГ-аарын арын уулзвар хүртэл 468 урттай 3 метрийн өргөнтэй 1404 м2 газарт, Нэгдэлчингийн өмнөх талбайд зүлэгжүүлэлт ногоон байгууламж хийснээр урт нь 270 метр өргөн нь 9,5 метр 2565 м2 усалгааны системийг, Цэлмэг өглөө дэлгүүрийн уулзвар хүртэл 380 метр 3 метрийн өргөнтэй 1900 м2 талбайд усалгааны системийн холболтыг хийн гүнийн худгийг ашиглалтад оруулж усалгааг тавихад бэлэн болоод байна. Баянхонгор-Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-аар ногоон байгууламж ногоон орчныг нэмэгдүүлж Мазаалай паркийн өмнөх талбай, далангууд болон бусад газруудад 5500 м2 газарт шуршдаг зүлэг тарьсан бөгөөд тус газруудад усалгааны системийг, Ахмадын саданд 104,5м урттай 52м өргөнтэй 5434 м2 газар, театрын өмнөх талбайд 32 м урттай 9,5 өргөнтэй 304 м2 газарт усалгааны систем, Баянхонгор аймгаас Оготнотой булгын орчимд ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэнг байгуулах шийдвэр гаргасны дагуу Баянхонгор-Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-аар 245 метрийн урттай 28 метрийн өргөнтэй 6860 м2 талбайд модны болон зүлэг цэцгийн хосолсон усалгааны системийг угсарч хүлээлгэн өгөөд байна.</p>
			Явган хүний зам засварын ажлыг 32 м2 талбайд ийгдэнэ.	100%			<p>2021 онд Баянхонгор-Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-аар нь эко хавтан, явган замын хавтангийн үйлдвэрлэлийг эхлээд байна. Одоогийн байдлаар манай байгууллага Замын бродир 7500, эко хавтан 11000, замын хавтан 20000 үйлдвэрлэж 5 хүнийг гэрээгээр ажиллуулж ажлын байраар хангахаас гадна ОБХэлтэс, Татварын хэлтэс, Чандмань ХХК, Музей, Цагдаагийн хэлтэс зэрэг байгууллагууд өөрийн байгууллагын гадна орчны тохижилтын явган хүний замын бродир, хавтан, эко хавтанг авч тохижуулаад байна. Мөн Баянхонгор хотын нийтийн эзэмшлийн талбай буюу Эрдэнэмандал ахлах сургуулийн урд Эхбулаг ШТС-аас Есөн-эрдэнэ захын уулзвар хүртэл замын бродир, явган замын хавтанг үйлдвэрлэсэн бродир, явган замын хавтангаараа ханган гэрээт иргэд суурилуулан ажилласан байна. 2021 онд бетонон зам, замын эвдрэлийг засах, нөхөж ажлыг зохион байгуулж Мазаалай паркийн уулзвараас МСҮТ хүртэл, Жаргалант паркийн уулзвараас эцэс хүртэл, Баянбулаг зочид буудлын урьд зам, НИК-иас Эрдэнэмандал 2-р багийн гудамж хүртэл, Эмэнлэгийн уулзвараас 10 мянгатын уулзвар хүртэл, 10 мянгатын уулзвар орчмын зам, Цагаанчулут 5-р багийн голын захаас амьчуулын уулзвар орчмын зам зэрэг газруудад 255 м2 замыг нөхөж ажлыг хийгээд байна. Нийтийн эзэмшлийн зам талбайд байрлах явган замын эвдэрсэн хэсгийг нөхөж ажлыг зохион байгуулж 3600 ширхэг явган замын хавтанг шинээр сольсон буюу 324 м2 явган нөхөөд байна.</p>
	3.2.6.2	Гудамжны гэрэлтүүлэг, цэвэрлэгээ	Нийтийн эзэмшлийн парк, гудамж талбайг гэрэлтүүлнэ.	100%			<p>Мөн цахилгааны инженер, техникийн ажилчид нь цахилгааны аюулгүй байдлыг хангаж Мазаалай, Гурван бүс, Ахмадын сад, Гандангийн өмнөх талбай зэрэг газруудын гэрэлтүүлгийн шитийн монтажийг цэгцлэн сайжруулах, эвдрэх мусаадан гэрэлтүүлгийг сольж цэвэрлэх, шаардлага хангаагүй кабелиудыг солих зэрэг ажлууд хийгдэж гэрэлтүүлгийг бүрэн асаагаад байна.</p>

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/	
3.2.6.3	Ногоон байгууламжийн үйл ажиллагаа	Одоо байгаа 11235ш мод, 17180м2 зүлэгжүүлсэн талбайн арчилгааг хийж 17000ш цэцэг тарьж зам талбайд байршуула мөн 2000м2 талбайд зүлэг нөхөн тарина. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай хөрс бор шороог бэлдсэн байна.	100%			Нийтийн эзэмшлийн талбайн төв замын тусгаарлах зурвас доторх нийт 18 цэцгийн мандал болон цэцэрлэгт хүрээлэн бусад газруудад 5-6 навчтай буюу бүрэн цэцэглэсэн 10000-15000 ширхэг цэцгийг 2021 оны 6 сарын 10-ны өдрөөс эхлэн ил талбайд шилжүүлэн суулгаж байршуулан ургуулаад байна. 2021 онд тус газар нь Мазаалай паркийн өмнөх талбай, далангуд, Нэгдэлчин зочид буудлын урд талын талбай, хуучин бирхийн өмнөх талбай зэрэг газарт 5000 м2 талбайд хөрсийг боловсруулан дэвсэж шуршдаг зүгийг тарьж усалгааны системийг суурилуулан өдөр тутмын арчилгаа тордогоо хийж гүйцэтгэсэн. Аюулгүйн тойргоос Нэгдсэн эмнэлгийн гэрлэн дохиотой уулзвар хүртэл 1404 м2 газарт бор шороон хөрс бэлтгэн үрээр зүлэг тарьж ургуулаад байна.	
3.2.6.4	Аймгийн орон нутгийн өмчийн газар	Улс, орон нутгийн төсвийн худалдан авах ажиллагааг 100% цахимаар зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна. Төрийн өмч ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бодлогоор удирдлагаар хангах, Орон нутгийн өмчийн дуудлага худалдаа зохион байгуулах	100%	187.2	186.4	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг 100% төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох tender.gov.mn-ээр зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Орон нутгийн өмчит 242 байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн тодруулга тайлан, үндсэн хөрөнгийн тодруулга тайлан, хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг 100% гаргуулж 242 байгууллагын өмч эзэмшлийн гэрээг дүгнэж 1 жилээр сунгааа мөн өмч хамгаалах байнгын зөвлөлийг холбогдох хуулийн дагуу байгуулсан эсэх, өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2020 оны тайлан, 2021 оны төлөвлөгөөнд хяналт тавьж мөргөжил арга зүйлээр хангасан. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 18 хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг амжилттай зохион байгуулж орон нутгийн орлогод 55 сая төгрөг, акталсан хөрөнгө худалдан борлуулсан, дэнчин хүчингүй болсон зэрэг 3.4 сая төгрөгийн орлого нийт 58 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.	
3.2.7	Орон нутгийн ахмад настанд үйлчлэх кабинет төв	10 ахмад настанд асрамжийн үйлчилгээ үзүүлнэ.	10 ахмад настанд асрамжийн үйлчилгээ үзүүлсэн.	151.8	151.8	2020 жилийн эцсийн байдлаар 11 ахмад настанд асрамжийн үйлчилгээ үзүүлсэн.	
3.2.8	Байгаль орчны газар	Байгаль орчны багц хууль болон дүрэм журам төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх, иргэдэд сурталчлах, аймгийн Засаг даргын 2021 оны өдрийн А/483 дугаар захирамжийг хэрэгжүүлэх	740.7	735.6	Аймгийн Засаг даргын 2021 оны А/483 тоот захирамжийн дагуу хяналт шалгалтыг Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Зооноос өвчин судлалын төвтэй хамтран тарвага бүхий сумдад ажилласан. Хууль бусаар тарвага агнасан, тэвэрлэсэн, худалдсан, худалдан авсан нийт-17 зөрчил илэрч холбогдох хуулийн дагуу харууллага хүлээлгэн зөрчлийг эрх бүхий албан тушаалтан Мэргэжлийн хяналтын Улсын алхах байцаагч Б.Түмэнчимэг, хяналт шалгалтад хамтран ажилласан экологиин Цагдаагийн байцаагч тус бүр шийдвэрлэсэн. "Байгалиа хамгааль" сарын аяны хүрээнд аймгийн зах, худалдааны төвүүдээр нэн ховор, ховор ан амьтныг агнахыг хориглосон, агнахгүй байх, амьтны гаралтай түүхийг эд, эрхтэн бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авахгүй, тэвэрлэхгүй байх талаар 128 иргэнд зөвлөмж хүргэж, иргэдэд хууль бус ангаас өөрсдийгөө хамгаалах, амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ, Амьтны тухай хуулийн 37 дугаар зүйл, Амьтны нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай гарын авлага тараасан. Аймгийн БОАЖГ, ГХУСАЗ, үүрэн телефоны "Юнител" ХХК -тай хамтран Баян-Овоо, Бөмбөгөр сумдын 18-аас дээш насны 1696 иргэдэд байгаль орчноо хамгаалах хууль бусаар алт олборлохгүй байх талаар уриалга, анхааруулгыг гаргаж Immessage хэлбэрээр хүргэж ажилласан. Ус ашиглагч аж ахуй нэгжүүд, мөн бохирдуулагч аж ахуй нэгжүүдэд хяналтыг Байгаль орчин аялал жуулчлалын газар, Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргааны даргын хамтарсан хяналт шалгалт хийж удирдамжийн дагуу хяналт шалгалтын дүнгээр ус ашиглагч иргэн аж ахуй нэгж тус бүрээр судалгаа, зөвлөмж, хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээ мэдээллийг өгөн ажилласан. Халуун усны газар -7, Авто угаалгын газар -14, Цайны газар – 24, Зоогийн газар, ресторан -18, Уурын зуух -11, Талх нарийн боовны цех -3 тус тус бүртгэгдсэн.	
3.2.9	Сум дундын ойн анги	10 төрлийн бут жимсний модны сулгагч иргэд болон ААН-д борлуулна. Өөрийн байгууллагын 2 га газарт тариалалт хийнэ.	100%	81.8	81.4	2021 оны хавар, намрын тариалалтаар 12 нэр төрлийн 800 ширхэг тарьц, суулгагч иргэн ААН-д худалдан борлуулсан. Хавар мод үржүүлгийн талбайдаа улиас, бургасны нийт 4500 мянган ширхэг үр үрсэлгээ бэлтгэж тариалалт хийсэн.	
3.2.10	Аймгийн халамжийн сан	Баянхонгор аймгийн 854 иргэнд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлнэ Баянхонгор аймгийн 174 иргэнд амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж үзүүлнэ	2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 7 ТББ-тай гэрээ байгуулан зорилтот бүлгийн нийт 520 иргэнд 65.6 сая төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн. Мөнгөн тусламж үзүүлсэн	150.1	85.9	143.1 85.9	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмаар нээлттэй тендерийг 60.000.000 төгрөгийн 6 багц үйлчилгээг үзүүлэхээр зарлаж шалгарсан 7 ТББ, аж ахуй нэгжтэй гурвалсан гэрээг байгуулан 520 иргэнд Сэргэн засах үйлчилгээ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдрийн үйлчилгээ, түр байрлуулан асрамжлах үйлчилгээг үзүүлсэн. Мөн зорилтод бүлгийн иргэдийг бүлгийн зохион байгуулалтад оруулан төсөл хөтөлбөрөөр дэмжих арга хэмжээг удирдамжийн дагуу зохион байгуулж 10 иргэний 5 бүлгийн төслийг дэмжиж нийт 530 иргэд 65.572.500 төгрөгийн үйлчилгээ үзүүлэн ажилласан.
3.2.11	Санхүүгийн хяналт, аудитын алба	Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг бууруулах тал дээр арга зүйн зөвлөгөө өгч ажиллана. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 99%-д хүргэнэ.	100%	193.8	193.6	Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг бууруулахаар хяналт шалгалтад хамрагдаж байгаа байгууллагын удирдлага, нягтлан бодогч, холбогдох албан тушаалтан нарт сургалтыг илэрсэн зөрчил тулгуурлан тухай бүр сургалтын зохион байгуулж, зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан. Шилэн дансны тухай хуулийн дагуу улирал бүр төсөвт байгууллагын шилэн дансны хэрэгжилтэд хяналт шалгалтын хийж, зөрчил дутагдлыг илрүүлж хуулийн хугацаанд холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажилласан. Сумдын Санхүүгийн албаны дарга, төсөвт байгууллагын нягтлан бодогч, нарт шилэн дансанд илэрсэн зөрчил дутагдлын талаар, түүнийг хэрхэн бууруулах талаар мэдээлэл хийсэн.	
3.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			60,861.0	59,017.3		
3.3.1	Сургуулийн өмнөх боловсрол	Хүүхдийн тоо 5911, Хамрагдалтын хувь 75,7, настай хүүхдийн СӨБ-д хамрагдалт 95,0 хувь	100%	13,562.1	12,923.5	Хүүхдийн тоо 5780, үүнээс эмэгтэй нь 2924 Хамрагдалтын хувь 68, таван настай хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт 91 хувь.	
3.3.2	Ерөнхий боловсрол	Бага боловсролын хамран сургалтын хувь 95,2, Суурь боловсролын хамран сургалтын хувь 90,8, 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь 95,2 дотуур байранд хүсэлт гаргасан хүүхдийн хамрагдалтын хувь 96,8-д хүргэнэ.	100%	30,775.2	30,021.9	2021-2022 оны хичээлийн жилийн жилд төрийн болон төрийн бус өмчийн 32 сургуульд 18496 суралцагч суралцаж байна Үүнээс 9325 нь эмэгтэй. Бага боловсролын хамран сургалт 98,1 хувь, суурь боловсролын хамран сургалт 95,9, 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь 90 хувь, Дотуур байранд амьдрах хүсэлтгээ гаргасан сурагчдын 99,1 хувь дотуур байранд амьдарч байна.	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилгот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/					
3.3.3	Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ	Баянхонгор сумын 10 багийн 30330 иргэнд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлнэ.	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан	10,957.0	10,665.8	Аймгийн хэмжээнд 2021 онд Энхбүрд, Оточномгон, Оточмандал, Наранмандал зэрэг ерхийн эрүүл мэндийн 4 төвүүд "Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон" төсвөөр санхүүжин, үйл ажиллагаа явуулж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг дараах хэлбэрээр үзүүлж ирсэн байна. Үүнд: 1. Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан нийт иргэд давхардсан тоогоор - 50385, 2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан иргэд-15999, энэ нийт үзлэгийн 31.7 хувийг эзэлж байна. 3. Өвчний учир үзлэгт хамрагдсан иргэд – 1886, 4.Архаг эмгэгийн улмаас диспансерын хяналтад үзүүлсэн иргэд -15138, 5.Гэрээр идэвхтэй эргэлтээр эргэсэн иргэд – 16523, 6. Яаралтай тусламж шаардлагатай гэрийн дуудлагаар үзлэг хийсэн - 839 7. Жирэмсний хяналтад хянасан эх-395 эмэгтэй, энэ нь аймгийн хэмжээнд 2021 оны нийт жирэмсэн эхүүдийн 47.5 хувийг эзэлж, жирэмсний эрт үеийн хяналт аймгийн хэмжээнд 90.4 хувьтай бөгөөд амаржсан 722 эхийг, шинэ төрсөн нярайн хамт эхийн 1 сарын хугацаанд 7 хоног бүр гэрийн эргэлтээр эргэж, зөвлөгөө өгч, хянасан байна. 8. Жилдээ халдварт өвчний 8839 тохиолдол илрүүлсэн, 10 000 хүн амд харьцуулахад 2472.0 байна. 9. Хүүхдийн өсөлт хөгжилт хэмжилтээр жилдээ 2044 хүүхэд жиллэсэн нь Баянхонгор сумын 5 хүртэл насны нийт хүүхдийн 53.8 хувийг эзэлж, өсөлтийн хоцрогдол, туранхай, тураалтай 40 хүүхдийг илрүүлэн эмчилсэн байна. 10. Халдварт бус өвчний эрт илрүүлдгийн үзлэгт хамрагдах ёстой хүн амын 72.6 хувийг хамруулан, артерийн даралт ихсэлттэй 28, чихрийн шижинтэй 2 тохиолдол илрүүлэн диспансерын хяналтад аван эмчилж байна. 11. Хөх умайн хузуу, элэгний хорт хавдрын илрүүлдгийн үзлэгт 9229 иргэн хамруулснаас хорт хавдрын 10 тохиолдол шинээр илрүүлэн хяналтад авч, энэ нь 10 000 хүн амд харьцуулахад 2.0 байгаа нь урд оноос 2.2-аар өссөн үзүүлэлттэй байна. 12. Товлолт дархлаажуулалтад 5346, томуугийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад 7507, тархвар судлалын заалтаар галзуугийн вакцинд 59, томуугийн вакцинд 50, халдварт саагийн эсрэг тарьдаг вакцин нөхөнгөөр 3-5 насны 1036 хүүхэд хамрагдсан байна. Коронавируст халдвар /сovid-19/-ын эсрэг вакцины 1,2,3 тунд 20819 хүн хамруулсан байна.						
						3.3.4	Соёлын үйлчилгээ	Соёл урлагийн бүтээлийг төв, хөдөө орон нутагт чанартай хүргэх	100%	4,072.5	3,923.4	С.Тогоомөнхийн зохиол ардын уламжлалд суурилсан "Хатан сүйх" дуулалт бүжгийн бэлтгэл ажил 2021 оны 4 дүгээр улиралд "Өвөл цагийн нээлт" Мөн Баянхонгор аймгийнхаа нийт 19 сумдын иргэд хөдөлмөрч соёлын бүтээлээр "Тэнгэрлэг түмний дуулалт" концертыг амжилттай сумуудаар тогтоосон бөгөөд тус тус уран бүтээлүүд, Монгол үзэсгэлэн-70, сэргээн тавьсан жүжиг-5, уралдаан тэмцээн-3, Монголын үндэсний телевизийн том ахын аялал нэвтрүүлэг 6 удаа орон нутгаар аялсан.
								Соёл урлагийн бүтээлийг төв, хөдөө орон нутагт чанартай хүргэх хүүхэд багачуудыг соёлын боловсрол олгоно.	Соёл урлагийн бүтээлийг төв, хөдөө орон нутагт чанартай хүргэсэн байна.	460.3	459.4	Концерт-7, Монгол үзэсгэлэн-70, сэргээн тавьсан жүжиг-5, уралдаан тэмцээн-3, Монголын үндэсний телевизийн том ахын аялал нэвтрүүлэг 6 удаа орон нутгаар аялж, бусад арга хэмжээ 54, нийт 100 арга хэмжээ 48.748 үзэгчийг хамруулж ажилласан.
						3.3.5	Газрын харилцаа, кадастр	Шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар батлуулж, 900 иргэнд эдлэн газартай, амины орон сууцны газар өмчлүүлнэ. иргэдийн газар эзэмших гэрээг дүгнэх замаар Орон нутгийн төсвийн орлогод 710,0 сая төгрөгийг төлбөрийн төвлөрүүлнэ.	676.5 сая төгрөг төвлөрүүлсэн	526.5	522.3	Газар болон барилга хот байгуулалтын чиглэлийн хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэн ажиллана. 20 сумд 106 нэгж талбарт газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг дуудлага худалдааг зохион байгуулж, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 66 га талбайг 872 иргэнд өмчлүүлнэ. Мөн газрын дуудлага худалдааны орлогоор аймгийн төсөвт 678.6 сая төгрөг төвлөрүүлсэн.
								Баянхонгор аймагт баригдаж байгаа 65 барилга, байгууламжид техник, хяналт хийж ажиллана.	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан	30.9	30.5	Баянхонгор аймагт баригдаж байгаа 53 барилга, байгууламжид техник, хяналт хийж ажиллана.
3.3.6	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн хоёрдугаар шатны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	100%	476.5	470.5	Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг газрын даргаар батлуулан сумдад хүргэсэн. Хөтөлбөрийг 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлж хэрэгжилт 90%-тай байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд боловсрол соёл урлагийн газар, Цагдаагийн газар, сумдын Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газруудтай хамтран ажилласан.						
		"Хамтарсан баг"-ийн үйл ажиллагааг арга зүйгээр дэмжих, хяналт үнэлгээ хийх, хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах арга хэмжээг зохион байгуулах	80.90%			Тайлант оны нэгдүгээр улиралд Хамтарсан багийн 2020 оны үйл ажиллагаанд /кейс дээр ажилласан байдал, илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх, холбон зуулах үйл явц, бичиг баримтын цэгч, бүрдүүлэлт, орон нутгийн иргэдэд танигдсан байдал/ хяналт үнэлгээг хийж, үр дүнг тооцож, баг тус бүрд зөвлөмжийг хүргэн үр дүнтэй ажилласан 4 багыг урамшуулсан. Хамтарсан багийн гишүүдийг чадавжуулах сургалтыг цахимаар-2, танимаар-2 удаа зохион байгуулж, арга зүйгээр ханган ажилласан. Хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 6145 болж өмнөх оноос 4.8%-иар, насанд хүрэгчдийн тоо 14521 болж өмнөх оноос 15.3%-иар өссөн байна. Зарцуулсан төсөв 11.923.500 төгрөг байна.						
		Нэг цэгийн үйлчилгээний төвийн буюу түр хамгаалах байрны хөвийн үйл ажиллагааг ханган, үйлчлүүлж буй хожирогчдод тухай бүр нь нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж, хамтран ажиллах	100%			Хамгаалах байранд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 26 эмэгтэй, 73 хүүхэд байрласан. Хүчирхийлэлд өртсөн хэлбэрээр ангилбал хараа хяналтгүй-5, бие махбодын хүчирхийлэлд өртсөн-6, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн-12, Балгийн хүчирхийлэлд өртсөн-6, төөрсөн-1, ээжтэйгээ хамт ирсэн-28 хүүхэд байна. Үйлчлүүлэгчид дунджаар 10-35 хоногийн хугацаатай байрласан. ГБХЗХГ-аас Түр хамгаалах байрны ажилтан албан хаагчдыг мэргэжлийн удирдлага арга зүйгээр өдөр тутам ханган зөвлөн тусалж байна. Мөн хагас, бүтэн жилээр хамгаалах байрны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн зөвлөмж хүргүүлсэн.						
4	БУЛГАН			75,763.8	68,629.7							
	4.1 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа				711.8	640.2						
4.1.1	Аймгийн ИТХ-ын хуралдаан	4 удаа	төлөвлөгөөнд хүрч ажилласан	611.8	540.2	Аймгийн ИТХ-ын хуралдааныг 3 удаа хуралдуулж 44 асуудал хэлэлцэж 44 тогтоол гаргаж, тэмдэглэлээр үүрэг чиглэл өгч ИТХ-д хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлж, нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөх бодлого, шийдвэр, дүрэм журмыг хуулийн хүрээнд бие дааж шийдвэрлэв. Төлөөлөгчдийг сонгогдсон тойрогтоо ажиллахад нь 2.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, нийт 75.7 сая төгрөг зарцууллаа. Аймгийн ИТХ-ын 2019 онд гаргасан шийдвэрийн эмхэтгэл, аймгийн ИТХ-ын 2020 оны ажлын төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын 2016-2020 онд баримтлан ажиллах чиглэлийн хэрэгжилтийн талаар товчжил хэвлүүлэн төлөөлөгч, Bulgan.khural.mn сайт, "Булганы мэдээ" сонин, "Сайхан монгол" ТВ-тэй хамтран ажиллаж, хуралдааныг шууд дамжуулж, хурлын үйл ажиллагааг тогтмол мэдээлж олонд түгээж ажилласан.						
4.1.2	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал	24 удаа	төлөвлөгөөнд хүрч ажилласан			Тэргүүлэгчдийн хурлыг 23 удаа хийж давхардсан тоогоор 62 асуудал хэлэлцэж, 32 тогтоол гаргаж, тэмдэглэлээр үүрэг чиглэл өгсөн байна.						

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
4.1.3	Иргэний танхимаар хэлэлцүүлэх хэлэлцүүлгийн тоо	Хэлэлцүүлэг, уулзалт, сургалт, хурал, ярилцлага-9		төлөвлөгөөнд хүрч ажилласан			ИТХ-ын дэргэдэх Иргэний танхимаас "Хүүхдийн мөнгөн тэтгэлэг олгох тухай", "Ягтах тусам нягтал сургалт хэлэлцүүлэг", цагдаагийн ахмадуудын тайлан, ИНБ-уудтай хийх 2021-2024 онд хамтран ажиллах талаар хэлэлцүүлэг, "Омбудудаа хайрлая" сэдэвт хэлэлцүүлэг, "Зуны амралт-Хүүхэд хамгаалал" сэдэвт хэлэлцүүлэг, "Тогтвортой амьжиргаа 3 төсөл"-тэй хамтран сумдын хурлын төлөөлөгчдөөс зориулсан орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт зарцуулалт хяналт ашиглалт сэдэвт сургалтуудыг зохион байгуулж давхардсан тоогоор сургалтад 259 хүн, хэлэлцүүлэгт 215, уулзалтад 189 хүн хамрагдсан байна.
4.1.4	ИТХ-ын төлөөлөгчийн тойрогт ажиллах хоног /1 төлөөлөгчийн/	28		төлөвлөгөөнд хүрч ажилласан			ИТХ-ын төлөөлөгчид 5250 иргэдтэй уулзалт зохион байгуулж санал хүсэлтийг сонсож 76 ахмад настанд гарын бэлэг гардуулан өгсөн. Төлөөлөгч Д.Оюунбилэг, П.Оюунцэцэг, Ж.Отгонтуяа нар "Нэг төлөөлөгч-Нэг санаачилга" аяны хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөхийн өмнөх байрны засварыг хийж тохижуулсан. Төлөөлөгч Л.Одончимэг зорилтод бүлгийн 2 өрхөд гэр, төлөөлөгч Д.Наманбаяр Хишиг-Өндөр сумын эмнэлгийн машины засварыг бүрэн засварласан, төлөөлөгч С.Гал-Эрдэнэ Баяннуур сумын Эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн зориулалтын автомашин, сумдад 100 тн малын тэжээлийн дэмжлэг үзүүлсэн бол төлөөлөгч М.Бат-Орших Сайхан сумын сургуулийн дотуур байранд 50 ширхэг зөөлөн эдлэл, сумын онцгой комисст 200 литр шатахуун, 1000 маск хандивлажээ. Төлөөлөгч Ч.Батсүх Хишиг-Өндөр суманд 1 худаг шинээр гаргах, 1 худгийг сэргээн засварлах ажлыг мэргэжлийн компаниар гүйцэтгүүлсэн хэрэгтэй ажил санаачлан хийсэн байна. Төлөөлөгч Д.Оюунбилэг Буриадын хороонд 1 худаг, Н.Баасанжаргал 2-р багийн үерийн далан, гэрэлтүүлгийн асуудлыг холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлсэн байна.
	ГХУСА33-ийн үйл ажиллагаа	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх сургалт /цагаар/ 96, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх /цагаар/ 64		төлөвлөгөөнд хүрч ажилласан	100.0	100.0	Аймгийн ИТХ-ын даргын удирдамжийн дагуу Хутаг-Өндөр, Тэшиг, Сэлэнгэ, Дашинчилэн, Баяннуур, Могод, Бүрэгхангай, Хишиг-Өндөр сумдад ажиллаж ИТХ-ын үйл ажиллагаанд зөвлөн тусламж, ИТХ-аас гаргаж буй тогтоол шийдвэрийн хууль эрх зүйн үндэслэлийг хянаж хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан. Тухайн сумдын төрийн албан хаагч, ИТХ-ын төлөөлөгч, иргэдэд Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, удирдлагын тухай хуулиар сургалт уулзалт ба ойролцоогоор 960 иргэнийг хамруулсан байна. Аймгийн ЕБС-ийн нийгмийн ажилтан, анги удирдсан багш нарыг хамруулан цахим уулзалт, "Омбудудаа хайрлая" сэдэвт бага насны хүүхдийг хүчирхийлэх гэмт хэргийн нөхцөл шалтгаан түүнээс урьдчилан сэргийлэх хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, "Хуулийн цаг" ТВ-ийн нэвтрүүлэг, "Амрыг эрье" FM радиогийн нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэсэн байна. Архидан согуурахтай тэмцэх тухай хууль, цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан "Шаг", "Согтуу" хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, торгох, хураагдсан эд үйлийг устгах зэрэг арга хэмжээ авч ажилласан.
4.2 Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ					33,704.4	28,384.9	
4.2.1	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бодлого, шийдвэрийг боловсруулах, хуралдаанд бэлтгэх болон харьяа агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ чиглэлээр цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэгээр шуурхай хангах	Хууль тогтоомжид нийцсэн байх		төлөвлөгөөнд хүрч ажилласан			Булган аймгийн Засаг даргын Тамгын газар нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүй, зохион байгуулалтын орчин бүрдүүлэн ажиллаж, Засаг дарга, түүний тамгын газар, агентлаг үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай орчин, нөхцөлөөр хангах, үзүүлэх үйлчилгээг сайжруулах чиглэлээр ажиллалаа. Ажиллагсадтай холбогдсон цалин, хөлсний зардалд 1003.7 мян төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 225.1 мян төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардалд нийт 104.3 мян төгрөг, албан томилолтын зардалд 38.1 мян төгрөг, хангамж, бараа материалын зардалд 130.0 мян төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 278.7 мян төгрөг тус тус зарцуулсан байна.
4.2.2	Аймгийн Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллага, сумдын удирдлагыг мэргэжлийн цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэгээр шуурхай хангах, тэдгээрийн үр нөлөөтэй, хэвийн үйл ажиллагааны эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	Мэдээллээр хангасан байх		төлөвлөгөөнд хүрч ажилласан			Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны сонгуулийн үр дүнд сонгогдсон аймгийн ИТХ-ын 2020 оны II хуралдаанаас "Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020-2024 онд баримтлан ажиллах чиглэл", аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж эхлээд байна. Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр агентлаг, хэлтсийн дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулсан.
4.2.3	Хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнгийн мэдээллийг хагас, бүтэн жилээр хийх	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх		төлөвлөгөөнд хүрч ажилласан	25,295.3	20,262.8	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгэм, эдийн засгийн үндсэн салбаруудын бодлогыг тодорхойлсон 5 бүлэг 70 зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 379 арга хэмжээг тусган, эдгээр зорилт, арга хэмжээг жигд бүрэн хангахад удирдлага зохион байгуулалтын ажлаа чиглүүлэн хөтөлбөрийн заалт бүрийг холбогдох сум, агентлаг, хэлтсүүдэд хариуцуулан эзэнжүүлж, бүтэн байгуулалтын шинжтэй чухал асуудлуудыг хэрэгжүүлэх арга хэмжээг жил, улирлын ажлын төлөвлөгөөнд тусган биелэлтийг тооцон ажиллав. Хөтөлбөрийн хэрэгжилт 2020 оны өссөн дүнгээр 92.2 хувь буюу "үр дүнтэй" хэрэгжсэн байна гэж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дүгнэсэн. Энэ нь өмнөх оноос 5.9 хувиар өссөн дүнтэй байна.
4.2.4	Төрийн албаны хүний нөөцийг үе шаттай сургаж, мэргэшүүлэн төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулах	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх		төлөвлөгөөнд хүрч ажилласан			Булган аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2020 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим санд байршуулсан аймгийн Засаг даргад хэрэгжүүлж ажиллахаар үүрэг болгосон 96 шийдвэрийн 191 заалтыг хяналтад авч, холбогдох журмыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тус санд хугацаанд нь байршуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хяналтад авсан 96 шийдвэрийн 191 заалтын 173 /90.5 хувь/ нь бүрэн хэрэгжсэн, 10 /5.2 хувь/ нь хэрэгжих шатанд, 4 /2.0 хувь/ нь хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй, 4 /2.0 хувь/ нь хэрэгжилт тооцох хугацаа болоогүй заалт байгаа ба биелэлтийн дүнг дунджаар авч үзвэл 96.1 хувьтай буюу 4.80 оноотой үнэлэгдэв. Хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүйн улмаас 1 заалт тасарч, 2 заалт хэрэгжээгүй байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хэрэгжилт удааширсан, эрчимжүүлэх шаардлагатай ажлуудыг илрүүлэн, гүйцэтгэлийг сайжруулан ажиллаж байгаа нь тайлангийн чанар сайжирсан зэрэг үр дүн гарч байна.
4.2.5	Төрөөс цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх		төлөвлөгөөнд хүрч ажилласан			Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийн гүйцэтгэл 371.8 сая төгрөг, үүнээс шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардалд 70.2 сая, цэрэг татлагын зардалд 12.0 сая, мал тооллогын зардалд 3.5 сая, Ахмадын хорооны санхүүжилтэд 41.6 сая, гамшиг ослын үр дагаврыг арилгахад 18.0 сая, бусад болзошгүй зардалд 226.5 сая төгрөгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 93 захирамжийг үндэслэн зарцуулсан байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
4.2.6	Мал эмнэлгийн үйлчилгээ	Халдварт өвчнөөс урьдчилсан сэргийлэх вакцинжуулалтад хамрагдах малын тоо /давхардсан тоогоор/ -718600	712100	439.9	439.9	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ технологийн хугацаанд чанартай хэрэгжүүлэх, мал эмнэлгийн ажил үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг сайжруулах, сумын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн, гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, мал амьтныг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүлжүүлэх нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээ гардиот хугацаандаа хийгдэж дууссан. 16 сумын 50 мал эмнэлэг үйлчилгээний нэгжтэй гурвалсан гэрээ хийсэн. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 1362.3 мянган толгой мал амьтан хамруулахаар төлөвлөж, малын тоо, эм биобалдмэлийг тархвар зүйн судалгаанд үндэслэн сүм тус бүрээр хуваарилан төлөвлөгөөг сумдад хүргүүлж ажиллаа. Биоккомбинатаас 12 нэр төрлийн 383.6 сая төгрөгийн эм биобалдмэлийг татан авч, сумдад олгосон. Үүнээс орон нутгийн санхүүжилтээр 146.5 сая төгрөгийн биобалдмэлийг Биоккомбинатаас татан авалт хийсэн. Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 12 нэрийн вакцинжуулалтад 1336.7 мянган толгой мал амьтан хамрагдаж 98.1 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Орон нутгийн санхүүжилтээр хийгдэх 4 нэрийн халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад 718.6 мянган мал хамруулахаас 712.1 мянган мал хамруулан 99.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлийн цуваа, баримтыг сумдаас хүлээн авч, шалган, цахим бүртгэлтэй тулгаж үйлчилгээний зардалд улсын төсвөөс 134.2 сая төгрөг, орон нутгийн санхүүжилтээс 451.0 сая төгрөгийг 50 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгосон.
		Малын халдварт өвчний гаралтыг бууруулах /хувиар/ 0.1	13.10%	167.3	167.3	Халдварт өвчнөөр нийт 844 мал, амьтан өвчилж 776 мал амьтан хоргодсон. 2020 оны мөн үетэй харьцуулахад халдварт өвчний өвчлөл 13.1%, хоргодол 23.9 хувиар өссөн нь байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан дотрын халдварт хордлогоор хоргодсон малын тоо 5.3 дахин өссөн байна.
4.2.7	Олон нийтийн оролцоо түшиглэсэн халамжийн үйлчилгээний хамрагдах хүний тоо	170	170	30.7	30.7	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг цар тахалтай байгаатай холбогдуулан нийгмийн халамжийн зорилтот бүлэгт чиглүүлэн, амьжиргааг нь дэмжих өрхтэй холбон зуучилж 15 сумын 33 төслийг дэмжин ажилласан. Тус үйлчилгээний бүлгийн төсөл хэрэгжүүлэх үйлчилгээнд ахмад настан 19, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой 17, өрх толгойлсон 24, хөгжлийн бэрхшээлтэй 13, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 1 иргэнийг хамруулж нийт 15.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. ОНОТХУ явуулах эрх авах байгууллагыг ХХҮЕГ дээр сонгон шалгаруулж, өдрийн үйлчилгээ, гэрийн асаргаа үзүүлэх эрхийг ХБИ-ийн Оргил мээж холбоо ТББ авсан. Тус төрийн бус байгууллага нь ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй 43 иргэнийг төрийн үйлчилгээнд 10 хоног хамруулан эмчилгээ сувилгаа, сургалт, зөвлөгөө мэдээлэл өгөх зэрэг үйлчилгээг үзүүлэн 3.8 сая төгрөг, гэрийн асаргаа сувилгаа шаардлагатай 10 иргэнд гэрээр очиж сувилгааны үйлчилгээг үзүүлэн 2.8 сая төгрөгийг тус тус олголоо. Ардын уламжлалт бариа засал орчин уеийн тоног төхөөрөмжөөр сэргээн засах үйлчилгээг үзүүлэх эрх авсан Акуа мед ХХК-тай хамтран ажиллаж ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй 32 иргэнийг сэргээн засах үйлчилгээнд хамруулан 8.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.
4.2.8	Нийгмийн халамжийн онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдах хүний тоо	38	38	45.6	44.4	Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийн үйлчилгээнд 38 иргэнийг хамруулан 45.6 сая төгрөг зарцуулах төсөвтэйгөөр нийт 37 иргэн хамрагдаж 44.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Үүнд гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон 30 иргэнд 36.0 сая төгрөг, бүтэн өнчин 3 иргэнд 3.6 сая төгрөг, хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, амьжиргааны түвшин доогуур 3 иргэнд 3.6 сая төгрөг, 4 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 1 иргэнд 1.2 сая төгрөгийн нэг удаагийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн байна.
4.2.9	Орон нутгийн Өмчийн газар			137.8	129.2	
4.2.9.1	Худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу хугацаанд нь зохион байгуулах	Тухай бүр хугацаанд нь	төлөвлөгөөнд хүрч ажилласан			2021 оны аймгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 31, улсын төсвөөс эрх шилжин ирсэн 11 төсөл арга хэмжээ нийт 42 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг tender.gov.mn цахим системээр дамжуулан зохион байгуулж, үр дүнг нийтлэн гэрээг бүртгэн ажилласан байна.
4.2.9.2	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтад хамрагдах хүний тоо	100	43			Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ гэрчилгээ олгох сургалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүсэлт хүргүүлсний дагуу цахимаар зохион байгуулж Бургэхангай, Булган, Төвшиг сумын 45 албан хаагчийг хамруулан 23 албан хаагч шалгалтад тэнцэж АЗ гэрчилгээ авсан байна.
4.2.9.3	Захиалагч байгууллагуудад цахим худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдах хүний тоо	50	17			Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn сайт хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 2021 оны 10 дугаар сард зохион байгуулж 17 албан хаагчийг хамруулсан байна.
4.2.9.4	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр хяналт тавьж өмч эзэмшлийн гэрээ дүгнэх/гэрээний дүгнэлтийн хувь/	100	80.6	137.8	129.2	Аймгийн ИТХ-ын 3,4,5 дугаар хуралдааны 20 удаагийн тогтоолоор орон нутгийн өмчит байгууллагын 18792.7 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэлээ. 6 байгууллагын 35 нэр төрлийн 339.3 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасах, 12 байгууллагын 25 нэр төрлийн 144.6 сая төгрөгийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах, 12 байгууллагын 49 нэр төрлийн 17325.6 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд авах, 14 байгууллагын 15 нэр төрлийн 983.2 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэх шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. 2021 оны өмч эзэмшлийн гэрээний дүнгээр 96-100 хувь буюу бүрэн "онц" дүгнүүлсэн 7 байгууллага, 86-95 хувь буюу "сайн" дүгнүүлсэн 64 байгууллага, 76-85 хувь буюу "дунд" дүгнүүлсэн 37 байгууллага, 75 түүнээс доош буюу "муу" дүгнүүлсэн 3 байгууллага, гэрээ дүгнүүлэггүй 26 байгууллага байна. Могод, Хишиг-Өндөр, Орхон сумын байгууллагууд гэрээний дүн ирүүлээгүй. Ахмадын хороо, Статистикийн хэлтэс гэрээний дүн ирүүлсэн боловч дутуу ирүүлсэн байна.
4.2.9.5	Орон нутгийн өмчит байгууллагын менежментийг сайжруулж, алдагдлыг бууруулж ашигт ажиллагааны түвшинийг нэмэгдүүлэх замаар орон нутагт орох орлогыг төвлөрүүлсэн байх	Орлого бүрэн төвлөрсөн байх	төлөвлөгөөнд хүрч ажилласан			Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 46 дугаар захирамжаар байгуулагдсан төрийн болон орон нутгийн компани, үйлдвэрийн газруудыг хэмнэлтийн горимд шилжүүлэн, шат дамжлага, чиг үүргийн давхардлыг арилгах замаар үйл ажиллагааны удирдлага, чиглэл, бүтэц орон тоог оновчтой болгох, зардлыг бууруулах асуудлыг судалж, санал дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулагдан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал гарсан бөгөөд тус саналыг газрын 2021 оны 04 сарын 05-ны өдрийн 147 тоот албан бичгээр холбогдох сумдын Засаг дарга, орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн удирдлагуудад хүргүүлэн ажилласан. "Булган Мээж" ОНӨХХК, "Хөдөө аж ахуй -Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК, "Төвшиг-Ус" ОНӨААТҮГ, "Илчиг Хутаг" ОНӨААТҮГ, "Аймгийн нөөцийн газар" ОНӨААТҮГ-ууд 2021 оны аж ахуйн нэгжийн албан татвараа бүрэн төвлөрүүлсэн байна.
4.2.9.6	Орон нутгийн өмчийг худалдах үйл ажиллагааг цаг тухайд нь зохион байгуулж орлогыг төвлөрүүлэх	Тухай бүр хугацаанд нь	төлөвлөгөөнд хүрч ажилласан			2021 оны жилийн эцсийн байдлаар 7 удаагийн нээлттэй, 10 удаагийн хязгаартай дуудлага худалдаа зохион байгуулж, 15 тээврийн хэрэгсэл, 2 барилгыг 67.8 сая төгрөгөөр худалдан борлуулж, үүнээс 45.5 сая төгрөгийг 2 байгууллагын дансанд, хөрөнгө хөрдоч түүхийг эд болгон худалдсаны үнэ 3.0 сая төгрөг, дуудлага худалдааны 22.3 сая төгрөг нийт 25.3 сая төгрөгийг хөрөнгө борлуулсны орлогын дансанд тус тус төвлөрүүлсэн байна.
4.2.10	Соёл, урлагийн үйлчилгээ			2,988.5	2,871.3	
4.2.10.1	Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн тоо /хүн амд эзлэх хувиар/	74	төлөвлөгөөнд хүрч ажилласан	1,788.4	1,737.4	ХЖТ нь өөрийн байранд концерт 2 удаа, дуурь 3 удаа, урлагийн наадам 1, хурал цуглаан 4, сургалт 4, лекц 7, цэнгүүн 2 удаа нийт 3319 хүнд үйлчилж, техник хэрэгсэл, уран бүтээлч нар 16 удаагийн явуулын үйлчилгээнд явж, Улаанбаатар хотын кино театрууд болон продакшнтай хамтран 10 удаагийн уран сайхны киног өөрийн байранд гаргаж, 678 хүүхэд багачууд, иргэдийн хүртээл болгосон байна. Шилдэг уран бүтээлийн цахим тоглолтыг зохион байгуулж нийт 56000 хүнд

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
4.2.10.2	Нийтийн номын сангийн байнгын уншигч /хүн амд эзлэх хувиар/	8.5	төлөвлөгөөнд хүрч ажилласан	161.9	161.0	Нийтийн номын сангийн байнгын уншигч хүн амд эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилт тавьж уншигчдын хүсэлтээр номын санчдын ажил үүргийн хувиарлалтад өөрчлөлт оруулж, нийтийн уншлагын танхимыг байнгын ажиллагаатай болгож өдөр бүр иргэдэд үйлчилж, номын сангийн үйлчилгээнд ашиглаж байгаа Lip4U программыг онлайн хувилбараар ашиглаж каталогоо интернэтэд байршуулснаар уншигчид цаг хугацаа орон зайнаас үл хамааран байнга ашиглах боломжтой болсон. Ном ариутгах төхөөрөмжийг худалдан авч гэрээр болон танхимаар ном олгох боломжийг нээн халдаар хамгааллын дэглэмийг баримтлан үйлчилж, номын үзэсгэлэн 47 удаа зохион байгуулж 1685 номоор үзэсгэлэн гаргаж 1303 хүн хамруулсан. Орхон сумын бүх багт явуулын номын үйлчилгээг зохион байгуулсан. Төр нийгмийн зүтгэлтэн Сономын Удалын нэрэмжит номын сан болсон. Төсвөөр болон хандив тусламжаар 147 нэр төрлийн 270 ширхэг 4945.2 мянган төгрөг, үүнээс худалдаагаар 90 нэр төрлийн 173 ширхэг 3656.0 мянган төгрөг, бэлгээр 57 нэр төрлийн 97 ширхэг 1289.2 мянган төг, 8 нэр төрлийн 29 ширхэг 546.0 мянган төгрөгийн тогтмол хэвлэл үүнээс сонин 21 ширхэг сэтгүүл 8 ширхэгээр сан хөмрөгөө баяжуулснаар 9.3 хувьд хүргэн 0.6 хуваарь биелүүлж 109 хувьд хүргэн ажиллалаа. Мэдээлэл арга зүйн танхимыг засварлан шинэчлэн томжуулж орон нутгийн номын санчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах боломжийг нэмэгдүүлсэн байна. Ковид цар тахлын хорио цээрийн дэглэмийн үеийн холбогдох заавар журмын дагуу "тусгаарлах өргөө" гаргаж нөөцөд байх хэрэгсэл материалыг бэлтгэн байгууллагын тасралтгүй ажиллагааг хангаж мэргэжлийн байгууллагаар 2 удаа ариутгал хийсэн байна.
4.2.10.3	Жилийн эцэст хүрсэн байх музейн үзэгчийн тоо	4500	4600	211.6	206.7	2021 онд музейн үзэгчдийн тоо 4600-д хүрсэн байна.
4.2.10.4	Соёлын байгууллагуудын суудлын тоо	3650	2910	826.6	766.2	Булган аймгийн хэмжээнд мэргэжлийн урлагийн байгууллага 1, Номын сан 1, Музей 1, Соёлын ордон 1, Соёлын төв 16, нийт 20 байгууллага урлагийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2910 хүний суудал бүхий заал талбайгаар үйлчилж байна. 2008 оноос хойш соёлын салбарын тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдээгүйн улмаас суудлын хүрэлцээ багасаад байна.
4.2.11	Хүүхдийн сувилал	Зорилтот бүлгийн асаргаанд хамрагдах хүүхдийн тоо -40	40	172.4	155.8	Зорилтот өрхийн 40 хүүхдийг хүлээн авч сувилгаа чийрэгжилт хийсэн байна.
		Сэргээн засах, чийрэгжүүлэлтэд хамрагдах хүүхдийн тоо -20	22			
		Хүнс, тэжээлийн дутагдал жингийн алдагдлаас гарах хүүхдийн тоо -15	15			
4.2.12	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	Санхүүгийн хяналт шалгалт хийх байгууллагын тоо -56	60	146.5	146.3	Төсвийн тухай хуулийн 69.3. "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна." заалт, Засгийн газрын 2016 оны 483 дүгээр тогтоол, Аудитын хорооны даргын баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн 9 төсвийн байгууллага, суманд 51 төсвийн байгууллага нийт 60 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийсэн байна. Тайлант хугацаанд 64 актаар 211834.2 мянган төгрөгийн төлбөр тогтоож, 396279.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 21 албан шаардлага хүргүүлсэн байна.
	Дотоод аудит хийх байгууллагын тоо -3	6			Аймгийн төвийн 6 цэцэрлэгийн хоолны зардалд дотоод аудит хийж, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гарган эрсдэлийн удирдлагаар хангаж ажилласан.	
4.2.14	Бэлгээ хамгаалах, нөхөн сэргээх арга			4,280.4	4,137.4	
4.2.14.1	Ойжуулах, ойг нөхөн сэргээх /га/	200	306			Аймгийн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Орхон, Хишиг-Өндөр, Сэлэнгэ, Хангал сумдад 130 га, аж ахуй нэгжийн хөрөнгөөр 176 га нийт 306 га талбайд ойжуулалт хийгдэж ой сангийн ойгоор бүрхэгдээгүй талбайн 3 хувийг ойжуулсан байна.
4.2.14.2	Ойн хортон шавжтай тэмцэх ажил хийх талбай /мянган га/	30.8	31.9			Ойн хортны тэмцлийн ажлын 1, 2 дахь багцын ажлыг гүйцэтгэхээр "Гранд форест" ХХК шалгарч 1-р багцад 206900.0 мянган төгрөгөөр 14 тоот гэрээ, 2-р багцад 180490.0 мянган төгрөгөөр 13 тоот гэрээг тус тус байгуулан Хангал, Сэлэнгэ, Бугат, Орхон, Хутаг-Өндөр, Сайхан, Баян-Агт, Бүрэгхангай сумдад 31950 га талбайд тэмцлийн ажлыг хийсэн. Ойн сангийн 20 хувь нь хамгаалагдсан байна.
4.2.14.3	Ой бүхий сумдад ойн хортны судалгааны ажил /мянган га/	300	300			Байгаль орчин, тогтвортой хөгжлийг санаачилга ТББ тендэрт шалгарч 19995.5 мянган төгрөгөөр 18 тоот гэрээ байгуулан ой бүхий сумдын 300000 га талбайд судалгааны ажлыг хийсэн байна.
4.2.14.4	Үлийн цагаан оготнын устгал хийх талбай /мянган га/	40	40	4,280.4	4,137.4	Дашинчилэн, Гурванбулаг, Рашаант, Баяннуур сумдад 40 мянган га бэлчээрийн талбайд энгийн механик, биологийн аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулсан. Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан бэлчээрийн хөнөөлт мэргэчдийн хаврын тодотгох судалгааны ажлын дүгнэлтийн дагуу Гурванбулаг суманд 10 мянган га, Рашаант суманд 10 мянган га, Дашинчилэн суманд 10 мянган га, Баяннуур суманд 10 мянган га талбайд энгийн механик, биологийн аргаар тэмцэх ажлыг зохион байгуулж, тухайн сумдын ЗДТГ орон нутгаа хэрэгжүүлэх үүрэгтэй ажилласан байна.
4.2.14.5	Хүн ам, бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар шинээр гаргах хөдлийн тоо	10	10			Аймгийн Засаг даргын 2021 оны А/330 дугаар захирамжийн дагуу хүн амын болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор Бугат сумын Нарангийн хавтгай, Баяннуур сумын Молцог элсний өвөр, Гурванбулаг сумын Гурван толгой, Могод сумын Бага хужирт, Дашинчилэн сумын Бор толгой, Сайхан сумын Хөх цооногт, Рашаант сумын Шивээт уулын өвөр, Хангал сумын Улаан бургас, Хутаг-Өндөр сумын Зүүн тэрэм, Булган сумын Буриадын хороонд инженерийн хийцтэй 10 ширхэг худаг гаргасан байна.
4.2.14.6	Шинээр хаших, хамгаалах бүлгийн эх /тоо/	10	10			Чандмань суурь комплекс ХХК Баян-Агт сумын Ихтийн булаг, Баяннуур сумын Баяннуурын эх, Бугат сумын Улаан хошууны булаг, Гурванбулаг сумын Хөл цагаан хошууны булаг, Могод сумын Усны эхийн булаг, Орхон сумын Тооройт булаг, Сайхан сумын Өвөр булаг, Сэлэнгэ сумын Тариахтайн рашаан, Тэшиг сумын Харлангийн булаг, Хутаг-Өндөр сумын Хавиргын булаг зэрэг 10 булаг шандын эхийг хашиж хамгаалсан байна.
4.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			41,347.6	39,604.6	
4.3.1	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ			8,745.1	8,065.2	
4.3.1.1	Суралцах хүүхдийн тоо	4598	2804			Ковид цар тахлын улмаас БШУ-ны сайдын тушаалын дагуу СӨБ-д 2, 3 настай хүүхдийг хамруулаагүй мөн хувилбарт сургалтаар хүүхэд хичээллээгүйгээс 2804 хүүхэд хамрагдаж 1794 хүүхдээр буурсан байна.
4.3.1.2	Хүүхдийн цэцэрлэгийн тоо	23	22	8,745.1	8,065.2	Цар тахалтай холбоотойгоор Жаргалтай үрс хувийн цэцэрлэг ажиллаагүй байна.
4.3.1.3	Хамран сургалтын хувь	77.7	72.8			Ковид цар тахлын улмаас БШУ-ны сайдын тушаалын дагуу СӨБ-д 2, 3 настай хүүхдийг хамруулаагүй мөн хувилбарт сургалтаар хүүхэд хичээллээгүйгээс хүүхдийн тоо буурснаар хамран сургалтын хувь 72.8 болж 4.9 хувиар буурсан байна.
4.3.2	Ерөнхий боловсролын үйлчилгээ			23,259.3	22,631.1	
4.3.2.1	Суралцах хүүхдийн тоо	11393	11282			Хүн амын статистик тоо мэдээнээс хичээлийн жилийн тооны прогнозыг тооцож гаргахад манай аймагт бүртгэлтэй зарим хүүхдүүд өөр аймаг суманд суралцаж байгаатай холбоотой 11282 хүүхэд суралцаж байна.
4.3.2.2	Ерөнхий боловсролын сургуулийн тоо	22	22	20,201.1	19,850.5	Бага боловсролын 2 сургууль, суурь боловсролын 5 сургууль, бүрэн дунд боловсролын 15 сургууль нийт 22 сургууль хичээллэж байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
4.3.2.3	Хамран сургалтын хувь	87.7	85.1			Ковид цар тахлын улмаас танхимын болон танхимын бус сургалт хичээллэж байсан мөн харьяалалтай хүүхдүүд өөр хот, аймаг, суманд сууж байгаатай холбоотойгоор хамран сургалт 85.1 хувь болж 2.6 хувиар буурсан байна.
4.3.2.4	Дотуур байранд хамрагдах хүүхдийн тоо	1895	1626	2,535.9	2,310.8	Ковид цар тахлын улмаас танхимын болон танхимын бус сургалт хичээллэж байснаас хүүхдүүд гэрээс хичээлдээ явах, цахимаар хичээллэж байгаагаас дотуур байрны хүүхдийн тоо 1626 болж 269 хүүхдээр багассан байна.
4.3.2.5	Үдийн цай хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо	5763	5757	522.2	469.8	Бага ангид суралцах хүүхдийн тоо 5757 хамрагдаж 99.9 хувь хамрагдаж байна.
4.3.3	Насан туршийн болон албан бус боловсролын үйлчилгээ			88.3	88.0	
4.3.3.1	Албан бус боловсролд хамрагдах хүүхдийн тоо	209	128	88.3	88.0	Ковидын нөхцөл байдалтай холбоотой бүрэн дунд боловсрол нөхөн эзэмшихээр бүртгүүлсэн насанд хүрэгчид суралцах хугацаагаар хойшлуулсан байна. ЕБС-ийн насны дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж байсан суралцагчдыг ЕБС-ийн ердийн ангид шилжүүлж суралцуулсан. Үүнд бага суурь боловсролд сурлагын хоцрогдолтой, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг дүйцсэн хөтөлбөрөөр сургадаг байсныг "Дүйцсэн хөтөлбөрийн сургалт явуулах журам"-ын дагуу ЕБС-ийн ердийн ангид шилжин суралцуулах ажлыг зохион байгуулж 128 хүүхэд хамруулсан байна.
4.3.3.2	Тасралтгүй боловсролын сургалтад хамрагдах хүний тоо	12000	15259			Насан туршийн боловсролын төвөөс Иргэдийн дунд 9 төрлийн 1233 удаагийн сургалт үйл ажиллагаагаар 15259 иргэн хамрагдаж, Даваардсан тоогоор нийт хүн амын 24.6 хувийг хамруулсан байна. Мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр ЕБС-ийн 8-12-р ангийн 560 сурагч, 50 багш, удирдах ажилтан 12, 90 эцэг эхэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.
4.3.4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ			8,559.6	8,141.9	
4.3.4.1	Эхийн эндэгдлийн түвшин /10000 амьд	0	0			2021 онд эхийн эндэгдэл гаргалгүй ажилласан байна.
4.3.4.2	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	16.2	14.3			Нийт 12 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 14.3 ногдож, зорилтод түвшнээс 1.9 промилээр буурсан эерэг үзүүлэлт байна.
4.3.4.3	Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд /	14.2	14.3			5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл зорилтод түвшингээс 0.1 промилээр нэмэгдсэн байна.
4.3.4.4	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт /10000 хүн амд/	22	21.1			Зүрх судасны өвчний шалтгаант 10000 хүн амд ногдох нас баралтын түвшин 0.9 промилаар буурсан эерэг үзүүлэлттэй байна.
4.3.4.5	Хорт хавдраас шалтгаалсан нас баралт /10000 хүн амд/	6.2	14.1			Аймгийн хэмжээнд хорт хавдрын шалтгаант нас баралтын 87 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 14.1 промил ногдож, 7.9-өөр нэмэгдсэн нь Ковид 19 өвчний тархалтын улмаас эмнэлгээр үйлчлүүлэгсдийн тоо эрс буурсан, иргэдийн дунд хавдрын эрсдэлт хүчин зүйл их, Эрүүл мэндийн боловсрол хангалтгүй, мэдлэгтэй хэдий ч тоомжиргүй ханддаг, хожуу үедээ оношлогдож байгаагаас шалтгаалсан байна.
4.3.4.6	Товполт дархлаажуулалтын хамрагдалтын хувь	99	96.1			Аймгийн хэмжээнд 2021 оны 3 сараас 11 сар хүртэлх хугацаанд Ковид-19 өвчнөөр 10874 хүн өвчилж, ЭМБ-ууд халдварын өндөр эрсдэлтэй улаан бүсад үйл ажиллагаагаа явуулж байсан тул заавал хийх дархлаажуулалтын хамралт зорилтод түвшингээс 2.8 хувиар буурсан байна.
4.3.4.7	Вируст гепатитын өвчлөл /10000 хүн амд/	1.3	2	8,559.6	8,141.9	Вируст гепатитын өвчний гаралт 10000 хүн амд 2 тохиолдол бүртгэгдэж өмнөх суурь үзүүлэлтээс буурсан эерэг үзүүлэлттэй байна.
4.3.4.8	Сүрьеэгийн тохиолдлын түвшин /10000 хүн амд/	9.7	буурсан			Ковид 19 цар тахлын өвчлөл нэмэгдэж, аймгийн хэмжээнд 664 ор дэлгэж, эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн. Энэ үед сүрьеэгийн тасаг, тасгийн эмч, сувилагч эмнэлгийн мэргэжилтнүүдийг дайчлан ажиллуулсантай холбоотойгоор сүрьеэ өвчний илрүүлэлт, эмчилгээний чанар буурсан байна.
4.3.4.9	Артерийн даралт ихсэх өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт	80	төлөвлөгөөнд хүрч ажилласан			Урьдчилан сэргийлэх үзлэгийг Эрүүл мэндийн даатгалаас нэмэлтээр санхүүжүүлдэг болсноор зорилтод насны иргэдийн үзлэгт хамрагдалт нэмэгдсэн байна.
4.3.4.10	Чихрийн шижин өвчний эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт	80	төлөвлөгөөнд хүрч ажилласан			Урьдчилан сэргийлэх үзлэгийг Эрүүл мэндийн даатгалаас нэмэлтээр санхүүжүүлдэг болсноор зорилтод насны иргэдийн үзлэгт хамрагдалт нэмэгджээ.
4.3.4.11	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт	80	72.8			Ковид 19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор зорилтод насны эмэгтэйчүүдийн үзлэгт хамрагдалт буурсан. Умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийг зөвхөн эмнэлгийн орчинд хийдэгтэй холбоотойгоор хамрагдалт зорилтод түвшингээс 7.2 хувиар буурсан байна.
4.3.4.12	Хөжний өмөнгийн хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт	50	60.3			Урьдчилан сэргийлэх үзлэгийг Эрүүл мэндийн даатгалаас нэмэлтээр санхүүжүүлдэг болсноор зорилтод насны иргэдийн үзлэгт хамрагдалт 10.3 хувиар өссөн байна.
4.3.4.13	Хачигт инцефлитын дархлаажуулалтын хамрагдалтын хувь /Голомтой бус I нутаг/	4	дархлаажуулалт хийгдээгүй			Хачигт халдвараас сэргийлэх дархлаажуулалтыг улирал утгуулан 4-5 сард зохион байгуулдаг. Тухайн үед орон нутаг "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн" байсан учир сайн дурын дархлаажуулалтын үйл ажиллагаа зохион байгуулагдаагүй.
4.3.4.14	Жирэмсний эхний 3 гурван сартайд хяналтад орсон эхийн эзлэх хувь	88	92.5			Нийт жирэмсний хяналтад шинээр 909 эмэгтэй орсноос 841 буюу 92.5 хувь нь эрт үедээ хяналтад хамрагдаж, нэмэгдсэн сайн үзүүлэлттэй байна.
4.3.4.15	Зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварын түвшин /10000 хүн амд/	35.8	буурсан			Зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварыг эмнэлгийн орчинд шинжилдэг. Ковид 19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор илрүүлэх үзлэг зорилтод түвшингээс 13.5 промилээр буурсан байна.
4.3.4.16	Амьгүй төрөлтийн түвшин /1000 төрөлтөд/	2	2			Нийт 2 тохиолдол бүртгэгдэж амьгүй төрөлтийн түвшин зорилтод түвшингээс 0.4 промилээр өссөн байна.
4.3.5	Газрын харилцаа, кадастрын үйлчилгээ			522.9	506.0	
4.3.5.1	Иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэхэд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах цахим хэлбэрээр олгох /тоо/	иргэн-350 өмчлөх, хуулийн этгээд-1210 эзэмших	төлөвлөгөөнд хүрч ажилласан			2021 онд газрын харилцаатай холбоотой 2708 өргөдөл, хүсэлтийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн 2299 өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэж газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн баталгаажуулсан. Үүнээс газар эзэмших эрх шилжүүлэх, хугацаа сунгах, ᠑ дугаартай гэрчилгээг гаргуулан авах, газар эзэмших эрхээ барьцаалахтай холбоотой 941 өргөдлийг шийдвэрлэсэн болж шинээр 586 иргэнд 75.15 га газрыг өмчлүүлж, 772 иргэн хуулийн этгээдэд 529 га газрыг шинээр эзэмшүүлсэн байна.
4.3.5.2	Инженерийн хийцтэй барилгуудад унэлгээ хийж, паспортжуулах ажлын бэлтгэл хангах, эхлүүлэх /тоо/	10	төлөвлөгөөнд хүрч ажилласан	522.9	506.0	"Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам"-ын дагуу Булган аймгийн Засаг даргын 2018 оны 05-р сарын 14-ний өдрийн А/290 дүгээр захирамжаар "Зөвлөл"-ийг байгуулсан ба 2020 оны 05-р сарын 19-ний өдрийн А/232 дугаар захирамжаар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Уг зөвлөл нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2019 оноос боловсруулан гаргаж, хэрэгжилтийг хангуулж байна. Мөн үнирч болзошгүй газар хөдөлгөөнтэй үед өндөр эрсдэл бүхий сургууль, цэцэрлэг, олон нийтийн барилгуудыг шинэчлэх ажлын хүрээнд зураг төсөл боловсруулах даалгавар гаргаж аймгийн нийгмийн бодлогын хэлтэс, хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлээд байна. Үүнд Бугат сумын Соёлын төвийн барилга, Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн барилга, Баян-Арт сумын 320 хүүхдийн сургуулийн барилга, Хишиг-Өндөр сумын 320 хүүхдийн сургуулийн барилга, Булган сумын 4-р цэцэрлэгийн барилга /280 хүүхэд/ болно. Эдгээр барилгууд нь газар хөдөлгөөний эрсдэл өндөртэй тул дээрх арга хэмжээг авч ажилласан. Дээрх арга хэмжээг авч ажилласны үр дүнд Бугат сумын Соёлын төвийн барилга, Булган сумын 4-р цэцэрлэгийн барилга, Хутаг-Өндөр сумын цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалтыг улсын төсөвт тусгуулан гүйцэтгүүлж байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсөвт 50.0 сая төгрөг тусгуулан аймгийн төвийн ЭӨЦ сургуулийн А блок, Сайхан сумын сургууль, Баян-Арт сумын 320 хүүхдийн сургууль, Хялганат тосгоны эрүүл мэндийн төвийн паспортжуулахаар төлөвлөөд байна.

13.2.12	Мэдээлэл шуурхай удирдлагын төв	өргөдөл гомдлын шийдвэрлэлт хугацаандаа шуурхай шийдвэрлэгдсэн байна. Иргэдэд мэдээлэл, лавлагааг үнэн зөв, шуурхай хүргэсэн байна.	өргөдөл гомдлын шийдвэрлэлт хугацаандаа шуурхай шийдвэрлэгдэж ажилласан. Иргэдэд мэдээлэл, лавлагааг үнэн зөв, шуурхай хүрсэн.	92.2	92.2	Үйлчилгээний нэгдсэн төвийн иргэдийн гомдол, мэдээлэл хүлээн авах 7032-1111 утсанд 2021 онд нийт 1249 өргөдөл гомдол ирснээс гомдол 494 буюу 40%, мэдээлэл, тодруулга авсан 682 буюу 54%, санал хүсэлт 73 буюу 6%-ийг эзэлж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувьд хангалттай шийдвэрлэсэн 981 буюу 80%, холбогдох тайлбар ирүүлсэн 200 буюу 14%, огт хариу ирүүлээгүй 68 буюу 6% байна. Арвайхээр сумын хэмжээнд нийт 64 цагт 140 камер ажиллаж байна. 2021 оны байдлаар хяналтын камерын системээс нийт 206 удаагийн бичлэг нөхөн үзсэн байна. хууль ёсны халтгаан гэмт хэрэг болон эз үйлээ хаясан гэсэн 48, замын хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн осолтой 147, нийтийн эзэмшлийн зам талбай, хайс хашлага дайрсан, мод хугалсан зэргээр 11 удаагийн камерын бичлэг нөхөн шүүсэн байна. Аймгийн Иргэний танхимд 2021 онд зохиогдох хэлэлцүүлгийн саналыг төрийн байгууллагуудаас авч нэгтгэн төлөвлөгөөг боловсруулсан ажилласан ч цар тахалтай холбоотойгоор зохион байгууллагдаагүй байна. 2021 оны байдлаар нийт 23 удаагийн хурал, уулзалт, семинар зохион байгуулагдсан байна. Үүнд нийгмийн даатгалын хэлтэс зэрэг сургалт, уулзалт зохион мэрэгжлээс шалтгаалах өвчлөл, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй” сургалт, Аймгийн хуульчдын зөвлөгөөн, Хэлтэс албадын дарга нарын Шуурхай хуралдаан, Хараагүйчүүдийн холбооны уулзалт зэрэг сургалт, уулзалт зохион байгуулагдсан. Иргэдэд зориулсан “Танд туслах цахим хөтөч” болох e-hutuch.mn, egazar.gov.mn, e-mongolia.mn сайтуудаас мэдээлэл авч хэвлэн авах боломжтой булан, номын булан /9 салбар чиглэлийн 100 гаруй номын фондоой/, гар утас цэнэглэгч шүүгээ, ойрын харааны нүдний шил, хэрэглэгчийн дэлгэц, автомат халуун хэмжигч, гар ариутгагч зэргийг суурилуулсан. Киоск машин: Иргэн иргэний үнэмлэх, банкны картаа ашиглан тус төхөөрөмжөөс 58 төрлийн лавлагаа мэдээллийг авч, 108 төрлийн үйлчилгээний төлбөр тооцоог хийх боломжтой. Тухайлбал, харилцаа холбоо, татвар, даатгал, торгуулийн төлбөр тооцоог хийх, хот хоороны автобусны билет захиалах гээд бүх төрлийн үйлчилгээг нэг цэгээс авах боломж бүрдлээ.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	13.2.13	Үндсэн тэнцлийн ашгаас Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	Байхгүй	байхгүй			байхгүй
	13.2.14	Соёлын үйлчилгээ	Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид нийцсэн байх, Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааг дэмжин, гадаад харилцааг хөгжүүлж, соёл, урлагийн үйлчилгээг аялал жуулчлалтай холбон сурталчлах, хөгжүүлэх бодлого барин ажиллана.	100%	1,350.9	1,350.9	Соёл, урлагийн байгууллагуудын үйлчилгээний орчин нөхцөл, материаллаг баазыг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвөөс 115 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна. 2020 онд соёлын дархлааг дэмжих зорилготой жилийн салбартаа зарлаж цахим болон үйл ажиллагааны томоохон ажлуудыг зохион байгуулсан. Эвент болон нэгдсэн арга хэмжээг 8-ийг зохион байгуулсан. Зохиогч багш уралдаан, соёлын өв, хөгжлийн дархлаа арга хэмжээ, Өндөр гэгээний соёлын өв уламжлагч шилдэг бүтээл шалгаруулах уралдаан, аман өвийг уламжлуулах ОУ-ын эрдэм шинжилгээний хурал болон үүнтэй холбоотой сарын аян, соёлын контентьг төрөл бүрээр хөгжүүлсэн. 20 гаруй мянган дагагч бүхий соёлын цахим орон зайтай болсон.
	13.2.15	Нийтийн биеийн тамир	Биеийн тамираар хичээллэгсдийн оролцоо нэмэгдэж, хөдөлгөөний хомсдолоос сэргийлж идэвхтэй хөдөлгөөн хийх иргэдийн тоо өсөж, халдварын бус өвчний өвчлөл бууран хүн амын дундаж наслалт нэмэгдэнэ. Иргэдийн бие бялдрын түвшин тодорхойлогдсон байна.	төлөвлөгөө боловсруулан биелэлтийг тооцон ажилласан.			МУ-ын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн хүрээнд "Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилт"-ыг жил бүрийн хавар, намрын улиралд зохион байгуулж үнэлэлт дүгнэлт гаргадаг. Энэ онд Ковид-19 халдварт өвчний улмаас БХЧТТС-ыг 1211 хүнээс авсан. Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 1211 хүн хамрагдсанаас 649 буюу 47% нь А, В үнэлгээтэй байна. Аймгийн хэмжээнд биеийн тамир, спортын нийт 94 удаагийн арга хэмжээнд /үүнээс 5307 эрэгтэй, 4230 эмэгтэй/ 9537 хүн оролцлоо. Спортын уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах 35 ажлыг 2020 оны календарчилсан төлөвлөгөөнд тусган батлуулж ажилласан. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган спортын 14 төрлөөр өсвөрийн багийг Арвайхээр, Бат-Өлзий суманд хичээллүүлж байна. Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын 7 төрлөөр 7 удаа оролцож алтан медаль 6, мөнгөн медаль 7, хүрэл медаль 6-г хүртсэн бол багийн дүнгээр алтан медаль 1, хүрэл медаль 1 нийт 21 медаль хүртсэн. Энэ онд "Ковид-19" цар тахал гарч, хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотойгоор спортын 20 удаа уралдаан тэмцээнд оролцож, орон нутагтаа 17 удаагийн уралдаан тэмцээн зохион байгуулсан.
	13.2.16	Орон нутагт аймгаас олгох санхүүгийн дэмжлэг	Батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгосон байх	100%	16,216.4	16,216.4	Аймгийн ЗД-ын 2021 оны А/14 дүгээр захирамжаар баталсан хуваарийн дагуу сумдад санхүүгийн дэмжлэг бүрэн олгосон байна
	13.2.17	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	ТЗШ-ийн байгууллагуудын байр ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангах	Хэвийн үйл ажиллагааг хангана	556.4	556.4	Төлөвлөгөөний дагуу бүрэн хэрэгжүүлсэн.
	13.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			54,629.8	53,212.0	
	13.3.1	Сургуулийн өмнөх боловсрол	Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, 3Г-ын 2012 оны 94 дүгээр тогтоол, 2020 онд БСШУСайд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу үйл ажиллагаа явуулсан байх.	бүрэн хэрэгжсэн	13,835.3	13,835.3	Сургууль, цэцэрлэгийн барилгуудын засвар бүрэн хийгдэж, үйлчилгээний орчин нөхцөл сайжирч, шаардлага хангасан сургалтын кабинетын тоо нийт анги танхимын 78.0 хувьд хүрсэн байна. сургуулийн өмнөх боловсролын 48 цэцэрлэгт 2-насны 259 бүлэгт 8116 хүүхдийг хамруулж хамран сургалт 88 хувьд хүрсэн байна. СӨБ-д нийт 961 багш сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна.
	13.3.2	Ерөнхий боловсрол	Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2, 3Г-ын 2012 оны 94, 106 дугаар тогтоол, 2020 онд БСШУСайд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу үйл ажиллагаа явуулсан байх.	СӨБ хамран сургалт 90.0, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалт 97.0 хувьд хүрсэн байна.	30,855.1	29,437.3	Ерөнхий боловсролын төрийн өмчийн 31 сургуульд 908 бүлэгт 23872 сурагчдад хичээлийн болон дотуур байрны 33 байранд хичээллэж сурах таатай орчин бүрдүүлэн ЕБС-д нийт 1431 багш ажиллаж, сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байна.
	13.3.3	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.4, 2019 онд ЭМСайд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу үйл ажиллагаагаа явуулсан байх.	бүрэн хэрэгжсэн, үйл ажиллагаа хэвийн явагдсан болно.	8,975.3	8,975.3	Урсгал санхүүжилтийг бүрэн санхүүжүүлж үйл ажиллагаа хэвийн явагдсан болно. Тус аймгийн 130 гаруй мянган иргэдэд 4 өрхийн эмнэлэг, 1 сум дундын эмнэлэг, 18 эрүүл мэндийн төвийн 408 эрүүл мэндийн ажилтан эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	13.3.4	Газрын харилцаа, кадастр	Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 2017 онд БХБСайд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу ажиллах, Газар олголтгыг иргэдэд ойлгомжтой, ил тод болгож, газар олгох үйл явцыг хялбаршуулах.	бүрэн хэрэгжсэн	568.3	568.3	Монгол улсын Засгийн газрын 2018 оны "Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бус), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай" 182 дугаар тогтоолын дагуу аймгийн хэмжээнд сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал "Газрын үнэлгээний бүслэлт, газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох" тухай тогтоол гаргаж Хууль зүй дотоод хэргийн яаманд хянуулан "Захираганы хэм хэмжээний акт"-ын улсын нэгдсэн бүртгэлд https://www.legalinfo.mn/ бүртгэгдэн хүчин төгөлдөр хэрэгжих байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр газар эзэмших эрхийн гэрчилгээ бүсэд шилжүүлэхийг хүүссэн 273, худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчлж авахыг хүүссэн 890 өргөдөл хүлээн авсан байна. Дээрх эрхийн харилцаанд орсон 799 нэгж талбарын үнийн мэдээ газрын цахим биржд бүртгэсэн байна. Аймгийн хэмжээнд 103-н байршилд 705,415 га газрыг барилга байгууламж, үйлдвэр, худалдаа үйлчилгээ, орон сууц, аялал жуулчлал, цэцэрлэгт хүрээлэн, тариалангийн зориулалтаар дуудлага худалдааны зарчмаар эзэмшүүлэхээр тусгагдсан. Дээрх 103 нэгж талбараас газрын цахим биржээр дамжуулан дэвхардсан тоогоор 53 нэгж талбарын газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулж 23 газрыг худалдан 185.8 сая төгрөг төвлөрүүлээд байна. 2021 онд орон нутгийн сонгууль, ковид-19 цар тахалтай холбогдуулан 52 нэгж талбарын дуудлага худалдааг зохион байгуулаагүй байна. Батөлзий, Бүрд, Баруунбаян-Улаан сумдад аялал жуулчлалын зориулалтаар дуудлага худалдаагаар эзэмшүүлэх 51 нэгж талбарыг ковид-19 цар тахалтай холбогдуулан зарлаагүй байна.
	13.3.5	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.15, 2020 онд ХНХСайд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу үйл ажиллагаа явуулсан байх. Хүүхэд, залуучуудын хөгжил, хамгаалал, хүмүүжил төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаанд хамрагдсан хүүхдийн тоо суурь түвшнээс 2 дахин нэмэгдсэн байна.	бүрэн хэрэгжсэн	395.8	395.8	Гэр бүл, залуучуудын чиглэлээр холбогдох хууль тогтоомжтой уялдуулан нийт 12 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Цаг үеийн нөхцөл байдалд тулгуурлан олон нийтийн арга хэмжээг цахим хэлбэрээр нийт 32 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, 1276 насанд хүрэгч, 1323 хүүхэд хамрагдаж, постер хэлбэрээр 168 мэдээлэл байршуулж, 1008 хүн хандсан байна. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, хүүхдийн нас, хүйс, газар зүйн байршил, гэр бүлийн харилцаа, нийгэм эдийн засгийн байдал зэрэг үзүүлэлтээр эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийг багийн Засаг дарга болон нийгмийн ажилтнуудын үнэлсэн үндэслэл нийт 425 хүүхдийн мэдээлэл бүртгэгдэж, өндөр, дунд эрсдэлтэй хүүхэд сум багийн хамтарсан баг хяналт тавин ажиглаж байна. Хүүхэд хамгааллын анхан шатны шаардлагатай үйлчилгээг хамтарсан багаар, цаг алдалгүй үзүүлэн, нөхцөл байдлыг судлан ажилласны үр дүнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 19 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 10 хэргээр буюу 34.5 хувиар буурсан боловч, зөрчил 145 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 34 зөрчлөөр буюу 33.1 хувиар өссөн байна.
14	ӨМНӨГОВЬ				257,078.8	230,081.8	
14.1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа				1,291.1	1,203.3	
	14.1.1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдааныг хуралдуулж, орон нутгийн болон цаг үеийн тулгамдсан асуудал шийдвэрлэж тогтоол шийдвэр батална.	ИТХ-2 ИТХТХ-22	1,291.1	1,203.3	2021 онд аймгийн ИТХ-2, ИТХТХ-21 хуралдаан хуралдаж 56 заалт бүхий 16 тогтоол батлан хэрэгжүүлсэн. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны үйл ажиллагааны тайлан хангалттай хэрэгжсэн, Засаг даргын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2021 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 90.1%, 2021 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн орлогын хэмжээг 234105038.5 мянган төгрөгөөр, төсвийн гүйцэтгэлийн зарлагын хэмжээг 234105038.5 мянган төгрөгөөр тус тус баталлаа. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан гаргасан тогтоол шийдвэрийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах, Төлөөлөгчид, Тэргүүлэгчдэд гарын авлага, тогтоолын эмхэтгэл хургуулах, мэдээллээр хангах арга хэмжээг 2 удаа зохион байгууллаа. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хүрээнд 36 ажил төлөвлөн хэрэгжүүлж 86% биелэлттэй байсан. Хэрэгжилт 100 хувь.
14.2	Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ				202,422.5	176,641.9	
	14.2.1	Засаг даргын ажлын алба	Аймгийн эдийн засгийн чадавч сайжирч, төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.	Төсвийн орлогыг 100-аас доошгүй хувиар биелүүлнэ.	3,828.1	3,735.9	Аймгийн орон нутгийн төсвийн орлого 2021 онд 3,828.1 тэр бум төгрөгийн төлөвлөгөөтэй, жилийн эцэст 3,736.0 тэр бум төгрөг төвлөрүүлэн хэрэгжилт 97.6% биелэлттэй байна. Агентлагийн дарга нарын шуурхай журал танхимаар 3, цахимаар-5 удаа зохион байгуулагдсан. Мөн цахим сургалт-2 удаа "Цахим систем, Харилцаа хандлага" сэдвүүдээр зохион байгуулагдсан. АЗДТГ-ын аппаратын шуурхай цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор 3 удаа, Хэлтсийн дарга нарын шуурхай 25 удаа хийж цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээлэл солилцсон. Засаг даргын зөвлөлийн хурал 20, Сумдын Засаг дарга нартай орон нутгийн удирдлагын өргөтгөсөн хурал цахимаар 3 удаа, Сумын Засаг дарга нарын сургалт 2 удаа зохион байгуулж, сумдын Засаг дарга нартай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээг дүгнэн ажилласан. Аймгийн ЗДТГ-ын даргын үйл ажиллагааны төлөвлөгөө 95.6 хувьтай дүгнэгдсэн. Хэрэгжилт 95.6 хувь.
	14.2.2	Засаг даргын нөөц хөрөнгө	Сангийн сайдын тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн захиран зарцуулах журам хэрэгжсэн байна.	ИТХ-аас баталсан төлөвлөгөө хэтрээгүй байна.	12,699.9	10,524.2	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын дагуу зарцуулсан. Хөрөнгө зарцуулах шийдвэрийг Засаг даргын зөвлөлд танилцуулан батлуулдаг. 2021 онд нийт 12.7 тэр бум төгрөг төлөвлөгдөж, 10.5 тэр бум төгрөгийг зарцуулсан. Хэрэгжилт 82.7%.
	14.2.3	Авто замын сан	Орон нутгийн авто замын нөхцөл байдал сайжирна.	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг авто замын санд 100 хувь төвлөрүүлнэ.	6,011.3	5,957.1	2021 онд авто замын сангийн зардалд 6.0 тэр бум төгрөг төлөвлөгдөж, 5.9 тэр бум төгрөгийн гүйцэтгэлтэй. Өмнөговь аймгийн Баяндаалай-Гурвантас сумын чиглэлд шинээр 10км зам барих, Бороо усны аюулаас эвдрэл үүссэн 67 км замыг нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилт 99%.
	14.2.4	Ахмад настны хөгжлийг дэмжих	Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль хэрэгжсэн байна.	Аймгийн ахмадын холбоонд төсвийн дэмжлэг үзүүлсэн байна.	115.2	115.2	Аймгийн ахмадын холбоонд орон нутгийн 2021 оны төсөвт 115.2 зуун мянган төгрөгийг баталж, 100 хувь олгосон. Хэрэгжилт 100 хувь.
	14.2.5	Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хэрэгжсэн байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль хэрэгжсэн байна.	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг зохион байгуулах	263.3	233.7	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 88.8 хувийн гүйцэтгэлтэй байна. 2021 онд нийт 95,796,338.62 Лусын төсвийн 906,000,00, орон нутгийн төсвийн 75,281,605,146 орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 253,000,000, замын сангийн хөрөнгөөр, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр, төсөл хөтөлбөрөөр/тендерийг зохион байгуулж, төрийн албан хаагч, иргэдэд 3 удаа А3 сертификатын сургалтыг зохион байгуулж ажилласан. Хэрэгжилт 95 хувь.
	14.2.6	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Байгаль орчны чиглэлийн багц хууль, тогтоомж хэрэгжинэ.	Дэвшүүлж байгаа хөтөлбөр, төсөл бүрэн хэрэгжсэн байна.	496.0	486.2	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайлант хугацаанд 2021 оны 12 сарын 31-ны байдлаар улсын төсвийн санхүүжилтээр 495,982.8 мян/төг-н санхүүжилт авч төсвийн гүйцэтгэл 486,173.3 мян/төг-н гүйцэтгэлтэй, 9,809.4 мян/төг-н хэмнэлттэй ажилласан. 2021 онд Нэмэлт санхүүжилтийн дансанд 2021 оны 12 сарын 31-ны байдлаар "Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг"-ээс "Хууль бус ан агнууртай тэмцэх" төслийн хүрээнд 10,484.4 мян/төг, ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ажилдаагүй нөөц хөрөнгөөс зөмж байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 191,181.7 мян/төг-ийн санхүүжилт олгосон. БОАЖЯ-аас "Хотуй,цэвэрхэн Монгол" аяны хүрээнд зохион байгуулах ажлын 710.7 мян/төг-ийн санхүүжилт олгосон. Мөн байгууллагын үндсэн үйл ажилгааны хүрээнд бий болсон орлого 1500.0 мян/төг, нийт 203,879.9 мян/төгөөр орсон. Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэл 202,095.4 мян/төг-ийн гүйцэтгэлтэй, 1784.5 мян/төг-ий татан төвлөрүүлж ажилласан. Дээрх санхүүжилтэд зарцуулах эрх нээлэн зориулалтын дагуу зарцууллаа. /Елын ам, Баянзүгийн менежментийн төлөвлөгөө, хөгжлийн төслийг хэрэгжүүлж ажиллалаа. Хэрэгжилт 98 хувь.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	14.2.7	Байгаль орчныг хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээ	Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хууль	Төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	6,944.0	6,496.2	Орон нутгийн төсвөөс Байгаль хамгаалах чиглэлээр 6.5 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Үүнд: Аймгийн хэмжээнд зөвхөн орон нутгийн төсвөөр 40га газарт нөхөн сэргээлт хийгдсэн. Мөн 4 булаг шанд хашиж хамгаалсан, шинээр ойжуулалт 40га газарт хийж нийт 115810 ширхэг мод тарьсан. Ан амьтан хамгаалах чиглэлээр тусгай хамгаалалтын бүсэд 2 худга шинээр гаргасан. Нийт төлөвлөгдсөн 17 төсөл, арга хэмжээнээс задарсан байдлаар 57 ажил зохион байгуулан бүрэн хэрэгжүүлсэн байгаа. Хэрэгжилт 92 хувь
	14.2.8	Жолоочийн хариуцлагын даатгалын санд олгох шилжүүлэг	Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хууль хэрэгжинэ	Хуулийн дагуу суурь орлогын 10 хувиар тооцож төвлөрүүлнэ.	7,000.0	8,683.2	АТБӨЯХАТ-ыг 2021 онд АИТХ-ын 3/2 тогтоолоор тодотгон 7.0 тэр бум төгрөгөөр баталсан. Гүйцэтгэлээр 124 хувь төвлөрүүлсэн. Хэрэгжилт 100 хувь
	14.2.9	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламж	Нийгмийн хамгааллын бодлогыг зорилтот булагт чиглүүлэх, халамжийн үйлчилгээний тараан хуваарилах тогтолцооноос татгалзаж хувь хүн, гэр бүлийг чадваржуулан халамж үйлчилгээг иргэдэд шуурхай чирэгдэлгүй хүргэнэ.	ХБиргэн, ахмад настан, өрх толгойлсон, бүтэн өнчин зорилтот бүлгийн иргэд.	115.5	93.7	2021 онд халамжийн үйлчилгээг 155 иргэнд үзүүлж, 93745.0 мянган төгрөг зарцуулж ажилласан. Үүнд: 1. Гэр оронгүй болсон, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон мөн хорих ангиас суллагдсан болон бүтэн өнчин зэрэг 47 өрхөд 56.4 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж 2. ХБИ. Ахмад настан, өрх толгойлсон эх зэрэг зорилтот бүлгийн 108 иргэдэд сургалт зохион байгуулж, өдрийн үйлчилгээнд хамруулахад 37.3 мянган төгрөг тус тус зарцуулсан. Хэрэгжилт 81.2 хувь
	14.2.10	Санхүүгийн хяналт, аудитын алба	Байгууллагуудын санхүүгийн баримт, үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.	Жилд 12-15 байгууллагын санхүүгийн баримтад хяналт, шалгалт хийж, заавар зөвлөгөө өгч ажиллана.	185.1	180.9	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 97.7 хувийн гүйцэтгэлтэй байна. 2021 онд нийт 143 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, 3 байгууллагад дотоод аудит хийж, арга зүйгээр хангаж ажилласан. Хяналт шалгалт, дотоод аудитад хамрагдсан байгууллагуудад 143 шалгалтын танилцуулга, 3 байгууллагад дотоод аудитын тайлан, ажлын баримт бичиг үйлдсэн ба зөрчилтэй ажилласан 132 байгууллагад зөрчилгүй арилгуулахаар 192 улсын ахлах байцаагчийн акт, 38 албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг тооцсон. Нийт 4664532.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 943294.5 мянган төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн акт тогтоож, 3721238.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. Төлөвлөгөөт 143, төлөвлөгөөт бус 5 байгууллагад хяналт шалгалт, дотоод аудитаар 3 нийт 151 байгууллагад хийсэн хяналт шалгалтын зөрчлөөс акт тогтоосон 943294.5 мянган төгрөгөөс 143198.4 мянган төгрөгийг төсвийн орлогод, 800096.1 мянган төгрөгийг тухайн байгууллагад төвлөрүүлэхээр шийдвэрлэн 3721238.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 38 байгууллагад хугацаатай албан шаардлагыг хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажилласан. Нийт тогтоосон актын төлбөрөөс 115154.5 мянган төгрөгийг төсвийн орлогод, 800096.1 мянган төгрөгийг тухайн байгууллагад төвлөрүүлж, 97.0 хувийг хугацаанд нь барагдуулаад байна. Хэрэгжилт 100 хувь.
	14.2.11	Сум дундын ойн анги	Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ногоон байгууламжийг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.	Аймгийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, ойн тухай хуулийн хэрэгжилтийг 100 хувьд хүргэх	488.3	445.3	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 91.2 хувийн гүйцэтгэлтэй байна. 2021 онд ойжуулалт нөхөн сэргээлт хийх 11 га газар, Ногоон хэрэм төслөөс хүлээн авсан Даланзадгад суманд 524 га талбай, Булган сумын Баянзагт 1040 га талбай нийт 1560 га газарт таримал ойн зурвас талбайг өдөр тутмын арчилгаа, хамгаалалтыг хийж хариуцан ажилласан. Мөн аймгийн төвийн Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг явуулж жилд 5-8 төрлийн 30-50 мянган ширхэг тарьц, суулгацыг үржүүлж байна. "90 жил-90 мянган мод" аяны хүрээнд шинээр байгуулсан ойн зурвас талбай, Гурван сайхан хорооллын засмал зам дагуух 80 га ойн зурвасын арчилгаа, усалгааг гүйцэтгэсэн. Мод үржүүлгийн газрын үрийн нөөц бүрдүүлэлт, сургалт сурталчилгааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажилсан. Хэрэгжилт 98.2 хувь.
	14.2.12	Олон нийтийн цагдаа	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн цагдааг ажиллуулах	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	324.0	324.0	Олон нийтийн цагдаагийн зардалд 324.0 сая төгрөгийн санхүүжилт олгож ажилласан. Хэрэгжилт 100 хувь
	14.2.13	Орон нутагт хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээ /Засаг дарга/	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	Арга хэмжээнүүд үр дүнтэй байх	12,619.3	10,468.1	2021 онд хөтөлбөр, төсөл арга хэмжээний төсвийн гүйцэтгэлийн хэрэгжилт 82.9 хувийн биелэлттэй. 2021 онд орон нутагт хэрэгжүүлэх 47 хөтөлбөр, төсөл арга хэмжээ төлөвлөсөн. Үүнээс: Эрүүл мэндийн чиглэлээр Эх хүүхдийн эрүүл мэнд, Эрүүл шүд, Элэг бүтэн Өмнөговьчууд, Харшлын эсрэг, Сүү тараг гэсэн 5 дэд бүлэг хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж нийт 6.7 тэр бум төгрөг зарцуулсан. Говийн ирээдүй-Хүүхэд, Чадварлаг-Багш, Сургагч солилцоо, Хос сайхан бичигтэн-Өмнөговь, Өмнөговь аймгийн 90 жилийн ойд зориулан түүх соёлын ном, уран бүтээл, оюуны бүтээлийг олон нийтэд тгээх, Залуус, Өсөлтийг өрх бүрд, Чинээлэг малчин, Нутгийн дэм, Шинэ мянган айл, Танд үйлчилье, Явуулын оффис гэсэн дэд хөтөлбөрүүдийг боловсруулан батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан. Хэрэгжилт 98 хувь
	14.2.14	Соёлын төв	Иргэдэд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.	Сумдын соёл урлагийн байгууллага жилд 60000 хүнд үйлчилнэ.	2,010.9	-	2021 онд Ковид-19 цар тахлын байдлаас шалтгаалан олон нийтийг хамарсан үйлчилгээ зохион байгуулагдаагүй. Өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд соёлын өвийг хамгаалах, цахим хэлбэрээр дуу, бүжгийн уралдаан зохиож ажилласан. Хэрэгжилт 96.7 хувь
	14.2.15	Номын сан	Аймгийн нийтийн номын сангаар үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж, хүртээмж сайжирна	Уншигчдын тоо 500 том хүн, хүүхэд 2000 хамрагдана.	267.1	165.0	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 61.8 хувийн гүйцэтгэлтэй байна. 2021 онд нийт 386 уншигч, 29073 ном олгож, 27871 иргэнд үйлчилсэн. Хэрэгжилт 74 хувь
	14.2.16	Музей	Аймгийн музейн үйлчилгээг сайжруулж, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Үйлчлүүлэгчдийн тоо 22000-д хүргэнэ.	365.2	263.0	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 72 хувийн гүйцэтгэлтэй байна. Цар тахлаас шалтгаалаад иргэдэд үйлчлэх хязгаартай, мөн шинэ Музейн байр ашиглалтад орж нүүх болсон учраас үйлчлүүлэгчдийн тоо бага байсан. Нийт 167 иргэнд үйлчилсэн. Үүнээс: 11 гадаад иргэн, 156 дотоодын иргэн хүнд үйлчилсэн. Хэрэгжилт 95.7 хувь
	14.2.17	Хөгжимт жүжгийн театр	Аймгийн ХЖТ-ын уран бүтээлийн чанар сайжирч, үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ	Аймгийн ХЖТ-аар үйлчлүүлэгчдийн тоог 54000 -д хүргэнэ	1,113.1	867.4	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 77.9 хувийн гүйцэтгэлтэй байна. 2021 оны 12 сарын 8-нд "Даланзадгадын үдэш-4" мюзиклийг бүх уран бүтээлчид, ажилчдын хамтарсан дуу, бүжиг, ерөөл, зохиомжит 2 цагийн тоглолтыг 300 үзэгчдэд хүргэсэн. 2021 оны 12 сарын 14-нд үзэгчдийн хүсэлтээр 185 үзэгчдэд дахин тоглогдсон. Говь нутгийн дууг хэн сайн дуулах вэ? Дууны уралдааныг говь нутгийн авьяаслаг дуунд дуртай, ард түмний дунд нээлттэй зарлаж 2 шаттайгаар зохион явуулж 1-р шатанд 70 хүн оролцож 2-р шатанд 42 хүн шалгарч хүүхэд, насанд хүрэгчдээс нийт 7 байр эзлүүлсэн."Бидний шүтээн Өмнөговь" Уран уншлагын наадмыг насанд хүрэгчид, хүүхдийн дунд говь нутгийн тухай бичсэн шүлэг найраглалуудыг уран яруу, тод унших уралдааныг зарласан. Хүүхдийн ангилалд 53 сургагч 77400 хандалттай, насанд хүрэгчдийн төрөлд 12 хүн /234,522 хандалт/ оролцож тус бүх эхний 3, 3 байрыг шалгаруулсан. "Эрүүл Өмнөговь" бүжгийн challenge-ийг Бүжиг ангийн хамт олон санаачлан 14 хоногийн хугацаатайгаар иргэд, аж ахуй нэгжийн дунд зарлаж 6 аж ахуй нэгж байгууллага, 43 иргэд оролцсон. Эхний 3 байрыг тус тус шалгаруулсан. Цахим орчин дахь тандалтын тоогоор 30709 иргэдэд бүжгийн урлагийг сурталчлан таниулсан. шинэ уран бүтээл гаргасан -18 Нийт 62546 хүнд үйлчилж, үүнээс 60918 том хүн, 1628 хүүхэд үйлчилсэн. Урын сангийн эрхлэгч Д.Балганцэрэн нийт 5 төрлийн 75 уран бүтээл урын санд бүртгэсэн. Хэрэгжилт 100 хувь.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулаа /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	14.2.18	Биеийн тамир, спортын газар	Иргэдийн биеийн тамир, спортод хандах хандлага сайжирч, хөдөлгөөний хомсдлоос үүдэлтэй халдварт бус өвчний тохиолдол буурч, эрүүл чийрэг бие бялдартай болсноор дундаж наслалт, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ.	Жилд нийтийн биеийн тамирын арга хэмжээг 50 удаа, аймгийн аварга шалгаруулах уралдаан тэмцээнийг 30 удаа зохион байгуулна.	241.1	180.8	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 75 хувийн гүйцэтгэлтэй байна. 2021 онд Спортын уралдаан тэмцээн, нийтийн биеийн тамирын арга хэмжээнүүд нийт 21 удаа зохион байгуулж, 5000 гаруй иргэн хамрагдаж, олон улс, улсын аварга, бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс өсөөр үеийн тамирчид алт-3, мөнгө-5, хүрэл-8 насанд хүрэгчид алт-12, мөнгө-14, хүрэл-16 нийт -58 медаль хүртэж ОУХМ, СМ-8, СДМ-3 байна. Улсын хэмжээнд Зарласан нийтийн биеийн тамирын 3 арга хэмжээнд бүгдэд эхний 3 байранд шалгарсан. Хэрэгжилт 97 хувь.
	14.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			53,365.2	52,236.6	
	14.3.1	Сургуулийн өмнөх боловсрол	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 100 хувьд хүргэнэ	Цэцэрлэгт 5345 хүүхэд хамрагдана.	10,609.1	9,768.4	Засгийн газраас баталсан нэг хүүхэд ногдох хувьсах зардлын нормативын дагуу сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийт 5457 хүүхэд хамрагдаж, нийт 9.8 тэр бум төгрөгийн төсвийг зарцуулсан. Хэрэгжилт 92.1 хувь
	14.3.2	Ерөнхий боловсрол	Суурь боловсролын хамран сургалтыг 100 хувьд хүргэнэ	Ерөнхий боловсролын сургуульд 11370 хүүхэд хамрагдана.	21,839.7	20,985.8	Ерөнхий боловсролын сургуульд нийт 14592 сурагч хамрагдаж, 20.9 тэр бум төгрөгийн төсвийг зарцуулж, хамран сургалт 100 хувь. Сургууль завсардалт байхгүй. Хэрэгжилт 96.1 хувь
	14.3.3	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	Салбарын холбогдох хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээнд техник хяналт тавьж, барилга угсралтын ажлын чанарыг сайжруулна.	520.1	498.1	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 95.8 хувийн гүйцэтгэлтэй байна. 2021 онд 70 угсралт, 31 засварын ажил нийт 101 ажил дээр барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах Улсын комисс ажилласан. Үүнээс: Барилга угсралтын 70 ажлаас 36 ажил хувийн хөрөнгө оруулалт, 3 ажил Улсын төсөв, 51 ажил Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, 31 засварын ажлаас 29 ажил Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 3 ажил хийгдээд байна. Хэрэгжилт 95.8 хувь
	14.3.4	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хүүхэд хөгжүүлэх дугуйлан, секц, бүлгүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хүүхдийн оролцооны чадавхыг нэмэгдүүлнэ.	Хүүхдийн эрхийн зөрчлийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилтыг үнэлж, орон нутгийн шийдвэр гаргах түвшинд хүүхдийн үзэл бодлыг илэрхийлж нөлөөлсөн шийдвэрийн тоо	408.6	403.2	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 98.7 хувийн гүйцэтгэлтэй байна. 2021 онд нийт 25 сургалт арга хэмжээнд 203 хүн, 43079 хандалт, өдөрлөг 16 зохион байгуулж 4282 хүн хамрагдсан 18318 цахим хандалт, бусад 27 арга хэмжээ зохион байгуулж 106 өрх, 825 хүн хамрагдсан. Чиг үүргийн дагуу 781 эцэг эх 3655 хүүхэд сургалт зохион байгуулсан. Бодлого шийдвэрийн тоо-89. Хэрэгжилт 94.3 % хувь
	14.3.5	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламжийн үйлчилгээг удирдлага зохион байгуулалтаар хангаж, иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшин нэмэгдэж, халдварт болон халдварт бус өвчний гаралт, багасаж, нас баралтыг бууруулах, эмзэг бүлгийн хүн ам эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Хүн амын 50 хувийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамруулж, халдварт бус өвчний үзлэгийг 10 хувиар нэмэгдүүлнэ.	5,269.1	5,088.6	2021 онд аймгийн онцгой комиссын 22 удаагийн хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу 387.553.796 төгрөгийг зарцуулсан. Төрийн өмчит эрүүл мэндийн төвүүд, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд 284.636 хүнд эрүүл мэндийн болон эмнэлгийн үзлэг үзүүлсэн. Иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшнийг нэмэгдүүлэх чиглэлээр 44 удаагийн сургалт, зөвлөгөө зохион байгуулсан. 2019 оны сүүлээс эхлэн дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын аюултай халдварт өвчний улмаас аймгийн хэмжээнд 2021 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд 17702 тохиолдол бүртгэгдсэн ба эх уурхай тодорхой 14851 тодорхойгүй 3075, идэвхтэй байгаа голомт 1, идэвхтэй 0, хаагдсан 112 голомтын 16397 хавьтлаас гэрлийн тусгаарлалтад хянагдсан байна. Нийт батлагдсан тохиолдлын 55-с дээш нас 1393, 0-17 насанд 3997, хөгжлийн бэрхшээлтэй -19, эмнэлгийн ажилтан 341, нас баралтын 19 тохиолдол бүртгэгдэж, 14481 иргэн эрүүлжигч эдгэрсэн байна. Аймгийн хэмжээнд нийт 17702 халдварын тохиолдол бүртгэгдсэнээс 9728 нь зөвөөрлөгдсөн тохиолдол батлагдаж Улаанбаатар хот руу 3078 хүн тээвэрлэгдсэн байна. Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийн артерийн даралт ихсэх өвчин илрүүлэх үзлэгт 12308, чихрийн шижин илрүүлэх үзлэгт 12584, умайн хүзүүний эсийн шинжилгээнд 1136, хөжний хавдар илрүүлэх үзлэгт 6842, элэгний эрт илрүүлэгт 7635 хүн хамрагдаж үзлэг 37.5%-тай хийгдсэн байна. Жилийн эцсийн байдлаар урьдчилан сэргийлэх үзлэг 124984 хийгдсэн ба түрүү оны мөн үетэй харьцуулахад 18191 нэмэгдсэн байна. Хэрэгжилт 85 хувь
15	СЭЛЭНГЭ				81,225.5	72,555.5	
	15.1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа			2,029.2	1,671.3	
	15.1.1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа	Хурлын үйл ажиллагааг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй зохион байгуулсан байх	Аймгийн ИТХ-аас 2021 онд 26 удаагийн тогтоол, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн худалдааны 73 тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна.	1,921.4	1,563.5	ИТХ-аар хэлэлцэх асуудал, Хурлын хороод, Ажлын албанаас зохион байгуулах үйл ажиллагаа, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус боловсруулж хэрэгжилтийг тайлагнан, үр дүнг тооцон ажилласан байна. 2021 онд аймгийн ИТХ-ын ээлжит хуралдааныг 2 удаа хуралдаж хурлаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж тогтоолуудыг гарган ажилласан. Мөн сумд болон аймгийн ИТХ-н төлөөлөгч нарыг чадавжуулах сургалтыг зохион байгуулсан. Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын дагуу орон нутгийн өмчийн харилцааны чиглэлээр 25 тогтоол гарсан бөгөөд хэрэгжилт 100 хувьтай байна.
	15.1.2	ГХУСА33-ийн үйл ажиллагаа	Аймгийн гэмт хэргээс сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөөг гаргаж батлуулах	5 зүйл 43 заалттай төлөвлөгөөг гарган батлуулж биелэлт 89.7 хувьтай	107.8	107.8	2021 онд 11 удаагийн , салбар зөвлөлийн гишүүн байгууллагатай хамтран Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажилласан үр дүнд 2020 онд 408 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулбал 117 хэргээр буюу 22.3 хувиар буурсан байна.
	15.1.3	ЦАУЗБСК-ийн үйл ажиллагаа	Нөхөн олговор авах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах	Хуулийн дагуу зохион байгуулагдсан.			Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн дагуу шаардлага хангасан иргэдийн материалыг бүрдүүлэх, холбогдох газарт хүргүүлэх, нөхөх олговор олгуулах ажлыг зохион байгуулж байна. 2020 онд 15 иргэний 920.0 сая төгрөгийн нөхөн олговрыг олгоод байна.
	15.2	Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			42,445.9	34,557.0	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
15.2.1	Иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон төрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Засгийн газрын болон аймгийн Засаг дарга, ИТХ-аас гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, сум, хэлтэс агентлагийн үйл ажиллагааг уялдуулах, аймаг, сумдын ЗДТГ-ын ажилтнуудад нутгийн удирдлагын чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгч сургалт семинарыг зохион байгуулж, мэдээллээр хангах, хууль, тогтоомж засгийн газрын тогтоол, засгийн газрын мөрийн хөтөлбөр, засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт, үр дүнгийн мэдээллийг холбогдох газарт хүргүүлэх	Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байх, ажлын үр дүн сайжрах. Биелэлт гаргах тогтоол шийдвэрийн тоо, хэрэгжилтийн байдалд ахиц гарсан байх. Гүйцэтгэл 88.8 %	8,944.8	8,369.0	Засгийн газрын болон аймаг орон нутгийн удирдах байгууллагаас гарсан, гарч байгаа бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймаг сумдын болон агентлаг байгууллагуудын удирдах ажилтны цугларалтыг зохион байгуулахын зэрэгцээ Удирдлагын академийн богино хугацааны сургалтад 38 албан хаагч сумдын бусчилсан сургалтуудад 825 албан хаагч хамрагдаж цаг үеийн олон ажлуудыг шийдвэрлэн ажиллаж байна. 2021 онд холбогдох хууль журам, сайдуудтай тухайн онд хамтран ажиллах гэрээний хүрээнд 15 сайдын 633 заалтыг хяналтад авч 88.08 хувийн биелэлтэйгээр холбогдох яамдад цахим болон цаасаар, дагалдах материалын хамт хүргүүлжээ. Аймгийн Засаг дарга 2020 онд Засгийн газрын гишүүн сайд нартай байгуулсан гэрээний үр дүнгийн дунджийг тооцоход хэрэгжсэн хүлээсэн үүргээ 88.08 хувьтай биелүүллээ. Үүнээс: Шаар сайдтай байгуулсан гэрээ 76.12 хувьтай байгаа нь хамгийн бага үзүүлэлт байгаа бол Эрүл мэндийн сайдтай байгуулсан гэрээний биелэлт 95.5 хувьтай үнэлэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлтэй байна. Улсын ЗЭНГХҮЧ, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засгийн хөгжүүлэх 2020-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг хяналтад авч хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичиг, тогтоол шийдвэрийн заалтуудын биелэлт, үнэлгээ дүгнэлтийг гарган 94.3 хувьтай биелүүллээ. 91 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 183 заалтыг хяналтад авч 97.14 хувийн биелэлттэйгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт цахим болон цаасаар, дагалдах материалын хамт хүргүүлжээ. Үүнээс: 100 хувийн биелэлттэй буюу бүрэн хэрэгжсэн - 165 заалт, 70 хувь буюу хэрэгжих шатандаа - 5 заалт, 30 хувь буюу хэрэгжилт хангалтгүй заалт байхуй, хэрэгжих хугацаа болоогүй/үнэлэх боломжгүй 8 заалт тус тус байна. Сүхбаатар аймаг нь 2021 оны Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийт 100 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж, 2021 оны 12-р сарын 10-ны өдрийн аймгийн ИТХ-аар аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хэлэлцэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт болон хүний хөгжилд чиглэсэн олон ажлын үр дүнг дүгнэж, 100 хувийн саналаар хангалттай гэж үзсэн байна. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2021 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт жилийн эцсийн байдлаар нийт 100 арга хэмжээний биелэлт дунджаар 81.3 хувьтай байна.
15.2.2	Орон нутгийн засаг захиргааны бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт "Хангалттай үнэлэгдэх"	85%			Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу 114 зорилтын хүрээнд 327 арга хэмжээг хэрэгжүүлснээс 100 хувийн биелэлттэй буюу үр дүнтэй- 187 арга хэмжээ, -70 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн- 96 арга хэмжээ, 40 хувь буюу эрчимжүүлэх шаардлагатай-25 арга хэмжээ, 0 хувь буюу үр дүнгүй, хангалтгүй -19 арга хэмжээ, үнэлэх боломжгүй-9 арга хэмжээ тус тус байгаа бөгөөд үг хөтөлбөрийн биелэлтийн үнэлгээний дундаж хувь урьдчилсан байдлаар 85.4 хувьтай дүгнэгдэж, аймгийн ИТХ-ын ээлжит 4-р хуралдаанаар төлөөлөгчдийн 100 хувийн саналаар ХАНГАЛТТАЙ үнэлгээ авлаа.
15.2.3	Гамшгаас хамгаалах сургалт сурталчилгаа	Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, бэлэн байдлыг хангах, багуудыг сургалтад хамруулах	Төлөвлөгөөнд тодотгол хийгдэж, комиссын гишүүд, баг, мэргэжлийн ангид сургалт дадалгад бүрэн хамрагдсан байна. Биелэлт 100%	800.0	763.4	Аймгийн гамшгийн үеийн болоод Дэлхий нийтэд бүртгэгдээд байгаа Ковид-19 цар тахлын үед ажиллах төлөвлөгөө, эрсдэлийн үнэлгээ хийж ажилласан байна. Мөн Монгол улсад Ковид-19 өвчлөл бүртгэгдсэнтэй холбогдуулж АНЭ-д Рентген аппарат авахад дэмжлэг, хүчилтөрөгчийн баллон суурилуулах, ЭМГ, МХГ, ОБГ зэрэг байгууллагуудад хөдөлмөр хамгаалах, ариутгалын бодис худалдаж авахад дэмжлэг тусгаарлах байрны хоол, байрны зардал, Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэд хэдэн удаа шилжсэнтэй холбогдуулж хяналтын постууд гаргаж ажиллахад шатахуун болоод, хөдөлмөр хамгаалах, томилолтын зардлыг гаргасан байна.
15.2.4	Урьдчилан төлөвлөх, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн арга хэмжээ	Засаг даргын мөрийн хөтөлбөртэй нийцсэн байх	Мөрийн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан.	784.7	784.1	Засаг даргын мөрийн хөтөлбөрт туссан ажлууд болоод, Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн холбогдолтой арга хэмжээнүүдийг санхүүжүүлсэн байна. Тухайлбал: аймаг, орон нутгийн хэвлэл мэдээллийн салбартай хамтран ажиллах гэрээний дагуу санхүүжилт 40 сая төгрөг, Хилийн цэргийн ангийн төхмөл хэрэгсэлд завсар үйлчилгээ оруулах, тэдний сургалт зөвлөгөөнийг зохион байгуулах, ЗД-ын хэрэгжүүлж буй үйл ажиллагааг орон нийтэд мэдээлэл мэдээллийн чанар хүртээмжийг сайжруулах зорилготой контент компанитай хамтрах, Залуучуудын үйл ажиллагааг дэмжих зэрэгээр үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн болно.
15.2.5	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	АИТХ-ын тогтоолоор батлагдсан 30 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх	79%	251.7	198.8	2021 онд 3-4 бүлгийн эхийг хамгаалахаар төлөвлөж байсан ч гүйцэтгэлээр 8 бүлгийн эхийг хамгаалсан Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр эзэнгүй хог хаягдлыг бүрэн цэвэрлэж 8 суманд энэ үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулж 7560 сэг зэм устгасан. 107 байгууллага 2064 өрх хамрагдаж 227 тун хог хаягдлыг устгасан.Баруун-Уртын голыг хашиж хамгаалах ажил бүрэн хийгдсэн.Нийт 600 метр газар хашиж хамгааллаа. 5 сумын 5 хотгийн цэцэг дэмжлэг үзүүлж 30 га газрын хог хаягдлыг цэгцэлсэн гүйцэтгэл 100% Уул уурхайн эвдэрсэн газруудад нөхөн сэргээлтийн ажил хийсэн. Тухайлбал Сүхбаатар аймгийн 6 сумын нутаг дэвсгэрт нийт 1га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.
15.2.6	Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх вакцинд хамруулахаар тооцсон малыг бүрэн хамруулах вакцин товлосон хугацаандаа хийгдсэн байх	100%	461.5	461.5	Товлосон хугацаанд хамрагдах ёстой мал бүрэн хамрагдсан.
15.2.7	Замын сан	Иргэдийг аюулгүй зорчих нөхцөлөөр хангах, хотын өнгө үзэмжийг сайжруулах	Аймаг орон нутгийн замыг сайжруулж засвар хийх 4 төсөл арга хэмжээ 80.5	530.0	427.2	Хөл бөмбөгийн талбайгаас 4-р тойрог хүртэлх 1.1 км замын хүчилт, явган зам, гэрэлтүүлгийн 427 2сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.
15.2.8	Хувийн хэвшлийн байгууллагуудыг дэмжих	Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хөрш зэргэлдээ орнуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Бичигт-Өргөө ОНӨҮГ-т дэмжлэг үзүүлэх	100%	70.0	70.0	АИТХ-ын тогтоолоор батлагдсаны дагуу 70.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
15.2.9	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	СХС-ийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах	Зээлийн эргэн төлөлт нэмэгдсэн.	1,275.7	911.8	2021 онд Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 250.0 сая төгрөг орж ирсэн ба энэ нь өмнөх оноос 96.6 сая төгрөгөөр илүү байна. Нэмж 911.8 сая төгрөгийн зээл оглосон байна.
15.2.10	Нөөц хөрөнгө	Нөөц хөрөнгийг журмын хүрээнд захиран зарцуулах	Журамд заасны дагуу зарцуулсан	400.0	364.1	Нөөц хөрөнгийг зарцуулах журмын 2.1.1-ийн дагуу Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, шөлжилт, гал түймэр, хүн мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэргэнд тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хягаарлах, үр дагаврыг арилгах арга хэмжээнд 269.1 сая төгрөг, 2.1.3 буюу Нөхөн төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардалд 55 сая төгрөг, 2.1.4 буюу Байгууллага иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэхэд 13.5 сая төгрөг, 2.1.5 буюу Энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд 18 сая төгрөг, 2.1.6 буюу Шангал, урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгт 8.5 сая төгрөг зарцуулсан байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
15.2.11	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	ОНХС-ийн хөрөнгө оруулалтын зардлыг хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой орон нутагт зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын ажил, төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төлөвлөн баталсан ажил үйлчилгээнүүдийг хугацаанд нь бүрэн, чанартай хийж гүйцэтгэх	Баталсан хөрөнгө оруулалтын ажлууд хугацаандаа бүрэн хийгдсэн байх. Төсөв 20155.5 сая төгрөг	23,044.9	16,497.0	Тайлант хугацаанд нийт 111 удаа цахим төндөрийг давтагдсан тоогоор харьяа 13 сум зарласан байна. Харьяа сумдад мэргэжил арга зүйн зөвлөгөөг мэргэжилтнүүд өгч ажилласан. Аймгийн ОНХС-аар хэрэгжсэн 59 төсөл арга хэмжээ 10583.1 сая төгрөг санхүүжигдсэн гүйцэтгэлээр 8506.4 сая төгрөг санхүүжсэн. Санхүүжилт 80.3 хувьтай.
15.3	Хот тохижуулах газар					
15.3.1	Хот тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаа	Төвлөрсөн хогийн нэгдсэн цэгийг цэглэх, айл өрх, ААН-эгж, байгууллагын ахуйн хог тээврийг тээвэрлэх хог хаягдлын нэгдсэн цэгт төвлөрүүлэх, хог хаягдлын нэгдсэн цэгт далан үүсгэх, торон хогийн сав, ангилан ялгадаг хогийн сав хийх	100%	1,084.8	1,084.8	Азийн хөгжлийн банкны санхүүжилтийн Баруун-Урт сумын хог хаягдлын цэгийг шинээр байгуулах ажлын хүрээнд хуучин хогийн цэгийг цэглэх, булшлах ажлыг зохио байгууллаа. Байгаль орчны газартай хамтарч аймгийн хэмжээнд нийт 8 сум бүх нийтийн цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулан 7560 сэг эм утгасан бөгөөд бүх нийтийн цэвэрлэгээнд нийт 107 байгууллага, 2064 өрх хамрагдаж 227 тн хог хаягдлыг утгасан. Хогоо ангилан ялгах болон хогийн саванд хийж хэвшүүлэх талаар өөрийн цахим хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлэл ажиллаж байна.
15.3.2	Гудамжны гэрэлтүүлэг, засвар үйлчилгээ	Гэр хорооллын айлуудын дундах гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	100%	53.0	53.0	Нийт 197.4 сая төгрөгийн гэрэлтүүлгийн ажлыг заасан хугацаанд бүрэн хийж дууссан. Энэ нь баруун-Урт сумын гэр хорооллын гудамж бүрд цамхаг гэрэлтүүлгийг суурилуулсан.
15.2.12	Аймгийн орон нутгийн өмчийн газар	Аймгийн худалдан авах ажиллагааны тухайн оны төлөвлөгөө батлуулах, худалдан авах ажиллагаа цахимаар зохион байгуулах хэрэгжүүлэх, хянах, тайлагнах, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хяналт тавих	96.30%	237.8	237.3	Аймгийн Засаг даргын ХАА-ын 2021 оны төлөвлөгөөгөөр 90 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээний төндөр зохион байгуулахаар төлөвлөснөөс 86 төндөрийг зарлаж гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан. Зохион байгуулагдсан төндөр шалгаруулалт бүрийн төндөрийн баримт бичигт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу төндөр оролцогчдоо давуу эрх олгох тухай тусгаж давуу эрх тооцуулах боломжоор хангаж ажилласан.Энэ онд давуу эрх тооцуулах хүсэлт, шаардлагыг хангаж давуу эрх тооцуулсан оролцогчдоос 751.0 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан. Худалдан авсан бүтээгдэхүүнийг гэрээний дагуу цаг хугацаанд нь нийлүүлэлтийг хийж хамтран ажиллаж байна.
15.2.13		Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн эзэмших, ашиглах, түрээсийн гэрээг байгуулах, ирүүлсэн санал хүсэлтийг шийдвэрлэх	6 байгууллагатай түрээсийн гэрээ байгуулсан, санал хүсэлт шийдвэрлэлт 100 %			Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн 8 байгууллагатай Контрактын гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтийг 2022 оны 01 сарын 29-нд дүгнэхээр тусган ажиллаж байна. 11 дүгээр сарын 29-ний өдөр аймгийн хэмжээний орон нутгийн өмчит 18 аж ахуйн нэгжийн удирдлага, нягтлан бодогчдыг хамруулсан чадавжуулах сургалтыг Санхүүгийн зохицуулах хороо, аймгийн ЗДТГ, аймгийн ОНӨГ хамтран зохион байгуулсан бөгөөд Төрийн аудитын байгууллага, Татварын алба хамтран оролцсон болно. Мөн АИТХ тэргүүлэгчийн 25 тогтоолоор орон нутгийн үндсэн хөрөнгийг бүртгэх, данснаас хасах зэргээр ажилласан байна.
15.2.14		Аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс ирсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хүрээнд цаг тухайд нь шуурхай шийдвэрлэх, орон нутаг дахь төсөвт байгууллагуудын худалдан авах ажиллагаа хариуцсан 200 ажилтанд дадлагажуулах сургалт зохион байгуулах	Санал хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь 100%, сургалт 110 хүнд			Нийт 5 өргөдөл гомдол ирсэн бөгөөд хуулийн дагуу тухай бүрд шийдвэрлэн ажилласан.
15.2.15	Орон нутгийн ахмад настанд үйлчлэх	Ахмадын хороонд дэмжлэг үзүүлэх, ахмад настны чөлөөт цагаа өнгөрөөх ахмадын хорооны барилгын өргөтгөлийг хийх		71.0	71.0	Аймгийн хэмжээний 13 сумын ахмадын хорооны үйл ажиллагаа сайжирч Халзан сум Улсын тэргүүний ахмадын хороогоор шалгасан.Аймгийн засаг даргын захирамжаар 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.Мөн 74.8 сая төгрөгийн дэмжлэгийг хуваарийн дагуу олгож ахмадуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлсэн.
15.2.16	Байгаль орчны газар	Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, байгаль орчны чиглэлийн орон нутгийн байгууллагуудын салбар дундын зохицуулалтыг уялдуулах, сургалт нөлөөллийн ажил хийх	Холбогдох сургалтуудыг зохион байгуулсан. Аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх, байгууллагуудын уялдаа холбоог хангах болзолт уралдаан заргийг зарлаж дүгнэсэн. БХСангийн зардлаар гүйцэтгэл 97.5%	387.7	377.2	Энэ жилийн хувьд цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цахим орчинд иргэд рүү чиглэсэн ажлуудыг зохион байгууллаа. 15 арга хэмжээг хэрэгжүүлснээс цахим сургалт-10, хэлэлцүүлэг 2, өдөрлөг -3 хийж, 6112 иргэн, 182 ААНБ оролцож зөвлөгөө мэдээлэл-2744, уралдаан тэмцээн-7, ТВ-мэдээ, нэвтрүүлэг-3, шторк-29 удаа, цахимаар 85 удаа мэдээ хүргэж хандалт 274295 иргэний хандалт авсан байна.Мөнхаан, Сүхбаатар, Асгат, Халзан, Эрдэнэцагаан, Түвшинширээ зэрэг сумд хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлгүй талбайнуудаа ИТХ-аар хэлэлцүүлэн орон нутгийн тусгай хэрэгцээнд аваад байна. Үүнээс Асгат, Халзан сумдын нутагт орших Баянаараа уулыг аймгийн ИТХ-ын 2021 оны 10 сарын 05 өдрийн 01 дүгээр тогтоолоор нийт 331569.175 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах, мөн улсын тусгай хамгаалалтад авахаар саналыг Засгийн газарт уламжилсан.
15.2.17	Ногоон байгууламжийн үйл ажиллагаа	Аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Ногоон байгууламжийн ургалт 88%	66.5	66.5	"Сүхбаатар-Ойжуулалт" Сум дундын ойн анги, "Ойжуулалт-хайлаас" ХХК, " Шаргын модод цэцэрлэг" ХХК-нд нийтийн эзэмшлийн 11 байршилд нийт 19750 ширхэг 7 төрлийн мод сөөгийг арчлан модны ургалтын 88%-д хүрсэн.Усалгаа арчилгааг тогтмол хийж гүйцэтгэсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	15.2.18	Аймгийн халамжийн сан	Нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэсэн байх	100%	115.5	115.0	2021 онд орон нутгийн төсвөөс Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 34.8 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 80.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. 18 нас хүрээгүй байдхаа бүтэн өнчин болсон 18-24 насны нийт 4 иргэнд 4.8 сая төгрөг, гэр оронгүй буюу цаашид гэр орон нь амьдрах боломжгүй болсон 21 өрхөд 25.2 сая төгрөг өөрийн гэр оронгүй нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай 4 иргэнд 4.8 сая төгрөг тус тус олгосон байна.
	15.2.19	Санхүүгийн хяналт, аудитын алба	67 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, үйл ажиллагааг сайжруулах	100%	258.2	242.5	2021 онд Төрийн албаны цалингийн нэгдсэн систем бүрэн нэвтэрч дууссан бөгөөд аймгийн хэмжээнд төрийн 123 байгууллагын 3000 гаруй албан хаагчид цалин хөлсөө шуурхай, хүссэн арилжааны банкаар, цалингийн мэдээллийг мэйл хаягаар хүлээн авах зэрэг боломж бүрдсэн. Энэхүү системээр цалин хөлсийг тооцоолсноор Нийгмийн даатгал, Хувь хүний орлогын албан татварын тайланг системээс шууд илгээх, мөн НББ-ын программд гүйлгээ татах зэрэг нягтлан бодогч нарын ажлын ачааллыг хөнгөвчилсөн систем юм. 2. Төрийн сангийн төлбөр тооцоог түргэн шуурхай цахимаар илгээх боломжийг бүрдүүлэх зорилгоор "Эрхийн бүртгэлийн систем"-ийн хөгжүүлэлтийг Сангийн яам хийсэн хувиар түүний дата мэдээлэл болох 123 төсвийн байгууллагын төлбөрийн баримтад 1,2 дугаар гарын үсэг зурах этгээдийн мэдээллийг цахим системд бүрэн оруулж дууссан. Энэ нь орон зайнаас үл хамааран төлбөр тооцоог гүйцэтгэх бэлтгэл ажлын томоохон хэсэг хийгдсэн гэсэн үг юм. 3.Засгийн газраас дэвшүүлсэн төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд төрийн сангийн төлбөр тооцоог бүрэн цахимжуулах, түүний цахим архивын бүрдлийг хангах, сургалтыг цахимаар өгөх зэргийг хамруулсан томоохон "portal" цахим системийг нэвтрүүлэхээр хөгжүүлэлтийг ажил хийгдэж байна. 4.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийн хувь, явц зэргийг бүрэн хянах боломжтой publicinvestment.gov.mn цахим систем нэвтэрснээр хөрөнгө оруулалтын зардлын ил тод байдлыг ханган ажиллаж байна.
	15.2.20	Соёлын үйлчилгээ	Соёлын байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах орчин үеийн стандартын шаардлага хангасан барилга байгууламжийг нэмэгдүүлж, иргэдэд соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын байгууллагуудыг орчин үеийн хэрэгцээ шаардлагыг хангахад нийцэхүйц техник тоног төхөөрөмжөөр хангана.	95.40%	3,144.6	3,001.1	Дарьгангын хүн чулуун хөргүүдийг авран хамгаалах ажлыг орон нутгийн хөрөнгөөр хийхээс гадна Элчин сайдын яамд, гадаадын хөрөнгө оруулалттай төслийн байгууллагуудтай хамтран ажиллахаар гэрээ хэлэлцээр хийж байна. Тика олон улсын байгууллагад Дарьгангын 13-14 дүгээр зууны үеийн хүн чулуун хөргүүдийн хулбар хийх төсөл хүргүүлж, нийт 189.5 сая төгрөгийн төсөл дэмжигдсэн.2021 онд Халзан сумын Цагаан эргийн хүн чулуун шинээр бүртгэж авсан. Мөнхоан сумын Улаан дарвагайн хөшөө чулууг шинээр 300.0 хийж, Наран сумын Мандалын болон Хүн ухаа, Ноёны хөндийн хүн чулууд, Онгон сумын Шивээгийн хүн чулууг хашаажуулах ажлыг шинээр хийж, нийт 650.0 төгрөг зарцуулсан. Аймгийн хэмжээнд нийт 30 гэрээт хамгаалагч ажиллаж, үл хөдлөх дурсгалуудыг харж хамгаалах ажлыг хийж байна. Баяндэлгэр суманд 300 хүний суудалтай Соёлын төвийн барилга 1,988,50 төгрөгийн улсын төсвийн санхүүжилтээр баригдахаар 2021 оны 08 сард эхэлсэн ба гүйцэтгэгчээр "Воркмастер" ХХК шалгарсан. Онгон суманд 300 хүний суудалтай Соёлын төвийн барилга баригдахаар 2022 оны улсын төсөвт суусан.
	15.2.21	Нийтийн биеийн тамир	Спортын клуб холбоод, тамирчид дасгалжуулагчдыг бүх талаар дэмжинэ.	100%	463.5	461.7	Баруун-Урт гол дагуу нийт 74 га газарт мини парк, соёл, спорт, үзвэр үйлчилгээний хэсэг, машины нэгдсэн зогсоол явган хүний болон дугуйн зам бүхий цогцолбор соёл амралтын хүрээлэн байгуулахаар бүсчлэн төлөвлөлт хийж зураг төсөв хийгдсэн. Бүтээн байгуулалтын ажил 14,0 тэрбум төгрөгийн өртгөөр 2022 онд хийгдэхээр төлөвлөгдсөн. ХААН банк байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд Баруун Урт сумын 2 дугаар багийн нутагт 69,0 сая төгрөгийн өртгөөр 3x3 сагсан бөмбөгийн стандарт талбай баригдсан.1800 хүний суудалтай, цэнгэлдэх хүрээлэн барих ажил хийгдэж эхэлсэн ба үндэсний баяр наадам, үндэсний спортын төрлөөр тэмцээн уралдаан зохион байгуулахаас гадна хөнгөн атлетикийн 4 төрлийн стандарт талбайтай төлөвлөгдсөн ба хөнгөн атлетикийн төрлийн спорт хөгжих нөхцөл бүрдэж байна. Хувийн хөрөнгө оруулалтаар ХААН банк байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд 3x3 сагсан бөмбөгийн стандарт талбай байгуулсан. Мөн оффис, спорт заал бүхий олон улсын сүлжээ зочид буудал баригдахаар барилгын шав тавигдсан ба "Их модун" ХХК 6,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж 2022 оны 07 дугаар сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Эдгээр бүтээн байгуулалтууд хийгдсэнээр спортын төрөлжсөн стандарт талбайн тоо нэмэгдээс гадна иргэд спортын олон төрлөөр сонгон хичээллэх, амжилт үзүүлэх нөхцөл бүрдэж байна.
	15.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			36,750.4	36,327.2	
	15.3.1.1	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, төрийн бус өмчийн цэцэрлэгт нэмэлт бүлэг байгуулах		90%			Улсын төсвийн хөрөнгөөр шинээр 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлж, 2021 онд 450.0 сая төгрөгийн ажил хийхээс 800.0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэж Монимарс ХХК хийсэн. Үүнд 1 давхрын цугтгалт хийгдсэн. Баруун-Урт сумын 4-р цэцэрлэгийн их засварын ажлыг Өвсний үндэс хүний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийн санхүүжилтээр 628.9 сая төгрөгийн их засварын ажлыг хийж дуусгаж ашиглалтад оруулсан. Аймгийн хэмжээний 24 цэцэрлэгийн 4-5 настны ангийг тоглоом наадгайгаар хангах ажлыг 240 сая төгрөгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэлээ.
	15.3.1.2	Сургуулийн өмнөх боловсрол	Сургуулийн өмнөх боловсролд 5 настай хүүхдийг бүрэн хамруулах, хувилбарт сургалт, гэр бүлийн орчинд сургуулийн өмнөх боловсролд хамруулах үйл ажиллагааг дэмжих, бага насны хүүхдэдтэйгээ ажиллах мэдлэг чадварыг эцэг, эхчүүдэд олгох ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж,	96%	8,401.4	8,325.7	БИ ЗАЛУУ БАГШ" хөтөлбөрийг хэрэгжүүлж, ЕЭС, СӨБ-д 1-15 дахь жилдээ ажиллаж буй 101 залуу багшийг хамруулан БХАН-ийн сургагч багш нартай хамтран 3 өдрийн цахим сургалт-2 удаа зохион байгуулсан. Сургалтаар залуу багш нар багшлах үр чадвараа дээшлүүлэхийн зэрэгцээ шилдэг арга туршлага үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх боломж бүрдэж байгаа юм.Цэг үеийн байдалтай холбоотойгоор тэмцээн уралдаан зохион байгуулах боломжгүй тул зарим дугуйлан секцийн үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах нөхцөл үүссэн бөгөөд нийт 115 төрлийн дугуйланд 2542 хүүхэд хамрагдаж үйл ажиллагааг 108 багш зохион байгуулсан байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
15.3.2.1	Ерөнхий боловсрол	Суралцагчийн авьяасыг нээн хөгжүүлэх секц, дугуйлан мичээллүүлэх тэдгээрийн тогтвортой байдлыг хангана.	100%	21,274.4	20,994.5	Улсын төсвийн 640.0 сая хөрөнгөөр баригдаж эхэлсэн. 2021 онд 200.0 сая төгрөг төлөвлөгдсөний дагуу барилгын ажлын 30 хувийг гүйцэтгэсэн. 2021-2022 онд Баяндэлгэр, Түвшинширээ, Наран, Халзан, Эрдэнэцагаан сумын ЕБС орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болох төсөл хамрагдсан. Эрдэнэт ТӨҮГ-ийн санхүүжилтээр хийгдэж байна. 2021 онд Түвшинширээ, Баяндэлгэр сумын ЕБС, дотуур байранд орчин үеийн ариун цэврийн байгууламж хийгдэхээр болсон. Нийт 10 сургууль, 6 дотуур байр, 7 цэцэрлэгт ариун цэврийн байгууламж хийгдэхээс 1-р ээлжид 2 сургууль, 2-р ээлжид 3 сургууль, 3-р ээлжид 6 сургууль, цэцэрлэгт хийгдэнэ. 2021 онд шинээр ашиглалтад орсон Наран, Уулбаян, сумын дотуур байр гүйцэтгэгч ХХК-ийн хөрөнгөөр камержуулалт, Баяндэлгэр сум дотуур байр, сургуульдаа 9.975 сая төгрөгийн камержуулалтыг орон нутгийн хөрөнгөөр хийсэн. Аймгийн хэмжээнд 2019 онд нийт дотуур байрын 61 хувь камержуулалттай байсан бол 2021 онд 10 дотуур байр буюу 84.6 хувь камертай болж хүүхдийн аюулгүй байдлыг хангасан.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 16 ерөнхий боловсролын сургуульд сургалтын лаборатори байгуулах ажлыг 320,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ.
15.3.2.2	Ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтныг хууль дүрмийн дагуу сонгон шалгаруулж, мэргэжлийн багшаар бүрэн хангах	Ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтныг хууль дүрмийн дагуу сонгон шалгаруулж, мэргэжлийн багшаар бүрэн хангах	100%			8 иргэн бүрэн дунд боловсрол эзэмших хүсэлт гаргасны дагуу 2 иргэнийг Баянгол дүүргийн насан туршийн боловсролын төвд Бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхээр шилжин суулгасан.БШУ яамны захираагч Азийн хөгжлийн банкны 18,9 сая төгрөгийн санхүүжилтээр "Хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлэх төсөл"-ийн хүрээнд "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээллийн төв байгуулагдав. Насан туршийн боловсролын үндэсний төвөөс үндсэн 5 чиглэлээр 10 удаагийн цахим сургалтад хамруулж багш нараа чадавхжуулсан.
15.3.3.1	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Апслэгдсэн нутгийн иргэдэд Явуулын амбулаторийн үйлчилгээ үзүүлж зорилтот бүлгийн хүн амыг ХДХВ/ДОХ, БЗДХ, сүрьеэг илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзэлт хамруулж эрүүлжүүлэх	65%			Хүн амын дундах ХДХВ-ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх БЗДХӨ-ийг бууруулах асуудлыг аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм эдийн засгийн хөгжүүлэх жилийн болон 5 жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна. Бэлгийн замаар дамжих халдвар 196, нийт халдварт өвчний 12765/196 1,5%-ийг эзэлж байгаа бөгөөд тэмбүү 64 буюу 32,6 хувь, заг хүйтэн 58 буюу 29,6%, трихомониаз 74 буюу 37,7 хувийг тус тус эзэлж байна. БЗДХӨ нь 2020 оны мөн үеэс 47 тохиолдлоор буурсан байна. Сүрьеэ өвчний нийт 43 тохиолдол бүртгэгдсэн энэ нь өмнөх оны мөн үеэс 20 тохиолдлоор, 10,000 хүн амд 3,4 промиллиор буурсан байна. Сүрьеэ, БЗДХ-ын чиглэлээр ЭМБ-ийн ажилчдад Цахим сургалтыг 3 удаа зохион байгуулж нийт 570 эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан, сургалтын өмнө болон дараах сорилоор мэдлэгийг үнэлэхэд 25%-иар өссөн үзүүлэлтэй байна. Аймгийн нэгдсэн эмнэлгийн Бэлгийн замаар дамжих халдварын кабинет, Сүрьеэгийн диспансерын тасагт ЭМГ-ын Халдварын сэргийлэлт хяналтын баг ДЭМЖЛЭГТ хяналт хийж, 25 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилласан. КОВИД-19 халдварын нөхцөл байдалтай холбоотой урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог сум, баг, байгууллагуудын түвшинд зохион байгуулаагүй. Сүрьеэ, БЗДХ өвчний чиглэлээр урьдчилан сэргийлэх төлбөртэй үзлэг - 1062 иргэнд хийгдсэн байна. Глобал сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн хүрээнд хавьтлыг илрүүлэх үзлэг зохион байгуулах хамтран ажиллах гэрээний дагуу Асгат, Дарьганга, Онгон, Халзан сумдад үзлэгт 869 хүн, рентген шинжилгээнд 619, лабораторийн шинжилгээгээр онош баталгаажуулахад 30 хүн туберкулины сорилд 113 хүнийг хамруулсан. Сургалт сурталчилгаанд 544 хүн оролцов. Сүрьеэгийн тандалт оношилгоо эмчилгээний стандартаар эрүүл мэндийн төвийн 78 мэргэжилтэнд сургалт явуулсан.
15.3.3.2	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Хүн амын дунд зонхилон тохиолдож буй элэг, хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг өмнөх тоон үзүүлэлтээс 10-15 хувиар нэмэгдүүлэх	86%	6,327.8	6,262.7	Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/420 "Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ" тушаалын дагуу томилогдсон анхан шатны эрүүл мэндийн 15 байгууллагад эрт илрүүлэг үзлэгийг хянах, үйл ажиллагааг эрчимжүүлэх багийг арга зүйгээр ханган ажиллаж ХБӨ-ийн эрт илрүүлэг үзлэг өмнөх оноос 10 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Эрт илрүүлэг үзлэг артерийн гипертензи-84,6% чихрийн шижин -82,2% хөхний үзлэг-91,8%, умайн хүзүүний эсийн шинжилгээ-85,6% -тай байна. Артерийн гипертензи өвчөөр батлагдсан 212, чихрийн шижин -10, хөхний үзлэгээр өөрчлөлттэй- 151 умайн хүзүүний эсийн шинжилгээгээр өөрчлөлттэй-9 тус тус хяналтад авч эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Хорт хавдрын шинэ тохиолдлын 61,7% нь эрэгтэй, 38,3% эмэгтэй, шинэ тохиолдлын 36,6 хувь нь I, II үе, 63,4 хувь нь III, IV үе шатандаа оношлогдсон байна.
15.3.3.3	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Апслэгдсэн сум багийн иргэдийн эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг үндэслэн сум, өрхийн эрүүл мэндийн төвийн жигд тасралтгүй үйл ажиллагааг хангах, тусламж үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, багаж, шатахуун тослох материал, сэлбэгийг улс, орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.	100%			Орон нутгийн 1,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баруун-Урт сумын Энхжин өрхийн ЭМТ-ийн шинэ барилгын угсралтын ажлыг эхлүүлээд байна. 2021 онд Орон нутгийн 0,5 тэрбум төгрөг, 2022 онд 1,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 2022 онд ашиглалтад орно. 2021 онд тус барилгын зөрөө болон 1 дүгээр давхрын цутгал хийгдэх төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэл 100 хувь хийгдээд байна. Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгын зураг төсвийг хийлгэж байна.2021-2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад Мөнххаан сумын ЭМТ-ийн 17 ортой шинэ барилга барих 2,0 тэр бум төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлж барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна. 2021 онд улсын төсвийн 0,5 тэрбум төгрөг, 2022 онд 1,5 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 2022 онд ашиглалтад орно. 2021 онд тус барилгын 1 дүгээр давхрын цутгал хийгдэх төлөвлөгөөтэйгөөс гүйцэтгэл 100 хувь хийгдээд байна.2021 онд эрүүл мэндийн салбарт нийт 2146,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хамгаалах хувцас, ариутгалын бодис, урвалж оношлуур, багаж хэрэгсэлээр хангаад байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалт- 1223,5 сая төгрөг, Орон нутгийн хөрөнгө оруулалт-765,2 сая төгрөг, Хандив тусламж-157,6 сая төгрөг
15.3.4	Газрын харилцаа, кадастр	Газар зохион байгуулалтын системд сумдын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг нэвтрүүлэх, газрын мониторингийн цахим системийг нэвтрүүлэх	100%	425.2	424.2	Аймгийн хэмжээний 13 сумын барилга, үл хөдлөх хөрөнгө, гудамж, зам талбайг сумын ИТХ-ын тогтоолыг үндэслэн Газрын удирдлагын нэгдсэн системийн хаягийн мэдээллийн системд хаяжуулалтын хуулийн дагуу шинэчилсэн хаягийг оруулж ажилласан байна. Аймгийн хэмжээнд хаягийн мэдээллийн системийн системд хаяжуулалтын ажлын явц хянасан нэгж талбар 95.2%-тай, хянасан барилга 94.2%-тай байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төр/	Гүйцэтгэл /сар.төр/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	15.3.5	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, Гэр бүл хүүхэд залуучуудад төрийн үйлчилгээг чанартай хүргэх, тэдний оролцоог нэмэгдүүлэх, хөгжих эрхийг хангах, хүндээ ээлтэй үйлчилгээг бий болгох	91%	321.6	320.1	Гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, хожирчигийг хамгаалах талаар хөтөлбөр гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр хэрэгжиж байна. Хэрэгжилтийн хүрээнд 2021 оны хагас жилийн байдлаар 129 өрхөд хүрч ажилласан. Аймгийн Засаг даргын 2021.05.11-ний өдрийн А/271 дүгээр захирамжийн нэгдүгээр хэсэрт "Шилдэг хамтарсан баг", шалгаруулах журмыг батлуулсан. Сүхбаатар аймгийн хэмжээнд 22 хамтарсан баг хамгааллын үйлчилгээ үзүүлж байна. 2021 оны байдлаар 178 кейс бүртгэгдсэнээс 87 кейст хариу үйлчилгээ үзүүлж хаасан байна. 91 кейс хяналтад байна. Хамтарсан багт шилжүүлсэн 156 ба ГБХЗХГ-аас хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн ГБХЗХГ дангаараа 12 шийдвэрлэж үйлчилгээг үзүүлсэн. Хамтарсан багийг арга зүйгээр хангах ажлын хүрээнд 2021 оны байдлаар 6 удаагийн арга хэмжээ сургалт, кейс конференц зохион байгуулсан байна
16	СҮХБААТАР				111,501.7	100,674.0	
	16.1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа			590.5	577.3	
	16.1.1	Монгол Улсын хуулиудад болон журамд заасан ИТХ-ын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, аймгийн хөгжлийн бодлого чиглэлийг тодорхойлсон тогтоол шийдвэрийн төслийг хэлэлцэх	5 доошгүй удаа хуралдаан хийгдсэн байна	Аймгийн ИТХ нь 2021 онд 3 удаа, ИТХ-ын тэргүүлэгчид 15 удаа хуралдсан байна.	495.5	487.5	2021 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааныг 3 удаа зарлан хуралдуулж аймгийн эдийн засаг, нийгэм, хөдөө аж ахуйн салбарын хүрээг хамарсан 13 асуудал хэлэлцэж 11 тогтоол гаргалаа. Хуралдааны дундаж ирч 89.3 хувьтай хуралдлаа. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд 15 удаа бэлтгэлийг ханган хуралдаж аймгийн эдийн засаг, нийгмийн бүх салбар хүрээг хамарсан 130 гаруй асуудал хэлэлцэж 135 тогтоол батлан гаргасан байна. Тэргүүлэгчдийн хуралдааны дундаж ирч 74.5 хувьтай хуралдсан байна.
	16.1.2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн дагуу сурталчлан таниулах ажлыг тогтмолжуулж, гэмт хэргийн тоог бууруулна.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн дагуу сурталчлан таниулах ажлыг тогтмолжуулж, гэмт хэргийн тоог бууруулна.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн хэрэгжилтийг хангуулан гэмт хэргийн тоо өмнөх оноос 218 хэргээр буюу 28.4 хувиар буурсан.	87.0	87.0	Тайлант онд Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 4 удаа хуралдаж 21 асуудлыг хэлэлцэн 5 тогтоол, 6 ажлын чиглэл, 2 зөвлөмж гарган сумдын салбар зөвлөлдүүдэд хүргүүлэн биелэлтийг тооцон ажиллалаа. 2021 оны ажлын төлөвлөгөөг 4 бүлгийн хүрээнд 56 ажил арга хэмжээг батлан биелэлт 91.1 хувьтай хэрэгжсэн байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, Жендерийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийн хэрэгжилт, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын гүйцэтгэлийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлж Хангалттай гэж дүгнэгдсэн байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлаа сурталчлах ажлын хүрээнд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд, МҮОНРТ-ийн орон нутгийн сурвалжлагч, Сэлэнгийн мэдээ сонин, Хөтөл-ТВ, Хараа-ТВ, Экосдус пицхерс дүрс бичлэгийн студийтай хамтран үйл ажиллагаагаа сурталчлан ажиллалаа. Энэ хүрээнд "Ногоон байгаль" видео шорт, Сэлэнгэ мөрнийг бохирдлоос хамгаалах сурталчилгаа мэдээлэл, гэмт хэргэ зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 26 удаагийн мэдээлэл, 24 нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэн сурталчиллаа. Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Мал мах", "Орон нутгийн зам, хөдөлгөөний соёл", "Байгалиа хамгааль-2021" зэрэг 6 удаагийн нэгдсэн арга хэмжээ, "Оранж өдөр" "Ятгах тусам нягтал", "Нэг хором" зэрэг 5 удаагийн нөлөөллийн арга хэмжээ, "Шинэ үеийн сонголт архи, тамхи биш", "Хүүхдэд ээлтэй, хүчирхийлэлгүй сум", "Гамшиг онцгой байдлын үе дах хүүхэд хамгаалал"
	16.1.3	ЦАУЗБСК-ийн үйл ажиллагаа	Шийдвэрийг үндэслэн нөхөн олговрыг олгох	3 иргэний 120.0 сая төгрөгийн нөхөх олговрыг олголоо.		-	2021 онд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комисс 2 удаа хуралдан 2020 оны сумдын салбар зөвлөлдүүдийн тайлан, аймгийн салбар комиссын тайлан, 2021 оны ажлын төлөвлөгөө батлах тухай, "Хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ зохион байгуулах асуудлыг хэлэлцээ. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комиссоос энэ онд "Улс төрийн хил хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль", мөн хуулийн нэмэлт өөрчлөлтийг сурталчлах, хэрэгжүүлэх, хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тэмдэглэх ажлыг орон нутагт бэлтгэлийг ханган зохион байгуулах ажлаа чиглүүлж Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Сэлэнгэ аймгийн салбар комисст хуулийн нэмэлт өөрчлөлт хэрэгжиж эхэлсэнээс хойш Хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан нөхөх олговорт хамрагдан Шүүхэд хандан шүүхийн шийдвэр ирүүлсэн 28 нэхэмжлэгч байна. Үүнээс тайлант онд 3 иргэнд 120 000 000 (нэг зуун хорин сая) төгрөгийн нөхөх олговрыг олгуулан ажиллалаа.
	16.1.4	Аймгийн ИТХ-ын хяналт шалгалтын ажил	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулах	Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилт, аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Монгол Улсын Засгийн газрын болон аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгах, 6 чиглэлээр зохион байгуулах	8.0	2.8	Аймгийн ИТХ-ын 2021 оны ажлын төлөвлөгөөнд 8 чиглэлээр хяналт шалгалтын ажлыг явуулахаар төлөвлөнөөс хяналт шалгалт 4 удаа хийгдлээ. Төлөвлөгөө тасарсан шалтгаан нь Ковид-19 цар тахал, малын гоц халдварт шүлхий өвчинтэй холбоотойгоор УОК-ийн өгсөн чиглэлийн дагуу хал хорио тогтоосны улмаас төлөвлөгөөт зарим ажил хойшлогдсон. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид бүрэн бүрэлдэхүүнээрээ Түвшин, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар суманд ажиллаж хууль тогтоомж, хурлын шийдвэрийн хэрэгжилт, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаж заавар зөвлөгөө өгч, зарим сумдад хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг гаргуулан ажиллалаа.
	16.2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага			42,448.9	34,293.2	
	16.2.1	Аймгийн эдийн засгийн, нийгмийн чадавхыг бэхжүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд, шударга, шуурхай хүргэж ил тод байдалд шинэчлэл хийж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн үнэлэмжийг дээшлүүлнэ	Төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамж дээшилнэ.	Сэлэнгэ аймаг нь 2021 оны шударга байдлын ерөнхий үнэлгээгээр 76.3 оноо буюу улсын дундажаас дээгүүр үнэлэгдсэн байна. Шударга байдлын үнэлгээг 2019 онтой харьцуулахад Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын үнэлгээ нь 1.8 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.	18,059.7	16,177.7	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутагт хамааралтай зорилт, арга хэмжээнүүдийг аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж, жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нарийвчлан төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний Сэлэнгэ аймагт хамааралтай нийт 94 зорилтын 185 арга хэмжээг хяналтаар авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Сэлэнгэ аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг нийт 2022 арга хэмжээтэйгээр боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 14 дүгээр тогтоолоор батлуулсан хэрэгжилтийг ханган ажилласан. Тус бодлогын баримт бичигт Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сэлэнгэ аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилт, арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлсэн. Тус бодлогын баримт бичгийн хэрэгжилт 2021 оны жилийн эцсийн байдлаар 80.0 хувьтайгаар дүгнэгдсэн. Төрийн үйлчилгээг шажим операторын горимоор үзүүлэх үйлчилгээг 2020 онд 1 шатлалт 54 үйлчилгээг лавлагааг үзүүлж байсан бол 2021 онд 2 шатлалт үйлчилгээг аймгийн хэмжээнд 15 байгууллагын 73 нэр төрлийн 269 үйлчилгээ болгон нэмэгдүүлсэн.
	16.2.2	Байгалийн гамшиг үр дагаврыг арилгах, халдварт өвчин түүний тархалтыг зогсооно. Иргэд олон нийтийн өргөдөл, хүсэлтийн дагуу тусламж дэмжлэг үзүүлнэ. Спорт, урлагийн амжилтыг урамшуулна.	Нөөц хөрөнгө журмын дагуу төлөвлөгдсөн зардалд зохистой зарцуулагдана	2020 онд аймгийн Засаг даргын 74 захирамжаар 374.8 сая төгрөгийн зардалыг нөөц хөрөнгөөс зарцуулсан байна.	1,645.1	1,442.9	Тайлант онд Ковид-19 өвчлөлтэй холбоотойгоор бараа материалын нөөц бүрдүүлэх, албан хаагчдын урамшуулалт, 4 замын постын зардал, тусгаарлах байр шинээр нээж тохижуулах зэрэгт 22 захирамжаар нийт 665.5 сая төгрөг, гал түймэр, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх зардалд 3 захирамжаар 61.0 сая төгрөг, малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх зардалд 5 захирамжаар 103.9 сая төгрөг, урлаг спортын арга хэмжээнд 12 захирамжаар 66.0 сая төгрөг, буцалтгүй тусламж, гэр худалдан авахад 27 захирамжаар 28.1 сая төгрөг, жуул бичиг, ном, сэтгүүл хөвлүүлэх, цэргийн тоо бүртгэл, цэрэг татлага, ХАБЭАН зардал, хэвлэл мэдээллийн байгууллага, хурал, аян зохион байгуулах арга хэмжээ зэрэгт 79 захирамжаар 465.7 сая төгрөг зарцуулсан.
	16.2.3	Байгаль орчны чиглэлийн гэмт хэргийг арилгах, ойн нөхөн сэргээлтийг чанартай гүйцэтгэж, хортон шавхтай тэмцэх ажлыг эрчимжүүлнэ. Иргэдийн байгаль орчинтой харилцах мэдлэгийг дээшлүүлнэ.	Ойжуулалтын хэмжээ нэмэгдэнэ	Байгаль орчны чиглэлийн гэмт хэргийг бууруулж, ойн нөхөн сэргээлтийг чанартай гүйцэтгэж, хортон шавхтай тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.	572.6	552.0	Ерөө сумын Бугант тосгоны Ундны усны эх үүсвэрүүдийг хашиж хамгаалах, гол шугамыг засварлах ажлыг "Сэлэнгэ-Ундрам ХХК гүйцэтгэж байнгын ашиглалтад оруулан хүлээлгэж өгч, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалаас 45.0 сая төгрөгийг зарцуулсан. Ерөө сумын Бугант тосгоны Бугант гол, Алтанбулаг сумын Хиагт гол, Цагааннуур сумын Сэлэнгэ мөрний Бүдүүний гүүр, Сүхбаатар сумын Баян хээрийн голын эвэр дарга голын онцгой хамгааралтын бүсийг тэмдэглэх ажилыг эхлээд хийж.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	16.2.4	Мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг үйлчилгээний чанар, хүртээмж малын халдварт өвчний статистик бүртгэлд үндэслэн олгоно.	Мал эмнэлгийн үйлчилгээ сайжирна	45 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 316.8 сая төгрөгийн санхүүжилтийг олголоо.	319.5	316.8	2021 онд Засгийн газрын 225 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар халдварт өвчнөөс сэргийлэх 5 төрлийн 42,3 сая төгрөгийн вакцин орлогод авч хуваарийн дагуу МЭҮНэгжүүдэд олгосон. Мал эмнэлгийн үйлчилгээний 45 нэгжүүдэд орон нутгийн 5 төрлийн вакцин тарьсан тарилгын үйлчилгээний хөлсийг гүйцэтгэн дээр үндэслэн хянаж баталгаажуулан 172,8 сая төгрөгийг олгосон. Цусны шинжилгээний дээж авах, сорил тавих үйлчилгээний хөлсөнд 10,8 сая төгрөгийг 42 МЭҮНэгжид, үхэр сүрэгт халдварт, арга халдварт өвчнийг илрүүлэх оношлох тандалт шинжилгээний дээж авах үйлчилгээний хөлсөнд 4,8 сая төгрөгийг 35 хүнд олгосон. Цус авах хуруу шил, зүү, зүү баригч болон лабораторийн шинжилгээнд хэрэглэгдэх цомог, оношлуур, хэрэглэгдэхүүний
	16.2.5	Замын сан	Зам засварын ажил болон шинээр зам барих ажлыг хийж гүйцэтгэнэ.	Сумдын зам засварын ажилд 515.9 сая төгрөгийг зарцуулсан.	553.5	515.9	Ерөө, Мандал сумдад 3,8 км хатуу хучилттай зам тавьж, замын зорчих хэсгийн уртын хэмжээг нэмэгдүүлсэн. Цагааннуур сумын төв доторх 2,53 км хатуу хучилттай замын үргэлжлэл 100 м зам шинээр тавих ажил 20 хувьтай байна. 17 суманд зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлгийн ажлыг хийх эрхийг суманд нь шилжүүлж, ажил хийгдэж дууссан.
	16.2.6	Хот тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаа	Орчны бохирдлыг бууруулсан байна.	Сүхбаатар, Сайхан, Мандал сумдад ОНХС-аас 141.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	1,001.3	968.4	Хот тохижилтын газрыг өмчийн хэлбэрийг өөрчлөн ОНӨААТҮГ болгон ажиллуулж байгаа. ОНХС-аас хур хог хаягдал, орчны бохирдлыг цэвэрлэх, төвлөрсөн хогийн цэгийн устгалын арга хэмжээний зардлыг Сүхбаатар суманд 25.2, Мандал суманд 77.3, Сайхан суманд 38.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож ажиллалаа. "Хогоо мөнгө босго" арга хэмжээг аймгийн хэмжээнд өрнүүлэн хуванцар хаягдал цуглуулан худалдан авч преслэн дахин боловсруулах ажлыг эхлүүлж, аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулах барих ажлын явц 70 хувьтай хийгдэж, нийт хог хаягдлын 30 хувийг булан устгаж байна.
	16.2.7	Сүхбаатар сумын гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, гэрэлтүүлгийн асаах цагийн хуваарийг чанд мөрдүүлж, иргэд олон нийтийн ая тухтай, аюулгүй орчныг бүрдүүлнэ.	Гэрэлтүүлгийн тоо нэмэгдэнэ	Иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.	80.0	80.0	Бүгд Найрамдах Австри улс болон Монгол Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд хэрэгжих буй "Дэд бүтцийн Сэлэнгэ төсөл"-д Сүхбаатар, Мандал, Сайхан сумдын алслагдсан баг, хороодын гэр хорооллын гудамж, зам, талбайн 1300 ширхэг шон бүхий орчин үеийн гэрэлтүүлэг Ерөө, Мандал, Сайхан, Жавхлант, Сүхбаатар сумын 2, 3-р багт 1 тэрбум 256 сая төгрөгийн гудамж, талбайн гэрэлтүүлгийг ашиглалтад оруулсан.
	16.2.8	Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмадуудын нийтийн тэвэрээр зорчиход хөнгөлөлт үзүүлнэ.	Нийтийн тэвэрийн зорчигч хөнгөлөлт эдэлнэ	Сүхбаатар суман дахь хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настуудын нийтийн тэвэрээр үнэ төлбөргүй зорчдог.	50.5	50.5	Сүхбаатар суман дахь хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настуудын нийтийн тэвэрээр үнэ төлбөргүй зорчдог. Сүхбаатар хөгжил тохижилт ОНӨААТҮГ-т түлш шатахуун, сэлбэг хэрэгсэл, тэвэрийн хөлсөнд 50.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлээ.
	16.2.9	Аймгийн орон нутгийн өмчийн газар	Орон нутгийн өмчит байгууллагуудад үйлчилгээ үзүүлнэ. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг чанартай зохион байгуулна.	"Сэлэнгэ аймгийн төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-уудыг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	146.4	146.2	"Сэлэнгэ аймгийн төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-уудыг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь хэсэгт заасны дагуу Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 5 удаагийн хурлаар орон нутгийн өмчит байгууллагуудын илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг хэлэлцүүлж 10 заалт бүхий 10 тогтоол гаргуулан орон нутгийн өмч хөрөнгийн ашиглалтыг сайжруулж ажилласан. Сүхбаатар сумын 6 дугаар багт байрлах Халуун усны барилга, газар эзэмших эрхийн 000323535 дугаар бүхий гэрчилгээтэй газрын хамт нээлттэй дуудлагын худалдаагаар худалдаж өр төлбөрийг барагдуулахыг зөвшөөрөх тухай тогтоолын төслийг холбогдох хууль журмын дагуу боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлаар оруулахаар бэлтгэсэн.
	16.2.10	Ахмад настны амралт, чөлөөт цагийн клуб, эмчилгээ, сувилгааны төв, ахмадын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	Ахмадын хороодын үйл ажиллагаа сайжирна	Ахмад настуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллалаа.	82.2	82.2	2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 250,0 сая төгрөгөөр Хуримын ордны "Аймгийн ёслол хүндэтгэлийн өргөө" болгон засварлах ажлыг "Танан цамхаг" ХХК-иар гүйцэтгүүлж, барилгын ажил бүрэн дуусаж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Аймгийн ахмадын холбооноос тавьсан хүсэлтийн дагуу Сэлэнгэ аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүд 80,0 сая төгрөг шийдвэрлэн нэмэлт ажлуудыг тус байранд хийж гүйцэтгэсэн. Мандал суманд "Ахмадын төвийн барилга" ажлын гүйцэтгэгчээр "Мэргэн дэнэн" ХХК шалгарч барилгын ажил 45 хувийн гүйцэтгэлтэй байна. "Дасгалаа хийж дархлаагаа дэмжье" сумдын ахмадуудын дунд зохион байгуулагдсан аянд 8 сумын ахмадууд оролцсон. Ахмад настуудыг ахмадын амралт сувилал, (Ковид-19) цар талхын улмаас зохион байгуулаагүй. Зөвлөгөө дэмжлэг шаардлагатай газруудад 12 ахмад мэргэжилтнүүдээс бүрдсэн зөвлөн туслах багийн ажлыг зохион байгуулж, 9.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт 8 ахмад настныг хамрууллаа.
	16.2.11	Байгаль орчны газар	Хүрээлэн буй орчны зохистой удирдлага хангагдана.	Сумдын байгаль орчны байцаагч нартай хурдан шуурхай ажиллахыг нөхцөлийг бүрдүүлж, байгаль орчны эсрэг хийгдэх гэмт хэргийн гаралтыг бууруулан ажиллаж байна.	710.1	670.9	Байгаль орчны холбогдох хууль, журмын хэрэгжилтийг ханган ажиллаж, байгалийн тэнцвэрт байдлыг хадгалж, зохистой ашиглах, нөхөн сэргээх боломж бүрдүүлэх зорилгоор сумдын байгаль орчны байцаагч нартай хурдан шуурхай ажиллахыг нөхцөлийг бүрдүүлж, байгаль орчны эсрэг хийгдэх гэмт хэргийн гаралтыг бууруулан ажиллаж байна.
	16.2.12	Сум дундын ойн ани	Ойн санг зориулалтын дагуу ашиглаж, нөхөн сэргээж, хамгаалсан байна.	Ойн нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэжээ.	351.0	307.6	Ерөө, Мандал, Цагааннуур, Баруунбүрэн, Сүхбаатар сумдын ойн ангиуд нь ойн санг хариуцан ойг нөхөн сэргээх, хамгаалах ашиглах үйл ажиллагааг зохицуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд ойн сангийн талбай 1931.2 мянган га, үүнээс ойгоор бүрхэгдсэн талбай 1441.0 мянган га, байгалийн ой 1397.4 мянган га, ойгоор бүрхэгдээгүй ойн талбай 406.6 мянган га буюу 43,6 хувийг эзэлж байна. Сибирь хуш модны үрийг сумын Ойн анги 1.5 га талбайд, Ерөөний бүсийн сум дундын Ойн анги 5 га талбайд тус тус мод үржүүлгийн газруудаа тарьж, ургуулсан. 2021 онд төв, суурин газрын ногоон байгууламжид 56240 ширхэг мод, бут, сөөг, ойн сангийн 1497 га талбайд ойжуулалт, ойн зурвасын ажил хийж хавар, намар нийт 3,7 сая ширхэг мод тарьсан.
	16.2.13	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг ил тодоор зохион байгуулна.	6.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдэнэ.	ОНХО-аар 1.5 тэрбум, ОНХС-аар 3.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэлийг санхүүжүүлж ажиллалаа.	18,552.3	12,731.8	Орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгө оруулалтаар дараах ажлыг хийж гүйцэтгэсэн: 2021 оны Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд 24.4 тэрбум төгрөгийн 99 ажил, арга хэмжээ хэрэгжсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Нэгдсэн эмнэлэг, Сүхбаатар сумын 1 дүгээр багийн өрхийн эмнэлгийн засварын ажлыг 125,0 сая төгрөгөөр хийж ашиглалтад оруулж, эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, коронавирсын тархалтыг хүмий, зогсоох ажиллагаанд шаардлагатай оношлуур, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад 421,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	16.2.14	Олон нийтийн оролцоотой үйл ажиллагааг дэмжиж, аймгийн зорилтот бүлгийн айл өрх, иргэдийн амьжиргааг дээшлүүлнэ.	Халамжийн үйлчилгээ зорилтот бүлэгт хүрнэ	Нийгмийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай 28 бүлгийн 56 өрхөд амьжиргааг нь дээшлүүлэх орлогын эх үүсвэртэй болоход нь төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар дэмжлэг үзүүлж 22.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон	140.5	66.4	"Нийгмийн халамжийн нэгдсэн систем"-ийг нэвтрүүлсэн. Энэхүү системийг нэвтрүүлснээр төрийн байгууллагууд болон иргэдтэй цахимаар мэдээлэл солилцож нийт 66665 иргэнд 62.0 тэрбум төгрөг зарцууллаа. Нийгмийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай 28 бүлгийн 56 өрхөд амьжиргааг нь дээшлүүлэх орлогын эх үүсвэртэй болоход нь төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар дэмжлэг үзүүлж 22.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон
	16.2.15	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн ил тод байдлыг хангаж, төрийн байгууллагуудын дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулна.	Төсвийн ил тод байдал хангагдана.	Аймаг, сумын ТЭЗахирагч нар нь 2020 онд шилэн дансанд нийт 2683 мэдээлэл байршуулахаас 99%-тай мэдээлэл байршуулсан.	132.4	132.2	Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид төр төсвийн 197 байгууллага, ОНГААТҮГ 14, төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хуль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага нэгж 15, мал эмнэлэг 45, хүнсний эрхийн бичгээр зорилтот бүлгийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх 41 аж ахуй нэгж нийт 311 аж ахуй хамрагдаж, шилэн дансны цахим хуудсанд албан ёсны нэр хаягтай мэдээлэгдсэн. Монгол Улсын Газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдан мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын дагуу шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулах зорилгоор Сант, Орхон, Жавхлантай, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Хушаат, Баянгол, Шаамар сумдын 59 төсөвт байгууллагын шилэн дансанд мэдээлэл байршуулалтад аудит хийсэн. Үүнээс 80 ба түүнээс доош хувьтай байгууллагууд Хушаат сумын ерөнхий боловсролын сургууль, Шаамар сумын Төсвийн ерөнхийлөн захирагч, Шаамар сумын эрүүл мэндийн төв зэрэг байгууллагын байгууллагын дарга эрхлэгч нарт албан бичиг хүргүүлэн төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангуулсан. Шилэн дансны мэдээлэл байршуулалтад хийсэн аудитаар 24 байгууллагын дарга нарт чиглэл хүргүүлж, мэдээллийг нөхөн байршуулж, мэдээлэл байршуулалт 98 хувьд хүрсэн.
	16.2.16	Мал амьтны халдварт өвчний тархаалтыг зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг	Малын халдварт өвчин буурна.	-	-	-	2021 онд аймгийн нийт малын тоо 1886,7 мянган толгой болж урьд оноос 204,2 мянган толгой буюу 12,1 хувийн өсөлттэй байна. Мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтрүүлэх ажлын төндөрийг 2 удаа зарласан боловч компаниудаас огт санал
	16.2.17	Газар тариалангийн бүс нутгийн хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор үүлэнд зориудаар нөлөөлнө.	Хур тунадасны хэмжээ нэмэгдэнэ	Цаг агаарын төлөв байдалд тогтмол задлан шинжилгээ хийж, зориудаар нөлөөлөх нөхцөл бүрдсэн тохиолдол бүрийг зохистой ашиглан ажиллалаа.	30.0	30.0	Аймгийн нутаг дэвсгэр дээр цаг агаарын үзэгдэлд зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн үед цаг уурын нуужин харах болон газрын генератор ашиглан утаа үүсгэн хур тунадас нэмэгдүүлж ажиллалаа. "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөгөө" боловсруулан хэрэгжүүлэх, цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх, мөндөр зайлуулах арга, техникийг судалж, туршиж ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. "Аймгийн хэмжээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллого хийх ажлын хүрээнд "Орчны бохирдлын эх үүсвэр, жор хаягдлын тооллогын мэдээллийн сан сэдэвт сургалт"-ыг аймгийн 17 сум, 6 тосгоны аж ахуйн нэгж, байгууллагын 73 иргэнийг хамруулсан. Агаарын бохирдлын жор уршиг, сөрөг нөлөөлөл талаарх сурталчилгааны видео контентыг аймаг болон сумдын цахим хуудсанд байршуулан сурталчилсан.
	16.2.18	Зөврийн ундны усны үнийн зөрүүний татаасыг ундны усны зөөвөрлөсөн хэмжээ, үйлчилгээний чанар, хэрэглэгчдийн үнэлгээнд үндэслэн олгоно.	Ундны усны хангамж сайжирна	Сэлэнгэ мөрний дагуу байрлах эх үүсвэрийн 5 гүний худагтай, хоногт 10400 м3 ус олборлох хүчин чадалтай.	21.7	21.7	Сүхбаатар сумын 309 үйлдвэр, ААНБ, орон сууцны 2398 айл өрх, гэр хорооллын 2520 айл өрхөд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. 358 аж ахуй нэгж, байгууллагатай усны гэрээг шинэчлэн байгуулж, ундны ус түгээх 14 худгийн ус түгээгчидтэй гэрээг шинэчлэн сунгалт хийж, нийт 2943 өрхийн 28.5 хувь буюу 840 өрх айл, аж ахуй нэгжийн 96 хувийг тоолууржуулсан.
16.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ				68,462.2	65,803.5	
	16.3.1	Сургуулийн өмнөх боловсрол	СӨБ-д 7914 хүүхэд, СӨБ-ын хувилбарт сургалтад 502 хүүхэд хамрагдана	Аймгийн хэмжээнд нийт 39 төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна.	17,442.6	16,286.3	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 82.5 хувьд хүрч /82.8/ өмнөх оньхоос 0.3 хувиар, цэцэрлэгийн хамран сургалт 78.9 хувь, /79.2/ өмнөх оньхоос 0.3 хувиар тус тус буурсан нь "COVID-19" цар тахал, томуу, томуу төст өвчин дэгдсэнтэй холбогдуулан танхимын сургалтад 3-5 настай, цахим сургалтад 2 настай хүүхдүүдийг хамрууллаа. 44 цэцэрлэгт нийт 291 бүлэгт 6612 хүүхэд хүмүүжиж, нэг багшид ногдох хүүхдийн тоо 23.6 болж, өмнөх оньхоос 0.4 хувиар буурсан нь "COVID-19" цар тахлын улмаас цэцэрлэгт шинээр хүүхэд нэмж бүртгэгдэжгүйтэй холбоотой. 2021 онд Сүхбаатар сумын 3 дугаар багт 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр ашиглалтад орлоо. 44 цэцэрлэг нь сүлжээний төхөөрөмж, шилэн кабелиар интернэтэд холбогдсон ба мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь авч, байнга холбоотой ажиллаж хэвшсэн.
	16.3.2	Ерөнхий боловсрол	Хүүхдэд ая тухтай орчин бүрдүүлж /хоол, байр/ үйлчилнэ.	Аймгийн хэмжээнд нийт 35 төрийн болон хувийн өмчийн сургууль сургалтын чанар үр дүнг дээшлүүлж, сурч боловсрох орчныг сайжруулан, чанартай хоолоор үйлчилж, дотуур байрны үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.	33,349.5	32,399.1	2021-2022 оны хичээлийн жилд төрийн өмчийн 34, төрийн бус өмчийн 1 сургуульд нийтдээ 21499 хүүхэд суралцаж, суурь боловсролын хамран сургалт 91.3%-тай байгааг өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад 1.9 хувиар хэснэсэн үзүүлэлттэй байгаа нь 5-р ангиас бага ангиас/ 6-р ангид давшин суралцсан сурагчийн тоо өмнөх оньхоос нэмэгдсэн байна. 35 сургуулийн бага ангийн 374 бүлэгт 10927 суралцагч суралцаж, нэг багшид ногдох хүүхдийн тоо 29.2 болж, өмнөх оньхоос 0.5-р буурсан нь бага ангийн мэргэжлийн багшийн хангалт нэмэгдэж, хавсарч ажиллах багшийн тоо багассантай холбоотой юм. Сургалтын үйл ажиллагаа танхимын бус хэлбэрт шилжсэний улмаас ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дунд бий болсон сурлагын хоцрогдлыг 3 жилд багтаан нөхөх, арилгах цогц арга хэмжээг 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж байна. Уг арга хэмжээний хүрээнд сурагчдын мэдлэг, чадварыг оношлох, үр дүнд тулгуурлан сургууль, багш нарт дэмжлэг үзүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор "Оношлох үнэлгээ"-г зохион байгуулж, 30 сургуулийн 2-12 дугаар ангийн 6576 суралцагчид хамрагдсан бөгөөд сургууль бүр сургалтын явцаа үнэлэх, суралцагчдын хоцрогдлын агуулгыг нарийвчлан тодорхойлж, үр дүнд суурилсан хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. 2021 онд Түшиг, Орхон суманд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байр шинээр ашиглалтад орлоо. Ерөнхий боловсролын 35 сургуулийн 33 нь танхимын бус цахим хэлбэрээр сургалт зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	16.3.3	Соёлын үйлчилгээ	Урлаг соёл, музей, номын сангаар үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлнэ.	Аймгийн хэмжээнд сумын соёлын төв, Сэлэнгийн долоо болон Мөнгөн хараа чуула, аймаг болон Мандал сумын номын сан, аймгийн Музей зэрэг нийт 25 соёлын байгууллагаар дамжуулан урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулж, иргэд олон нийтэд түгээн ажиллаж байна.	4,894.4	4,722.0	"Соёлын өвийг дээдлэн сэргээцгээе" аяныг зохион байгуулж, Монгол баатарлаг туульс "Жангар", "Эрийн сайн хан харангуй" туульсыг цувралаар 2787 иргэнд, ардын өв уламжлалыг сурталчлах, үлгэрээр хүүхдээ хүмүүжүүлэх арга зүйг эцэг эхчүүдэд уриалгах зорилготой "Домог хуучлах цаг" цахим уралдаан зохион байгуулж 2423 иргэнд хүргэсэн. "Монголын нууц товчоо" бүтээлийг 282 хоногийн турш цуврал болгон цахимаар хүргэж, "Монголын нууц товчоо"-той хамт селфи чөлөнөхийг зарлаж төр, хувийн хэвшлийн 12 байгууллага, 10,000 гаруй иргэдийг хамрууллаа. "Ном уншигч-Подкаст" ярилцлагыг "Үндэсний бичиг соёлын өдөр", "Агуу зүйл энгийнээс эхэлдэг", "Тогтмол явган алхалт хийх нь хүний эрүүл амьдрах үндэс юм" сэдвээр зохион байгуулж, монгол үйгүржин бичгийн аппликейшн, Номын сангийн уншлага, үйлчилгээ, эрүүл амьдралын хэв маягийн тухай зөвлөмжийг бэлтгэн 314 уншигчдад хүргэлээ. "Соёл урлаг-Хүний хөгжилд" аймгийн хөтөлбөрийн хүрээнд "Соёлын аялал жуулчлал, бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх эдийн засгийн эргэлтэд оруулах замаар хүний хөгжлийг дэмжих" зорилтыг дэвшүүлж хэрэгжилтийг ханган ажиллалаа. "Ардын хувьсгалын 100 жил", "Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жилийн ой"-д зориулан "Сэлэнгийн брэнд" гар урлал, бэлэг дурсгалын бүтээлийн уралдааныг зохион байгуулж, 60 нэр төрлийн бүтээл оролцлоо. Улсын хоршоологчдын зөвлөгөөн, "Цагаан эсгийний баяр", NOMAD NATURE CAMP-д "Жавхлантай Монгол өв соёл" аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулан зан үйлийн үзүүлбэр, язгуур урлагийн тоглолт, газрын биллэрд, үндэсний уламжлалт гар урлал, цагаан идээ, соёлын үйлдвэрлэлийн чиглэлээр үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Мэргэжлийн урлагийн байгууллагын 71.3 хувь, соёлын төвийн дарга нарын 85 хувь, номын санч нарын 65 хувь мэргэжлийн ажилтнууд байна. Цахимаар зохион байгуулсан 103 сургалтад 153 уран бүтээлч, соёлын ажилтнуудыг хамруулсан. Соёлын биет болон биет бус өвийн бүртгэл мэдээллийн санг шинэчилж, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 100 гаруй хүний бичлэгийг цахимаар нийтэд хүргэж, сурталчилсан. Мөн соёлын биет бус өв түүний өвлөн уламжлагчдын талаар 219 удаагийн сургалт, арга хэмжээ зохион байгуулж, мэдээлэл бэлтгэн 42207 иргэнд хүргэлээ. Соёл урлагийн байгууллагад ажиллагсдын 10 хувь мэргэжлийн сургуульд суралцаж байна. Мэргэшүүлэх богино хугацааны 103 удаагийн сургалтад 153 уран бүтээлч, соёлын ажилтныг хамрууллаа. Урлагийн боловсрол олгох олон талт арга хэмжээ, сургалт, нөлөөллийн 2 арга хэмжээг шинээр зохион байгууллаа.
	16.3.4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Хяналт сайжирч, урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээнд хамрагдагсдыг нэмэгдүүлж, өвчлөл эндэгдэл буурна.	Аймгийн Эрүүл мэндийн салбар нь 2021 онд Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, Сайхан сумын сум дундын эмнэлэг, сум тосгоны эрүүл мэндийн төв 20, өрхийн эрүүл мэндийн төв 5, үүдэн хувийн эмнэлэг 15, ортой хувийн эмнэлэг 7, эмийн сан 32, эм ханган нийлүүлэх байгууллага 1, эрүүл мэндийн төвийн эмийн сан 20, сувилал 3, зоонозын өвчин судлалын төв, хүүхдийн сувилал, хувийн лаборатори 2, ариутгалын газар 1, сувилахуйн төв 1 бусад эмнэлэг 5 нийт 118 нэгж, удирдах ажилтан 8, их эмч-247, эм зүйч, эм найруулагч-30, сувилагч-329, эмнэлгийн тусгай мэргэжилтэн-305, бусад ажилтан-362 нийт 1360 ажиллагсадтайгаар аймгийнхаа хүн амд анхан шатны болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.	10,842.3	10,511.9	Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн салбарын бүх шатны эмнэлгүүд ариун цэврийн байгууламжийг сайжруулан "Нүүхэн жорлонг халж чадсан анхны аймаг боллоо" Эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг бодит цагийн горимоор хүлээн авдаг болсон. Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг бодит цагийн горимоор хүлээн авдаг болсон. Аймгийн онцгой комиссын шийдвэрээр "COVID-19" цар тахлын халдварын дараах хяналт болон уушгины эмгэг илрүүлэх "Эрүүл амьдралын төлөө хамтдаа" үзлэг оношилгоог Хушаат, Хүдэр, Түшиг, Цагааннуур сумд, Дулаанхаан тосгонд зохион байгууллаа. Ковидоор өвдөөд эдгэсэн 1632 иргэн байгаагаас 1187 иргэдийг үзлэгт хамруулан эмчилгээ хяналтад авч зөвлөгөөг өгч эрүүлжилтийн хувь 82.0 байна. Сэлэнгэ аймгийн хэмжээнд 1241 иргэн хорт хавдраар өвчилж, хяналтад байгаа үүнээс 2021 онд шинээр 180 иргэн оношлогдож хавдрын эмчийн хяналтад орсон байна. Нийт батлагдсан хорт хавдрын 40 хувь элэгний хавдар байна. Орон нутгийн сэтгүүлчид болон ММЗ, Сэлэнгэ цахим телевизүүдээр дамжуулж хүн амд сургалт сурталчилгааг тогтмол хийж байна. 2021 оны байдлаар давхардсан тоогоор 126672 хүн амбулаторийн үзлэгийн цагийг "Е-Health" программаар захиалж үйлчлүүлсэн. Аймгийн хэмжээнд 55 эмийн санг Эрүүл мэндийн даатгалын цахим системд холбон иргэдэд цахимаар үйлчилж байна.
	16.3.5	Газрын харилцаа, кадастр	Аймгийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр тусгагчийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлнэ.	Газрын тухай хууль болон холбогдох хууль журмын биелэлтийг хангах, иргэдийн газар өмчлөх асуудлыг тухай бүр шийдвэрлэх, аймгийн хөгжлийн суурь болох хот төлөвлөлтийн суурийг бий болгох зорилго тавин ажиллаж байна.	575.3	574.4	Аймгийн 17 сумын 2021 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд нийт 139 зориулалтаар 5572 нэгж талбар бүхий 8817.8 га газрыг өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулахаар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 79 зориулалтаар 1241 нэгж талбар бүхий 882.96 га газрыг эзэмшүүлж, ашиглуулсан байна. Тариалангийн газрын тооллогын ажлын хүрээнд тэлсэн талбайн хэмжээг нэгж талбар тус бүрээр гаргаж, шинээр атар хягалсан болон газар дээр нь очих шаардлагатай талбайд хэзэрийн хэмжилт хийн 17 сумын 323087 га 4175 нэгж талбар бүхий тариалангийн талбай нэг бурийн кадастрын зураглалыг Спот, Ландсат, Сэнтинел хиймэл дагуулын мэдээнд суурилсан зургаан шинэчлэн тогтоолоо. Аймгийн хэмжээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг даган бий болсон үтрэм, бригадын төвийн газар эзэмших эрхийг баталгаажуулах ажлын хүрээнд Баруунбүрэн сумын 1, Баянгол сумын 2, Жавхлантай сумын 2, Мандал сумын 1, Орхон сумын 2, Сайхан сумын 2, Түшиг сумын 1, Цагааннуур сумын 7 нийт 18 нэгж талбарын эрх зүйн харилцааг үүсгэн газрын кадастрын мэдээллийн санд баталгаажуулан хаягжуулалтыг хийсэн. 2021 оны байдлаар Төрийн албан хаагчийн 120 айлын орон сууцны барилга, Дулаанхаан тосгоны сургуулийн ариун цэврийн байгууламжийн барилга, Сүхбаатар сумын 5-р багт бага зардалтай эрчим хүчний хэмнэлттэй 50 ортой цэцэрлэг, Сүхбаатар сумын 3-р багт 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Мандал суманд иргэн Жимсээгийн үйлчилгээний төвийн барилга, Мандал суманд иргэн Д.Хулангийн авто засварын төвийн барилга, аймгийн Татварын хэлтсийн барилгуудыг паспортжуулсан.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	16.3.6	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, төрөлж нутгаараа бахархах, түүх, ёс заншил, уламжлалт соёлоо дээдлэх, амьдралын арга ухаанд сургах замаар өрсөлдөх чадвартай, хөдөлмөрч, хүмүүнлэг иргэнийг төлөвшүүлнэ.	Аймгийн хэмжээнд 3 байгууллага үйл ажиллагаа явуулж, төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна.	661.5	645.9	"Оролцоод хөгжье" хүүхдийн оролцооны IX чуулганыг цахимаар зохион байгуулж, 34 сургуулийн төлөөлөл 150 суралч оролцож аймгийн Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүнд 3 чиглэлийн хүрээнд 25 санал санаачилгыг гардуулсан. Хүүхэд залуучуудад үндэсний өв, соёлыг сурталчлан таниулж, бахархан дуурайх, өвчлүүлэн уламжлуулах зорилготой "Ирээдүйн амжилтын эзэд" хүүхэд өв соёлыг түгээн дэлгэрүүлэх агуулга бүхий контентийг бэлтгэж, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчиллаа. "Угийн бичгээ хөтөлж-Ураг удмаа мэдэцгээ" 13 удаагийн сургалтыг зохион байгуулж, орон нутагт сургалч багш бэлтгэн, 452 гараах материал, гарын авлага тарааж, угийн бичиг хөтөлж олон нийтийн санаачилгыг өрнүүлэх эрчимжүүлэх талаар сум бүрд ажлын хэсэг байгуулж заавар, зөвлөгөө өгч өрхүүдэд багийн Засаг даргын албан мэдэгдэл хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна. 2021 онд 56 өрх шинээр угийн бичиг хөтөлж, угийн бичиг хөтөлгөө өрх 6468 болж нийт өрхийн 31.9 хувийг эзэлж байна. Сумууд өрхийн угийн бичиг хөтөлгөлийн талаар цахим бүртгэл үүсгэн иргэдэд нээлттэйгээр сурталчлан ажиллаж байна. Гэр бүлийн боловсрол олгох "Сайн авь" онлайн сургалт, цахим болон танхим хосолсон Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль хичээл, гэр бүлийн талаарх нийт 28 сургалт, 6 хэлэлцүүлэг зохион байгуулж, 2500 гаруй иргэдийг хамруулж, "Сэлэнгэ хүүхэд", "Сэлэнгэ Залуучуудын хөгжлийн төв", "Сэлэнгэ аймгийн сэтгэлзүйн зөвлөгөө үйлчилгээ" пэйж хуудсуудаар олон нийтэд хүргэлээ. Дэлхийн зөн Монгол олон Улсын байгууллагын "Сэлэнгэ Нэгдсэн хөтөлбөр"-тэй хамтран сумдын 849 өрхөд тус бүр 100,000 төгрөгийн тусламж үзүүлсэн ба зорилтот бүлгийн залуучуудад дэм болох тэдний төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор 9 удаагийн сайн үйлсийн яанг зарлаж, 245 өрхөд 27 сая төгрөгийн тусламж үзүүлж, "Гэр бүлийг дэмжих туршилт"-ын хөтөлбөрт хамрагдсан өрхийн 30 иргэнд "Гэр бүлийн баяр хөөр" 3 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Эцэг, эх нь хөл хорионд орсон эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа нийт 32 өрхийн 63 хүүхэд хүнс болон дулаан хувцас, ковидын тасагт хэвтэн эмчлүүлж байгаа 42 хүүхэд, 17 сум, 6 тосгоны нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн нарт амин дэм, витаминжуулалтын дэмжлэг үзүүлээ. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 17 сумын хамтарсан баг, иргэд олон нийтийн хандив тусламжаар зорилтот 397 өрхийн 884 хүүхэд хүнсний багц дэмжлэг, амин дэм, гар ариутгах санитол, амны хаалтын тусламж, 152 өрхөд түлээ, түлшний дэмжлэг үзүүлээ. "Хайраар дүрэн болц" аяныг 13 хүнсний дэлгүүр, талхны цехтэй хамтран зохион байгуулж, хүндрэлтэй нөхцөлд буй 80 өрхийн 300 хүүхэд хүнс, түлээ нүүрсний тусламж үзүүлээ.
	16.3.7	Нийтийн биеийн тамир	Нийтийн биеийн тамир, спортын хүний нөөц, дэд бүтцийг сайжруулж, үндэсний өв соёлыг уламжлуулан нийтийн хүртээл болгох, иргэдийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлнэ.	Аймгийн хэмжээнд Биеийн тамир спортын газар, 9 спортын цогцолбор, 19 спортын холбоод, 9 чийрэгжүүлэх фитнес клуб ажиллаж байна.	696.7	663.9	Аймгийн хэмжээнд Биеийн тамир спортын газар, 9 спортын цогцолбор, 19 спортын холбоод, 9 чийрэгжүүлэх фитнес клуб хамтран ажиллан нийт биеийн тамирын 27, цахим хэлбэрийн биеийн тамирын 2 арга хэмжээг зохион байгуулсан. "Covid-19" цар талхын улмаас улсын чанартай онлайн болон улсын аварга шалгаруулах 5 тэмцээнд 43 тамирчин оролцож 21 медаль хүртэж 2021 оны зэрэг цолд тодорхойлон хүргүүлснээр олон улсын хэмжээний мастер 1, спортын мастер 2, спортын дэд мастер 12, 1-р зэргийн тамирчин 141 төрөн гарсан. 2021 онд "Иргэдийн спортын наадам"-ыг Сагсан бөмбөг, Волейбол, орс таталт, өртөөт марафон төрлөөр зохион байгуулж нийт 14 сум 38 байгууллагын 1212 иргэнийг хамруулсан. Аймгийн хэмжээнд 2 жил тутамд "Бага олимп" спортын 10 төрлөөр өсвөр үеийнхний дунд тэмцээн зохион байгуулахаас Сагсан бөмбөг, чөлөөт бөх, жүдо, даамны төрлөөр зохион байгуулж нийт 2145 хүүхэд хамруулсан. Улсад зохион байгуулагдсан шатар, даамын тэмцээнд 6 тамирчныг оролцуулж, Мандал сумын тамирчин н.Анхбаяр даамын тэмцээнд тэргүүн байр, С.Сундуй шатрын тэмцээнд тэргүүн байранд шалгарч, Ази тивд хүүхэд хамруулсан. Иргэд зохион байрранд шалгарсан амжилтыг үзүүлээ. Алхалт, гүйлт гимнастрада, иог, эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн зэрэг үйл ажиллагааг сарын аян нийтийг хамарсан хэлбэрээр цахимаар явуулан алхалтын холбоо бүжгийн холбоо, дугуйн холбоо, биеийн тамирын арга хэмжээ 13, тэмцээн уралдаан 8 зохион байгуулан спортын 8 холбоо, 30 аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран үйл ажиллагааг зохион байгуулж явуулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн багийн спорт суугаа волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Мандал суманд зохион байгуулан 4 багийн 40 гаруй тамирчдыг хамрууллаа. Алтанбулаг суманд спортын цогцолбор ашиглалтад орж байгууламжийн үйл ажиллагааг хэвийн явуулах чиглэлээр арга зүйчтэй болгон, төсөв хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж хэвийн горимд шилжүүлэн ажлыг эхлүүлсэн.
17	Төв				108,663.8	96,225.6	
	#####	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа			393.7	374.4	
	17.1.1	Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч, хороо ажлын хэсгүүдэд үзүүлэх үйлчилгээ	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	92.4%	78.7	78.7	Аймгийн ИТХ нь 6 удаа хуралдаж 27 асуудал хэлэлцэн 32 тогтоол, Тэргүүлэгчдийн ээлжит хуралдааныг 11, ээлжит бус 6, нийт 17 удаа хуралдуулж, 90 асуудал хэлэлцэн, 70 тогтоол, 16 тэмдэглэл тус тус батлан гаргасан байна.
	17.1.2	Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албаны үйлчилгээ	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	97.6%	239.3	219.9	Аймгийн ИТХ-ын Ажлын алба нь аймгийн ИТХ-ын ажлын албаны стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 94.5% бийрүүлж гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 96.61 хувьтай байна.
	17.1.3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ: сургалт сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөний дагуу явагдаж үр дүнг бодитой тооцох	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	85.4%	75.7	75.7	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилт 88 хувьтай .2021 оны байдлаар аймгийн салбар зөвлөлөөс Цагдаа, хууль хяналтын байгууллагуудтай хамтран тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 3 удаагийн аян, 7 нэгдсэн арга хэмжээ, 17 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулан ажилласан.
	17.2	Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			55,609.2	46,020.9	
	17.2.1	Гүйцэтгэх засаглалын удирдлага, тэдгээрийн ажлын алба	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	98.0%	3,427.1	3,427.1	Аймгийн ЗДТГ-ын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 98%-тай гарсан байна.
	17.2.2	Засаг захиргааны түвшин хоорондын шилжүүлэг	Батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгосон байх	бүрэн олгосон	9,333.7	9,333.7	Аймгийн Засаг даргын А/767 тоот захирамжаар баталсан хуваарийн дагуу Сумын ОНХСанд олгох орлогын шилжүүлгийг бүрэн олгосон .
	17.2.3	Орон нутагт аймгаас олгох санхүүгийн дэмжлэг	Батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгосон байх	бүрэн олгосон	16,755.5	16,755.5	Аймгийн Засаг даргын А/21 тоот захирамжаар баталсан хуваарийн дагуу санхүүгийн дэмжлэгийг бүрэн олгосон .
	17.2.4	Орон нутгийн төсвийн нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ	Төлөвлөсөн зардлыг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байх	Төлөвлөсөн зардлыг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан	2,354.7	1,584.6	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилтийг тодотгон 2354.7 сая төгрөгөөр баталж, зарцуулалтыг журмын дагуу захирамжаар шийдвэрлэж, тайлагнасан байна.
	17.2.5	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтээр	20 арга хэмжээг төлөвлөн, гүйцэтгэлээр 678.0 сая зарцуулсан байна.	752.0	678.4	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд 20 арга хэмжээг төлөвлөн, гүйцэтгэлээр 678.0 сая зарцуулсан байна.
	17.2.6	Байгаль орчин аялал жуулчлалын газар	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	92.0%	524.3	524.3	2021 оны байгууллагын чиг үүргийн үзүүлэлтүүд, аймгийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, Шийдвэрийн хэрэгжилтийн жилийн эцсийн дүн 92 хувьтай гарсан байна.
	17.2.7	Ойжуулалт / сумдын /	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	98.0%	149.9	143.0	2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 98%-тай гарсан байна.
	17.2.8	Орон нутгийн өмчийн бодлого	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	92.0%	230.3	227.7	2021 оны байгууллагын чиг үүргийн үзүүлэлтүүд, аймгийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, Шийдвэрийн хэрэгжилтийн жилийн эцсийн дүн 92 хувьтай гарсан байна.
	17.2.9	Санхүүгийн дотоод хяналт	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	93.0%	163.7	160.9	2021 оны байгууллагын чиг үүргийн үзүүлэлтүүд, аймгийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, шийдвэрийн хэрэгжилтийн жилийн эцсийн дүн 93 хувьтай гарсан байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	17.2.10	Аймгийн ОНХСангийн хөрөнгө оруулалт	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	92.5%	7,225.2	6,684.5	Аймгийн ОНХСангийн хөрөнгийн эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний гүйцэтгэл 92.5 хувьтай гарсан.
	17.2.11	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага /сумдын /	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	85.5%	11,681.3	5,147.3	Сумдын 2021 оны жилийн эцсийн үйл ажиллагааны дүн 85.55 хувьтай гарсан байна.
	17.2.12	Хот тохижуулах үйл ажиллагаа	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	98.0%	585.8	566.0	2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 98%-тай гарсан байна.
	17.2.13	Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	Зорилтод бүлэгт олгоно. /98 хүн /	Зорилтод бүлгийн 53 хүнд олгосон	120.6	63.7	Зорилтод бүлгийн 53 хүнд олгосон
	17.2.14	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	Зорилтод бүлэгт олгоно. / 64 хүн/	Зорилтод бүлэгт 29.9 төгрөг олгов.	30.5	29.9	Зорилтод бүлэгт 29.9 төгрөг олгов.
	17.2.15	Сум хөгжүүлэх сангийн зарлага			3,832.9	2,127.6	
17.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ				52,660.8	49,830.3	
	17.3.1	Сургуулийн өмнөх боловсрол			12,535.7	10,911.7	
	17.3.2	Ерөнхий боловсрол			25,830.3	25,316.2	
	17.3.3	Монгол туургатан театрын уран бүтээлийн үйлчилгээ	32	92%	1417.7	1,382.84	2021 оны байгууллагын чиг үүргийн үзүүлэлтүүд, аймгийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, Шийдвэрийн хэрэгжилтийн жилийн эцсийн дүн 92 хувьтай гарсан байна. МТ Театрын уран бүтээлийн тоо 30-аар үйлчилгээ үзүүлсэн байна.
	17.3.4	Номын сангийн үйлчилгээ, мэдээллийн уншигч.	14000	100%	245.5	241.42	Номын сан нь нийт 34358 хүнд үйлчилгээ үзүүлсэн. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 100%.
	17.3.5	Музейн үзэмрээр дамжуулан танин мэдэхүйн мэдээллийг иргэд , хүүхэд залууст хүргэх	18000	14500	253.2	246.03	Музейн үзэмрээр дамжуулан танин мэдэхүйн мэдээллийг 14500 иргэд , хүүхэд залууст хүргэж ажилласан.
	17.3.6	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	Амбулаторийн үзлэгт хамрагдах иргэний тоо - 133917 Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах иргэний тоо - 72024 Дархлаажуулалтын хамрагдалтын хувь - 99.6%	Амбулаторийн үзлэгт хамрагдах иргэний тоо - 173323 Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах иргэний тоо - 108873 Дархлаажуулалтын хамрагдалтын хувь - 96.3%	10,383.2	9,862.3	Амбулаторийн үзлэгт хамрагдах иргэний тоо - 173323 Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах иргэний тоо - 108873 Дархлаажуулалтын хамрагдалтын хувь - 96.3%
	17.3.7	Өрхийн эрүүл мэндийн төвийн анхан шатны болон НЭМ-ийн тусламж үйлчилгээ.	Амбулаторийн үзлэгт хамрагдах иргэний тоо - 20700 Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах иргэний тоо - 15700 Дархлаажуулалтын хамрагдалтын хувь - 100% Гэрээт идэвхтэй хяналтын тоо -6500	Амбулаторийн үзлэгт хамрагдах иргэний тоо - 37763 Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах иргэний тоо - 29848 Дархлаажуулалтын хамрагдалтын хувь - 96.1% Гэрээт идэвхтэй хяналтын тоо -7819	436.8	436.8	Амбулаторийн үзлэгт хамрагдах иргэний тоо - 37763 Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах иргэний тоо - 29848 Дархлаажуулалтын хамрагдалтын хувь - 96.1% Гэрээт идэвхтэй хяналтын тоо -7819
	17.3.8	Нийтийн биеийн тамир	21000	23065	382.1	300.8	2021 онд төлөвлөгөөг давуулан биелүүлж ажилласан.
	17.3.9	Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	93.00%	514.0	474.2	2021 оны байгууллагын чиг үүргийн үзүүлэлтүүд, аймгийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, шийдвэрийн хэрэгжилтийн жилийн эцсийн дүн 93 хувьтай гарсан байна.
	17.3.10	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	94.50%	662.3	658.0	2021 оны байгууллагын чиг үүргийн үзүүлэлтүүд, аймгийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, шийдвэрийн хэрэгжилтийн жилийн эцсийн дүн 94.5 хувьтай гарсан байна.
18	УВС				90,215.7	85,512.1	
	18.1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа			2,300.2	2,216.1	
	18.1.1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	МУ-ын ЗНДНТУТХ, болон Төсвийн тухай хуульд заасан ИТХ-ын чиг үүргийг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлнэ.	Хуралдаан төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй зохион байгуулагдсан байна.	2,300.2	2,216.1	МУЗНДНТУТХууль болон Төсвийн тухай хуульд заасан ИТХ-ын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ИТХ-ын хуралдаан 4 удаа, ИТХ-ын Таргуулагчдийн хуралдаан 7 удаа үр дүнтэй хуулийн хугацаандаа зохион байгуулагдсан ба хуралдаанаас гарсан шийдвэр, тогтоолын хэрэгжилтийг хангуулан, ИТХ-ын төлөөлөгчид, ИТХ-ын байгууллагын ажилтнуудад мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулж, ГХУСЗөвлөл тогтмол үйл ажиллагаагаа явуулж ажиллаж байна.
	18.2	Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			30,684.5	27,511.5	
	18.2.1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	ИТХ, Засаг даргад үзүүлэх бодлогын зөвлөгөө, аймгийн эдийн засаг, нийгмийн бодлого, хууль тогтоомж, хөтөлбөр, төсөл, зорилтын хэрэгжүүлэлт, зохицуулалтыг хангана.	Хууль тогтоомжийн хүрээнд, төлөвлөсөн хугацаандаа чанартай хийгдсэн байна.	19,471.6	18,160.1	Аймгийн Эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 238 зорилтыг дэвшүүлэн хэрэгжилтийг зохион байгуулж, 90.0% буюу үр дүнтэй хэрэгжсэн, улсын болон орон нутгийн төсөл, хөтөлбөр, гадаадын төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэн ард иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаа. Нутгийн захиргааны байгууллагууд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хариуцуулсан чиг үүргийн талаар тус бүр хувийн хэрэг нээж, хэрэгжүүлэх төлөвлөгөө, зохиосон ажил, үр дүнг тусган баяжуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тайлант онд 110 тогтоол, шийдвэрийн 208 заалтаас 100 хувийн хэрэгжилттэй 147, хэрэгжих шатанд буюу 70 хувийн хэрэгжилттэй 39 заалт, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн хэрэгжилттэй 10, хэрэгжих хугацаа болоогүй 12 заалт байгааг журмын дагуу үнэлэхэд биелэлтийн дундаж 90.4 хувиар үнэлэгдлээ. Засаг даргын нөөц хөрөнгийг Сангийн сайдын баталсан журмын дагуу, ИТХ-аар баталсан төлөвлөлтийн хэмжээнд зарцуулсан байна.
	18.2.2	Орон нутгийн нөөц хөрөнгө	Нөөц хөрөнгийг захиран зарцуулах журам хэрэгжсэн байна.	ИТХ-аас баталсан төлөвлөлтийн хэмжээнд зарцуулагдсан байна.	433.1	433.1	
	18.2.3	Нийгмийн халамжийн үйлчилгээ	Нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай зохион байгуулна.	Халамж, үйлчилгээний 2 төрлийн үйл ажиллагааг иргэдэд хууль тогтоомжийн хүрээнд, хугацаанд нь зохион байгуулж, хүргэсэн байна.	145.1	91.1	Нийгмийн халамжийн 2 төрлийн үйлчилгээг иргэдэд хууль тогтоомжийн хүрээнд хугацаанд нь зохион байгуулж, хүргэсэн байна.
	18.2.4	Орон нутгийн өмчийн газар	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль болон холбогдох хууль, тогтоол, журам хэрэгжсэн байна.	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг чанартай зохион байгуулна.	176.3	164.8	2021 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ажил 50, бараа 16, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр бараа 1, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ажил 2, бараа 1, Замын сангийн хөрөнгө оруулалтаар 2 ажил, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар ажил 13, бараа 10 нийт 42,446.9 сая төгрөгийн үнийн дүн бүхий 159 бараа, ажил, үйлчилгээ "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн хүрээнд 100% зохион байгуулж, тайланг улирал бүр Сангийн яаманд хүргүүлсэн байна.
	18.2.5	Аймгийн ахмадын хороо	Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль хэрэгжсэн байна.	Аймаг, сумын ахмадуудад дэмжлэг үзүүлнэ.	42.7	33.1	Ахмад настны тухай хуулийн дагуу аймгийн ахмадын хорооны тогтмол зардал, сумдын ахмадуудад нэг удаагийн урамшуулал зэргийг санхүүжүүлсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
18.2.6	Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ	Хувийн мал эмнэлэг үржлийн нэгжтэй гэрээ байгуулан төлөвлөгөөт малыг 100 хувь хамруулж, халдварт өвчний гаралт буурсан байна.	Халдварт өвчнөөс сэргийлэх тарилга үйлчилгээнд малыг 100 хувь хамруулна.	569.5	569.5	Хувийн мал эмнэлэг үржлийн нэгжтэй гэрээ байгуулан малын халдварт өвчнөөс сэргийлэх 8 төрлийн тарилга үйлчилгээнд 1920.5 мянган малыг хамруулсан байна. Мал эмнэлгийн үйлчилгээг дэмжин, халдварт, паразит өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малын хамралтыг 46%-д хүргэж 2021 онд аймгийн хэмжээнд малын халдварт өвчний 216 тохиолдол гарч 1773 толгой мал өвчилсөн байна.	
18.2.7	Орон нутгийн замын сан	Орон нутгийн авто замын нөхцөл байдал сайжирна.	Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг автозамын санд 100 хувь төвлөрүүлнэ.	345.0	344.9	Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр аймгийн ЗДТГ-ын гаднах автозогсоолыг шинэчлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлсэн. Ажил 2022 онд үргэлжлэн хийгдэх ба олгодоогүй санхүүжилт 197.2 сая төгрөгийг ТЕЗ-ийн барьцаа дансанд байршуулсан.	
18.2.8	Санхүүгийн хяналт, аудитын алба	Санхүүгийн болон үйл ажиллагааны дотоод хяналт сайжирна.	Төлөвлөгдсөн хяналт үр дүнтэй хийгдсэн байна.	169.5	167.8	2021 онд төлөвлөгөөт санхүүгийн хяналт, шалгалтыг 13 сумын ИТХурал, Соёлын төвөөс бусад 66 төсвийн байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийж дүнг Аймгийн дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж, ДАХорооны 30 тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна. Санхүүгийн хяналт шалгалтаар 15 актаар 35.387.289 төгрөгийн зөрчлийн акт тогтоож, 305 үүрэг зөвлөмж өгч ажилласан. Тавьсан актын барагдуулалт 100 хувьтай, өгсөн үүрэг зөвлөмжийн биелэлт 98,4 хувьтай байна. Мөн 14 төсвийн байгууллагад Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2, 2.2.1 дэх заалтын хэрэгжилтийн байдал, Түргэн Малчин Өндөрхангай Наранбулаг Баруунтуруун сумдад Газрын төлбөрийн орлого бүрдүүлэлтэд хэсэгчилсэн буюу хязгаарлагдмал аудит хийж дүнг аймгийн дотоод аудитын хорооны хуралдаанаар хэлэлцүүлээ. Аймгийн ДАХорооны 3 удаагийн хуралдаанаар 2 тогтоол хэлэлцүүлэн батлуулж, 7 зөвлөмж үүрэг өгч тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.	
18.2.9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалах	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Үйл ажиллагааны тогтмол зардал бүрэн олгогдоно.	31.9	31.9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалах зориулагдсан байрны гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус, үйлчлэгчийн цалингийн зардлуудыг тус тус бүрэн санхүүжүүлсэн.	
18.2.10	Байгаль орчныг хамгаалах	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Байгууллагын үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэн байна.	615.8	615.6	Байгаль орчныг хамгаалах үндсэн чиглэлийн үйл ажиллагаануудыг 2021 оны төлөвлөсний дагуу хуулийн хүрээнд зохион байгуулан бүрэн хэрэгжүүлж, албан хаагчдынхаа мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтуудыг амжилттай зохион байгуулсан байна.	
18.2.11	Байгаль хамгаалах сан	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Сангийн үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэн байна.	499.0	462.7	Хуулийн дагуу аймгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр нөхөн сэргээлт хийх, хог хаягдлын менежмент хийх, ногоон байгууламж, ундны усны чанарын шинжилгээ хийж мэдээллийн сан үүсгэх, цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадсыг нэмэгдүүлэх зэрэг 9 төрлийн ажил, арга хэмжээг зохион байгууллаа. Орон нутгийн музейн үзэгчдийн тоо 6500, шинэ үзмэрийн тоо 11, үзэсгэлэнгийн тоо 4 орлогын төлөвлөгөө 33.5 хувийн биелэлтэй.	
18.2.12	Соёлын үйлчилгээ	Иргэдэд хүргэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Урлаг соёл, музей, номын сангаар үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлнэ.	3,718.5	3,648.7	Сумдын зохион байгуулсан соёл урлагийн арга хэмжээ 1092, зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан тоо 106791, дугуйланд хамрагдсан тоо 1832, жилийн орлогын төлөвлөгөө 30,000.0 мянган төгрөг ба орлогын гүйцэтгэл 19.0 хувийн биелэлтэй. ХДТ-ын үзэгчдийн тоо 7343, орлогын үйлчилгээ 4220.0 мянган төгрөг ба 24 хувийн биелэлтэй. Орон нутгийн номын сан уншигчдын тоо 16464, шинээр авсан ном 521, явуулын номын сангийн үйлчилгээ 164 хүнд 752 номоор үйлчилсэн байна.	
18.2.13	Биеийн тамир, спорт	Биеийн тамирын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.	Иргэд, хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх, спортын олон талт арга хэмжээг зохион байгуулж, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.	329.6	329.6	Аймгийн хэмжээнд өсвөр болон насанд хүрэгчид, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд 26 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 5032 хүн хамрагдсан.	
18.2.14	Гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Төлөвлөгдсөн ажлууд бүрэн хэрэгжинэ.	900.0	890.0	Төлөвлөгдсөн ажлууд бүрэн хэрэгжсэн байна.	
18.2.15	Орон нутгийн хөрөнгө оруулалт	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Төлөвлөгдсөн үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэн байна.	789.8	642.0	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх арга хэмжээг орон нутагт нэн тэргүүнд шаардлагатай ажлуудыг эрэмбэлэн 23 ажил, арга хэмжээг төлөвлөснийг хуулийн хүрээнд бүрэн хэрэгжүүлсэн байна.	
18.2.16	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	ТЗШ-ийн байгууллагуудын байр ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангах	Хэвийн үйл ажиллагааг хангана.	2,447.1	926.7	ТЗШ-ийн байгууллагуудын байр ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаа.	
18.2.17	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	ТЗШ-ийн байгууллагуудын байр ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангах	Хэвийн үйл ажиллагааг хангана.			ТЗШ-ийн байгууллагуудын байр ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаа.	
18.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			57,231.1	55,784.5		
18.3.1	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	Хамрагдалтын тоог нэмэгдүүлж, сурах орчныг сайжруулан, авьяас чадварыг хөгжүүлнэ.	34 цэцэрлэгт өдрийн ангид 5567 хүүхэд, хувилбарт сургалтаар 1980 хүүхэд СӨБ-ын үйлчилгээ үзүүлнэ.	12,260.1	11,664.5	34 цэцэрлэгт 2020-2021 оны хичээлийн жилд 2-5 насны 7547 хүүхдээс 5567 хүүхэд цэцэрлэг 1980 хувилбарт сургалтаар СӨБ-д хамрагдлаа. Хамран сургалтын хувь /бохир жин/ 93.0 хувь Хүүхдийн тоо 7547 нийт зарцуулсан төсөв 7149.5 сая, төгрөг 100 хувийн биелэлтэй.	
18.3.2	Ерөнхий боловсролын үйлчилгээ	Сургалтын чанар үр дүнг дээшлүүлж, сурч боловсрох орчныг сайжруулан, чанартай хоолоор үйлчилнэ.	29 сургуульд өдрөөр 17650 хүүхэд, АББ-оор 722 хүүхэд сургалтын үйлчилгээ үзүүлж, 24 сургуулийн дотуур байранд амьдрах 3074 хүүхэд ая тухай орчин бүрдүүлж /хоол, байр/ үйлчилнэ.	33,495.5	32,975.2	30-н сургуульд суурь боловсролын хамран сургалтын хувь 93.6 өдрөөр суралцагчдын тоо 18528, АББ-оор 402 хүүхэд, дотуур байранд хамрагдах хүүхдийн тоо 3031, удийн цай хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо 9215, элсэлтийн ерөнхий шалгалтын аймгийн дундаж оноо 509.9, 100 хувийн биелэлтэй.	
18.3.3	Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тасралтгүй, чанартай хүртээмжтэй үзүүлэх боломж бүрдэнэ	Хяналт сайжирч, урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээнд хамрагдагсдыг нэмэгдүүлж, өвчлөл эндэгдэл буурна.	10,537.2	10,256.2	Нярай, хүүхэд, өсвөр үеийн тусламж үйлчилгээ нь 5 хүртэлх насны хүүхэд гэрийн эргэлт болон эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж, 0-19 насны 4091 хүүхэд хэвтэн эмчлүүлж, мөн насны 20476 хүүхэд амбулаториор үзүүлсэн байна. Төрсөн ах 2016, үүнээс гэрээт төрсөн 8, амьд төрсөн хүүхэд 2024, амьгүй төрсөн хүүхэд 18, эхийн эндэгдэл 0, жирэмсний жожуу үеийн хяналт 4-6 сартай 77, 7 ба түүнээс дээш сартай 10 хяналтад хамрагдсан. Өвчнийг эрт илрүүлэх, хурдачилсан шинжилгээ хийх оношлох, зөвлөгөө өгөх, хүндрэлээс сэргийлэхэд 63169 хүнд шинжилгээ хийсэн. Урьдчилсан сэргийлэх үзлэгт нийт 100943 хүн хамруулсан.	
18.3.4	Газрын харилцаа, кадастрын үйлчилгээ	Газрын шинэтгэлийн бодлогыг эрчимжүүлнэ.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төлөвлөсөн үйл ажиллагааг хугацаанд нь хийж гүйцэтгэнэ.	564.5	539.7	2021 онд газрын төлбөрийн орлогоос 467,232,000 мян/төг төлөврүүлсэн. Газар эзэмших эрхийн дуудлага худалдааг 62 байрилд зохион байгуулснаас 26 байрилд ялагч торчор 3,62 га газар эзэмшүүлсэн. 2471 иргэн аж ахуй нэгжээс өргөдөл хүсэлт хүлээн авснаас 2205 иргэний өргөдлийг шийдвэрлэсэн.	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	18.3.5	Гэр бүлийн болон хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Гэр бүлийн болон хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Засгийн газрын хөтөлбөрүүдийг хугацаанд нь хэрэгжүүлж, хяналт, дүн шинжилгээ хийж, орон нутгийн бодлогод тусгаж ажиллана.	Гэр бүл, хүүхдийн хөгжил, оролцооны хөтөлбөр, стратегийг орон нутагт хэрэгжүүлж, орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн талаарх бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, шинэчлэхэд хүүхэд, олон нийтийн оролцоог 80 хувьд хүргэнэ	373.8	348.9	2021 онд 21 зорилт 37 арга хэмжээний хүрээнд ажлын төлөвлөгөө гаргаж үйл ажиллагааны биелэлтэд нь 1 удаа дотоод хяналт үнэлгээ хийж, гэр бүл, хүүхэд, залуучуудад чиглэсэн үйлчилгээ, хамтын ажиллагааг өргөжүүлэх, салбар дундын уялдаа холбоог сайжруулах зорилгоор үйлчилгээний шинэ нэр төрлийн нэмэгдүүлэн 2020 оны жилийн эцсийн байдлаар 2 дэд хөтөлбөр хэрэгжүүлэн, 1 ОУБ-тай хамтран ажиллаж, 6 төрлийн судалгаа, 21 төрлийн сургалт, 16 төрлийн хэлэлцүүлэг, 6 төрлийн зөвлөгөөн, 7 төрлийн клуб хичээллүүлсэн. Мөн "Тур хамгаалах байр"-ыг стандарт шаардлагад нийцүүлж орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр "Хүүхэд, эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг" төсөлд хамрагдан жишиг "Тур хамгаалах байр"-ыг засваруулан хүлээн авч хүчирхийлэлд өртсөн 100 иргэнийг түр хамгаалалтад авч, стандартын дагуу мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж чадсан ба тус оны хугацаанд 520 иргэнд мэргэжлийн сэтгэлзүйн зөвлөгөө үзүүлсэн зэрэг томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд давхардсан тоогоор 25000 гаруй хүүхэд, 9600 гаруй иргэд, 12400гаруй залуучууд нийт 47000 гаруй иргэдэд хүрч ажилласан. Үр дүн: 2020 онд 37 арга хэмжээ төлөвлөснийг 98.6 %ийн гүйцэтгэлтэйгээр хийж хэрэгжүүлсэн ба Аймгийн 83000 гаруй иргэдийн 47000 гаруй хүнд буюу нийт хүн амын 56.6 хувьд хүрч ажилласан байна.
19	ХОВД				94,740.1	88,386.7	
	19.1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа			476.4	476.1	
	19.1.1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа	Иргэдийн оролцоонд тулгуурлан тодорхойлон тулгамдсан асуудал ээлж дараатай шийдвэрлэгдэж, НӨУБ-ын үйл ажиллагаанд иргэдийн оролцоо нэмэгдэнэ. Хууль тогтоомжийг сурталчлах.	99%	404	403.7	Хуралдаан 2 удаа зохион байгуулж, Тэргүүлэгчдийн хуралдааныг 14 хоногт 1-эс доошгүй удаа зохион байгуулсан Хороодын хуралдааныг 4 удаа, Төлөөлөгчдийн өдөрлөгийг 5 удаа тус тус зохион байгуулсан.
	19.1.2	ГХУСА33-ийн үйл ажиллагаа	Төлөөлөгчид, тэргүүлэгчдийн ажлыг сурталчлах, сайн туршлагыг дэлгэрүүлэх, мэдээллийн сүлжээг ажиллуулан иргэдийн саналыг сонсох, авч байх, иргэд олон нийтийг мэдээллээр хангах.	100%	60.0	60.0	Цахим хаяг дахь хандалтын тоог нэмэгдүүлсэн. Мөн лэйж хуудсыг ажиллуулж мэдээллийг өргөн хүрээнд өгч ажиллаж байна.
	19.1.3	ЦАУЗБСК-ийн үйл ажиллагаа	Орон нутаг руу чиглэсэн бүтээн байгуулалтад суурилсан, эдийн засаг үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжлийн нэгдсэн бодлого боловсруулах, мөрдөж хэвших.	100%	12.4	12.4	Тэргүүлэгчдийн хурлыг цаг тухай бүрд хийж өмчийн харилцааны нийт 138 тогтоол гаргаж ажилласан
	19.2	Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			41,110.1	38,156.0	
	19.2.1	Иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон төрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	97%	2,927.9	2,248.5	"Утгах үйлчилгээ-Иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7043-1111 төвийн журам", "Хайрцаар санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх журам", аймгийн удирдлагууд иргэдтэй уулзах цагийн хуваарийг http://khovd.gov.mn/?page_id=3926 цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, өөрчлөлт орсон тухай бүрд нь шинэчилж ажиллав. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд 2021 он 11 дүгээр сарын байдлаар 10826 өргөдөл, гомдол хүлээн авснаас 10539 өргөдлийг шийдвэрлэн хариуг өгч, шийдвэрлэх хугацаа болоогүй 267 өргөдөл байгаа бөгөөд 100 хувь шийдвэрлэсэн байна. Утгах үйлчилгээ-Иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7043-1111 төвд дуудлагаар 170, биечлэн 10, нийт 180 мэдээлэл хүлээн авснаас талархал 1, санал хүсэлт 117, гомдол 43, шүүмжлэл 19 тус тус ирснийг бүртгэн холбогдох албан тушаалтанд уламжилж, 160 санал хүсэлтэд хариу өгч, 20 санал хүсэлт шийдвэрлэлтийн хугацаандаа явагдаж байна."Цахим Ховд" хөтөлбөрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулан хэрэгжүүлж эхлээд байна. Уг хөтөлбөрийн хүрээнд цахимаар иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах шийдвэрлэх явцыг цахимаар хэрэгжүүлдэг болно. УЕБЕГ-т Япон улсын КОИКА-н буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа "Улсын бүртгэлийн үйл ажиллагааг дэмжих" төслийн хүрээнд шинэчилсэн бүртгэлийн тоног төхөөрөмжийг Монгол улсын 330 сум,172 хороо,9 дүүрэг, 21 аймгийн анхан шатны нэгж,хилийн чанд дахь дипломат төлөөлөгчийн 49 газарт олголоо. Энэ төслийн хүрээнд тус хэлтэс нь 2021 оны 08 дугаар сарын 24- ны өдрүүдэд Улсын бүртгэлийн ерөнхий газраас нийт 21 ширхэг шинэчилсэн бүртгэлийн иж бүрэн тоног төхөөрөмж хүлээн авлаа. Аймгийн 17 сумын 16 улсын бүртгэгчдэд иж бүрэн компьютер, олон үйлдэлт принтер, зургийн аппарат, хурууны хээ уншигч,сканер зэрэг 5 төрлийн тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгснөөр улсын бүртгэгч нар шинэчилсэн программаа ашиглан иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх хүрээнд 11 байгууллагын 54 төрлийн үйлчилгээг амжилттай нэвтрүүлж, тайлант онд нийт 17 сумын 3200 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлээд байна. Цаашид энэ үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, 2 шатлалт үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.
	19.2.2	Орон нутгийн засаг захиргааны стратегийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	100%	2,879.6	2,689.9	Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдаж, түүнийг дагаж гарсан дүрэм, журам, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан байгууллагууд сургалтын хөтөлбөрөө шинэчлэн боловсруулаад байна. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад ТЖАХ-ыг үе шаттайгаар сурган бэлтгэж байна. Үүнд:Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 105; Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 31; Ахлах түшмэлийн сургалтад 4 төрийн жинхэнэ албан хаагч тус тус хамрагдан төгсөж, сертификат гардан авлаа. Түүнчлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулж буй цахим сургалтад 801, Төрийн албаны зөвлөлөөс "Түрээв гариг" бүр зохион байгуулдаг сургалтад 3680, Архивын ерөнхий газраас зохион байгуулсан цахим сургалтад 384 албан хаагч тус тус хамрагдсан байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
19.2.3	Орон нутгийн засаг захиргааны бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	100%	2,835.6	2,762.0	Төрийн байгуулалтын чиглэлээр "Стандарттай Ховд", "Хариуцлагатай тунгалаг төр", "Цэцэг Ховд" аймгийн дэд хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж, төрийн бүх шатны байгууллагын сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгаж төрийн үйлчилгээг иргэдэд ил тод чанартай, тэгш хүртээмжтэй хүргэдэг мэргэшсэн ёс зүй, харилцаа хандлага сайтай төрийн албан хаагчтай "Авлига хүнд сурталгүй аймаг" болох зорилтын хэрэгжилт хангагдаж, чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 буюу (MNS ISO 9001-2016), Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO:14001:2015 бүлэг стандартыг 9 байгууллага үйл ажиллагаандаа нэвтрүүлж, анхны баталгаажуулалтын дагуу магадлан янхав аудит хийгдэж байна. Тайлант 2021 онд Жаргалант, Дарви, Дөргөн, Мянгад сумд чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 буюу (MNS ISO 9001-2016) стандарт нэвтрүүлэхээр "Менежмент ба үр чадварын хүрээлэн" ТББ-тай гэрээ байгуулан зөвлөх үйлчилгээ авч эхэллээ. "Соёлтой төрийн үйлчилгээ-Авлига хүнд сурталгүй аймаг" болох зорилтын хүрээнд Төрийн албаны тухай хууль, түүнийг дагаж гарсан дүрэм, журмын хүрээнд 17 сумын ЗДТГ, ЗД-ын эрхлэх асуудлын хүрээний 23 агентлаг "Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах" хөтөлбөрөө шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдад буцалтгүй тусламж үзүүлэх, цалинтай чөлөө олгох зэрэг асуудлыг байгууллагууд хөдөлмөрийн дотоод журамдаа тусган шийдвэрлэж байна. Түүнчлэн Шүүхийн шинжилгээний алба Булган суманд 79.0 сая төгрөгөөр 2 албан хаагчдаа ажлын байр, орон сууц барьж ашиглалтад оруулсан. Прокурорын газар 56.0 сая төгрөгөөр 2 албан хаагч, Гадаадын иргэн харьяатын Баруун бүсийн газар 50.0 сая төгрөгөөр Булган суманд 3 албан хаагчдад шинэ байр авахад нь дэмжлэг тусалцаа үзүүлсэн, аймгийн Онцгой байдлын газар 34, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба 24, Зэвсэгт хүчин 123-р анги 24, Цагдаагийн газар 24 айлын орон сууцны тус тус хувийн хөрөнгө оруулалтаар барьж, ажилтан албан хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэн, аятай тухтай ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлсэн байна.
19.2.4	Орон нутгийн засаг захиргааны хяналт шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа	Хяналт шалгалт-2, судалгаа мониторинг-1-2 удаа	80%	2,325.2	2,294.0	Засгийн газрын 2020 оны 2018 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам"-ын дагуу төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын төрийн жинхэнэ албан хаагч нарын үйл ажиллагааг үнэлэхэд ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг гол шалгуур болгон үнэлж байна.
19.2.5	Урьдчилан төлөвлөх, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн арга хэмжээ	Хууль тогтоомжид нийцсэн байх	100%	2,132.9	2,132.9	Цар тахлын эсрэг 2238.1 сая төгрөгийн багц арга хэмжээний хүрээнд орон нутгийн төсвөөс 2132.9 сая төгрөгийг зарцуулж, 44.0 сая төгрөгийг хандив, тусламжийн дэмжлэг ирснээс 44.0 сая нь мөнгөн хөрөнгөөр, 61.2 сая төгрөгийн бараа материал хүлээн авч зарцуулж 4.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.
19.2.6	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	Байгаль орчны доройлтыг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хангана.	100%	2,120.6	1,985.2	2021 оны байдлаар "Ногоон хөгжлийн хөтөлбөр"-ийн байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр 9 арга хэмжээг хэрэгжүүлснээс 6 арга хэмжээ 100 хувьтай, 3 арга хэмжээ нь 70 хувьтай, хөтөлбөр 90 хувьтай хэрэгжиж байна. Цөлжилт газрын доройтолдо өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах ажлын даалгавар боловсруулж Булган-Алтай, Мянгад, Дөргөн, Манхан сумдад тус бүр 10 га, нийт 50 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг Ховд сафари ХХК, Грийн фантом ХХК, Үр жимс хоршоод хийж гүйцэтгэлээ. Энэ хаврын мод тарилт тавдугаар сарын 08-наас эхэлж, зургаадугаар сарын 15-ныг хүртэл, намрын мод тарилт 10 дугаар сарын 4-20-ныг хүртэл үргэлжилж, халдвар хамгааллын дэглэм баримтлан 30-аас дээш хүн цуглуулахагүйгээр зохион байгуулж, 7 төрөл зүйлийн 47316 ширхэг мод тарьжээ. Мод тариад оржих бүс цаашид арчилгаа тордолгоог сайн хийх, мөн иргэдийг өөрсдийн амьдарч байгаа орчиндоо мод тарьж эвхийг уриалан ажиллаж байна.
19.2.7	Агаарын бохирдлыг бууруулах	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авч, бохирдлыг бууруулах	100%	700.0	700.0	Ус, цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/28 дугаар тушаалаар 2021 оны 04 дүгээр сарын 10-наас цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаагаа эхлүүлж, "Ховд-Бороо-1" "Ховд-Бороо-2" 2 экспедицийн инженер, техникч, мэргэжилтэн нийт 8 хүний бүрдэгдүүнтэй ажилласан. Ховд аймгийн нийт нутаг дэвсгэрт 2021 оны 04-07 дугаар саруудад 2 экспедит нийт 48 удаагийн гаралтаар 70 ширхэг пуужин хараж хур тунадасны хэмжээг 45-55 хувиар нэмэгдүүлсэн байна. 2021 оны 5, 6, 7 дугаар саруудад олон жилийн дунджаас ахиу хур тунадас орсон. Их нууруудын хотгорын сумдаар 609.0 мм, Алтайн өвөр говийн сумдаар 225.7 мм, өндөр уулын сумдаар 407.0 мм хур тунадас орсон. 2021 онд олон жилийн дунджаас 55 хувиар илүү хур тунадас орж, нийт нутгаар зууншлагын байдалд таатай нөлөө үзүүлсэн байна.
19.2.8	Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ Бод -14,3 мянга Бог -123,3 мянга	98%	490.0	490.0	Аймгийн хэмжээнд 11 сумын 4385 өрхийн 1,636.5 малыг Лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрууллаа. Засгийн Газрын 2018 оны 225 дугаар тогтоолын дагуу энэ онд Улсын төсвөөс санхүүжих арга хэмжээнд Боом, Галзуу, Томуугаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд: бод 67,0 мянга, бог 75,5 мянга нийт 142,5 мянган толгой малыг голомтын болон эрсдэлтэй сумдын малыг хамруулахаар төлөвлөн ажиллаж, боомын дархлаажуулалт 49,2 мянган толгой малыг хамруулахаас 50,1 толгой буюу 101,5 хувьтай, галзуугийн дархлаажуулалтад 81,0 мянган толгой мал хамруулахаас 74,6 буюу 92,1 хувьтай, томуугийн дархлаажуулалтад 12,3 мянган толгой мал хамруулахаас 12,0 мянга буюу 97,6 хувьтай хийж гүйцэтгэлээ. Нийт 142,5 мянган толгой малаас хамрагдалтын хувь 136,7 толгой буюу 96,0 хувьтай хийж гүйцэтгэсэн байна. Орон нутгийн төсвөөс санхүүжих арга хэмжээнд ДХХ, Цусан халдвар, Дуут халдвар, Колибактериозоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд бод 69,7 мянга, бог 393,3 мянга, нийт 463,0 мянган толгой малыг голомтын болон эрсдэлтэй сумдын малыг хамруулахаар төлөвлөн ажилласан. Дархлаажуулалтын арга хэмжээнд 452,4 мянган толгой буюу 97,7 хувийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэлээ. Иргэн, хуулийн этгээдээс санхүүжих арга хэмжээнд Шөвөг яр, Сохор догол, Сахуугаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд бод 23,5 мянга, бог 523,2 мянга, нийт 546,7 мянган толгой малыг голомтын болон эрсдэлтэй сумдын малыг хамруулахаар төлөвлөн ажилласан. Дархлаажуулалтын арга хэмжээнд дээрх 3 нэрийн арга хэмжээг 533496 толгой мал буюу 97,6 хувьтай гүйцэтгээд байна. Нийт дүнгээр 2021 онд 1152,2 мянган толгой малыг хамруулахаас 1122,6 мянган толгой мал буюу 97,4 хувьтай хийж гүйцэтгэлээ.
19.2.9	Замын сан	Орон нутгийн авто замын ашиглалт сайжрах	100%	647.0	557.7	Дэлхий нийтээр тархсан ковид-19" вирус цар тахлын улмаас БНХАУ болон ОХУ-тай хиллэдэг хилийн боомтууд хаасны улмаас гадаадын жуулчидтай холбоотой ямар нэгэн арга хэмжээ зохион байгуулах боломжгүй болсон хэдий ч босоо тэнхлэгийн авто замын дагуу аялал жуулчлалын дэд бүтэц байгуулах ажлын ТЭЗҮ, зураг, төсөв боловсруулах ажлыг олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэж, "Таван од" аялал жуулчлалын хөтөлбөр, орон нутгийн аялал жуулчлалын маршрут, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах арга хэмжээнийг тасралтгүй зохион байгууллаа.
19.2.10	Нийтийн тээврийн алдагдалд олгох татаас	Унааны хөнгөлөлт авах ахмад настан, ХБИ-ийн тоог гаргаж хөнгөлөлтийг тухай бүр олгох	100%	60.0	60.0	Бат хөсөгтөн ХХК-тай нийтийн тээврийн үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлэх зорилгоор хамтран ажиллахаар жил бүр гэрээ байгуулан ажиллаж байна.
19.2.10	Хот тохижуулах газар			416.5	415.5	
19.2.10.1	Хот тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаа	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	100%	129.6	129.6	2021 онд тус байгууллага нь 418,5 сая төгрөгийн төсөвтэй 22 орон тоотой үйл ажиллагаа явуулж, төлөвлөсөн арга хэмжээг бүрэн гүйцэтгэлээ.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилгот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	19.2.10.2	Гудамжны гэрэлтүүлэг, цэвэрлэгээ	Гудамжны гэрэл цахилгааны төлбөр төлөх	100%	127.8	127.8	Аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт байгаа 2560 ширхэг гэрэлтүүлгийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллав. Төв гудамж, талбайн цэцэг гэрэлтүүлгийн шатсан ламп сольж засварлав. Хотын төвд байрлах цэцгийн мандал гагнаж, хотын төвд 7560 м2 талбайн хог цэвэрлэж зайлуулав
	19.2.10.3	Ногоон байгууламжийн үйл ажиллагаа	Хотын дотор ногоон байгууламж зүлэгжүүлэх цэцэг тарих ,Хотын дотор ногоон байгууламж услах ,Нурсан саад хашлага өрөх,Төмрөн саад гагнах	100%	29.8	29.8	15600 м2 талбайд зүлэгжүүлэлт,цэцэгжүүлэлт хийж, хотын захад байгаа мод бутыг 2 хоногийн зайтай 6 сараас 9 сарын хооронд усалгаа хийсэн.
	19.2.10.4	Хог хаягдлын тээвэрлэлт, устгах, дарах үйлчилгээ	Албан байгууллагын хог захиалгаар ачиж зайлуулах,Эзэнгүй хог хаягдал ачиж зайлуулах,СӨХ-ын хог захиалгаар ачиж зайлуулах Гудамж талбайн цэвэрлэсэн хог хаягдал ачиж зайлуулах	100%	131.2	131.2	СӨХ болон албан байгууллага, аж ахуйн нэгжийн хог, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн эзэнгүй хог хаягдал нийт 650 машин хог ачсан мөн хотын ойр орчим эзэнгүй хог хаягдлыг ачиж зайлуулав. Хогны цэгийн хог ооволдож түрэх ажлыг хийж гүйцэтгэсэн.
	19.2.11	Аймгийн орон нутгийн өмчийн газар	Орон нутгийн өмчийн харилцааны холбогдох хууль тогтоомжийг үндэслэн шаардлагатай үед нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, өмчийн мэдээллийн сан бүрдүүлж, бүртгэлийг цахим шилжүүлэх ажлыг зохион байгуулах	100.0%	218.1	216.9	Эх оронч худалдан авалтыг дэмжих хүрээнд 2021 онд зарласан тендер шалгаруулалтын баримт бичигт дотоодын үйлдвэрээс бараа бүтээгдэхүүн худалдан авалтыг түлхүү оруулсан бөгөөд тухайн онд 2 тэрбум 824 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн худалдан авахаар тендерийн материалд мэдээллээ ирүүлсэн байна. Аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох, тэгш боломжоор хангах зорилгоор давхардсан тоогоор 142 удаа үүнээс:71 тендерийг нэг удаа, 15 тендерийг 2 удаа, 4 тендерийг –3 удаа, 3 тендерийг –4 удаа, 2 тендерийг 5 удаа, 1 тендерийг 7 удаа цахим системд зарлаж, үр дүнг орууллаа. Тендерийн үр дүнг нийтэлсний дараа тендэрт ялагдсан компани ялсан компанийнхаа бичиг баримтыг татан үзэж, тендэрт оролцсон аж ахуйн нэгжүүдийн бичиг баримт стандартад нийцсэн эсэх, үнэлгээний хороо зөв үнэлсэн эсэхтэй санал нийлж байгаа, хэрэв санал нийлэхгүй бол гомдол гаргах нь нээлттэй байна. Гэрээ байгуулсан ажлын дүнгээс харахад:45 компани – 1 ажил, 16 компани – 2 ажил, 2 компани – 3 ажил, 3 компани – 4 ажил, 2 компани – 5 ажил, нийт 68 компани гүйцэтгэгчээр шалгарсан байна. "Шилэн тендер-2021" арга хэмжээний хүрээнд "Төрийн худалдан авах ажиллагааны нээлттэй ил тод байдлыг сурталчлах "Цахим аян"-ыг 2021 оны 04 дүгээр сарын 15-аас 2021 оны 05 сарын 30-ныг дуустал хугацаанд Ховд аймгийн төрийн болон ТӨҮГ-уудыг хамруулан нийт 23 байгууллага, 17 сумдын 242 хүнийг хамруулан зохион байгууллаа. Үнэлгээний хороо байгуулах ажлыг сугалаагаар 15 удаа 105 үнэлгээний хороонд нийт 525 хүн томилон ажиллуулснаас төрийн албан хаагч-315, ТББ, иргэний төлөөлөл-210 оржээ.
	19.2.12	Орон нутгийн ахмад настанд үйлчлэх кабинет төв	Ахмадуудад зориулсан үйл ажиллагааг дэмжинэ.	100%	63.2	63.2	Ахмадуудад зориулсан үйл ажиллагааг дэмжиж ажилласан.
	19.2.13	Орон нутгийн ахмад настанд үйлчлэх кабинет төв	Ахмадуудад зориулсан үйл ажиллагааг дэмжинэ.	100%	76.1	76.1	Аймгийн "Ахмадаа ачилья" дэд хөтөлбөрийн төслийг шинэчлэн боловсруулан 6 удаагийн хэлэлцүүлгийг ахмад настан, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлүүдийн дунд зохион байгуулсан. Хөтөлбөрийг 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулсан. Хөтөлбөр 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлнэ. Салбарын мэдээллийн системийн шинэчлэл, цахим төрийн үйлчилгээг хөгжүүлэх программ хангамжийн шинэчлэлт 2022 оноос бүрэн хэрэгжихээр туршилтын шатандаа явагдаж байна.
	19.2.14	Байгаль орчны газар	Байгаль орчныг хамгаалан, нөхөн сэргээх, зохистой ашиглах, байгаль хамгаалалд иргэдийн оролцоо хяналтыг нэмэгдүүлэх	100%	457.5	457.5	Цөлжилт газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах ажлын даалгавар боловсруулж Булган-Алтай, Мянгад, Дөргөн, Манхан сумдад тус бүр 10 га, нийт 50 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг Ховд сафари ХХК, Грин фантом ХХК, Үр жимс хоршоод хийж гүйцэтгэлээ. Энэ хаврын мод тарилт тавдугаар сарын 08-наас эхэлж, зургаадугаар сарын 15-ныг хүртэл, намрын мод тарилт 10 дугаар сарын 4-20-ныг хүртэл үргэлжилж, халдвар хамгааллын дэглэм баримтлан 30-аас дээш хүн цуглуулахгүйгээр зохион байгуулж, 7 төрөл зүйлийн 47316 ширхэг мод тарьжээ. Мод тариад орших бус цаашид арчилгаа тордолог сайн хийх, мөн иргэдийг өөрсдийн амьдарч байгаа орчиндоо мод тарьж хэвшихийг уриалан ажиллаж байна.
	19.2.15	Сум дундын ойн анги	ад зохион байгуулах, Мод үржүүлгийн	100%	54.8	54.8	Аймгийн ИТХ-ын ажлын албатай хамтран агаар орчны бохирдол болон цөлжилтийг сааруулах хог хаягдал, ногоон байгууламжийн менежментийг сайжруулахад иргэд олон нийтийн оролцоо нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангах зорилгоор 2021 онд "Хог биш мод тарьж" аяныг хоёр дахь жилдээ өрнүүлж, аж ахуйн нэгж, албан байгууллагууд, сумдыг хамруулан Ховд аймгийн хэмжээнд өргөн цар хүрээтэй зохион байгуулж, 1837 иргэн гар бие оролцон ажиллаж, алим, цацаргана, ранетка, интоор, бэсрэг алим, үрэл, үхийн нүд, улиас, хайлаас, шар хуаис, бургас зэрэг 10 гаруй төрлийн 47316 ширхэг мод, бут сөөгийг Хавар, намрын мод тарих өдрүүдээр тарьж, аймгийн ногоон байгууламжийн талбай, таримал ойн хэмжээг нэмэгдүүлээ.
	19.2.16	Аймгийн халамжийн сан	Хамрагдах иргэдийг үнэн зөв тодорхойлж, тусламжид хамрагдсан иргэдэд зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуула.	100%	134.6	134.6	Орон нутгийн төсөвт хуваарилагдсан хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн 134,6 сая төгрөгийг сарын хуваарийн дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт сар бүр санхүүжилтийг олгон зориулалтын дагуу зарцуулахад хяналт тавин хэрэгжүүлээ.
	19.2.17	Санхүүгийн хяналт, аудитын алба	Санхүүгийн зөрчил буурч, төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, хариуцлага сайжирна.	100%	213.6	213.6	Санхүүгийн хяналт шалгалтаар 117 ширхэг улсын ахлах байцаагчийн актаар орон нутгийн төсвийн орлогод 167,3 сая төгрөг, тухайн байгууллагын төсөвт орох, нөхөн олгох, сум хөгжүүлэх сангийн төсөвт оруулахаар 11.7 сая төгрөгийн, нийт 179.1 сая төгрөгийн акт тогтоож ажилласан байна.
	19.2.18	Соёлын үйлчилгээ	Чанартай уран бүтээл туурвиж, иргэдэд соёл урлагийн үйлчилгээг өндөр түвшинд хүртээмжтэй хүргэх	100%	2,961.6	2,961.6	"Олон үндэстэн ястны өв соёл урлаг" дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 62 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж эхлээд байна.мcМонгол хөвмийг дэлхийн дээд амжилтын ном Гиннест бүргүүлсэн бахархалт өдрийг тохиолдуулан жил бүр "Khovd open" арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд тус арга хэмжээний хүрээнд "Хөвмийн өв" цахим уралдааныг мэргэжлийн ангилал, сонирхогч, 6-11 нас, 12-16 насны ангиллаар зохион байгуулж, нийт 64 хөвмийч оролцож, эхний 5 байр эзэлсэн шагналтай хөвмийч болон хөгжилт драмын театрын уран бүтээлчид хамтран "KHOVD OPEN" live тоглолтыг 10 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж, хөвмийтэй холбоотой нэвтрүүлэг, ярилцлагыг хийж телевиз сайтуудаар иргэд, олон нийтэд сурталчиллаа.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	19.2.19	Нийтийн биеийн тамир	Иргэдийн нийтийн биеийн тамираар хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, тамирчдын амжилтыг өсгөх. Дотоод, гадаад аялал жуулчлалыг хөгжүүлэх	100%	486.4	486.4	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 67 дугаар тогтоолоор "Спортын аварга" дэд хөтөлбөрийг Олимп, дэлхий, тив, улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд амжилт гаргасан тамирчин дасгалжуулагч нарт олгох мөнгөн урамшууллын журмын хамт батлуулан хэрэгжүүлж эхэллээ. 2021 оны 3, 4-р сард Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир спортын улсын хорооноос улс орон даяар цахим гүйлтийг зохион байгуулж, энэ гүйлтэд манай аймаг эхний 5 байранд шалгарч хамгийн хол зай туулсан тамирчдаас 2 тамирчин шалгарлаа. Мөн өглөөний алхалт гүйлтийн аяныг амжилттай зохион байгуулж, 3800 хүн хамрагдсан байна."Дугуйтай Хөвд" дэд хөтөлбөрийн төслийг боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталж, хэрэгжүүлж эхлэхэд бэлэн боллоо. 2022 оны хавраас үйл ажиллагааг эхлүүлнэ. Тус хөтөлбөрийн хүрээнд улс, бүс, орон нутгийн чанартай тэмцээн уралдаан зохион байгуулах, секц дугуйлан ажиллуулахаас гадна аймгийн төв доторх дугуйн замуудыг нэмэгдүүлэх, хотын төвөөс гадна дугуйн зориулалтын зам байгуулах ажлуудыг тусгасан байна. Иргэдийн эрүүл дадал хэвшлийг дэмжих зорилгоор гүйлт, алхалтын замыг аймгийн Орон нутгийн төсвийн 300,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Их гүүр, Шар сумийн чиглэлд барьж, ашиглалтад хүлээн авч, иргэд олон нийт ашиглаж эхэллээ.
	19.2.20	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах, хэрэгжилтийг хангуулах	82%	18,908.9	17,175.6	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 17,175.6 сая төгрөгийн 15 ажил, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 30,0 сая төгрөгийн 1 ажил, Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 458,0 сая төгрөгийн 8 ажил, Замын сангийн хөрөнгөөр 355,0 сая төгрөгийн 6 ажил, ОНХСангийн хөрөнгөөр 7,771,1 сая төгрөгийн 88 ажил нийт 25,789,7 сая төгрөгийн 118 худалдан авах ажиллагааг зохион байгуулан Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу тайланг хагас жилээр гарган хугацаанд нь илгээсэн ба Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам шинэчлэгдсэн тул шинэ журмаар жилийн эцсийн тайланг цахим системд илгээсэн.
19.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ				53,153.6	49,754.6	
	19.3.1	Сургуулийн өмнөх боловсрол	Хамран сургалтын хувийг нэмэгдүүлнэ.	Төрийн өмчийн цэцэрлэгийн тоо-33 Хүүхдийн тоо-6257 Хамран сургалтын хувь 80 Төрийн бус өмчийн цэцэрлэгийн тоо-10 Төрийн бус өмчийн цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо-540	13,887.3	13,811.8	Аймгийн хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилд төрийн өмчийн 33, хувийн өмчийн 10 нийт 43 сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийт 5308 хүүхэд, 209 бүлэгт суралцаж байна. Үүнээс үндсэн өдрийн 194 бүлэгт 4565 хүүхэд, хувилбарт сургалтын 15 бүлэгт 743 хүүхэд хамрагдаж байна. Нийт хамрагдах 3, 4, 5 настан 6523 хүүхэд байгаагаас 5308 буюу 81,4%-ийг СӨБ-д хамруулаад байна.
	19.3.2	Ерөнхий боловсрол	Боловсролын чанарын шинэчлэлийг орон нутагт хэрэгжүүлж, багш, хүүхэд, иргэд хөгжих орчныг төгөлдөржүүлэн оюунжсан, бүтээлч, чадамгайтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлэхэд оршино.	Сургуулийн тоо 27, хүүхдийн тоо-20206, хамран сургалтын хувь-96.5, бага-96.2, суурь- 95.6, дотуур байрны хүүхдийн тоо-1745, үдийн цай хөтөлбөрт- 9485, элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо-509,2	30,153.6	30,097.6	Аймгийн хэмжээнд үндэсний лаборатори сургууль 1, цогцолбор сургууль 2, лицей сургууль 1, гүнзгийрүүлсэн сургалттай сургууль 1, ердийн сургалттай ерөнхий боловсролын 20, нийт 25 сургуульд 20538 сурагч хамрагдаж, 2021-2022 оны хичээлийн жилд 1079 багш, 696 ажилтан, 85 удирдах ажилтан, нийт 1860 хүн ажиллаж, энэ хичээлийн жилд сургууль төгсөгчдийн тоо 1318 байна."Чадварлаг оюутан-Шинэ хөвдөн ирээдүй" журмын хүрээнд элсэлтийн ерөнхий шалгалтад амжилттай оролцож, 800 оноо авсан 5 сурагч, 750-иас дээш оноо авсан 18 сурагч, нийт 23 сурагчийг 11,2 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа. Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилттай оролцож, тэргүүлсэн 17 сурагчийг 6,7 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан, орон нутагт хэрэгцээтэй мэргэжлээр суралцаж байгаа 3,5 дээш голч дүнтэй 19 оюутны материалыг хүлээн авч, 12 дугаар сард багтаан Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг сонгон шалгаруулна.
	19.3.3	Соёлын үйлчилгээ			-		
	19.3.3	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг тогтвортой, тасралтгүй үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх	99.80%	7,897.4	7,823.2	Шинэ болон сэргэж буй халдварт өвчнүүдийн тархалт, дэгдэлтийг тандах зорилгоор сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс 7 хоног бүр халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц тохиолдлын тандалтын мэдээг 2011 оны 11 сарын 19-ний байдлаар 44 дүгээр 7 хоног буюу 1012 удаагийн мэдээллийг бүрэн авч нэгтгэж дүн шинжилгээ хийж ажиллалаа. Тандалт судалгаагаар цочмог халууралт, тууралттай хам шинж 4, цэрүүт тууралттай өвчний хам шинж 13, цочмог усархаг суулгалт 2, цочмог цусархаг суулгалтын хам шинж 3, шарлалттай хам шинж 1 тус тус илэрснийг Халдварт өвчин судлалын үндэсний төвд мэдээлж оношийг баталгаажуулах, хяналтад авах арга хэмжээг авлаа. Тус оны жилийн эцсийн байдлаар тому тому тест өвчний тандалтаар амбулаториор давхардсан тоогоор 248638 хүн үйлчлүүлсэнэ тому, тому тест өвчний хам шинж 14028 тохиолдлоор мэдээлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 4.5 хувиар буурсан байна. Коронавируст халдвар (Ковид-19)-ын тандалтаар түргэвчилсэн төстээр 74098 сорьц, ПГУ-ын шинжилгээнд 48041 сорьц цуглуулан шинжилж, 19235 тохиолдлыг илрүүлж, 67322 хавьтлыг хяналтад авч ажилласан байна. Аймгийн Засаг даргын 2020 оны А/97 дугаар захирамжаар шуурхай штаб, байгуулж, коронавируст халдвар (Ковид-19)-ын тохиолдлын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг шинээр батлуулж, гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед аймгийн нутаг дэвсгэрт коронавируст халдварын цар тахлын хариу арга хэмжээг чангатгах, эрчимжүүлж, халдварын тохиолдол хяналтаас гарсан буюу "Улаан түвшин"-ний төлөвлөгөө, гамшигаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөө, Хөвд аймгийн төв болон сумдын нутаг дэвсгэрийг бүсчлэн хаах төлөвлөгөө зэргийг батлуулан хэрэгжүүлж, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд 5 удаа тодотгол хийв.
	19.3.4	Газрын харилцаа, кадастр	Орон нутгийн газрын бодлогыг тодорхойлон, хэрэгжүүлэх, зөрчлийг арилгуулах	100%	519.9	519.9	Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын санхүүжилтийг 2022 оны орон нутгийн төсөвт тусгуулахаар ажиллаж байна.
	19.3.5	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Шалгуур үзүүлэлтэд заасан үзүүлэлтүүдийн хүрэх түвшинд хүрч ажиллах	98%	695.6	681.5	НТБТ, Жаргалант сумын 3, 7, Буянт сумын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийн хэрэглэгдэхүүний баяжилт хийлээ. 3-р сургуульд харааны бэрхшээлтэй хүүхдийн 5-н сонсох төхөөрөмж, сурах бичиг, 11 сургуульд оюуны бэрхшээлтэй хүүхдийн сурах бичгийг олгов. Дохионы хэлний орчуулагч, аутизмын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, дэмжлэгийн баг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн 8 төрлийн сургалтад 87 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, 24 захирал, 24 сургалтын менежер 216 багш хамрагдлаа. Сургууль цэцэрлэгийн үйлчлэгч манаач нийт 63 хүнд "Хүүхэд хамгаалах тэгш хамруулах боломж" сургалт зохион байгуулаа
20	Хөвсгөл				127,163.9	118,208.8	
20.1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа				2,209.6	2,115.1	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
20.1.1	Нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлж, түүний хэрэгжилтийг хангаж, тэргүүлэгчдийн хуралдааныг товлон зарлах, хэлэлцэх асуудлыг оруулж, хэлэлцүүлж гарсан шийдвэрийг байгууллагуудад танилцуулах, Засгийн газраас болон аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл явцын талаар болон түүний биелэлтийн талаарх тайлан мэдээллийг ИТХ-ын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх	Хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын хэрэгжилт сайжрах, хуралдааны тоо	Хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын хэрэгжилт сайжрах, хуралдааны тоо	2,026.1	1,932.8	Аймгийн болон 23 сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан 2021 онд нийт 80 удаа хуралдсан бөгөөд энэхүү хуралдаанаар шат шатны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аймаг орон нутгийн тулгамдсан асуудал, иргэдийнхээ хэрэгцээ, шаардлагад нийцсэн хөрөнгө оруулалт, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг хүргэх чиглэлээр төлөөлөгчдийнхөө санал, санаачилгыг тусгаж томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, дуусгах, төрийн үйлчилгээг хүргэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг ажлуудын зардлыг баталснаас гадна сумдын хурлаас тухайн сумын төсөв хөрөнгө, хийж хэрэгжүүлэх томоохон хөтөлбөр бүтээн байгуулалтын ажлуудыг хэлэлцэн шийдвэрлэж байна. Шат шатны тэргүүлэгчдийн хурал 207 удаа хуралдсан бөгөөд хурлаар хүн амын эрүүл мэнд, боловсрол, өмч хөрөнгө, төсөв санхүү, өргөлдөгчид, санал хүсэлт, байгаль орчны асуудал зэрэг олон асуудлыг хэлэлцэн зохиж шийдвэрүүдийг гарган ажилласан байна.
20.1.2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах, гэмт хэргийн гаралтыг бууруулах.	Гэмт хэргийн гаралт буурсан байна.	100%	183.5	182.3	Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл 19 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж энэ оны тухайд 6 удаа хуралдаж тодорхой асуудлуудыг шийдвэрлэн ажиллаж байна. Гэмт хэргийн гаралт, бууралтыг өмнөх онтой харьцуулбал 181 тохиолдлоор буюу 33.8 хувиар өссөн байна. Энэ нь Ковид цар тахлын үед цахим гэмт хэрэг 235 удаагийн тохиолдолд гарч өссөн нь нийт өсөлтөд голчлон нөлөөлсөн байна.
20.2	Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			37,779.8	30,176.0	
20.2.1	Засгийн газрын болон аймгийн Засаг дарга, ИТХ-аас гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, сум, хэлтэс агентлагийн үйл ажиллагааг уялдуулах, аймаг, сумдын ЗДТГ-ын ажилтнуудад нутгийн удирдлагын чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгч сургалт семинарыг зохион байгуулж, мэдээлээр хангах	Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байх, ажлын үр дүн сайжрах. Биелэлт гаргах тогтоол шийдвэрийн тоо, хэрэгжилтийн байдалд ахиц гарсан байх	96.05	22,281.9	17,936.6	2021 оныг "Иргэдээ сонсох жил" болгон зарлаж иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил, олон улсын төсөл хөтөлбөрийн болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Аймгийн Засаг дарга төрийн байгууллагын удирдлагуудтай үр дүнгийн гэрээ байгуулан хэрэгжилт үр дүнд тооцон ажиллаж байна. Мөн Засгийн газрын болон аймаг орон нутгийн удирдах байгууллагуудад гарсан, гарч байгаа бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймаг сумдын болон агентлаг байгууллагуудын удирдах ажилтнуудын үзлэлт, хурлыг улиралд 1 удаа цахим болон бусад хэлбэрээр зохион байгуулахын зэрэгцээ бусад сургалт зөвлөгөөн, бусчилсан сургалтуудыг удаа дараа явуулж мэдээлэлээр хангахын зэрэгцээ цаг үеийн олон ажлуудыг шийдвэрлэн ажиллаж байна. 2021 онд хөгжсөх хууль журам, сайдтай байгуулсан гэрээ, аймгийн Засаг даргын Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг хяналтад авч хэрэгжүүлэх 90 гаруй эрх зүйн баримт бичиг, тогтоол шийдвэрийн 430-аад заалт байгаа бөгөөд тус бүрд биелэлт, үнэлгээ дүгнэлтийг гарган ажиллаж байна.
20.2.2	Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэр, Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Хөтөлбөр, төслийн мэдээлэл, үйл ажиллагааны үр дүнгийн мэдээллийг графикт хугацаанд гаргаж холбогдох газарт хүргүүлж мэдээлж байх					
20.2.3	Төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавих, үйл ажиллагааг сайжруулах	Хяналт хийх байгууллага, дансны тоо, хяналтаар гарсан үр дүнгийн хувь	100	182.6	180.9	2021 оны төлөвлөсөн ажлаа бүрэн хэрэгжүүлж, дүнд хугацааны стратеги төлөвлөгөөний дагуу ажилласнаар байгууллагуудад тавигдаж байгаа төлбөр, торгууль, акт, албан шаардлагын хэмжээг 2020 онтой харьцуулахад 92% хувь буурсан байгаа нь энэ ажлын гол үр дүн юм. Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалттай түвшинд явж байна. Төсвийн гүйцэтгэл 180.9 сая төгрөг буюу 99.1%-ийн гүйцэтгэлтэй.
20.2.4	БХНСАХ-ний зардлаар хэрэгжүүлэх ажил үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, батлагдсан ажлын даалгавар, техникийн нөхцөл, зураг төсвийн дагуу батлагдсан төсөвт багтаан хугацаанд нь хэрэгжүүлэх.	Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байх	72.7	1,300.7	945.9	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх заалтын дагуу байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд нийт 1,300.7 сая төгрөг зарцуулахаас 945.9 сая төгрөг буюу 72.7 хувийг зарцуулсан байна. Төлөвлөсөн ажил үр дүн сайтай хэрэгжсэн.
20.2.5	Худалдан авах үйл ажиллагааг болон холбогдох сургалтуудыг зохион байгуулах. Орон нутгийн өмчийн байгууллагын менежментийг сайжруулж, ашигтай ажиллуулах замаар орлогыг төвлөрүүлэх. Орон нутгийн өмчит этгээдийн санхүү эдийн засаг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийх.	Худалдан авах ажиллагаа хууль журмын дагуу зөрчилгүй зохион байгуулагдаж, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа хууль журмын дагуу явагдах	90.7	232.2	210.6	A-3 сертификатын сургалтыг Мөрөн суманд зохион байгуулж нийт 321 хүнд сургалт өгч, 228 хүнд худалдан авах ажиллагааны A-3 сертификат олгосон байна. Хувийн хэвшлийн 265 аж ахуйн нэгжид үндэсний тоон гарын үсгийн e-tokenг төхөөрөмж олгож, нэвтрэн ашиглах мэдлэг, үр чадвар эзэмшүүлсэн. Үүний үр дүнд Хөвсгөл аймгийн ТЭЗ-ийн төсвийн багцад хамаарах 237 захиалгаг байгууллагууд төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нэвтрэн тендер зарлах чадвартай болсны зэрэгцээ 20 онд 312 тендерт 972 аж ахуйн нэгж оролцож тендер ирүүлсэн бол байгууллага 512 худалдан авах ажиллагааг гардан зохион байгуулсан. Орон нутгийн өмчийн газрын www.umch.khs.gov.mn цахим сайтад 226543 хүн хандаж мэдээлэл авсан байна. Төсвийн гүйцэтгэл 210.6 сая төгрөг буюу 90.7%.
20.2.6	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамруулахаар тооцсон мал бүрэн хамрагдсан байх, аймгийн хэмжээгээр малын гоц халдварт болон бусад өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх.	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамруулахаар тооцсон мал бүрэн хамрагдсан байх, аймгийн хэмжээгээр малын гоц халдварт болон бусад өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх.	94.4	1,050.0	991.5	Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 795.3 мян.тол мал, амьтан хамрагдахаас 755.6 мян.тол мал амьтан хамруулж, 95%, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2839.8 мян.тол мал хамруулахаас 3900.0 мян.тол мал амьтан хамруулж 137%-ийн гүйцэтгэлтэй байна. Аймгийн нийт мал сүргийн 15.2%-ийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулаа.Мал эмнэлгийн ариун цэврийн ариутгал халдваргүйтгэлийг ХАА-н болон 451.8 мян/м2 талбайд хийж 100 хувийн гүйцэтгэлтэй. Шүлхий өвчнөөс эрүүл, тайван статусаа хамгаалах, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх хамгаалалтын бус тогтоох стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Тариалан, Их-уул, Рашаант, Галт, Жаргалант зэрэг 5 сумдын 2741 өрхийн 92 639 үхэр сүргийг дархлаажуулж 89.5%, Бруцеллээ өвчний вакцинуулалтад 1 048 868 ожин төл малыг хамруулахаар төлөвлөж, 99.4 хувьтай байна. Зардлын гүйцэтгэл 991.5 сая төгрөг буюу 94.4%-тай байна.
20.2.7	Төв доторх замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах, гэмтэлтэй замыг засварлах, шинээр нэмж барих, хөдөөгийн зарим зам давааг засах, ажил үйлчилгээг чанартай хийх	Төлөвлөсөн зам засварын ажлууд бүрэн, чанартай хийгдсэн байх. Төсөв 837.9 сая төгрөг.	81.2	837.9	680.0	Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зам давааны замын засвар, гэрлэн дохио суурилуулах, хяналтын камер суурилуулах, замын тэмдэг тэмдэглэгээ сайжруулах зэрэг олон ажил, арга хэмжээ батлагдсан бөгөөд ажлуудыг тодорхой түвшинд хийж гүйцэтгэгдсэн. Гарсан гүйцэтгэл 680.0 сая төгрөг буюу 81.2%-тай байна.
20.2.8	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	Байгаль орчны чиглэлээрх бүхий үйл ажиллагаанд ахиц гарсан байх	99.4	914.4	908.7	Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, өсгөн үржүүлэхэд, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж түнцд хяналт тавих эрх, үүрэг бүхий сумдын Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч мөн Ойн алба, ойн анги, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төсөл хөтөлбөр, Төрийн бус байгууллага, ойн мэргэжлийн байгууллагууд, ард иргэдийн оролцоотойгоор манай байгууллага нь байгаль орчны тулгамдсан асуудлуудыг хамтран ажиллаж байна. Төсвийн гүйцэтгэл 908.7 сая төгрөг буюу 99.4%
20.2.9	Нийгмийн халамж	Батлагдсан төсөв төлөвлөгөөт хугацаандаа зорилтот бүлгийн иргэдэд хүрсэн байх	99.8	1,446.8	1,443.7	Тэтгэмж цаг хугацаандаа олгогдож байгаа. Төсвийн гүйцэтгэл 1,443.7 сая төгрөг буюу 99.8 хувь байна. Аймгийн халамжийн сангийн 2020 оны батлагдсан төсөв 963.6 сая төгрөг, үүнээс амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн гүйцэтгэл 118.4 сая төгрөг буюу 99 хүнд, бусад тэтгэмж, хөнгөлөлт 745.8 сая төгрөг буюу 397 хүнд, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж 25.9 сая төгрөг буюу 623 хүнд үзүүлсэн байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
20.2.10	Ахмад насны хөгжил хамгаалал	Ахмадын асрамж үйлчилгээний төвийн асруулагчдад үзүүлэх үйлчилгээ бүрэн хүрсэн байх	100.0	548.0	483.8	Энэ хөтөлбөрт асрамж үйлчилгээний газрын болон аймгийн ахмадын хороонд олгодог санхүүгийн дэмжлэг багтаж байна. Асрамжийн газрын тухайд 2021 онд 44-49 хүн үйлчлүүлсэн бөгөөд эдгээр үйлчлүүлэгчдийн эрүүл ахуй, хоол хүнс, эмнэлгийн үйлчилгээг байнгын чанартай хүргэсээр байна. Асруулагчдад шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлээр ханган ажилласнаар асруулагчдын өвчлөл тодорхой хэмжээгээр багассан үр дүнтэй байна. Асруулагчдад норм нормативын дагуу өвөл, хавар, зун, намрын болон хувь хүний онцлог, насны онцлогт тохирсон чанартай хувцас хэрэгслийг 4 удаа олгосноор ахуйн хэрэглээний хэрэгцээ хангагдсан. Мөн сар бүр ариун цэвэр ахуйн хэрэглээг хангаснаар асруулагчдын ариун цэвэр амьдрах орчин нь цэвэр цэмцгэр орчинд амьдарч байна. Ахмадын хорооноос ахмадын сан байгуулж ажиллуулах чиглэлийг төсөвт байгууллагуудад хүргүүлж анхаарсны үр дүнд 10 агентлаг, сумдаас 20 гаруй төсвийн байгууллага ахмадын сан байгуулж төсөв хөрөнгө батлан үйл ажиллагаагаа жигдүүлээд байна. Ахмадуудад эрүүл мэндийн чиглэлээр сургалтуудыг удаа дараа зохион байгуулж хэвтэрт байгаа ахмадуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээр үзүүлж хэвшээд байна. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг асуудлаар аймгийн ХХҮГ-тай хамтран ажиллаж байгаа бөгөөд тодорхой үр дүн гарч эхлээд байна. Аймгийн асрамжийн үйлчилгээний жилийн төсвийн гүйцэтгэл 483.8 сая төгрөг буюу 99.9%-ийн гүйцэтгэлтэй байна.
20.2.11	Ангилдаагүй бусад	Цаг үеийн шинж чанартай, зайлшгүй хийж гүйцэтгэх ажил, арга хэмжээг санхүүжүүлж, ард иргэд олон нийтэд хүртээмжтэй байдлаар үр дүнтэй зарцуулах, хэрэгжүүлэх.	100.0	396.1	339.2	Үүнд аймгийн баяр наадмын зардал, сайн малчин тариачны шагнал, алдар гавьяа амжилтын буухиа арга хэмжээний зардал, хэрэглэгчийн үнэлгээ хийх зардал зэрэг засаг даргын хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, цаг үеийн шинжтэй бусад шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэх зардлууд багтаж байгаа бөгөөд зориулалтын дагуу зарцуулж байна. Гүйцэтгэл 339.2 сая төгрөг буюу 87.9%-тай байна.
20.2.12	Усан хангамжийн татаас	Усны үнийг тогтвортой байлгах	100%	308.8	308.8	Усны үнийг тогтвортой байлгах. Өгөх дэмжлэг 308.8 сая төгрөг.
20.2.13	Ойжуулалт	Аймгийн ойн нөөц бялгийг тогтоох, хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг зохион байгуулах	100%	180.6	174.5	Цагаан-Үүр, Жаргалант, Мөрөн, Улаан-Уул сумдад үйл ажиллагаа явуулж байгаа ой ангиудад олгож байгаа санхүүгийн дэмжлэгийн дүн, төсөв замаар байгаа бөгөөд батлагдсан хуваарийн дагуу бүх санхүүжилтийг олгож байна. 4-н ой ангийн тухайд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын шийдвэрээр аймгийн бүх сумдын хуваан хариуцаж бөгөөд хариуцсан сумдаа ой хэргийн түймрээс урьдчилан сэргийлэх, байгаль орчныг нөхөн сэргээх зэрэгт холбогдох сургалт сурталчилгаа явуулахын зэрэгцээ мод бэлтгэл, ойжуулалт, ойн хортонтой тэмцэх мэргэжлийн байгууллагуудын мэргэжил арга зүйгээр ханган хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна. Ой ангиуд нь нийт төсвийн 46-55%-ийг нь өөрийн орлогоор бүрдүүлж байгаа бөгөөд татаасаар авч байгаа санхүүгийн дэмжлэгийг ажиллагсдын цалинд зарцуулж байна. Жилийн төсвийн гүйцэтгэл 174.5 сая төгрөг буюу 96.6%.
20.2.14	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	СХС-ийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах, зээл олголтыг нэмэгдүүлэх	45	2,567.5	1,154.4	Сум хөгжүүлэх сан нь Хоршоог хөгжүүлэх сан болон өөрчлөгдөж байгаагаар холбоотой зээл олголтын үйл ажиллагаа зогссоной холбоотой. Гарсан гүйцэтгэл 1,154.4 сая төгрөг буюу 45.0%
20.2.15	Орон нутгийн нөөц хөрөнгийг журамд заасан хүрээнд шаардлагатай зардлуудад хуваарилан зарцуулах	Санхүүжилтийг төлөвлөгөөт хуваарийн дагуу бүрэн олгох, журмын дагуу зарцуулах	99.8%	423.2	422.4	Онцгой байдал, ган зуд, үер усны аюул осол, хүн малын гоц халдварт өвчний улмаар гарсан хожирол барагдуулахад зарцуулж байна. Нөөц хөрөнгө зарцуулах журамд заасан 30% буюу түүнээс дээш хувийг 2.1.1, 2.1.2 дахь заалтын дагуу зарцуулах ба зарцуулахгүй үлдэгдлийг тооцон ажиллаж байна.
20.2.16	Хууль тогтоомжийн дагуу аймгийн Засаг даргын хүлээлгэсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах.	Тухайн төсвөөр хэрэгжүүлэх ажил үйлчилгээг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх	99.1	909.1	900.7	Үүнд аймгийн баяр наадмын зардал, сайн малчин тариаланчдын шагнал, алдар гавьяа амжилтын буухиа арга хэмжээний зардал, хэрэглэгчийн үнэлгээ хийх зардал зэрэг Засаг даргын хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, цаг үеийн шинжтэй бусад шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэх зардлууд багтаж байгаа бөгөөд зориулалтын дагуу зарцуулж байна.
20.2.17	Ус түгээгч аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжиж төсвөөс татаас өгөх.	Усны үнийг тогтвортой байлгах	100	318.8	318.8	Ус түгээгч аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжиж ОНХСангийн суурь зардлаас 308.8 сая төг. Орон нутгийн орлогоос 10,0 сая төг нийт 318.8 сая төгрөгийн татаасыг олгосон.
20.2.18	Ойжуулалт	Аймгийн ойн нөөц бялгийг тогтоох, хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг зохион байгуулах	98.1	159.6	156.5	Цагаан-Үүр, Жаргалант, Мөрөн, Улаан-Уул сумдад үйл ажиллагаа явуулж байгаа ой ангиудад олгож байгаа санхүүгийн дэмжлэгийн дүн, төсөв замаар байгаа бөгөөд батлагдсан хуваарийн дагуу бүх санхүүжилтийг олгож байна. 4-н ой ангийн тухайд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын шийдвэрээр аймгийн бүх сумдын хуваан хариуцаж бөгөөд хариуцсан сумдаа ой хэргийн түймрээс урьдчилан сэргийлэх, байгаль орчныг нөхөн сэргээх зэрэгт холбогдох сургалт сурталчилгаа явуулахын зэрэгцээ мод бэлтгэл, ойжуулалт, ойн хортонтой тэмцэх мэргэжлийн байгууллагуудын мэргэжил арга зүйгээр ханган хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна. Ойн ангиуд нь нийт төсвийн 46-55%-ийг нь өөрийн орлогоор бүрдүүлж байгаа бөгөөд татаасаар авч байгаа санхүүгийн дэмжлэгийг ажиллагсдын цалинд зарцуулж байна.
20.2.19	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, СХС-ийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах, зээл олголтыг нэмэгдүүлэх. Батлагдсан төсөв 2,870.6 сая төгрөг	Зээлийн эргэн төлөлт болон зээл олголтыг өмнөх оноос 5%-иар нэмэгдүүлэх	57.8	2,568.6	1,486.0	Зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгааг шалтгаалж зээл олголт бага хийгдсэн.
20.2.20	Хот тохижуулалт	Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлах хамгаалах, хог хаягдлын болон зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, золбин нохойн устгалыг хийх.	100	1,019.6	1,019.6	Төв замын дагуух ногоон байгууламжид 22 мянган ширхэг хайлаас тарьж хотын ногоон байгууламжийг 25 мянгад хүргэсэн, үүнд 14 нэр төрлийн модлог ургамал багтдаг. Мөн зуны сард хотын төвөөр 10 мянган ширхэг цэцэг тарьсан. Сард дунджаар 2334.3 тн буюу жилийн дүнгээр 21011.6 тн хог ачиж түрж бүлсэн. 103,1 мянган м2 авто зам, 33.2 мянган м2 явган зам, 23.6 мянган м2 авто машины зогсоолын талбайг цаг хугацаанд нь цэвэрлэж байна. Энэ онд 586 золбин нохой устгасан бөгөөд өмнөх оны мөн өдөр 512 нохой устгаж байсантай харьцуулбал 9.9%-иар нэмэгдсэн байна. Төсвийн гүйцэтгэл 100.0%-тай байна.
20.2.21	Гудамжны гэрэлтүүлэг	Гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, асалтын чанар байдлыг сайжруулах.	10000.0%	133.4	114.4	Гэрэлтүүлгийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаагийн хэрээр зардал өндөр гарч байна. Төсвийн гүйцэтгэл 114.4 сая төгрөг буюу 85.7% байна.
20.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			87,174.5	85,917.7	
20.3.1	Сургуулийн өмнөх боловсрол					
20.3.1.1	Цэцэрлэгийн өдрийн үйлчилгээ	СӨБ-н бага насны хүүхдийн хөгжлийн стандарт хэрэгжиж, сургалт хүмүүжлийн таатай орчин бүрдэнэ.				Төсвийн гүйцэтгэл 17,762.2 төгрөг буюу 97.8%. 9218 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг төрийн 39, төрийн бус өмчийн 6 цэцэрлэгээр дамжуулан хүргэсэн. Ингэснээр сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт Хөвсгөл аймагт 80.8% болсон. 2019-2020 оны хичээлийн жилд "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөвсгөл аймгийн цэцэрлэгүүдийн 62% нь хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн шалгуурыг хангасан. Сургуулийн өмнөх бага насны хүүхдийн хөгжлийн стандарт гараагүй бөгөөд сургуулийн өмнөх боловсролын орчны стандарт MNS 6558.2015 хэрэгжиж байна.
20.3.1.2	Хувилбарт сургалтын үйлчилгээ.	Нүүдлийн, ээлжийн, явуулын сургалтын хэлбэрээр СӨБ-д хамрагдаагүй хүүхдийг хамруулж хамран сургалтын нэмэгдүүлнэ. /1925 хүүхэд/	97.8	18,161.8	17,762.2	Хувилбарт сургалтаар 1729 хүүхэд хамрагдаж нүүдлийн цэцэрлэг, явуулын цэцэрлэгээр дамжуулан сургуулийн өмнөх боловсролыг үзүүлсэн. Ингэснээр цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдийг бүрэн хамруулсан байна
20.3.1.3	Нийгмийн баталгааг хангах	СӨБ-н ажиллагсад хамрагдана				Тэтгэмж авах болзол хангагдсан бүх албан хаагчид холбогдох тэтгэмжээ бүрэн авсан.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилгот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/	
	20.3.1.4	Хувийн хэвшлийн татаас	Мөрөн суманд 5, Жаргалант суманд 1 нийт 6 хувийн цэцэрлэгт 452 хүүхэд хамруулна.			Хувийн цэцэрлэгүүдэд санхүүжилтийг бүрэн олгож байна, аймгийн хэмжээнд төсвийн татаас авч байгаа 6 хувийн цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа ба Төсвийн гүйцэтгэл 443.0 сая төгрөг буюу 100.0%, хамрагдаж байгаа 558 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэсэн.	
	20.3.2	Соёл урлаг Орон нутгийн иргэдэд урлаг соёлын үйлчилгээг хүргэх	Хүн амд хүрэх урлаг соёлын үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэнэ.	98.7	3,905.7	3,854.3	Мэргэжлийн урлагийн байгууллага болон сумдын соёлын төвүүд аялагдсан сум багийн иргэдэд соёлын үйлчилгээг хүргэсэн. 2021 онд соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулсан эвент арга хэмжээнүүдэд орон нутгийн онцлог бүхий соёлын биет бүс өвүүдийг түгээн дэлгэрүүлсэн. Нийтийн номын сангийн үйлчилгээг сайжруулж улсын хэмжээнд тэргүүн байр эзэлсэн амжилт гаргалаа. Аймгийн Орон нутгийн судлах музей улсын тооллогыг амжилттай зохион байгуулсан. Энэ онд нийт давхардсан тоогоор 235 гаруй мянган иргэнд урлаг соёлын үйлчилгээ үзүүлсэн.
	20.3.3	Ерөнхий боловсролын үйлчилгээ					
	20.3.3.1	Бага, суурь, бүрэн дүнд боловсрол олгох үйлчилгээ.	"Оюунлаг Хөвсгөл", Боловсролын шинэчлэл цөм хөтөлбөрийг хэрэгжүүлж хүүхэд бүрийн хөгжилд ахиц гарсан байна. /24817 хүүхэд/				
	20.3.3.2	Үдийн цайгаар үйлчлэх.	Хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр үйлчилнэ. /13466 хүүхэд/				
	20.3.3.3	Сургалтын хөвийн үйл ажиллагааг хангах.	"Хүүхдэд ээлтэй сургууль" хөтөлбөр хэрэгжиж, сурагчид, багш ажиллагсдын суралцах, ажиллах таатай орчныг бүрдүүлнэ. /35 сургууль/	98.9	49,057.1	48,517.5	Төсвийн гүйцэтгэл 48,517.5 сая төгрөг буюу 98.9%. Суралцагчийн тоо 27890. Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролд "Сайжруулсан сургалтын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэн Хичээлд суурилсан хөгжлийг дэмжих жил болгон зарласан. Үүний хүрээнд элсэлтийн ерөнхий шалгалтын онооны дундаж улсын дундаж үзүүлэлттэй ижил түвшинд байна. Хамрагдсан хүүхэд оны эхний төлөвлөлтөөр 13922 байсан бөгөөд хүүхдийн төрөлт, өсөлттэй холбоотойгоор 2019-2020 оны хичээлийн жилд шинээр 1 дүгээр ангид элсэн суралцагч 14323 болж нэмэгдсэн.
	20.3.3.4	Нийгмийн баталгааг хангах /ЕБС/.	Хуулийн дагуу тэтгэмжүүдийг олгодоно.				
	20.3.3.5	Хувийн хэвшлийн татаас.	Далай ван сургууль 167 хүүхэд хамруулан ЕБС-н үйлчилгээг үзүүлнэ.				
	20.3.4	Насан туршийн болон албан бус боловсрол					
	20.3.4.1	Насан туршийн боловсрол буюу дүйцсэн хөтөлбөрөөр боловсрол олгох үйлчилгээ.	Сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхэд, насанд хүрэгчдэд боловсрол олгож , завсардалтын тоо 20%-р буурна. /549 суралцагч/	97.4%	467.2	454.9	Төсвийн гүйцэтгэл 477.1 сая төгрөг буюу 96.2%. Сургууль завсардсан 374 хүүхдийг сургасан. Сургууль завсардсан хүүхдийн 74% нь сургуульд хамрагдсан. Огт сургуульд хамрагдаагүй, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 22 хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд хамруулсан. Хөвсгөл аймгийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд хамруулах чиглэлээр хийж буй ажлууд нь улсын хэмжээнд туршлага болж байгааг БСШУСЯ-аар, ХНХЯ-аар хамтарсан баг ирж туршлага судалсан. 2019 оны 12 сарын байдлаар хэвтрийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 97 хүүхэд сургуулийн гадна байна. цаашид эдгээр хүүхдүүдийг явуулын багш болон хувилбарт сургалтын арга хэлбэрээр дэмжин боловсролын үйлчилгээнд хамруулах шаардлагатай байна.
	20.3.4.2	Дотуур байрны үйлчилгээ.	"Хүүхдэд ээлтэй дотуур байр" хөтөлбөрийг хэрэгжүүлэн сурагчдын сурлагын амжилтад ахиц гарч, тав тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ. /3470 хүүхэд/				Төсвийн зарлагын гүйцэтгэл 4,710.7 сая төгрөг буюу 96.1% зарцуулсан. 3539 хүүхэд дотуур байрны үйлчилгээ авсан. Дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд шинээр Баянзүрх, Түнэл, Улаан-Уул сумдад 375 хүүхдийн шинэ дотуур байрыг барьж ашиглалтад орууллаа. Алаг-Эрдэнэ сумын сургуулийн 100 хүүхдийн дотуур байранд ус ариун цэврийн байгууламжийг шийдвэрлэн дотор ариун цэврийн өрөөтэй болсон. Ингэснээр хүүхдэд ээлтэй дотуур байр нэмэгдсэн.
	20.3.5	Биеийн тамир спортын арга хэмжээг улам өргөжүүлэх, шат шатны уралдаан тэмцээнд оролцогчдын тоо болон амжилтыг нэмэгдүүлэх	Шат шатны тэмцээнд оролцогчдын тоо болон амжилтыг нэмэгдүүлэх.	97.7	163.5	159.8	3 дугаар улирлын байдлаар аймгийн аварга шалгаруулах тэмцээн 25-г зохион байгуулсан бол улсын аварга шалгаруулах 32 төрлийн тэмцээнд тамирчин оролцуулсан. Нийтийн биеийн тамирын өдөрлөг 5 удаа зохион байгуулсан.
	20.3.6	Эмнэлгийн тусламж үйлчилгээ					
	20.3.6.1	Сумын эрүүл мэндийн төвийн анхан шатны тусламж үйлчилгээ	Нийт үзлэгийн 70%-д урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулсан байх. Эхний 3 сарын жирэмсний хяналтыг 90%-д, 6 буюу түүнээс дээш удаа жирэмсний хяналтын үзлэгт хамрагдалт 100%-	98.3%	14,335.0	14,091.8	Төсвийн гүйцэтгэл 14,091.8 сая төгрөг буюу 98.1%-ийн гүйцэтгэлтэй байна Аймгийн Эрүүл мэндийн газраас Сумдын Засаг дарга, ЭМТ-ийн дарга нартай 2019 оноос эхлэн хамтын ажиллагааны гэрээ байгуулан хагас бүтэн жилээр дүгнэн цаашид анхаарах асуудлуудад зөвлөмж чиглэл өгч хамтран ажиллаж хэвшсэн.
	20.3.6.2	Өрхийн эрүүл мэндийн төвийн анхан шатны болон НЭМ-ийн тусламж үйлчилгээ	Иргэд өмчлүүлсэн газрын хэмжээ нэмэгдэх, барилга байгууламжийн угсралтын ажилд хяналт хийх ажлыг чанарт ахиц гарах	100.0%	636.2	636.2	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрээг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж гаргахад Гурван гал ЭЭМТ бүрэн хангалттай, Далайн-элбэрэлт ЭЭМТ хангалттай, Дэлгэрмөрөн ЭЭМТ хангалттай, Энх-Үйлс ЭЭМТ-3 хангалттай, Энэрэл ЭЭМТ 324.3 буюу 90.0 % - бүрэн хангалттай тус тус дүгнэгдсэн байна.
	20.3.7	Газрын харилцаа, кадастр	Иргэд өмчлүүлсэн газрын хэмжээ нэмэгдэх, барилга байгууламжийн угсралтын ажилд хяналт хийх ажлыг чанарт ахиц гарах	100.0%	636.2	636.2	Сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу иргэнд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг аймгийн хэмжээнд нэгтгэн аймгийн ИТХ-аар батлуулан ажилласан. Орон нутаг хэрэгжүүлэх барилга байгууламжийн угсралтын ажилд захиалагчийн хяналт хийж ажиллаж байгаа бөгөөд Барилгын хөгжлийн төвтэй "Аймагт хэрэгжүүлэх барилга, байгууламжийн угсралтын ажилд захиалагчийн хяналт хийлгэх гэрээ" байгуулан ажиллаж байна.
	20.3.8	Хүүхэд хамгаалал, гэр бул залуучуудын хөгжлийн асуудлыг тодорхойлох, шаардлагатай ажил үйлчилгээг зохион байгуулах.	Эрсдэлийн түвшин өндөртэй нас насны хүмүүсийн тоог цөөрүүлэх, секс дугуйланд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх	98.4%	448.0	441.0	Үйл ажиллагааны чиглэлээр 11 төрлийн үйлчилгээг үзүүлснээр өмнөх хугацаанд эрсдэлийн түвшин өндөртөйд тооцогдож байсан 1241 насанд хүрэгч, 152 хүүхэд, 42 гэр бүлийн асуудлыг шийдвэрлэж ажилласан байна. Шатар, даам, саробан самбин болон урлагийн чиглэлээрх сургалтуудыг зохион байгуулж байгаа бөгөөд 372 хүүхэд хамрагдаж байна. Төсвийн гүйцэтгэл 441.0 сая төгрөг буюу 98.4%-ийн гүйцэтгэлтэй байна.
21	ХЭНТИЙ			96,670.3	86,864.7		
	21.1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа		2,008.5	1,944.6		
			Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017-2020 оны үйл ажиллагааны үндсэн зорилт бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг бүрэн тооцож ажиллах				

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төр/	Гүйцэтгэл /сар.төр/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
21.1.1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн орон нутаг, сонгогдсон тойрог, иргэдтэйгээ эргэх холбоотой ажиллах, бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах					Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 93 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдэв.
		Улсын Их Хурлын баталсан хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих Аймгийн Засаг даргын "8 Б" зорилт бүхий үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, дэд хөтөлбөрүүдийн заалт бүрийг хангуулах	100%		2,008.5	1,944.6	
21.1.2	ГХУСА33-ийн үйл ажиллагаа	"Ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026" хөтөлбөр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж, дэмжлэг үзүүлж ажиллах					Гэмт хэргийн гаралт, зөрчил өнгөрсөн оны мөн үеийнхээс 32-41 хувь түвшингээр буурсан үзүүлэлт гарсан.
		Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тэргүүлэгчдэд олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах,	100%				
		Сумдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга зүйн зөвлөгөө, санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллах					
		Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг байгууллагуудтай хамтарч ажиллах, бодлого, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх					
21.2	Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ				38,171.0	32,074.3	
21.2.1	Иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон төрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллана.	100%				Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
21.2.2	Орон нутгийн засаг захиргааны бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.	100%		20,369.7	18,983.0	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийг АИТХурлаар хэлэлцүүлэн 91,07 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдэв.
21.2.3	Орон нутгийн засаг захиргааны хяналт шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа	АИТХ-аар батлагдсан дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.	100%				Хэнтий аймгийн Засаг даргын 2016-2021 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 12 дэд хөтөлбөрийг 2017 онд аймгийн ИТХ-аар батлуулж, жил бүр төлөвлөгөө гарган ажиллаж байна.
21.2.4	Аймгийн орон нутгийн өмчийн газар	Худалдан авах ажиллагааны талаар: Төсөл, тендер шалгаруулалтыг цахим худалдан авалтад шилжүүлж, орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж ажиллах	100%		155.1	138.4	2021 онд хэрэгжсэн улсын болон орон нутгийн төсвийн, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон 17.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгүүдийн эзэмшигч, ашиглагч байгууллагуудыг тодруулан тухайн байгууллагын балансад бүртгүүлэх ажлыг зохион байгуулав. Мөн хандив тусламж болон байгууллага өөрийн нэмэлт санхүүжилтээр худалдан авсан нийт 5.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгүүдийг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэх зөвшөөрөл олгов.
		Өмчийн харилцааны талаар: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт тавьж өмч эзэмшлийн гэрээний дүгнэх ажлыг тогтмолжуулж өмч эзэмшлийн гэрээний үр дүнг байгууллагын дарга эрхлэгч нарын жилийн ажлыг дүгнэх нэг үзүүлэлт болгож хэвших, үл хөдлөх хөрөнгө болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөдлөх хөрөнгийг олж авах саналыг хэрэгцээ шаардлагад нь үндэслэн ОНӨГазрын зөвшөөрлөөр тухайн оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж батлуулж ажиллах	100%				
		Ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах, ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажил	100%				Дадал, Цэнхэрмандал, Баян-Адарга, Өмнөдэлгэр, Батширээт сумдад ойн мэргэжлийн байгууллагуудын өөрийн хөрөнгийн ойжуулалт 87 га талбайд хийгдсэн бөгөөд 38 га талбайн ойжуулалтын зардал 44,7 сая төгрөг барьцаа байдлаар байршуулаад байна. Нийт өөрийн хөрөнгийн ойжуулалтын хэмжээ 125 га талбайд хийгдсэн байна.
		Жилд хүлээн авах гадаад, дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлэх	100%				43500

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
21.2.5	Байгаль орчин аялал жуулчлалын газар	Гадаргын усны тооллого зохион байгуулах		100%	830.1	812.8	Хэрлэн голын сав газарт хамаарах 11 сум, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт хамаарах -3 сумын нутаг дэвсгэрт гадаргын болон гүний усны тоо бүртгэлийн ажлыг сав газрын захирагдтай хамтран зохион байгуулж, мэдээллийн санд бүртгэсэн.
		Онон голыг онцгой хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх		100%			Онон голын онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор Батширээт, Биндэр, Баян-Адрага сумдын нутаг дэвсгэрт 40ш тэмдэгжүүлтийг Цахиурт Өндөр ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.
		Ядарсан, гэмтсэн, дүрвэсэн амьтдыг тэжээн тэнхрүүлэх хоргодох байр, хашаа барих		100%			Ядарсан гэмтсэн, дүрвэсэн амьтдыг тэжээн тэнхрүүлэх зорилгоор шургаагаар 98 м2 хоргодох байрыг Мөрөн сумын нутаг дэвсгэр Өндөрхан ууланд байгуулсан. Уг ажлыг "Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн холбоо" ТББ хийж гүйцэтгэсэн.
		Зэрлэг амьтанд гоц халдварт өвчний тандан судалгааг явуулж, нэн ховор, ховор амьтны байршил нутагт биотехникийн арга хэмжээ авах, тэжээлийн цэгийг бий болгож, мониторинг судалгааг явуулах		100%			БОАЖЯ-ны тусгай зөвшөөрлөөр Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт судалгааг 8 сумын нутаг дэвсгэр 16 цагаан зээрээс авсан. Шинжилгээгэр гоц халдварт өвчин илрээгүй. Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн холбоо ТББ-тай хамтран Батширээт, Биндэр сумын нутаг дэвсгэрт амьдардаг ховор амьтдад биотехникийн арга хэмжээ авсан.
		Хэнтий аймгийн Хэрлэн голын агнуурын ач холбогдолтой загасны нарийвчилсан агнуур зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөө боловсруулах		100%			Хэрлэн голын агнуурын ач холбогдолтой 9 сумын нутаг дэвсгэрт Загасны нарийвчилсан агнуур зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллага болох Эко үйлчилгээ ТББ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, БОАЖЯ-нд хүргүүлж батлуулсан.
21.2.6	Сумдын ойн анги	Ойжуулалт		100%	166.7	137.6	60 га
		Ойн хөнөөлт шавьж устгах ажил		100%			1000 га
		Тарьц, суулгац үржүүлэх		100%			100 ширхэг
		Ногоон байгууламж нэмэгдүүлэх ажил		100%			5 га
		Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах ажил		100%			2 удаа
		Ойн нөхөрлөлийн ойн менежмент төлөвлөгөөнд хяналт тавих, "Нөхөрлөл хөгжил" 2019 наадмыг зохион байгуулах		100%			1 удаа
21.2.7	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	Төсөл арга хэмжээг бүрэн санхүүжүүлж ажиллана.	100%	1,906.4	1,452.0	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 898.5 сая төгрөгийн 38 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлан ажилласан.	
21.2.8	Орон нутгийн хөгжлийн сан	Төсөл арга хэмжээг бүрэн санхүүжүүлж ажиллана.	100%	10,880.5	9,377.4	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд 6723.9 сая төгрөгийн 194 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлан ажилласан.	
21.2.9	Аймгийн халамжийн сан	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чанартай хүргэх төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэн ажиллана.	100%	133.5	110.7	ОНОТХУ-ний бүлгийн төслийг 17 сум, тосгоноос ирүүлсэн төслүүдээс 28 бүлгийн 65 иргэний төслийг шалгаруулж, 38890,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна. ХХҮЕГЗраас магадлан итгэмжлэгдсэн "Оточ гурван эрдэнэ" "Билиг барамид" ТББ байгууллагуудаар уламжлалт аргаар сэргээн засах үйлчилгээг үзүүлж 5838,0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 38 ахмад настны эрүүл мэндийн байдалд нь дэмжлэг үзүүлээд байна. Амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийн үйлчилгээнд гэнэтийн аюул ослын улмаас гэр оронгүй болсон, 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өгчигч болсон, хорих ангис суллагдсан гэр оронгүй иргэн, амьжиргааны эх үүсвэрээ алдсан иргэдэд 66000,0 мянган төгрөгийн тэтгэмж олгож 55 өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлж ажилласан.	
21.2.10	Санхүүгийн хяналт, аудитын алба	Байгууллагын дотоод хяналтын нэгжийн ажлыг тогтмолжуулж, эрсдэлийг тодорхойлж түүнийг бууруулах, гаргахгүй байхад анхааран ажиллана		100%	129.6	125.4	2021 онд төлөвлөгөөт 84 байгууллага хамрагдахаас 80, төлөвлөгөөт бус 4 нийт 84 газарт санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдсэн. Үүнээс эрсдэл тооцоход санхүүгийн хяналт шалгалт хийгдсэн 74 байгууллагаас 2 байгууллага дунд түвшинд, 72 байгууллага бага түвшинд үнэлэгдэж бага эрсдэлийн эзлэх хувь 97% ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3%-иар өссөн.
		Төсөвт байгууллагуудад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, эрсдэлийг бууруулан санхүүгийн үйл ажиллагааг сайжруулна		100%			Шилэн дансны улирлын тайлан илгээлт 99%-тай, сарын мэдээлэл эхний 11 сарын байдлаар нийт 24931 талбарыг мэдээлэхээс 24376 талбар мэдээллийг хугацаандаа мэдээлж хэрэгжилт 98%-тай хэрэгжиж мэдээллийн их бүрэн байдал 98,5%-тай хэрэгжсэн.
21.2.11	Сангууд	Зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх		80%	3,599.4	937.0	Зээлийн эргэн төлөлтийг 80 хувиар эрчимжүүлэв.
21.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ				56,490.8	52,845.8	
21.3.1	Сургуулийн өмнөх боловсрол	Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж 2-5 настай хүүхдийг бүрэн цэцэрлэгт хамруулах		100%	15,609.3	14,345.6	Ковид-19 цар тахлын улмаас БШУ-ны сайдын тушаал гарч анги дүүргэлтийг багасгах чиглэл өгсний дагуу хүүхдийн хамрагдалт багассан. Энэ онд нийт хүүхдийн 82,2%-ийг хамруулсан.
21.3.2	Ерөнхий боловсрол	Ерөнхий боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, хамтран сургалтыг өмнөх оныхоос 1,7 хувиар нэмэгдүүлнэ. Дотуур байрны хамрагдалтыг өмнөх оныхоос 2,8 хувиар нэмэгдүүлнэ.		100%	25,552.8	24,113.0	Статистик тоо мэдээгээр 17483 хүүхэд байгаагийн 15889 хүүхэд буюу 90,8 хувь нь Хэнтий аймагт ЕБС-д хамрагдаж байна. Бусад хүүхдүүдийн хувьд суурь боловсрол эзэмшин сургуулиас гарсан, дараагийн шатны буюу МСУТ, Политехникийн коллежид орсон, өөр аймаг сум руу шилжсэн шалтгаантай байна. Дотуур байранд суух хүсэлт гаргасан 1592 хүүхдийн 1470 буюу 92,3%-ийг хамруулсан.
	Сумдын соёлын төвүүд	Үзэгчдийн эрэлт хэрэгцээг хангасан соёл олон нийтийн шинэлэг үйлчилгээг тасралтгүй явуулахад анхаарч, соёлын төвийн үзэгчдийн тоог нэмэгдүүлэх		100%	2,818.1	2,574.9	Соёлын төвүүдийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан.
		Музейн сан хөмрөгийг баяжуулж, улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэн баримтжуулах		100%	197.6	194.9	Хан Хэнтий уулын аймгийн 100 жилийн ой 2023 онд тохиох бөгөөд энэ жил "Халхын Сэцэн ханууд" сэдэвт ном бүтээх, ажлын хэсэг байгуулж төлөвлөгөө боловсруулан, холбогдох судалгаа шинжилгээний байгууллагатай хамтран гэрээ байгуулж ажиллахаар төлөвлөсөн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
21.3.3	Музей	Түүх, соёлын үл хөдлөх 6730 дурсгалын 50-иас доошгүй хувийг сумдын ЗДТГ-тай хамтран Иргэдийн оролцоотойгоор соёлын үл хөдлөх дурсгалын 10% нь харуултай хамгаалалттай болсон байх	100%			Улсын бүртгэл мэдээллийн сангийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нэгдсэн бүртгэлд Хэнтий аймгийн 992 дурсгалт газрын 6885 дурсгал бүртгэлтэй байдаг. Үүнээс 2016-2020 оны байдлаар нийт дурсгалын 64,5 хувийг гэрээт харуултай болгож ажиллалаа.
	Номын сан	Ном уншлагыг дэмжих олон талт арга хэмжээг зохион байгуулж, номын сангаар үйлчлүүлэх уншигчдын тоог нэмэгдүүлэх, номын фондыг цахим каталогт оруулах,	100%	133.5	127.0	Khenti.LIB4U.net цахим програмд 22611 нэр төрлийн 52161 сан хөмрөгт буй нийт номын каталогийг 100 хувь цахимжуулж цахим бүртгэлийн програмд тайлант хугацаанд 2687 уншигч-үйлчлүүлэгчид хандаж хайлт хайлтын үйлчилгээ авч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.4 хувиар өссөн байна
		Хүүхэд залуусын номтой нөхөрлөх иргэд олон нийтийн ном унших боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Ном уншигчаа" хөдөлгөөнийг өрнүүлэх	100%			Сан хөмрөгийн болон нийтийн уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхим, гэрээр ном олгох танхимуудын хуучирч элэгдсэн болон шинээр ирсэн 4964 номд сэлбэн засалт хийж сан хөмрөгтөө буй ном хэвлэлийг цахимаар байнга сурталчилж байна.
		"Үндэсний бичиг соёлын өдөр"-ийн хүрээнд "Бичиг үсгийн баяр" монгол бичгийн "Уран бичлэг"-ийн уралдаан зохион байгуулах	100%			Зөөврийн номын сангийн үйлчилгээг аймгийн ШШГГазар, ДЗОУБ-ын ОНХХ-ийн хамт олон, ЕБ-ын Тэмүүжин цогцолбор сургууль, худалдаа үйлчилгээ Бэртэ молл ХХК, Цэцэн хан өлгий ХХК болон Жаргалтхаан, Батширээт, Баян-Овоо, Хэрлэн сумдын Соёлын төв зэрэг 5 сумын 11 аж ахуйн нэгж, байгууллагын 760 хүнд давхардсан тоогоор 4516 номоор үзүүлээ.
21.3.4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хүний нөөцийн хангалтыг сайжруулах, эхийн эндэгдэлгүй ажиллах, нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг улс, аймгийн дундаж түвшинд хүргэх, жирэмсний эрт үеийн хяналтыг сайжруулж 85,0 хувьд хүргэх, зорилтот насны хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж ажиллах	100%	9,745.7	9,476.8	Жирэмсний эрт үеийн хяналт 2020 онд 88,3%, 2021 онд 91,3% байгаа нь оны эцсийн зорилтот түвшинд хүрж 3%-иар өссөн үзүүлэлттэй байна. Жирэмсэн ээжүүдийн томуугийн вакцинуулалт 16-24 насанд 7.5%, 25-34 насанд 30,5%, 35-49 насанд 12,5% хамрагдсан байна.
		Халдварт өвчний гаралтыг бууруулж улсын дундаж түвшинд хүргэх. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр: Хүн амын эрүүл мэндийг дэмжих, эрүүл бус зан үйлийг өөрчлөх, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн ажиллах, товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлнэ.	100%			Хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг сэдэвчилсэн төлөвлөгөөний дагуу сар бүр зохион байгуулан ажиллаж байна. Товлолт дархлаажуулалтыг 98,9 хувьд хүргэн ажилласан.
21.3.5	Газрын харилцаа, кадастр	төлөвлөгөөг хэрэгжүүлэх, аймгийн эдийн засаг нийгмийн зорилтыг хот байгуулалт, төлөвлөлийн бодлоготой уялдуулан хотын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах газрын кадастр эрхлэх, мэдээллийн сан байгуулж иргэдэд мэдээллээр үйлчлэх	100%	632.2	576.6	Монгол Улсын Хаягжуулалтын тухай хууль, Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам", MNS 5283:2014 стандартын дагуу хаягийн тэмдгийг суурилуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. "Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан"-ийн программ хангамжийг нэвтрүүлж барилга байгууламжийн суурь мэдээллийг бүрэн оруулаад байна.
21.3.6	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Хууль зөрчсөн болон хохирогч хүүхдэд хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үзүүлсэн үйлчилгээний үр дүн, шийдвэрлэлтийн хувь	100%	347.5	342.5	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо 11 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа ба 2020 оны ажлын төлөвлөгөөг батлан ажилласан.
		Хүүхдийн спортын их наадмыг орон нутагт зохион байгуулах, шигшээ тэмцээнд оролцох	10000%	203.4	203.4	Бүх төрөлд амжилттай оролцсон.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төр/	Гүйцэтгэл /сар.төр/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
21.3.7	Нийтийн биеийн тамир	Нийтийн биеийн тамир, спортыг орон нутагт хөгжүүлэх "Эрүүл мэнд-Хөдөлгөөн-Хөгжил" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх		100			Хөтөлбөрийн хэрэгжилт 70%-тай байна.
		Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих		100			ӨШБагийн үйл ажиллагаа хэвийн явагдах таатай орчныг бүрдүүлэн ажиллаж байна
		Хан Хэнтий нутгаас Олон улс, Тив, дэлхий, олимпын наадмын спортын тэмцээн уралдаанд оролцож амжилт гаргасан гаргасан тамирчид, багш, дасгалжуулагчдыг урамшуулах		80			Медаль хүртсэн тамирчдыг хамруулсан.
		Спортын эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн сан байгуулах		100			Сан бүрдүүлэлтийг 70%-д хүргэсэн.
		Шигшээ багийн дасгалжуулагч, тамирчдын мэдээллийг программд шивж санг бүрдүүлэх.		70			Шигшээ багийн дасгалжуулагч, тамирчдын мэдээллийг программд шивж санг бүрдүүлэн ажилласан.
		Дасгалжуулагч, тамирчдыг мэдлэг, мэргэжил, үр чадварыг сайжруулах, туршлага солилцох гадаад, дотоодын хамтарсан бэлтгэл, сургалт семинарт хамруулах, орон нутагт зохион байгуулах.		90			4-5 удаа оролцуулж, улирал бүр сургалт зохион байгуулсан
21.3.8	Хан Хэнтий чуулга	Зүүн монголын уламжлалт соёлын өвийг хадгалан хөгжүүлж, зорилтот зах зээлд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ, уран бүтээлийг хүргэдэг бүс нутгийн тулгуур чуулга болно	1	1,250.7		891.1	Нөөцийн удирдлагыг оновчтой зөв ашиглаж, чанартай уран бүтээл туурвижын тулд Монголын Морин Хуур Чуулгын ерөнхий удирдаач Улсын Филармонийн уран сайхны удирдагч Д.Түвшинсайханаар удирдуулан хөгжмийн тоглолт зохион байгуулах болсонч тоглолт цуцлагдсан, үзвэр үйлчилгээний чанар дээр анхааран үзэгчдэдээ тав тухыг үзүүлэх зорилгоор теле тоглолтуудыг онлайнгаар тоглож үзэгчдийн хүртээл болгоод байна.
22	УЛААНБААТАР				1,779,149.7	1,591,452.5	
22.1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа				43,072.8	39,873.8	
22.1.1	Нийслэл, дүүргийн ИТХ-ын үйл ажиллагаа	ИТХ-ын чиг үүргийг цаг хугацаанд бүрэн хэрэгжүүлэх.	НИТХ-ын ээлжит хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдааныг төвлөсөн хугацаанд багтааж хуралдаж, хэлэлцэх асуудлыг бүрэн шийдвэрлэсэн.	26,720.5		24,519.0	Монгол Улсын хууль тогтоомж, Төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхтэй уялдуулан нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулан хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэд хөтөлбөр, төсөл, журмыг хэлэлцэн баталж, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Нийслэлийн ИТХ-ын Хуралдааны дэгийн дагуу 2021 онд ээлжит хуралдаан 6 удаа, ээлжит бүс хуралдаан 4 удаа, нийт 10 удаа цахимаар тус тус зохион байгуулж, нийт 31 асуудал хэлэлцэж 24 тогтоол гарсан
22.1.2	ГХУСА33-ийн үйл ажиллагаа	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуульд заагдсан арга хэмжээг хуулийн дагуу бүрэн хэрэгжүүлэх.	Олон нийтийн цагдаа, оюутан цагдаа, урамшилт эргүүл болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг хуулийн хүрээнд санхүүжүүлсэн.	16,352.2		15,354.8	Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн 2021 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу батлагдсан төлөвлөгөөний үйл ажиллагааны хөтөлбөр тус бүрээр төсвийг зарцуулсан
22.2	Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ				1,249,127.4	1,076,582.5	
22.2.1	Орон нутгийн гүйцэтгэх засаглал, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	Орон нутгийн гүйцэтгэх засаглал, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээнд шинэ менежмент нэвтрүүлэх, мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглах, төрийн албан хаагчийн мэдлэг, үр чадвар, хариуцлагыг дээшлүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд ШУУРХАЙ, ТЭГШ, НЭЭЛТТЭЙ хүргэнэ.	186,961.4		166,852.4	2021 онд батлагдсан нийт зарлагын төлөвлөгөөний биелэлт 76.7-тай гарсан. Энэ нь Монгол улсын засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай" 114 дүгээр тогтоол, "Коронавирус халдварын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай" 168 дугаар тогтоол, "Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай" 187 дугаар тогтоолуудын дагуу төсвийн байгууллагуудын зардлыг эрэмбэлэн санхүүжүүлэх, зарим зардлын санхүүжилтийг түр зогсоосонтой холбогдон гарсан хэмнэлт болно. Иргэн хуулийн этгээдийн төрийн үйлчилгээ авах эрэлт, хэрэгцээнд тулгуурлан үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, бүх шатны төрийн байгууллагатай хамтарч ажиллах ажлын хүрээнд: Төрийн захиргааны төв болон нийслэлийн нутгийн захиргааны нийт 19 байгууллагын 108 нэр төрлийн төрийн үйлчилгээг үзүүлж байсан бол 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн байдлаар 22 байгууллагын 177 нэр төрлийн төрийн үйлчилгээ болж нэмэгдэн, оператор хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд нээлттэйгээр үзүүлж байна. Үүнд: Төрийн 11 байгууллагын 98 нэр төрлийн төрийн үйлчилгээг www.operator.e-mongolia.mn нэгдсэн системээр, оператор ажилтнууд үзүүлж байна.
22.2.2	Хот төлөвлөлт, барилгажилт	Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг" – ийн хүрээнд ажиллана.	Улаанбаатар хотыг 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийн дагуу хотын дагуул, хаяа хот, тосгонд нутаг дэвсгэрийн бүсчлэлийн чиглэлээр хөгжүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.	10,386.0		9,764.7	"Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/-ыг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 35 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Монгол улсын Засгийн газраас өгсөн үүрэг даалгаврын дагуу Барилга, хот байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч хамтран "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар"-ыг баталж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-тай байгуулан ажиллаж, эхлэлийн тайлан гарсан. Өдоогоор Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгавар"-ыг батлуулж боловсруулах ажил хийгдэж байна.
22.2.3	Нийслэлийн өмчийн хэрэгжүүлэх	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар нийслэлийн өмчийн бүртгэл, хяналт, үйл ажиллагааг хариуцан ажиллана.	Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот 23 үйлдвэрийн газрын ашигт үйл ажиллагааг нэмэгдүүлэх, нийслэлийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллана.	1,746.5		1,229.9	Нийслэлийн Өмчийн ашиглалт хадгалалт хамгаалалт, бүртгэл хяналт тавьж аж ахуйн тооцоот нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжруулах үр ашгийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сар.төг/	Гүйцэтгэл /сар.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	22.2.14	Хот тохижуулах үйл ажиллагаа	НИТХ-ын 2013 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр" болон бусад хот тохижуулах үйл ажиллагааны хөтөлбөр арга, хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулна.	ан м2 талбайд цэцэрлэгжүүлэлтийн а	92,837.3	90,763.6	Дүнжингарав худалдааны төвөөс зүүн тийш Улиастайн фрезер хүртэл замын хойд хэсэгт үүссэн хур хогийг ХТГ-тай ажил гүйцэтгэх гэрээгээр, БГД ийн 20 р хороо 4-р цахилгаан станцын зүүн урд үүссэн хур хогийг ХТГ-тай ажил гүйцэтгэх гэрээгээр,СХД ийн 32-р хороо Эмээлтэд малын сэг зэм бүхий хур хогийг СХД-ийн Тээвэрлэлт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-аар ажил гүйцэтгэх гэрээгээр, СХД ийн 21-р хороо Жаргалант тосгонд үүссэн хур хогийг ХТГ-тай ажил гүйцэтгэх гэрээгээр, Налайх Төв аймгийн Сэргэлэн сумын заагт Олон улсын зам дагуу үүссэн хур хогийг Улаанбаатар шинэчлэл ХХК-тай шууд гэрээгээр, СБД-ийн 19-р хороо, Санзайн зам дагуу үүссэн хур хогийг ХА-аар Улаанбаатар шинэчлэл ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулан гүйцэтгүүлэв. БГД-ийн 20-р хороо Эрчим хүчний гудамжны явган хүний зам дээр олон жил журимтлагдсан шороог цэвэрлүүлэх ажлыг тухайн замыг арчилдаг Улаанбаатар шинэчлэл ХХК-аар ажил гүйцэтгэх гэрээгээр тус тус гүйцэтгүүлэв.
	22.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ			486,949.6	474,996.2	
	22.3.1	Сургуулийн өмнөх боловсрол	Нийслэлийн Боловсролын салбарын батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээний дагуу хуваарилан дүүргүүдэд, дүүргүүд төсвийн шууд захирагч нарт хуваарилах.	Сургуулийн өмнөх боловсролын тусгай шилжүүлгийг нийслэл 9 дүүрэгт, дүүргүүд сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд болон төрийн бус өмчийн цэцэрлэгүүдэд тус тус хуваарилан ажилласан.			2020-2021 оны хичээлийн жилд нийслэлийн төрийн өмчийн 152 сургуулийн 7952 бүлэгт 261 754 хүүхэд, төрийн бус өмчийн 122 сургуулийн 1682 бүлэгт 39658 хүүхэд, 8 насан туршийн боловсролын төвд 781 хүүхэд нийт 286 байгууллагад 303 502 санхүүжих дундаж хүүхэд суралцахаар тооцож нийт 241.2 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгийн төсөв батлагдсанаас 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 234.4 тэрбум төгрөг буюу 6.8 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны нийт төсвийн 71 хувь нь буюу 171.3 тэрбум төгрөг багш, ажилтны үндсэн цалин, нэмэгдэл, урамшууллын зардал байна.
	22.3.2	Ерөнхий боловсрол	Нийслэлийн Боловсролын салбарын батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээний дагуу хуваарилан дүүргүүдэд, дүүргүүд төсвийн шууд захирагч нарт хуваарилах.	Ерөнхий боловсролын сургуулийн тусгай зориулалтын шилжүүлгийг нийслэл 9 дүүрэгт, дүүргүүд ерөнхий боловсролын сургуулиуд болон төрийн бус өмчийн сургуулиудад тус тус хуваарилан ажилласан.			2021 оны төсвийн жилд төрийн өмчийн 289 цэцэрлэгийн 2625 бүлэгт 98051 хүүхэд, төрийн бус өмчийн 430 цэцэрлэгийн 1395 бүлэгт 29859 хүүхэд, нийт 719 цэцэрлэгийн 4020 бүлэгт, 127910 санхүүжих дундаж хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдахаар тооцож, 205.9 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгийн төсөв батлагдсанаас 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 195.5 тэрбум төгрөг буюу 10.4 тэрбум төгрөг буурч батлагдсан.
	22.3.3	Соёлын үйлчилгээ					
	22.3.4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Нийслэлийн Өрхийн эрүүл мэндийн салбарын батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээний дагуу хуваарилан дүүргүүдэд, дүүргүүд төсвийн шууд захирагч нарт хуваарилах.	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тусгай зориулалтын шилжүүлгийг нийслэл 9 дүүрэгт, дүүргүүд Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тус тус хуваарилан ажилласан.	486,949.6	474,996.2	Нийслэлийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх 141 Өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан үзүүлж байна. Нийт өрхийн эмнэлгийн 84 буюу 64 орчим хувь нь магадлан итгэмжлэгдсэн байгаагаас 75 ӨЗМТ нь эрүүл мэндийн даатгалын 4 төрлийн тусламж үйлчилгээгээр санхүүжилт аван ажиллаж байна. ӨЗМТ-ийн 98.5 хувь нь зориулалтын байраар, 70 хувь нь автомашинаар хангагдаж тоног төхөөрөмжийн хангалт 80 хувь байна.
	22.3.5	Газрын харилцаа, кадастр	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээний дагуу хуваарилан төсвийн шууд захирагчид олгох.	Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны 2021 оны тусгай зориулалтын шилжүүлгийн дүнг хөтөлбөр, арга хэмжээний дагуу бүрэн санхүүжүүлэн ажилласан.			2021 онд Нийслэлийн газар зохион байгуулалтын алба нь Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын тухай багц хууль, газрын харилцааны чиглэлээр батлагдан гарсан хууль, тогтоомжууд болон Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн засаг даргаас баталсан тогтоол, захирамж, шийдвэр, хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэн аж ахуйн нэгж байгууллагад шуурхай хүргэх үндсэн үйл ажиллагааны зэрэгцээ "Нэг хот-нэг стандарт" Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас "Байгууллагын соёл, үйлчилгээний чанар"-ыг сайжруулах зорилтот жил болгон зарласантай холбогдуулан дээрх хүрээнд үйл ажиллагааг чиглүүлэн ажилласан байна.
	22.3.6	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээний дагуу хуваарилан төсвийн шууд захирагчид олгох.	Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын 2021 оны тусгай зориулалтын шилжүүлгийг хөтөлбөр, арга хэмжээний дагуу бүрэн санхүүжүүлэн ажилласан.			Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, хамгааллын хууль тогтоомж, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, чиг үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага юм. Манай байгууллага нь Гэрлэх ёслолын ордон, Хүүхдийн урлан бүтээх төв, Монголын хүүхдийн ордон, Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборуудын бодлого төлөвлөлт, төлөвлөгөө, төсөл хөтөлбөрүүдийг бодлогын, нэгдмэл удирдлагаар хангах, Нийслэлийн 9-н дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Гэр бүлд зөвлөгөө өгөх төв, олон нийтийн оролцоонд түшиглэсэн хүүхэд хөгжил, хамгааллын төвүүд, хүүхдийн зуслан, халамж асрамжийн төвүүдийг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангах, хяналт тавин ажиллаж байна. "Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль" 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсээр нийслэлийн 9 дүүрэгт Залуучуудын хөгжлийг дэмжих төвүүд байгуулагдан ажиллаж залуучуудад сэтгэлзүй, гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн үйлчилгээ болон хууль эрх зүйн үйлчилгээнд холбон зуучлах, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг цогц үйл ажиллагаа явуулах боломжтой болсны дагуу Залуучуудын хөгжлийн жишиг төвийг Налайх дүүрэгт байгуулсан ба тус төв нь холбон зуучлах, зөвлөгөө өгөх, мэдээлэлээр хангах, сайн дурын ажлыг бүртгэж, баталгаажуулах, лавлагаа, гаргах, хөгжлийг дэмжих, номын сангийн үйлчилгээ гэсэн 5 чиглэл, 16 төрлийн үйлчилгээг үзүүлж, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөл боломжоор ханган ажиллаж байна.
	22.3.7	Нийтийн биеийн тамир					

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ
ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ЧАНАРЫН БОЛОН ТОО ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
1	2	3	4	5	6	7	8
1	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА				13,177.8	11,993.1	
1.1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа				13,098.2	11,916.0	
1.1.1	Төрийн байгуулал, улс орны удирдлагын талаар Улсын Их Хурал, Засгийн газар, шүүх эрх мэдлийн байгууллагуудтай хамтарч ажиллана. Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	Төлөвлөсөн хугацаанд 100 % хийгдсэн	5,865.1	5,020.0	Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийг түшиглэн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнг байгуулах тухай зарлиг гаргасан. Бүх шатны шүүгчийг томилох, чөлөөлөх, шилжүүлэн ажиллуулахтай холбогдсон үйл ажиллагааны хүрээнд хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах хязгаарт хүрсэн 7, хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан 2, Шүүгчийн албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр гаргасан 3 албан тушаалтныг тус тус шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх зарлигийг хуульд нийцүүлэн гаргав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгийг 2100 сурагчид олгох болон Тэрбум мод үндэсний хөдөлгөөний талаар "Засгийн газарт чиглэл өгөх тухай" зарлиг гаргав. "Ерөнхийлөгчийн ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээг тогтоох тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. Монгол Улсын Ерөнхийлөгч шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гацаанаас гаргаж, эрчимжүүлэх үүднээс Шүүхийн тухай хууль бүхэлдээ Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн тухай гаргасан хүсэлтээс 09 дүгээр сарын 06-ны өдөр татгалзсан. "Мэдээллийн "МОНЦАМЭ" агентлагийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. Монгол Улсын Их Хурлаас 2020 онд батлагдсан 10 боть, 2732 нэгж хуудас бүхий нийт 241 хуулийн уг эх дээр төрийн тамга дарж баталгаажуулав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Шүүх эрх мэдэл, хууль сахиулах алба хаагчдын үндэсний чуулган"-ыг 10 дугаар сарын 15-ны өдөр, "Хүний эрхийн үндэсний форум"-ыг 12 дугаар сарын 10-ны өдөр Төрийн ордонд тус тус зохион байгууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1990-2019 оны зарлигуудад тулгалт хийж, 8 зарлигийг нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын санд бүртгүүлж, 4 зарлигийг Legalinfo.mn сайтад байршуулав.	
1.1.2	Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах чиглэлд хэрэгжиж байгаа хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход санаачилга гарган ажиллана.	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	Төлөвлөсөн хугацаанд 100 % хийгдсэн	219.0	139.0	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, бүрэлдэхүүн хэсэг бүрээр нь үнэлэлт дүгнэлт өгөн үзэл баримтлалыг шинэчлэх эсэх талаар санал боловсруулан танилцуулах ажлын хэсэг томилох тухай захирамж гаргасан. Түүнчлэн "ҮАБЗ-ийн хуралдааны дэг", "ҮАБЗ-ийн хуралдааны аюулгүй байдлыг хангах журам"-д оруулах санал боловсруулж, ҮАБЗ-ийн Ажлын албанд хүргүүлэв. Батлан хамгаалах яамнаас боловсруулж ирүүлсэн "Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах" тухай хуулийн төсөлтэй танилцаж, УИХ-д өргөн барих чиглэлийг Монгол Улсын Засгийн газарт өгөв. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 48 дугаар захирамжаар Монгол цэрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын Энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тэмдэглэх, Олон улсын Энхийг сахиулагчдын хурал зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг томилж, ажлын хэсгийн хуралдаан зохион байгуулж, төлөвлөгөөг батлан ажиллаж байна.	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
1.1.3	Гадаад харилцаанд Монгол Улсыг бүрэн төлөөлж, гадаад бодлого, олон улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулна.	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	Төлөвлөсөн хугацаанд 100 хувь хийгдсэн	1,265.2	1,026.0	Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг тэмдэглэх хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021 оны 12 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд Оросын Холбооны Улсад албан ёсны айлчлал хийв. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд амжилттай оролцож, үг хэлэв. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ИБУИИВУ-ын Глазгоу хотноо 2021 оны 11-р сарын 1-2-ны өдрүүдэд болсон Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалтад амжилттай оролцов. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021 оны 9-р сарын 17-ны өдөр Тажикстан Улсын нийслэл Душанбе хотод болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд цахимаар үг хэлэв. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгч Мүн Жа Ин-тэй 2021 оны 9-р сарын 10-ны өдөр дээд төвшний цахим уулзалт хийлээ. Уулзалтын үр дүнд хоёр улсын харилцааг "Стратегийн түншлэл"-ийн төвшинд дэвшүүлэн хөгжүүлэхээр тохиролцож, хамтарсан тунхаглал гаргав. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021 оны 9-р сарын 3-ны өдөр ОХУ-ын Владивосток хотноо болсон Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын нэгдсэн хуралдаанд ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путинг урилгаар цахимаар оролцож үг хэлэв. Үүний үр дүнд Дорнын эдийн засгийн олон улсын чуулга уулзалтад Монгол Улс дөрөв дэх удаагаа төрийн тэргүүний төвшинд амжилттай оролцов. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В. Путинтай 2021 оны 7-р сарын 9-ний өдөр утсаар ярьж хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг хоёр тал жилийн туш өргөн хүрээнд тэмдэглэж буйн ач холбогдол, үлдсэн хугацаанд төлөвлөсөн арга хэмжээнүүдийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэх, шинэ чиглэлийн төмөр зам барих, эрчим хүчний төслүүд, ОХУ-аас БНХАУ-д байгалийн хий нийлүүлэх хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих төсөл зэрэг асуудлаар санал солилцсон. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх БНХАУ-ын дарга Ши Жиньпінтэй утсаар ярьсны дагуу Монгол-Хятадын Төрийн тэргүүн нар цөлжилт, шороон шуургатай тэмцэх төслийг хамтран хэрэгжүүлэхийг дэмжсэний хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас боловсруулсан төслийн төлөвлөгөөг Ерөнхийлөгчийн Тамгын газарт ирүүлснийг судлан үзэж, төлөвлөгөөг дахин боловсруулах чиглэл хүргүүлээд байна.
1.1.4	Хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ажиллана.	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	Төлөвлөсөн хугацаанд 100 хувь хийгдсэн	5,748.9	5,731.1	1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021-2027 оны Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг 2021 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 16 дугаар зарлигаар батлав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн өв болж үлдэх, улс орны өмнө эн тэргүүнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд манлайлан оролцох ажил, арга хэмжээг нарийвчлан тодруулж, уялдуулан зохицуулах үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021-2024 оны төлөвлөгөөг боловсруулаад байна. Урт болон дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг Тамгын газрын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт тухай бүр тусган хэрэгжүүлэх болно. Энэ хүрээнд Тамгын газрын үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг боловсруулж, мөн оны 09 дүгээр сарын 06-ны өдөр албажуулсан болно. Тус төлөвлөгөөнд 2021 оны сүүлийн хагаст хэрэгжүүлэх нийт 142 заалт тусгагдсан. Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 142 ажил, арга хэмжээнээс 100 хувь "үр дүнтэй" бүрэн хэрэгжсэн-97, 70 хувь "тодорхой үр дүнд хүрсэн" боловч зарим шалгуур үзүүлэлт, зорилгот түвшиндээ бүрэн хүрээгүй-29, 40 хувь "эрчимжүүлэх шаардлагатай"-1, гадаад хүчин зүйлсээс шалтгаалан хэрэгжээгүй, үнэлэх боломжгүй, хугацаа болоогүй -15 ажил, арга хэмжээ тус тус байна. Төлөвлөгөөний биелэлтийн дундаж үнэлгээ 92 хувь байна.
1.2	Монгол Улсын Ерөнхийлөгч, хууль тогтоох байгууллага болон гүйцэтгэх засаглалын судалгаа, шинжилгээ			79.6	77.1	
1.2.1	Монгол хэлний тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа эрхлэх	Судалгааны тайлан гаргах	Төлөвлөсөн хугацаанд 100 хувь хийгдсэн	79.6	77.1	Соёлын яаманд байгуулсан Үндэсний соёлын нэгдмэл үнэт зүйлийг судлан тодорхойлох, индекс гарган үнэлэх ажлын хэсэгтэй хамтран ажиллаж байна. Энэ хамтын ажиллагааны хүрээнд эхний шатны судалгааны үр дүн гарч дараачийн шатны судалгааг эхлүүлээд байна. Архи, согтууруулах ундааны зохистой хэрэглээг дэмжих, архидан согтуурахтай тэмцэх хууль, эрх зүйн орчныг судлан санал, дүгнэлт танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, уулзалтуудыг зохион байгуулав. Тус ажлын хэсгээс гарсан санал зөвлөмжийг үндэслэн Ерөнхийлөгчийн зарлигийн төслийг боловсруулав. Архины хэрэглээ, эрх зүйн орчны чиглэлээр манай оронд хийгдсэн судалгааг тоймлон, шинээр нэмж хийх судалгааны чиглэлийг гарган ажиллав.
2	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА			61,907.4	60,371.6	
2.1	Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих			61,907.4	60,371.6	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	2.1.1	Хууль, тогтоолын төсөл хэлэлцэж батлах	150-аас доошгүй ажлын өдөр хуралдаж хууль, тогтоолын төсөл хэлэлцэж батлах	100%	57,454.4	55,812.5	Дэлхий даяар тархсан Коронавируст халдварын цар тахлын нөхцөл байдал 2021 онд арилагагүй бөгөөд уг вирусыг нь мутацлагдсантай холбоотой нөхцөл байдлаас шалтгаалж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороод, намын бүлгүүдийн хуралдааныг 2020 онд хэрэгжүүлсэн туршлага, технологийн ололтыг ашиглаж, цаг үеийн нөхцөлд байдалд нийцүүлж цахим хэлбэрээр зохион байгуулах техникийн болон зохион байгуулалтын бэлтгэлийг хангаж ажиллалаа. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 72 удаа 324 цаг 34 минут, Байнгын, дэд, түр хороо 266 удаа (үүнээс Байнгын хороод 231, дэд хороод 14, түр хороод 21 удаа) 409 цаг 19 минут хуралдаж, 913 (давхардсан тоогоор) хууль, тогтоолын төсөл, 59 тайлан, илтгэл, мэдээлэл, хяналт шалгалтын дүнг хэлэлцсэн байна. Байнгын болон дэд, түр хорооны 112 тогтоолыг батлуулан, олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцн зөвшилцөх 10, хэлэлцэх эсэхийн 73, анхны хэлэлцүүлгийн 104, зөвшилцөх 6, соёрхон батлах 9, холбогдох Байнгын хороонд хүргүүлсэн 38, бусад асуудлаар 72 санал, дүгнэлт, эцсийн хэлэлцүүлгийн 64 танилцуулга, анхны хэлэлцүүлгийн 2107 (үүнээс дэмжигдсэн 2056, дэмжигдээгүй 51), эцсийн хэлэлцүүлгийн 98 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бэлтгэн чуулганы нэгдсэн хуралдаанд оруулан хэлэлцүүлж, шийдвэрлүүлэв. Хууль, эрх зүйн газар 415 хууль, 106 тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэн, Байнгын болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, анхдагч хууль 26, олон улсын гэрээ, хэлэлцээр соёрхон батлах тухай хууль 7, хуулийн шинэчилсэн найруулга 13, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 351, хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль 18, Улсын Их Хурлын 106 тогтоолыг тус тус батлуулсан байна.
	2.1.2	Хууль, тогтоолын биелэлтийг хянан шалгах, холбогдох тайлан, мэдээллийг хэлэлцэх, сонсох	12-аас доошгүй удаа хяналт шалгалт хийх, 6-аас доошгүй удаа тайлан хэлэлцэх, 12-оос доошгүй удаа мэдээлэл сонсох	100%			Тайлант хугацаанд 2020 онд байгуулагдсан 9 ажлын хэсэг үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллаж, 28 ажлын хэсэг шинээр байгуулагдсан. Нийт 37 ажлын хэсгээс Улсын Их Хурлын тогтоолоор 2 түр хороо, Улсын Их Хурлын даргын захирамжаар 7, Байнгын хорооны тогтоолоор 27, Дэд хорооны тогтоолоор 1 ажлын хэсэг байгуулагдан ажилласан байна. Тайлант хугацаанд хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий 15 ажлын хэсэг удирдамжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэн санал, дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулж, холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газар болон холбогдох байгууллагуудад Улсын Их Хурлын 1 тогтоол, Байнгын хорооны 4 тогтоолоор үүрэг чиглэл өгч ажилласан байна. Байнгын, дэд, түр хорооны хуралдаанаар эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын гишүүд болон холбогдох бусад байгууллагын ажлын хэсгийн нийт 47 удаагийн болон ажлын дэд хэсгийн хуралдаанаар мэдээлэл, илтгэл, тайланг хэлэлцсэн байна.
	2.1.3	Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааг чиглүүлэн удирдаж, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах	Хуульд заасны дагуу хангагдсан байх	100%	4,453.0	4,559.1	Байнгын хороодоос ирүүлсэн саналд үндэслэн Улсын Их Хурлаас 2021 онд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийх хууль тогтоомжийн цаглаарын хэрэгжилтийг ханган ажиллаж тайлант хугацаанд нийт 11 хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ, 1 хөтөлбөрийн хэрэгжилтэд зөвлөх багт тус тус ажилласан. Монгол Улсын Их Хурлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэлийг сонсох, хэлэлцэх цаглаарын дагуу 2021 оны жилийн эцсийн байдлаар Байнгын болон Түр хорооны хуралдаанаар нийт 47 удаагийн тайлан, мэдээлэл сонсоход давхардсан тоогоор Улсын Их Хурлын нийт 288 гишүүн 820 асуулт асууж, санал хэлсэн статистик мэдээллийг Хяналт шалгалтын мэдээллийн санд бүртгэлжүүлж ажилласан. Улсын Их Хуралд ажлаа шууд харицан тайлагнадаг 6 байгууллагууд 2020 оны үйл ажиллагааны тайландаа "Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу системчилсэн үнэлгээ хийсэн эсэхэд хяналт тавьж, санал, дүгнэлтээ холбогдох Байнгын хороодод хүргүүлсэн. Байнгын хорооны хуралдаанаар дээрх байгууллагуудын үйл ажиллагааны тайланг хэлэлцээд тодорхой асуудлаар үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн биелэлтэд хяналт тавин ажиллалаа.
3	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА				2,666.9	2,666.9	
	3.1	Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих			2,666.9	2,666.9	
	3.1.1	Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг шийдвэрлэх					Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2021 онд 191 өргөдөл, мэдээлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас, урд оны үлдэгдэл 30, нийт 221 өргөдөл, мэдээлэл, хүсэлт, гомдлыг хянан шалгалтад байна. Үндсэн хуулийн цэц 2021 онд Бага суудлын хуралдаан 19, Дунд суудлын хуралдаан 8, Их суудлын хуралдаан 3-г буюу нийт 30 удаа Цэцийн хуралдаан хийсэн байна. Хуулийн хугацаандаа
	3.1.2	Бага суудлын хуралдаанаар гомдол шийдвэрлэх		Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх	2,666.9	2,666.9	
	3.1.3	Дунд, их суудлын хуралдаанаар маргаан хянан шийдвэрлэх					
4	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ				5,227.7	4,143.4	
	4.1	Хяналтын шатны шүүн таслах ажиллагаа			5,227.7	4,143.4	
	4.1.1	Хяналтын журмаар хуулийн хугацаанд хянан шийдвэрлэх эрүүгийн хэргийн тоо		750	970	1,273.0	1,008.9
	4.1.2	Хяналтын журмаар хуулийн хугацаанд хянан шийдвэрлэх иргэний хэргийн тоо		1700	2696	2,885.4	2,286.9
	4.1.3	Хяналтын журмаар хуулийн хугацаанд хянан шийдвэрлэх захиргааны хэргийн тоо		630	499	1,069.3	847.5
5	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА				61,161.3	60,077.1	
	5.1	Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах			61,161.3	60,077.1	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	5.1.1	Хэрэг, маргааныг хуулийн хугацаанд шийдвэрлэх /хувиар/	93	94.6	61,161.3	60,077.1	Монгол Улсын шүүх 2021 онд 61 тэрбум төгрөгийн төсөвтэйгөөр хэрэг, маргааныг анхан болон давж заалдах, хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэв. Монгол Улсын шүүхийн 2021 оны шүүн таслах ажиллагааны статистик нэгдсэн дүн мэдээнд хэрэг маргааны 94.6 хувийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн байна.
6	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА				1,431.8	1,417.3	
	6.1	Хүний эрхийн хэрэгжилтийг хангах			1,431.8	1,417.3	
	6.1.1	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл	1	1			Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийг Ковид-19 цар тахал ба хүний эрх сэдвийн хүрээнд 6 багц хүний эрхийн асуудлаар Комиссоос хийсэн хяналт шалгалт, ажиглалт, мониторинг, иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэл, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж, цар тахлын үед Засгийн газар, Улсын онцгой комисс, яамд, агентлаг, холбогдох төрийн байгууллагуудын шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилт, иргэний нийгэм, олон улсын байгууллага, судлаачдын хийсэн судалгаа, мэдээлэлд тулгуурлан боловсруулж 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хурлын даргад өргөн барив.
	6.1.2	Хяналт шалгалт хийх, судалгаа явуулах, дүн шинжилгээний тайлан боловсруулах, санал гаргах	Хяналт шалгалт 38, судалгаа 6, дүн шинжилгээ, санал гаргах 50	Хяналт шалгалт 118			2021 онд Комиссын гишүүний баталсан удирдамжийн дагуу 118 хяналт шалгалт хийсэн. Үүнээс Ковид-19 цар тахлын хүрээнд 16, Гомдлын мөрөөр 22, мэдээллийн мөрөөр 1, Албан тушаалтны хүсэлтээр 7, Комиссын гишүүний санаачилгаар 72 хяналт шалгалт хийсэн байна.
	6.1.3	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх гомдол шийдвэрлэх	Гомдол шалгаж шийдвэрлэх-600, хуульзүйн зөвлөгөө-3000	Гомдол шалгаж шийдвэрлэх-1446, хуульзүйн зөвлөгөө-21128			2021 онд 1017 иргэнд 21128 минутын хууль зүйн зөвлөгөөг утсаар, цахимаар болон биечлэн өгсөн байна. 2021 онд 1146 гомдол, мэдээлэл хүлээн авч 1032 гомдол, мэдээллийг шийдвэрлэж хариу өгсөн байна.
	6.1.4	Хүний зөрчигдсөн эрхийг сэргээлгэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргах, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүсэлт тавих, шаардлага хүргүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчигдэх нөхцөл бий болсон шалтгаан нөхцөлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэх	Төлөөлөн нэхэмжлэл 2, шаардлага 30, зөвлөмж 32	Төлөөлөн нэхэмжлэл 2, шаардлага 43, зөвлөмж 57	1,431.8	1,417.3	Комиссын гишүүн Б.Энхболд гишүүний хариуцсан иргэн Ж.Наранбаатарыг төлөөлөн гаргасан төрөөс хохирол гаргуулахтай холбоотой нэхэмжлэлтэй шүүх хурал Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх хурал 2021.05.28-ны өдөр хуралдсан бөгөөд Комиссын гишүүнийг төлөөлөн ахлах мэргэжилтэн А.Шинэбаяр оролцсон. Тус шүүхийн 181/ШШ2021/01042 дугаар шүүхийн шийдвэрээр төрөөс (/засгийн газрын нөөц сангаас/) 28 сая төгрөгийг гаргуулж түүнд иргэн Ж.Наранбаатарт олгохоор шийдвэрлэсэн. Комиссын гишүүн Д.Сүнжид гишүүний хариуцсан иргэн Б.Оюунжаргалын төлөөлөн гаргасан шүүхэд гаргасан нэхэмжлэлийг тэй шүүх хурал Баянзүрх дүүргийн ИХАШШ-ийн 2021-05-27-ны өдөр хянан хэлэлцэж болсон бөгөөд Комиссын гишүүнийг төлөөлөн референт Г.Ууганбаатар оролцсон. Тус шүүхийн 101/ШТ/2021/00194 дугаар шүүхийн шийдвэрээр Комиссыг тухайн иргэнийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй гэж дүгнэн, хэргийг хэрэгсэхгүй болгосон. Тайлант хугацаанд 2021 онд Комиссын гишүүний 43 шаардлага боловсруулсныг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Тайлант хугацаанд 2021 онд Комиссын гишүүний 57 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.
	6.1.5	Хүний эрхийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа зохион байгуулах	400 цагийн сургалт, 8000 хүн				Нийслэл болон 21 аймгийн 2021 онд 17954 оролцогчийг оролцуулан 514.3 цагийн 306 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна. Сургалтыг төрийн байгууллага, хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийг хамруулан зохион байгуулсан.
7	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР				72,879.2	67,674.3	
	7.1	Прокурорын хяналт			72,879.2	67,674.3	
	7.1.1	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих /хувиар/	100%	100%			Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, Эрүүгийн хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих, гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд хяналт тавих, прокурорын байгууллагын нэгжүүдийн хэрэг бүртгэх, мөрдөх байцаах ажиллагаанд хяналт тавих ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцсон.
	7.1.2	Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих /хяналтын тоо/	7100	7035	72,879.2	67,674.3	Ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын чиглэлээр шалгалт, судалгааны чанар үр нөлөөг сайжруулах, төв, орон нутгийн прокурорын газрын ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын ажлыг газар дээр нь шалгаж заавар, зөвлөгөө өгөх, хуулиар тогтоосон нөхцөл, журмын дагуу ял эдлүүлэх, ял завшуулахгүй байх, ялтын эрхийг нь хангах, тэднийг нийгэмшүүлэх, хорихоос өөр төрлийн ялын бодит биелэлтийг сайжруулах, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх, ялын биелэлтийг хангуулах талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах, баривчлах, албадах байруудын ахуй нөхцөлийг дээшлүүлэхэд хяналтын ажлаа чиглүүлж, нээлттэй болон хаалттайгаар хорих ангидын үйл ажиллагааг шалгаж, танилцав.
	7.1.3	Зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих /зөрчлийн тоо/	1,500,000	2,230,146			Прокурорын байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд, хяналтын ажлын чиглэлээр мөрдөгддөг заавар, журмын хэрэгжилтийг хангуулах, нэгж газруудын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, эрх бүхий 32 байгууллагын нийт 10513 эрх бүхий албан тушаалтны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.
8	МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИН БИЧГИЙН ДАРГА				5,943.0	5,930.5	
	8.1	Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах			5,943.0	5,930.5	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	8.1.1	Бодлогын зөвлөгөө /тоогоор/	90	532	4,739.4	4,738.8	Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол, оршин тогтнохын, дотоодын эдийн засгийн, хүрээлэн байгаа орчны, мэдээллийн, хүний аюулгүй байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг бэхжүүлэх төрийн нэгдмэл бодлогыг боловсруулах, аюулгүй байдлыг ханган, хууль тогтоомж, Зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, бодлогын зөвлөгөөгөөр хангах, хяналт тавих, үндэсний аюулгүй байдлын тэргүүн гишүүдийн хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд Монгол улсын үндэсний ашиг сонирхол, оршин тогтнох тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эдийн засаг, экологийн тэнцвэртэй хөгжлийг хангах, бодлого үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх, төрийн болон орон нутгийн төр захиргааны байгууллагуудад Монгол улсын хууль тогтоомж, зөвлөлийн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд нь бодлогын зөвлөгөөгөөр хангах, бодлого боловсруулах, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагуудын салбар хоорондын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан. ҮАБЗ-ийн 2021 онд хуралдаанаар 22 зөвлөмж, 11 тэмдэглэл, 93 захирамж, 194 тушаал, 115 танилцуулга, 82 илтгэх хуудас, 1 танилцуулах тойм мэдээ, 10 шуурхай мэдээ, 4 шинжээчийн дүгнэлт гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.
	8.1.2	Эрдэм шинжилгээ, судалгаа /тоогоор/	150	189	1,203.5	1,191.7	ССХ 2021 онд 4 сектор, 24 судлаачийн бүрэлдэхүүнтэй ажиллаж төлөвлөгөөт болон цаг үеийн, даалгаварт судалгаа гүйцэтгэлээ. Шуурхай мэдээ, танилцуулах мэдээнээс эхлэн санал, зөвлөмж, бодлогын судалгааны цогц тайлан хүртэлх төрөл бүрийн цар хүрээний 115 мэдээлэл, материал бэлтгэж ҮАБЗ болон холбогдох байгууллагад хүргүүлж, зарим хэсгийг хүрээлэнгийн дотоод хэрэгцээнд, цаашдын судалгааны бааз болохоор хадгалж байна. Хүрээлэнгээс гаргасан эрдэм шинжилгээ, судалгааны бүтээгдэхүүн, ажлын гүйцэтгэлийг тоогоор илэрхийлбэл дараах үзүүлэлттэй байна. Илтгэх хуудас 12, Шуурхай мэдээ 8, Танилцуулах мэдээ 81, Мэргэжлийн сэтгүүл 2, Гадаадын байгууллагатай хамтарсан семинар 10, Нууцаар хүргүүлсэн санал, зөвлөмж, Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл 32, Төлөвлөгөөт болон захиалгат судалгаа 43 ширхгийг тус тус гаргаад байна.
9	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР				26,878.0	24,176.6	
	9.1	Төрийн аудитын үйлчилгээ			26,878.0	24,176.6	
	9.1.1	Санхүүгийн тайлангийн аудит	6484	6677			Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг төрийн аудитын байгууллага 5331, хараат бус аудитын компани 1346 нийт 6677 байгууллагыг хамруулан санал дүгнэлт гарган ажилласан.
	9.1.2	Гүйцэтгэлийн аудит	94	195	26,878.0	24,176.6	Нэгдсэн удирдамжаар 110, УИХ болон аймгийн ИТХ-ын хүсэлтээр 24, өөрсдийн санаачилгаар 59, өгөдөл гомдлын дагуу 2 буюу нийт 195 гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэсэн.
	9.1.3	Нийцлийн аудит	67	33			Нэгдсэн удирдамжаар 12, УИХ болон аймгийн ИТХ-ын хүсэлтээр 5, өөрсдийн санаачилгаар 16 буюу нийт 33 нийцлийн аудитыг хийж гүйцэтгэсэн. Нийцлийн аудитын тоо буурсан нь санхүүгийн тайлангийн аудиттай хавсран хэрэгжүүлэх бодлого баримталсантай холбоотой.
10	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА				29,794.8	26,740.3	
	10.1	Авлигатай тэмцэх			29,794.8	26,740.3	
	10.1.1	Мэдүүлгийн бүрдүүлэлтэд хянагдсан хөрөнгө орлогын мэдүүлгийн тоо	3850	3850	8,000.0	6,685.1	Авлигын эсрэг хууль, НАНБХАСЗАСЗУСТХ-ийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2019 оны ХАСХОМ-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. Улсын хэмжээнд нийт төрийн болон нутгийн захиргааны нийт 117 байгууллагын 43692 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ гаргаж бүртгүүлэхээс хуулийн хугацаанд 100 хувь мэдүүлгээ гаргасан. Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээнээс үзэхэд 484 албан тушаалтан "хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлт"-ийн талаар мэдүүлж, 36677 албан тушаалтан "тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүй илэрхийлсэн мэдэгдэл", 333 нь "ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл" гаргасан байна. Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон бусад 314 албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэж байгаа нийт 311 албан тушаалтан мэдүүлгээ хуулийн хугацаанд шинэчлэн гаргасан. Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон бусад албан тушаалд шинээр томилогдсон 158 албан тушаалтан мэдүүлгээ бүртгүүлж, 26 албан тушаалтан хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлснийг хуулийн хугацаанд хүлээн авч, хяналт тавин ажиллалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд нэр дэвшигчээс хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хүлээн авах, мэдээлэх ажлыг хариуцан зохион байгуулсан. Нам, эвсэл, бие даагч нийт 18 нэр дэвшигчээс 17 нэр дэвшигч буюу 94.5 хувь нь хуулийн хугацаанд мэдүүлж, 1 нэр дэвшигч мэдүүлгээ гаргаж бүртгүүлээгүй. Монгол Улсад зөвлөх үйлчилгээ үзүүлсэн Дэлхийн банкны шинжээчийн тайлан болон холбогдох бусад баримт бичигт тулгуурлан "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт эрсдэл тооцох аргачлал"-ыг боловсруулав. Аргачлалын дагуу 2019-2020 онд мэдүүлэг гаргасан 40.0 мянга гаруй албан тушаалтны мэдээлэлд эрсдэл тооцооноос 8292 албан тушаалтан эрсдэлтэй гэсэн тооцоо гарсан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор улсын хэмжээнд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 737 эрх бүхий албан тушаалтнаас холбогдох судалгааг авч, тайланг нэгтгэн боловсруулав.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	10.1.2	Авлигатай тэмцэх талаарх сургалтад хамрагдах хүний тоо /мянган хүн/	16	28.356	5,000.0	5,348.1	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 134 удаа зохион байгуулж, 341 иргэн, 27304 нийтийн албан тушаалтан, нийт 27645 хүнийг хамруулав. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт хийх сургагч багш нарыг чадавжуулж, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх зорилт тавьснаар орон нутгаас бэлтгэгдсэн сургагч багш нар 4480 хүнд, "Шударга ёсны боловсрол" хөтөлбөрийн хүрээнд бэлтгэсэн ЕБС-ийн багш нар нийт 20892 хүүхэд, 332 эцэг эхэд буюу нийт 25704 иргэн, албан хаагч, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, эцэг эхэд сургалт зохион байгуулсан байна. 2021 оны байдлаар Төрийн болон нутгийн захиргааны төв болон тэдгээрийн салбар нэгж 118 байгууллагад ажиллаж байгаа ЭБАТ-ын судалгааг шинэчлэн хийлээ. УИХ-ын Тамгын газрын албан хаагчид, УИХ-ын гишүүдийн зөвлөх, туслах, Эрүүл мэндийн яам болон түүний харьяа байгууллагууд, Баянгол дүүргийн Татварын хэлтэс, Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид зэрэг 508 албан тушаалтан, шинээр томилогдсон эрх бүхий албан тушаалтнуудад 2 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 203 албан хаагч тус тус хамрагдсан байна. Мэдүүлэг гаргагч албан тушаалтны хуулийн хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлэх үүргийн талаарх сурталчилгааны шторжийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах зорилгоор МҮОНТ, ТВ-9, Монгол HD зэрэг телевиз, Өдрийн сонин, Өнөөдөр сонин болон АТТ-ын цахим сайт, www.news.mn, www.ikon, www.medeed.mn сайтуудтай хамтран ажиллав.
	10.1.3	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх судалгаа дүн шинжилгээ	3	5	1,500.0	1,337.0	Төрийн байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээг 14 байгууллагад гэрээгээр гүйцэтгүүлэв. Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудад авлигын эрсдэлийн тайланг танилцуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөсөн. Мөн "Шударга байдлын үнэлгээ"-ний 2021 оны судалгааг гүйцэтгэж, дүнг танилцуулах, мэдээлэх ажлыг зохион байгуулав. Шударга байдлын үнэлгээнд 2021 онд 46 яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар зэрэг нийт 68 байгууллагыг хамруулсан. Шударга байдлын үнэлгээний дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгууллаа. Улс төр, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа"-г хийлээ. Судалгаагаар 2021 онд улс төрийн хүрээнд дэх авлигын түвшин 3.82 пункт, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын түвшин 3.85 пункт гарсан. Хүүхдийн шударга байдлын 2021 оны судалгааг аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 8080 сурагч, 1169 багш, албан хаагч, 1968 эцэг, хэзээ мэдээлэл цуглуулан хийж, судалгааны үр дүнд хүүхдийн шударга байдлын түвшин 4.06 гарсан. Судалгааны дүнг олон нийтэд танилцуулсны дээр судалгаанд хамрагдсан ерөнхий боловсролын сургууль, Сангийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт тус тус хүргүүлэв. "Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийн авлигын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох судалгаа"-г нийслэлийн 9 дүүргийн иргэдээс түүврийн дагуу биечлэн уулзах, харилцаа холбооны хэрэгслээр холбогдон асуулга асуух зэргээр 4067 өрхийг хамруулан хийлээ.
	10.1.4	Иргэд, байгууллага, албан тушаалтнаас хүлээн авсан гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх /хувиар/	98.9	98.9	9,294.8	8,022.1	2021 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас гаргасан 2314 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авснаас Мөрдөн шалгах хэлтэст 1491 буюу 64.4 хувь, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст 560 буюу 24.2 хувь, Гүйцэтгэх ажлын хэлтэст 194 буюу 8.4 хувь, Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын албанд 43 буюу 1.9 хувь, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст 26 буюу 1,1 хувь нь тус тус хуваарилагдан хянан шалгагдсан байна. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн тухайд байгууллагын хэмжээнд 2021 онд өмнөх оны 105, энэ оны 1491 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, нийт 1596 гомдол, мэдээллийг хүлээн авсан. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 560, нийт 600 гомдол, мэдээллийг хянан шалгах аас тайлант хугацаанд 561 гомдол, мэдээллийг хянаж, шийдвэрлэлт 93.5 хувьтай байна. Хянан шалгасан гомдол, мэдээллээс 90 албан тушаалтанд холбогдох зөрчил тогтоогдож, хуульд заасан үндэслэлээр буцаасан 28, гэмт хэргийн шинжтэй гэж үзэж шилжүүлсэн 74, бусад байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн 108, гомдлоо буцаасан 14, зөрчил илрээгүй 191, бусад 30 байна. Хяналт шалгалтын явцад хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, зөрчлийг давтан гаргахгүй байх, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, албан тушаалтны ёс зүй, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 52 байгууллага, албан тушаалтанд зөвлөмж, шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Байгууллагад хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлт 98.9 хувьтай байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	10.1.5	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх багц ажил, хэрэгжүүлэх арга хэмжээ	17	17	6,000.0	5,348.0	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан 216 арга хэмжээний гүйцэтгэл 2021 онд 68.7 хувьтай байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээ, тайланг цахим хэлбэрээр khutulbur.iaac.mn цахим санг ашиглаж байна. Нийслэлийн ерөнхий боловсролын 12, 24, 32, 40, 84 дүгээр сургуульд "Шударга ёсны клуб"-ыг байгуулав. Авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 5 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулав."Орон нутгийн төсвөө хянаж-BudgeThon" хакатоныг зохион байгуулав. "Аавын захиас", "Тангараг" "Өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр", "Шударга ёс гэж юу вэ?" сэдэвт богино хэмжээний 4 кино контент, гомдол, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарын утсыг сурталчилсан 2 төрлийн шторжийг бүтээв. "Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2020" эмхэтгэл, Авлигын гэмт хэргийг 2013, 2015, 2016, 2017 онд хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн эмхэтгэл, "Зөв зөв шударга зөв", "Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч танаа", "Засаг дарга танаа", Шударга ёсны боловсрол OECD гарын авлага, 4 төрлийн сурталчилгааны материал, 6 төрлийн зурагт хуудсыг эрхлэн хэвлүүлж, түгээж байна. Радиогийн нэвтрүүлгээр дамжуулан иргэдийн авлигын эсрэг мэдлэг, мэдээллийг дээшлүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээллийг хүргэж байна. "Бүлтээхэй, дэлдээхэй хоёрын шударга тоглоом" теле жүжгийг бүтээж, олон нийтийн хүртээл болгов. Хүүхэд, багачуудад "Зөв дадал-21" арга хэмжээ, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад "Шинэ үе авлигыг тэвчихгүй" цахим илтгэлийн уралдаан" болон "Шударга ёсны боловсрол: Гэр бүл, хүмүүжил, төлөвшил" чөлөөт уулзалт, их, дээд сургуулийн оюутнуудад "Таны эрх, таны оролцоо: Залуучууд авлигыг тэвчихгүй" нээлттэй өдөрлөгийг 4 үе шаттай зохион байгуулав. "Иргэдэд зориулсан нээлтэй өдөрлөг"-ийг нийслэлийн 8 байршилд хийж, иргэдтэй харилцах 110 мэдээллийн аппликэйшний нийт хандалт 5724 байна. Зорилтот бүлгүүдэд зориулсан видео контент, зурагт хуудас, постер, плакат, тараах материалыг бэлтгэн хэвлүүлж, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор нийт 46 видео, контент, шторк бүтээж, олон нийтийн сүлжээ, радио, телевизээр тасралтгүй сурталчлан түгээж ажиллалаа.
11	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА				7,102.7	5,590.2	
	11.1	Санхүүгийн зах зээлийн зохицуулалт			7,102.7	5,590.2	
	11.1.1	Хорооны зохицуулалтын хүрээнд шинээр хамрагдсан үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч, үнэт металл, үнэт чулуу, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагааг зохицуулах хуулийн төсөл боловсруулах	2	2	7,102.7	5,590.2	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагааны болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаатай холбогдон үүссэн харилцааг зохицуулах хуулиудын төслийг боловсруулах ажлыг Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэн зөвлөх үйлчилгээ хэрэгжиж эхлэв. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагааны хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Сингапур болон БНСУ-ын эрх зүйн орчны судалгаа, Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаатай холбогдон үүссэн харилцааг зохицуулах хуулийн төсөл боловсруулах хүрээнд Энэтхэг, ИБУИНВУ, Сингапур, Канад, Арабын нэгдсэн эмират улсуудын эрх зүйн орчны судалгааг хийж, тайланг гаргасан.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	11.1.2	Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох /шинээр боловсруулах журмын төсөл/	24	35			Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хадгаламж зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл, Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль/, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл, Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулийн төсөл, Коронавируст халдвар /ковид19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл, Эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт тухай бүр орж ажиллалаа. Санхүүгийн зохицуулах хорооноос 2021 онд нийт 7 захиргааны хэм хэмжээний акт баталсныг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн тухай бүр хянаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээ. Үүнд: 1. "ББСБ-аас гаргах хаалттай ерийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам", 2. Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам, 3. Банкний ХК хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам, 4. Үнэт цаасны бүртгэлийн журам, 5. Компанийн ерийн хэрэгслийн бүртгэлийн журам, 6. Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам, 7. Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам.
	11.1.3	Шинээр буюу шинэчлэн батлагдсан хууль тогтоомжуудад нийцүүлэн банкнаас бусад санхүүгийн салбарт мөрдөх дүрэм, журамд өөрчлөлт оруулах	34	29			"Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам"-д хоёр удаа түр хугацаанд өөрчлөлт оруулж, "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-д заасан ангилалд өөрчлөлт оруулж, "ХЗХ-ны активыг ангилах, активын эрсдэлийн санг байгуулж, зарцуулах журам"-ын зээлийн ангиллыг 2021.12.31-ний өдөр хүртэлх хугацаагаар сунгасан байна. Даатгалын багц дүрэмд 2 удаа, Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журамд 1 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. "Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам"-д, даатгалын нөөц сан болон АЖД-ын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл шаардлагуудад холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулсан. "Даатгалын компаниудын эрсдэлд суурилсан хөрөнгийг тооцоолох аргачлал"-ын эрсдэлийн коэффициентүүдийг тодорхойлж журмын төсөл, Даатгагчийн өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх аргачлал, журам-ын төслийг боловсруулав. Сэндбоксын зохицуулалтын орчны журам-ыг боловсруулж баталсан. "Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам"-ыг шинэчлэн, "Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам"-ын шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэж, санал авахаар цахим хуудаст байршуулсан. Мөн "Малын индексжүүлсэн даатгалын давхар даатгалын компанийн санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журам", "Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам", "Үнэт металл, үнэт чулууны , эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам", "Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам", "Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын нэгдсэн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам", "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх нөхцөл шаардлага"-д нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл зэрэг баримт бичгийг боловсруулав.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	11.1.4 Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарт эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх /хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагын тоо/	480	477			СЗХ-ны Ажлын албаны даргын тушаалаар Эрсдэлийн үнэлгээний систем хөгжүүлэх ажлын хэсгийг байгуулж, "Эрсдэлийн үнэлгээний систем"-д салбарын санхүүгийн үзүүлэлтэд тулгуурлан судалгаа хийж ажлын хэсэгт хүргүүлсэн. Системийн хэмжээнд бий болж болохуйц эрсдэлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг цогц байдлаар хэрэгжүүлэхэд банкнаас бусад салбарын хэмжээнд зайны болон газар дээрх хяналт, шалгалтын бодлогыг санхүүгийн зах зээлийн хөгжлийн бодлого, хөтөлбөртэй нийцүүлж Олон Улсын Үнэт Цаасны Хороодын Байгууллагаас гаргасан эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын зөвлөмж, заавруудыг мөрдөж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гаргаж, Дэлхийн банкны төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт, аргачлалын дагуу ХЗХ-дын ЗХШУ-ийн 30 улирлын түүхэн мэдээлэлд тулгуурлан эрсдэлийн үнэлгээний аргачлалыг сайжруулсан. Газар дээрх хяналт шалгалтын гүйцэтгэлийн тоон мэдээллийг санхүүгийн зах зээл, салбар чиглэлээр ангилбал үнэт цаасны зах зээлд хамаарах 164, даатгалын зах зээлд хамаарах 2, ББСБ-ын салбарт хамаарах 45, ХЗХ-ны салбарт хамаарах 7, үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарт хамаарах 13, үнэт металл, үнэт чулууны арилжааны үйлчилгээний салбарт хамаарах 12 этгээд байна. Мөн ҮМҮЧЭТХЭЭЭ нэр бүхий 16 хуулийн этгээд, 101 иргэнд нийт 117 этгээдэд газар дээрх үзлэгийг хийж гүйцэтгэлээ. Эдгээрээс МУТСТ чиглэлээр 60 этгээдэд хяналт шалгалтыг хийсэн.
	11.1.5 Эрдэм шинжилгээ судалгаа /тоогоор/	24	30			<u>Хөгжлийн бодлого, эрх зүйн зохицуулалтын чиглэлээр:</u> Япон улсын санхүүгийн зах зээлийн хөгжил; Үл хөдлөх зуучлал, үнэт металл, үнэт чулууны салбарын үйл ажиллагааны зохицуулалтын олон улсын туршлага; Үндэсний баялгийн сан; Криптовалютын олон улсын зохицуулалт; Ковид-19-ийн нөлөө ба банкнаас бусад санхүүгийн зах зээл; Зан төлөвийн эдийн засаг ба санхүүгийн хяналт, зохицуулалт; Компанийн засаглалыг сайжруулах нь; Санхүүгийн хүртээмжийг хэмжих үзүүлэлтүүдийг тодорхойлох; Хөрөнгийн зах зээл системийн эрсдэлийг үнэлэх; ХЗХ болон ББСБ-уудын системийн эрсдэлийг эрт дохиологч аргачлалаар үнэлэх нь; Тогтвортой хөрөнгийн зах зээлийг бүрдүүлэх, түүний цар хүрээг хурдасгахад технологийн дэвшил, Хадгаламж, зээлийн хоршооны салбарын төвлөрлийн эрсдэл; "Санхүүгийн чадамжийг үнэлэх түүвэр судалгаа"; Ногоон хөгжил-ногоон санхүүжилт; Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн олон улс дахь зохицуулалт; Даатгалын салбарын хөрөнгө оруулалтын бодлого, нөөц сангийн бодлогын талаарх олон улсын судалгаа; Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хүрээнд олон улсын даатгалын мэргэжлийн оролцогчтой холбоотой хууль, тогтоомжийг судалж судалгаа; Заавал даатгалын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа боловсруулсан. <u>Зохицуулалтын салбарын үйл ажиллагааны талаар:</u> Олон улсын финтекийн зохицуулалтын талаарх судалгаа; КОВИД-19-ын нөлөөлөл; Нөхөн төлбөр ба татварын уялдаа; Гүйцэтгэлийн баталгааны даатгалын олон улсын судалгаа; Олон улсын ногоон даатгалтай холбоотой судалгаа; Хувийн тэтгэврийн сангийн хууль эрх зүйн орчны талаар судалгаа; Ипотекийн даатгалын судалгаа; Даатгалын дэд бүтцийн байгууллага болон даатгалын нэгдсэн мэдээллийн сангийн талаар олон улсын судалгаа; ХЗХ-ны ОУ-ын зохицуулалтын судалгааг хийж гүйцэтгэлээ. Санхүүгийн групп компаниас үүсэх эрсдэлийг үнэлэх; Компанийн засаглалыг сайжруулах; Холбоо хамаарлаас үүсэх системийн эрсдэлийн судалгааг хийж гүйцэтгээд байна.
	11.1.6 Мэдээлэх үүрэгтэй этгээдийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох, тохиромжтой этгээд болон улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэхийг нягтлан шалгах, санхүүгийн хориг жагсаалтад хамаарал бүхий этгээдтэй хамааралтай эсэхийг таньж мэдэх, байгууллага тус бүрийн эрсдэлийг үнэлэх, харьцуулах, хяналт шалгалтын нэгдсэн статистик, төлөвийг харах боломжтой хувийн хэргийн мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ, шийтгэлийн түүх зэргийг нэг дороос харах боломжтой нэгдсэн цогц программ хангамжийг хөгжүүлэх	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх			ФАТФ-аас 2023 онд зохион байгуулах ээлжит үнэлгээнд бэлтгэх, мэдээлэх үүрэгтэй этгээд тус бүрийн эрсдэлийн үнэлгээ, шинжилгээ, зайны хяналтыг боловсронгуй болгох, нэгдсэн санг боловсронгуй болгохын сацуу мэдээлэх үүрэгтэй этгээд болон хянан шалгагчдад ногдох гар ажиллагааг багасгах чиглэлээр 2021.07.08-ний өдөр Мэдээллийн технологийн хэлтэст эрсдэлийн үнэлгээний программ хөгжүүлэх ажлын даалгаврыг МУТА-наас боловсруулж хүргүүлсэн. Дээрх ажлын даалгаврыг гүйцэтгүүлэх төндөр шалгаруулалтад "Эм Ди Эс Коммуникэйшн" ХХК шалгарч гэрээ байгуулсан. 2021.11.02-ний өдөр ажлын даалгавартай холбоотой мэдээлэл өгөх уулзалтыг зохион байгуулсан. Ажлын даалгавартай холбоотойгоор МУТА-наас эрсдэлийн үнэлгээний программыг гүйцэтгэж буй компанийг тухай бүр мэдээллээр ханган ажиллаж байна.
	11.1.7 Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч, үнэт металл, үнэт чулуу, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээний аргачлал боловсруулах	2	2			Хорооны даргын 2021 оны 213 болон 214 дүгээр тушаалаар үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн болон үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын байгууллагын үйл ажиллагааны зохицуулалтын стратеги бодлого, хууль тогтоомж болон оролцогчдын үйл ажиллагааны дүрэм, журам, дагаж мөрдөх шалгуур үзүүлэлт, стандартыг боловсронгуй болгох, учир болзошгүй эрсдэлээс зах зээлд оролцогчдыг хамгаалах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд Ажлын албаны даргын 2021 оны №А/61, №А/62 тушаалаар "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх баг"-тай гэрээ байгуулсан бөгөөд салбарын 2022-2025 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулсан. Төлөвлөгөөний дагуу холбогдох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр Хорооны 2022-2025 оны стратеги төлөвлөгөө, байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
12	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА			2,769.6	2,425.0	
12.1	Төрийн албаны ерөнхий удирдлага, зохицуулалт			2,769.6	2,425.0	
12.1.1.1	Хүний нөөцийн аудит хийх дүрэм, журам, аргачлал боловсруулж, мэргэшсэн аудиторуудыг бэлтгэж, төв, орон нутгийн төрийн байгууллагуудад төрийн албаны чадахуйн зарчмын хэрэгжилтийн аудит хийсэн байна.	20 байгууллага, 500 албан хаагч	1 байгууллага, 78 албан тушаалтан			Төрийн албаны зөвлөлөөс Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.4-т заасныг үндэслэн "Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх журам"-ыг 2021 оны 80 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж эхэллээ. Хүний нөөцийн аудитад Канад Улсын Төрийн албаны комиссын үйл ажиллагаанд ашигладаг Олон улсын аудитын дээд байгууллагын аудитын гарын авлага (20166); аудитын стандарт, практик туршлага, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт (3000)-д нийцүүлэн гаргасан "Аудитын гарын авлага"-ыг арга зүйн баримт бичиг болгон ашиглаж байна. Хүний нөөцийн аудитын хамрах хүрээг тодорхойлохдоо байгууллагын хүний нөөцийн бүхий л үйл ажиллагааг, эсхүл тодорхой хэсгийг хамруулахаар журамласан бөгөөд Эрчим хүчний яаманд "Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлагын хэрэгжилт" сэдвээр аудит төлөвлөн хэрэгжүүлэв. Аудитын мөрөөр ажиллах арга хэмжээний 12 зөвлөмж гаргаж Эрчим хүчний яаманд хүргүүлэв. НҮБХХ-ийн "Монгол улсын иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төслийн дэмжлэгтэйгээр хүний нөөцийн аудитын арга, аргачлалын талаарх Канад улсын туршлагаас суралцаж хүний нөөцийн аудит хийх ажилтнуудын мэдлэг чадварыг нэмэгдүүлэв. Мөн Төрийн албаны салбар зөвлөлийн дарга нарын нэгдсэн сургалтыг зохион байгуулж, хүний нөөцийн аудитын хүрээ, хэрэгжүүлэх арга зүйн талаар мэдлэг, мэдээлэл өгсөн болно.
12.1.1.2	Төрийн албаны тухай хуулийн үзэл баримтлалд бусад хууль тогтоомжийг нийцүүлэх талаар судлан, нэг мөр зохицуулах ажлыг манлайлан хэрэгжүүлж, төрийн байгууллагуудыг стратегийн болон бодлогын удирдамжаар хангасан байна.		668 төрийн байгууллага, албан тушаалтныг хамруулан 59 хууль тогтоомжийг өөрчлөх, нэмэлт оруулах, эшлэл өөрчлөх талаар хууль тогтоомжийг нийцүүлэх			Төрийн албаны тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2017 оны 75 дугаар тогтоолын 1-ийн 5-д заасны дагуу бусад хуульд буй төрийн албаны харилцааг зохицуулсан заалтуудыг Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуульд нийцүүлэн боловсронгуй болгох зорилгоор сонгон шалгаруулалт, томилгоотой холбоотой салбарын 19 хууль, төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, ёс зүй, нийгмийн баталгааг хангахтай холбоотой 23 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, зүйл, заалт, хэсгийн нэр томьёо, үг, өгүүлбэр болон хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, салбарын 17 хуулийн эшлэлийг өөрчлөх, хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтад эшлэл хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд зааж техникийн шинжтэй өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуульд заасны дагуу бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийн үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулж, Улсын Их Хуралд хүргүүлсэн. Төрийн албаны тухай хуулийн зохицуулалтыг нийгмийн орчин нөхцөл, цаг үе, хөгжлийн үйл явцтай уялдуулан илүү уян хатан болгох, цар хүрээг өргөтгөх санал, санаачилгын хүрээнд Улсын Их Хуралд хууль санаачлагчдаас өргөн барьсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албан хаагчийн ёс зүй сахилга хариуцлагын тухай, Чадахуйд суурилсан сонгон шалгаруулалтын тухай зэрэг хуулиудыг хэлэлцүүлэх, батлах бүх шатанд Төрийн албаны зөвлөл санаачилгатай, манлайлан ажиллаж байна.
12.1.1.3	Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын үйл ажиллагааг хэвшүүлж, төрийн үйлчилгээг сайжруулах талаар явуулсан бүх төрлийн судалгааны дүнг нэгтгэн төрийн албаны шинэтгэлийн бодлого, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.					Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг хамарсан төрийн албаны мэдээллийн санг /төрийн албаны замын зураг/ тодорхойлон Монгол улсын Ерөнхий сайдад танилцууллаа. Энэ санг тодорхойлсноор өнөөгийн байдлыг нэг хавтгай дээрээс бүрэн харах нөхцөл бүрдлээ.
12.1.2.1	Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн цахим системийг хөгжүүлж, төрийн албатай холбоотой мэдээллээр сонирхогч этгээдийг шуурхай хангаж ажилласан байна.		60 иргэн, байгууллага	36 байгууллага /салбар, аймаг, нийслэл/ 2756 албан тушаалтан		

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	12.1.2.2 Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт, төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын бүртгэл, шалгалтыг технологийн дэвшилд тулгуурлан бүрэн цахим хэлбэрээр хийдэг болно.	5000 тест, Цахим хэлбэрт бүрэн шилжих	5000 тест, Цахим хэлбэрт бүрэн шилжив			Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд албан тушаалын тодорхойлолтод суурилсан, цахим технологи ашигласан, шалгалтын агуулга, аргачлал, зохион байгуулалт, арга хэлбэрийн томоохон шинэчлэл хийгдэж, шалгалт хараат бус, ил тод, шударга явуулах нөхцөл хангагдлаа. Хууль тогтоомж, шалгалтын сорил, ном, гарын авлага судлах боломжтой Төрийн албаны зөвлөлийн албан ёсны эрх бүхий "e-laz" гар утасны аппликэйшн шинээр гаргаж иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран мэдлэгээ сорих, батжуулах, шалгалтад бэлтгэх нөхцөлийг бүрдүүлэв. Мөн "E-Mongolia" цахим үйлчилгээний нэгдсэн порталд "Сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын зар" болон "Төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцэж нөөцөд бүртгэгдсэн иргэдийн талаарх лавлагаа"-г оруулж төрийн нэгдсэн цахим үйлчилгээнд нэгдэв.Төрийн албаны шалгалт зохион байгуулах үйл ажиллагаанд цахимжилт, технологийн шинэчлэлийг 100 хувь нэвтрүүлээ. Төрийн жинхэнэ албаны шалгалтыг Төрийн албаны тухай хуульд заасан Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах, ард түмэнд үйлчлэх, ил тод байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх төрийн албаны үндсэн зарчмуудтай нийцүүлж, хөндлөнгийн нөлөөлөлгүй, шударга явуулдаг болсноор сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай холбоотой гомдол, маргаан буурч, шалгалтад оролцогчдоод хүлээн зөвшөөрөгдөх болсон нь чухал үр дүн болж байна.
	12.1.3.1 Төрийн албаны мэргэшлийн шалгалтын сорил, бодлогын даалгавар, ярилцлагын асуулт, хариултын санг шинэчилнэ.					Төрийн албаны шалгалтын агуулгыг шинэчлэх ажлын хүрээнд Шинжлэх ухааны академи, Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Удирдлагын академи, их, дээд сургуулиуд, Хуульчдын холбооны эрдэмтэн, судлаачдын зөвлөл үйлчилгээг авч, хууль эрх зүйн мэдлэгийн 600, Монгол Улсын түүх, нийгэм, эдийн засаг, соёлын мэдлэгийн 600, монгол хэлний ярианы болон бичгийн чадварын 750, асуудал шийдвэрлэх чадварын 200, дүн шинжилгээ хийх чадварын 446, удирдан зохион байгуулах чадварын 70, ур чадварын 1000 сорил, даалгавар, асуултын сан шинээр бүрдүүлэв. Мөн хуучин ашиглаж байсан хууль, эрх зүйн мэдлэг шалгах 2500, монгол хэлбичгийн 700, мэдээллийн технологийн 200 сорилыг магадлан шалгаж нийт 7000 орчим сорилыг төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалтад ашиглаж эхэллээ
	12.1.3.2 Төрийн албан хаагчийн бүртгэл, мэдээллийн иж бүрэн цахим систем бий болгож, албан тушаалын тодорхойлолт, цалингийн болон бусад системтэй холбож, шаардлагатай судалгаа, мэдээллээр Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, сонирхогч этгээдийг хангадаг болно.	төрийн 4374 байгууллага	4377 байгууллагын 184000 албан хаагч	2,769.6	2,425.0	Төрийн албаны "Хүний нөөцийн удирдлагын тогтолцоо" цахим системийн хөгжүүлэлтийн ажлын хүрээнд төрийн албаны цалингийн систем, нийгмийн даатгал төлөлтийн систем, боловсролын мэдээллийн сан, иргэний бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл зэрэг мэдээллийн сан, системтэй интеграци хийж мэдээллийн чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулснаар төрийн албаны "ХНУМТ" цахим системд бүртгэлтэй байгаа 4377 байгууллагын 184000 албан хаагчийн бүртгэл, судалгаа сайжирлаа. Ингэснээр УИХ, Монгол улсын Ерөнхийлөгч, Засгийн газар болон мэдээллийн хүсэлт ирүүлсэн байгууллага, албан тушаалтанд шаардлагатай мэдээллийг гарган хүргүүлэхэд зарцуулах хугацаа, мэдээллийн үнэн зөв байдал сайжирлаа. Албан тушаалын тодорхойлолтын цахим системийн хөгжүүлэлтийн ажил явагдаж байна.
	12.1.3.3 Төрийн албаны үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлж, иргэн, Төрийн байгууллага, албан хаагчдын оролцоог дэмжсэн цахим, дижитал орчин, бүтцийг бүрдүүлж, төрийн албаны шинэтгэлийн үйл явцыг олон нийтэд ил тод, нээлттэй болгосон байна. Төрийн албан хаагчийн хөдөлгөөний тоо бүртгэлд үндэслэн шаардлагатай нөөц бүрдүүлэлтийн хэрэгцээг тодорхойлдог болно.	төрийн 4374 байгууллага	4377 байгууллагын 184000 албан хаагч	2,769.6	2,425.0	Төрийн албаны "ХНУМТ" цахим систем, сонгон шалгаруулалтын системийг e-монголиа цахим системтэй холбох ажлыг эхлүүлж байгууллагад ажиллаж байгаа, цалингийн тодорхойлолт, анкетыг ХУР системээр дамжуулан өгөхөөр хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлээ. Ингэснээр төрийн 4377 байгууллагад ажиллаж байгаа 184000 албан хаагч, нөөцөд байгаа 20000 шахам иргэн тухайн баримт бичгийг цахимаар авч ашиглах нөхцөл бүрдэж үйлчилгээ цахимжина. Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсыг шинэчлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2 удаа зарлан тухай бүрд нь 3 ба түүнээс дээш компани оролцоогүй учир шууд гэрээ байгуулахаар Үнэлгээний хорооны зөвлөмжийг захиалагчид хүргүүлэн гэрээ байгуулахаар ажиллаж байна.
	12.1.3.4 Төрийн албан хаагчийн хөдөлгөөний тоо бүртгэлд үндэслэн шаардлагатай нөөц бүрдүүлэлтийн хэрэгцээг тодорхойлдог болно.					Төрийн албаны "ХНУМТ" цахим системийн бүтэц, бүртгэлийн чанарыг сайжруулах ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна. Цалингийн системээс мэдээллийг авах интеграцийг хөгжүүлэн сул орон тоо, шаардлагатай нөөцийн талаарх судалгаа мэдээллийг цаг тухайд нь гарган авах, бүрэлдэхүүн хөдөлгөөнд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлнэ.
	12.1.4.1 "Ёс зүйтэй, сахилга хариуцлагатай төрийн албан хаагч" хөтөлбөр хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн талаар төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, гарсан зөрчлийг таслан зогсоох, цаг тухайд нь шийдвэрлэх, холбогдох албан хаагчдад хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг байгууллага нэг бүрд хэвшүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	270 ёс зүйн зөвлөл	466 ёс зүйн зөвлөл			Төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн зөвлөлийг чадавжуулах, нэгдсэн зохион байгуулалтад оруулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх аргачлал боловсруулахад шаардлагатай мэдлэг, ур чадвар арга зүйд сургах зорилго бүхий сургалтыг 14 яам, 13 УИХ-аас удирдлага нь томилогддог байгууллага, 10 агентлаг, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар, 21 аймгийн ЗДТГ, 420 Нутгийн захиргааны байгууллагын нийт 466 Ёс зүйн зөвлөлийн 598 гишүүдийг тус тус сургалтад хамруулж, арга зүйгээр хангасан.
	12.1.4.2 Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, ёс зүйн хэм хэмжээний биелэлтэд хяналт шалгалт хийж, бодлого, арга зүйн зөвлөмжөөр хангасан байна.					Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, тавих ажлын хүрээнд Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх 51 ажлын хэсэг байгуулж 375 байгууллагын 5277 төрийн жинхэнэ албан хаагчийг томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	12.1.4.3	Ажлын байранд эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн болон бусад төрлийн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэхтэй холбогдсон арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулна.	30 байгууллага, 200 албан хаагч	375 байгууллагын 5277 төрийн жинхэнэ албан хаагч			Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ажлын үр дүн, гүйцэтгэл, үр чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн онол, практик, олон улсын туршлагын талаарх шинэ мэдлэг, мэдээллийг түгээх зорилго бүхий арга зүйн сургалтыг долоо хоног бүрийн Пүрэв гарагийн 10 цагаас зохион байгуулж хэвшүүлснээр Төрийн албаны зөвлөлийн "7:4:10" хэмээх сургалт, танин мэдэхүйн "Брэнд" ажил боллоо. Цахим сургалтыг 2021 онд 8 багц сэдвийн хүрээнд 32 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 30784 хэрэглэгчийн эрхийг ашиглан 100 гаруй мянган албан хаагчийг хамруулсан. Пүрэв гарагийн "7:4:10" цахим сургалтын агуулга, үр өгөөж, төрийн албан хаагчийн хэрэгцээнд нийцсэн байдал, багшийн арга зүй, сэдэв, сургалтын арга хэлбэр, зохион байгуулалтын талаарх судалгааг тухай бүр хийсэн бөгөөд оролцогчдын 85.3 хувь нь сургалтын сэдэв, агуулга оновчтой, үр өгөөжтэй, цаашид сургалтыг үргэлжлүүлэх саналтай байна гэж дүгнэжээ.
	12.1.5.1	Төрийн албаны зөвлөлийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг шинэ агуулга, хэлбэрээр өргөжүүлэн хөгжүүлж, бусад улсын төрийн албаны төв байгууллагуудтай идэвхтэй, тэнцвэртэй хамтран ажиллаж, туршлага солилцон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.	5 гадаад улс, олон улсын байгууллага	АНУ, БНХАУ, ОХУ, БНТУ, Япон Улсын Элчин сайдын яамны төлөөлөгч			"Ирээдүйн төрийн албыг цогцлоох нь" уриан дор зохион байгуулагдсан НҮБ-ын Төрийн албаны өдрийг тохиолдуулан Монгол Улсын төрийн албан хаагчдыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулж, төрийн албаны шинэтгэлийг дэмжиж ажилладаг Засгийн газар, олон улсын байгууллагуудын төлөөлөл, тэтгэлгээр суралцаж төгссөн, суралцаж буй 400 гаруй төрийн албан хаагчийн цахим уулзалт өдөрлөгийг анх удаа зохион байгууллаа. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Канад Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төслийн хүрээнд Сингапурын Үндэсний их сургуулийн харьяа Ли Куан Юүгийн нэрэмжит Төрийн бодлогын сургуулийн тэтгэлэгт цахим хөтөлбөрт төрийн байгууллагын төлөөлөл 20 албан хаагчийг сонгон шалгаруулж суралцуулаа.
	12.1.5.2	Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн албан хаагчдын дүн шинжилгээ хийх, бодлогын баримт бичиг боловсруулах, хяналт шалгалт, аудит хийх төрийн албан хаагчдад арга зүйн зөвлөгөө өгөх мэдлэг чадварыг дээшлүүлсэн байна.	32 салбар зөвлөл	49 Салбар зөвлөлийн дарга,нарийн бичгийн дарга нар давхардсан тоогоор 1421 удаа			Төрийн албаны зөвлөлөөс 2021 онд зохион байгуулсан сургалтуудад 49 Салбар зөвлөлийн дарга,нарийн бичгийн дарга нар давхардсан тоогоор 1421 удаа хамрагдсан. Мөн Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд зориулсан "Хүний нөөцийн аудит хийх онолын сургалт", "Төрийн албаны хүний нөөцийн удирдлагад цогц чадамжийн хүрээг нэвтрүүлэх нь", "Төрийн байгууллагын замын зураглал гаргах нь" уулзалт, сургалт, Бодлогын инновац төслийн хүрээнд "Системийн сэтгэлгээ (System Thinking) , Загварчлалын сэтгэлгээ (Design Thinking), Зан үйлд нөлөөлөх чадвар (Behavioral Insights)" сургалтуудад хамрагдсан байна. Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж байгаа "Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төслийн санхүүжилтээр "Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн чадавхыг сайжруулах арга зүйн хөтөлбөр болон гарын авлага боловсруулах" сургалтуудад хамруулсан. 2021 оны 11 сард "Цогц чадамжийг нэвтрүүлэх нь: Ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх, хүний нөөцийн мэргэжилтнийг чадавхжуулах" бүсчилсэн сургалтыг Сэлэнгэ, Өвөрхангай, Завхан аймгуудад зохион байгуулагдаж 15 аймгийн салбар зөвлөлийн нарийн дарга нар болон холбогдох албан хаагчид хамрагдсан.
	12.1.5.3	Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны чадавхыг сайжруулж, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг дээшлүүлэх арга хэмжээ авсан байна.	10 албан хаагч	давхардсан тоогоор 56 албан хаагч			Тайлант хугацаанд нийт албан хаагчдын цалингийн шатлал ахиулах, зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох, төрийн дээд одон медаль, шагналын, төрийн алба хаасан хугацааны зэрэг судалгаа шинжилгээг тухай бүр хийсний үр дүнд 3 албан хаагч төрийн дээд шагнал, Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр 9, салбарын жуух бусад шагналаар 4 албан хаагч шагнуулсан байна. 2021 онд Ахлах түшмэлийн зэрэг дэв 12 албан хаагчид, дэс түшмэлийн зэрэг дэв 5 албан хаагчид, эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв 3 албан хаагчид, Тэргүүн түшмэлийн зэрэг дэв 4 албан хаагчид олгов. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу гачигдал тохиолдсон дэмжлэг шаардлагатай 6 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэв. Сингапурын үндэсний их сургууль Ли Куан ю-ийн богино хугацааны сургалтад 2 албан хаагч, JCI төслийн Төрийн албан хаагчдад зориулсан хөтөлбөрт сургалтад 2 албан хаагч, Удирдлагын академийн тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн багц сургалтад 6, шинээр томилогдсон болон давтан сургалтад 4 албан хаагчийг хамрууллаа. Байгууллага 4 чиглэлийн хүрээнд зохион байгуулах 18 сургалтыг төлөвлөн, хэрэгжилт 100 хувьтай хэрэгжив. Албан хаагчдыг коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зориулсан дэмжлэг, халдвар хамгааллын хэрэгслээр тухай бүр хангаж ажиллаа. Коронавируст халдварын эсрэг 1, 2, 3 дугаар тунд албан хаагчид бүр хамрагдав. Байгууллагын хэмжээнд 9 удаа шинжилгээ хийлгэх үйл ажиллагааг зохион байгуулж, халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлэв.
13	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА				10,382.2	10,224.5	
	13.1	Албан ёсны статистикийг хөгжүүлэх			4,913.1	10,224.5	
	13.1.1	Албан ёсоор гаргах статистикийн мэдээ, тайлангийн нэр төрөл	406	406			ҮСХ-нд яам, агентлаг, төрийн бусад байгууллага болон нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсээс 2021 онд ирүүлэх мэдээ, тайлангийн батлагдсан графикийн дагуу албан ёсны болон захиргааны 406 төрлийн мэдээг авсан.
	13.1.2	Албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн тархаалт	474	474			ҮСХ-ноос албаны ёсны статистикийн мэдээ, тооллого, судалгааны үр дүнг тархах 2021 оны батлагдсан хуваарийн дагуу 474 үзүүлэлтийг нэгтгэн боловсруулж, цахим болон хэвлэмэл хэлбэрээр тархаасан.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	13.1.3	Шинээр болон шинэчлэн сайжруулсан аргачлал, ангиллын тоо	5	8			ҮСХ-ноос 2021 онд 6 аргачлал, 2 ангиллыг шинээр боловсруулж, баталж мөрдүүлсэн. Үүнд: БОЭЗДС-ийн хүрээний Усны хөрөнгийн данс байгуулах аргачлал, Хатуу хог хаягдлын данс байгуулах аргачлал, Газрын ашиглалтын биет хөрөнгийн данс байгуулах аргачлал, Шинжлэх ухаан, технологийн статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал, Эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, аргачлал, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал болон Улсын бүртгэлийн нэгдсэн ангилал, код Ашгийн бус байгууллагын үйл ажиллагааны ангилал
	13.1.4	Статистикийн мэдээллийн санд суурилж, нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтээр хийх судалгааны тоо	26	53	4,913.1	5,041.0	Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын үр дүнгээр боловсруулсан сэдэвчилсэн судалгаа-13 үүнд: Хүн ам зүйн үндэсний атлас, Өрх гэр бүлийн байдал, Хүүхэд, залуучууд, Өндөр настан, Шилжих хөдөлгөөн, суурьшил, Хүн амын 2020-2050 оны шинэчилсэн хэтийн тооцоо, Боловсролын 2020-2050 оны хэтийн тооцоо, Боловсрол, бичиг үсгийн мэдлэг, Жендерийн тэгш байдал, Интернет, гар утасны хэрэглээ, Эдийн засгийн идэвх, Хөгжлийн бэрхшээл, Хүн ам зүйн үндэсний атлас Сэдэвчилсэн судалгаа-12: 1. Ажлын байрыг хадгалах хөнгөлөлттэй зээлийн үр нөлөө, 2. Хөдөө аж ахуйн статистикийн мэдээлэлд алсын зайнаас тандан судлах арга зүй, 3. Дээд боловсрол эзэмшигчдийн мэргэжил ба хөдөлмөр эрхлэлтийн хамаарлын судалгаа, 4. Эмэгтэйчүүдийн сэтгэл санааны хүчирхийлэл, хянах зан үйлд өртөхөд нөлөөлсөн хүчин зүйлийн шинжилгээ, 5. Коронавирус ба эдийн засаг, 6. Коронавирусийн нөхцөл байдал, халдварын тархалт, 7. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн байдал 1990-2020 он, 8. Эдийн засгийн аюулгүй байдлын 2020 оны танилцуулга, 9. Боловсролын байгууллагын дархлаажуулалт, 10. Нийгэм, эдийн засгийн хөгжлийг хэмжиж буй байдал, 11. Мэргэжил ба хөдөлмөр эрхлэлтийн хамаарлын судалгаа, 12. Салбар хоорондын тэнцлийн шинжилгээ
	13.2	Улсын хэмжээний тооллого					
	13.2.1	Статистикийн хуулийн дагуу хийсэн байвал зохих улсын хэмжээний тооллогын тоо	3	3			1. ААНБ-ын ээлжит тооллого, 2. Мал, тэжээвэр амьтдын жилийн эцсийн тооллого 3. Хашаа, худгийн тооллого
	13.3	Улсын хэмжээний судалгаа			5,469.1	5,183.6	
	13.2.1	Статистикийн хуулийн дагуу хийсэн байвал зохих улсын хэмжээний судалгааны тоо	16	27	5469.1	5183.6	1. Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа, 2. Өрхөд суурилсан мэдээлэл, харилцаа холбооны технологийн судалгаа, 3. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, 4. Ажиллах хүчний судалгаа, 5. Ургацын алдагдал тооцох туршилтын судалгаа, 6. ААН-ийн үйл ажиллагаанд үзүүлж буй коронавирсийн нөлөөллийг судлах панел судалгаа, 7. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс тооцох судалгаа, 8. Барилгын өртгийн судалгаа, 9. Аж үйлдвэрийн үйлдвэрлэгчийн үнийн судалгаа, 10. Тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн судалгаа, 11. Худалдааны салбарын үйлдвэрлэгчийн үнийн судалгаа, 12. Холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнийн судалгаа, 13. Зочид буудал, зоогийн газрын үйлдвэрлэгчийн үнийн судалгаа, 14. Бичил уурхай эрхлэгчдийн судалгаа, 15. Малын хагас жилийн түүвэр судалгаа, 16. ААН, байгууллагын хөрөнгө, хөрөнгө оруулалтын судалгаа, 17. Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа нэмэх, 18. Коронавирсын нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа, 19. Цаг уурын хүндрэлийг даван туулж байгаа байдал, өрхийн панел судалгаа, 20. Жендер ба хүрээлэн буй орчин, 21. Малчдын аж байдал ба жендер судалгаа, 22. Олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн хөтөлбөр, 23. Өрхийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийг тодорхойлох судалгаа, 24. ААН-ийн үнийн хүлээлтийн судалгаа, 25. Иргэдийн инфляцын хүлээлтийн судалгаа, 26. Худалдан авалтын менежерийн судалгаа, 27. Бизнесийн түүвэр судалгаа.
14	СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА				28,122.3	25,712.7	
	14.1	Бүх шатны сонгууль зохион байгуулах			28,122.3	25,712.7	
	14.1.1	Сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой боловсруулах журам, заавар, маягт	40	40	20,713.6	19,470.2	Сонгуулийн Ерөнхий Хороо 2021 онд нийт 25 удаагийн хуралдаан зохион байгуулж, МУ-н Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах ажиллагаанд мөрдөж ажиллах журам, заавар-15, маягт, загвар, аргачлал, шаардлага-5 баталж, 109 тогтоол, нийт 171 шийдвэр гаргаж сонгуулийн байгууллага, нэр дэвшигч, нам, эвсэл, холбогдох бусад байгууллагад мөрдүүлж ажиллаана.
	14.1.2	Сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах сургалт, семинарын тоо	22	103	463.6	272.4	Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагын ажилтанд гэрчилгээ олгох сургалт 21 аймаг, 9 дүүрэгт цахимаар, Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны гишүүн, МТБ-ийн гишүүн, даамлын "Сонгуулийн зохион байгуулалт" сургалтыг 103 удаа зохион байгуулж, нийт 22094 хүнийг хамруулсан байна.
	14.1.3	Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх /өмнөх оны суурь үзүүлэлтээс өсөх хувь/	5		1,188.7	1,160.5	Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, сонгогчийн ирцийг нэмэгдүүлэх зорилгоор хууль тогтоомж сурталчилсан, саналаа хэрхэн тэмдэглэх, саналаа яаж өгөхийг тайлбарласан "Сонгогчийн ном" сургалт, сурталчилгааны ном, сонгуульд идэвхтэй оролцохыг уриалсан зурагт хуудас, санал хураалтад оролцохыг уриалсан телемаркетинг үйлчилгээ, радио телевизийн реклам, сонгуулийн хууль, тогтоомж, журам, зааврыг сурталчилсан, санал авах өдрийн тухай ярилцлага, мэдээ, мэдээллийг цахим орчинд, и-мэйл сурталчилгаа, сонин, хэвлэл, радио, телевиз, гудамжны мэдээллийн самбар, лэд дэлгэцээр өргөн хүрээгээр сурталчилгаа хийсэн. Мөн сонгуулийн дүн мэдээ, сонгогчийн ирцийн мэдээг дэлгэцээр шууд дамжуулсан.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	14.1.4	Сонгуулийн хороодын үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтын тоо	22	25	154.6	108.0	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайланд орон нутгийн аудитын байгууллагаар аудит хийлгэсэн. Мөн МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардал болон УИХ-ын 18, 28 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардалд Үндэсний аудитын газраар аудит хийлгэж дүгнэлт гаргуулсан.
	14.1.5	Сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянах	20	0	-	-	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд сонгуульд оролцсон нам, эвсэл болон нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд төрийн болон орон нутгийн аудитын байгууллага аудит хийхээр хуульд өөрчлөлт орсон.
	14.1.6	Сонгуулийн автоматжуулсан системийг бүрэн ашиглах, хэвийн үйл ажиллагаа, санал хураах тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах /төхөөрөмжийн тоо/	5000	5500	4,766.1	3,968.3	2750 ш батарей, 2750 ш санал тоолох төхөөрөмжийг шалгах, цэнэглэх ажлыг хуваарийн дагуу зохион байгуулж бэлэн байдлыг хангаж ажилласан. МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд 2087 хэсэг, УИХ-ын нөхөн сонгуульд 148 хэсэгт санал тоолох төхөөрөмжийг бүрэн ашигласан байна.
	14.1.7	Программ хангамжийн аюулгүй ажиллагааг хангах	бүрэн хамгаалагдсан байх	бүрэн хамгаалагдсан	355.7	351.8	Бүрэн хамгаалагдсан
	14.1.8	Мэдээллийн бааз үүсгэх	21	24	479.9	381.6	Байнгын бус үйл ажиллагаатай сонгуулийн байгууллагын ажилтны мэдээллийн сан /20000 гаруй хүн/, МУ-ын Ерөнхийлөгчийн болон УИХ-ын нөхөн сонгуулийн саналын хуудасны зурган файл, хэсгийн хорооны хяналтын камерын дүрс бичлэг болон хүлээж авсан сонгуулийн дүнг мэдээллийн сан үүсгэн хадгалсан. МУ-ын Ерөнхийлөгчийн болон УИХ-ын нөхөн сонгуулийн дүнг аймаг, дүүрэг, тойргоор нь шууд дамжуулсан.
15	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД				169,474.6	165,931.3	
	15.1	Төрийн өмчийн бодлогыг хэрэгжүүлэх			1,191.6	1,051.3	
	15.1.1	Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүү, эдийн засаг, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын тоо	25	35			ТӨБЗГ нь ТБОНӨТХ-ийн 66.4 дэх заалтын дагуу 2021 авч хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөг Сангийн яамтай зөвшилцөн баталснаар төлөвлөгөөт 19, төлөвлөгөөт бус 6, гүйцэтгэлийн 10, нийт 35 хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас Монгол Улс бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, цар тахлын эрсдэлийг даван туулахад Засгийн газраас зарим зардлыг тэвчих шийдвэр гарсан зэрэг дээд газрын шийдвэрээр 2021 онд хөдөө орон нутагт хийхээр төлөвлөсөн 13 хуулийн этгээдийн хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй бөгөөд гүйцэтгэлийн 10 шалгалт, системийн 1 шалгалт нэмж гүйцэтгэн ажилласан. Тайлант онд нийт 19 баримтын хяналт шалгалтын тайланг газрын хуралдаанд танилцуулан, хуралдаанаас гарсан саналыг "Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай" шийдвэрийн төсөлд тусган албажуулан холбогдох байгууллагуудад тайлангийн хамт албан бичгээр хүргүүлж, төлөвлөгөөт бус шалгалтын 6 тайланг танилцуулгын хамт Сангийн яаманд хүргүүлэн, гүйцэтгэлийн 10 шалгалтын тайланг нэгтгэн танилцуулсан.
	15.1.2	Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт /өмч эзэмшлийн гэрээний дүгнэлтийн хувь/	100	93.03	1,191.6	1,051.3	Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр хяналт тавьж 2020 онд 961 хуулийн этгээдтэй гэрээ байгуулж байсан бол 2021 онд 985 хуулийн этгээдтэй байгуулж, дүгнэсэн бөгөөд гэрээний биелэлтийн дундаж дүн 93.03 хувьтай байгаа нь өнгөрсөн онхоос 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн дүнг ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанд танилцуулан 538 дугаар тогтоолыг батлуулан хэрэгжүүлж байна.
	15.1.3	Төрийн өмчийн байгууллагын менежментийг сайжруулах, ашигтай ажиллуулах замаар орлогыг төвлөрүүлэх	Орлогыг бүрэн төвлөрүүлсэн байх	Орлогыг бүрэн төвлөрүүлсэн. /Төлөвлөгөө 115% биелсэн/			Ногдол ашиг 209,645.7 сая төгрөг, түрээсийн орлого 2,510.1 сая төгрөг, өмч хувьчлалын орлого 453.0 сая төгрөг, нийт 212,608.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Улсын төсөвт төвлөрүүлбэл зохих ногдол ашигийг "Эрдэнэс Монгол" ХХК 766.7 сая төгрөгөөр, "Улаанбаатар Төмөр зам" ХНН 1,125.0 сая төгрөгөөр, Төрийн банк 3,061.2 сая төгрөгөөр тус тус дутуу төвлөрүүлээд байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 677 тоот тогтоолоор санал солилцон 2022 оны 2 улиралд багтаан төвлөрүүлэхээр хойшлуулсан байна.
	15.1.4	Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу Төрийн өмчийн эд хөрөнгийн үзлэг тооллогыг 2021 оны 4 дүгээр улиралд зохион явуулах	Тооллогыг төлөвлөсөн хугацаанд зохион явуулах	Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу хойшлогдсон			Дэлхий дахинд үүссэн цар тахлын улмаас Засгийн газрын 9 дүгээр тогтоолд 2020 оны 46 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж 2021 онд төрийн өмчийн улсын тооллогыг явуулахаар хойшлуулж, Засгийн газрын 2021 оны 278 дугаар тогтоолоор дахин нэмэлт өөрчлөлт оруулан 2022 онд явуулахаар шийдвэрлэсэн. Тооллогын ажилд шаардлагатай төсвийг 2022 оны улсын төсөвт тусгасан бөгөөд тооллогын ажлыг эхлүүлэн 2022 онд багтаан дуусгахаар төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.
	15.1.5	Өмч хувьчлалын үйл ажиллагааг зохион байгуулж, орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх	Орлогыг бүрэн төвлөрүүлсэн байх				
15.2	Ангилалдаагүй бусад хөтөлбөр				158,244.2	155,119.6	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	15.2.1	Цөмийн энергийн салбарт баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх /хувиар/	100	90	1,315.7	1,221.0
	15.2.2	Дозиметрийн тохируулга, баталгаажуулалт хийх /тоогоор/	180	268		2021 онд 55 аж ахуйн, нэгж байгууллагын 279 ширхэг хэмжих хэрэгслийг баталгаажуулахаар хүлээн авснаас 268 хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийж, гэрчилгээ олгосон.
15.3	Жендерийн эрх тэгш байдлыг хангах			350.7	348.8	
	15.3.1	Яамд /салбар/-ын жендерийн нэгдсэн бодлого, аймаг, дүүргийн жендерийн дэд хөтөлбөрийн тоо	Яам-9, аймаг-21, нийслэл, дүүрэг-10	Яам 12, аймаг 21, нийслэл, дүүрэг 10		21 аймаг бүрэн дэд хөтөлбөрөө боловсруулсан. Нийслэл болон нийслэлийн 8 дүүрэг жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрөө боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийслэлийн ХУД дэд хөтөлбөрөө батлуулаагүй. 12 яам бодлого баталсан. Шинээр байгуулагдсан 3 яам бодлогоо батлаагүй байна.
	15.3.2	Оролцоонд суурилсан жендерийн үнэлгээ хийсэн яам /салбар/, аймаг, дүүрэг	Яам-9, аймаг-21, нийслэл, дүүрэг-10	Яам 12, аймаг 21, нийслэл, дүүрэг 10		2021 онд шинээр Увс, Говьсүмбэр, Булган, Дорнод, Баянхонгор, Өмнөговь, Ховд, Төв аймаг болон нийслэлийн СБДүүрэг тус бүр жендерийн дэд хөтөлбөртөө Оролцооны ХШУ-г хийсэн. Нийт 12 яам Оролцоонд суурилсан жендерийн үнэлгээ хийсэн ба Эрчим хүчний яам бодлого боловсруулах суурь үнэлгээний ажлаа эхэлсэн.
	15.3.3	Жендерийн үндэсний сургагч багшийн тоо	180	154		Жендерийн сургагч багш бэлтгэх сургалтыг 2021 онд 43 төрийн байгууллагын 50 төрийн албан хаагчийг анхан шатны сургагч багшаар бэлтгэж, үүнээс 25 албан хаагчийг дунд шатны сургагч багшаар бэлтгэх сургалтад хамруулан нийт 154 жендерийн сургагч багштай болсон бөгөөд 2020-2021 онд бүхэлдээ цар тахалтай жил байсан тул сургалтын үйл ажиллагаа хойшилсноор сургагч багшийн тоо зорьсон үр дүндээ хүрээгүй.
	15.3.4	Жендерийн сургалтад хамрагдсан удирдах ажилтан, төрийн албан хаагч	удирдах ажилтан 65.0 хувь, төрийн албан хаагч 75.0 хувь	Удирдах ажилтан 65 хувь, төрийн албан хаагч 75 хувь		2021 оны байдлаар ажлын алба нь 29 сургалт, семинарыг давхардсан тоогоор 2490 /1013 эрэгтэй, 1477 эмэгтэй/ төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдад мэдээлэл хүргэж ажиллав. Удирдах ажилтны жендерийн цахим модулиар 2021 оны байдлаар төрийн албаны 268 удирдах ажилтныг шинээр сургалтад хамруулж нийт 1427 удирдах ажилтан цахим сургалтад хамрагдсан байна.
	15.3.5	Аймаг, нийслэл, дүүргийн жендерийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд орон нутаг дахь төрийн бус байгууллагаас хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тоо	30	30	350.7	348.8
						Төслийн хүрээнд орон нутгийн жендерийн дэд хөтөлбөрт оролцоонд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалыг боловсруулж, аргачлалыг 21 аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээ, жендерийн асуудал хариуцсан холбогдох албан тушаалтнуудад танилцуулах чадвар бэхжүүлэх сургалтыг Булган, Дундговь, Говь-алтай аймгуудад 2020 оны 8 дугаар сарын 20-28-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 220 (үүнээс төрийн 66, төрийн бус байгууллагын 144 төлөөлөл) оролцуулсан. Энэ хүрээнд орон нутгийн жендерийн дэд хөтөлбөрт оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах нээлттэй тэтгэлэг зарлаж, Баянхонгор, Булган, Дорнод, Өмнөговь, Ховд аймгийн нийт 23 ТББ-аас бүрдсэн таван багийг сонгон шалгаруулж, ОХШУ-г 2020.10-2021.02 сард хийж гүйцэтгэсэн. 2021 онд Эдгээр 5 аймгийн ОХШУ-ний тайлан болон бодлогын зөвлөмжийг дээрх 5 аймгийн удирдлагууд болон ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн. Түүнчлэн дээрх сургалтын хүрээнд Говьсүмбэр, Увс, Төв аймгийн орон нутгийн ИНБ-уудас бүрдсэн баг ОХШУ-ний аргачлалын дагуу тус 3 аймгийн жендерийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд ОХШУ хийсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	15.3.6	Аймаг, нийслэл, дүүрэгт ажиллаж байгаа хохирогчийг хамгаалах нэгжийн тоо	30	33			Монгол Улсад хохирогчийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хамгаалах байр-16, нэг цэгийн үйлчилгээний төв-17, нийт 33 хамгаалах байр ажиллаж байна. Эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ тогтмол явуулж буй эмнэлэг Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн-6, хувийн хэвшлийн-6, хөдөө орон нутагт 8, нийт 20 эмнэлэг байна.
	15.3.7	Эрэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн тасаг, кабинет	30	20			
	15.4	Биеийн тамир, спорт			9,688.1	9,411.6	
	15.4.1	Нийтийн биеийн тамираар хичээллэгчийн тоо /нийт хүн амд эзлэх хувиар/	47	40	259.6	259,3	Биеийн тамирын 2021 оны статистик судалгаагаар улсын хэмжээнд биеийн тамир, спортын арга хэмжээг 1160 удаа зохион байгуулж, 365 085 хүн хамрагдсан. Ковид-19 цар тахлын үед улсын хэмжээнд иргэдийг биеийн тамирын дасгал хөдөлгөөн, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн дархлааг дэмжих, эрүүл зөв хооллолт, зөв дадал хэвшилтэй болгох зорилгоор "Эрүүл мэндийн цахим гүйлт", "Дасгал хөдөлгөөнөө хийцгээе", "Цахим гимнастрада", "Иргэдийн наадам-21" зэрэг арга хэмжээнд 80.250 хүн, "Үнэгүй фитнес" төрийн бус байгууллагын цахим дасгалд 80.000 мянган хүн тус тус хамрагдсан. Нийт 2021 онд улсын хэмжээнд 1160 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 525.335 иргэн хамрагдаж, 6-65 насны 2.803.900 иргэдийн 18.7 хувь хамрагдсан байна. Ковид-19 цар тахалтай холбогдуулж төлөвлөсөн арга хэмжээнүүд зохион байгуулагдаагүй болно.
	15.4.2	Олон улсын болон тив, дэлхийн чанартай тэмцээнээс авах медалийн тоо	120	91	9,428.5	9,411.6	Үндэсний шигшээ багийн тамирчид 2021 онд олимп, тив дэлхийн, олон улсын тэмцээнээс 19 алт, 29 мөнгө, 43 хүрэл нийт 91 медаль хүртсэн. Олимпын наадам 1 мөнгө, 3 хүрэл, пара олимп 1 алт, ДАШТ 2 алт, 3 мөнгө, 9 хүрэл, Залуучуудын ДАШТ 2 хүрэл, мастер тэмцээн 1 хүрэл, Азийн АШТ 5 алт, 5 мөнгө, 12 хүрэл, Их дуулга 6 алт, 5 мөнгө, 12 хүрэл, Гранпри 2 алт, 4 мөнгө, 2 хүрэл, Олон улсын тэмцээн 3 алт, 11 мөнгө, 2 хүрэл нийт 19 алт, 29 мөнгө, 43 хүрэл төлөвлөгөөний биелэлт 82%-тай байна.
16	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД				477,886.4	473,649.7	
	16.1	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаа			378,851.4	377,760.2	
	16.1.1	Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийх /гамшгийн тохиолдлын буурах хувиар/	10	10	378,722.9	377,631.7	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 75 дугаар тогтоол, 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 222 дугаар тогтоолын хүрээнд БНХАУ-аас Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын эсрэг вакцины тээвэрлэлтийн зардал болох 1,868.9 сая төгрөгийг МИАТ ТӨХК-д шилжүүлж, Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд 294 удаагийн нислэгээр 34,084 (Монгол 26591, Гадаад 7,493) иргэн тусгай болон захиалгат нислэгээр эх орондоо ирэн, УОК-ын шийдвэрээр тусгаарлалтын үйл ажиллагааг цуцалсантай холбогдуулан иргэдийн тусгаарлах байрны төлбөр 119.0 сая төгрөгийг Төрийн санд төвлөрүүлсэн байна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 240 дүгээр тогтоол, 2021 оны 40, 75, 222 дугаар тогтоолын дагуу Ковид-19-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд дотоодын халдварын улмаас тусгаарлагдсан иргэд, тусгаарлах байранд ажилласан алба хаагчдын төлбөр 5.0 тэрбум төгрөгийг тусгаарлах байруудад олгосон бол иргэд, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллага, гадаад улс орноос нийт 187.2 сая төгрөг цугларсан ба нийт 901.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Хандив тусламжийн зарцуулалтын мэдээг www.nema.gov.mn болон www.shilendans.gov.mn цахим хуудсуудад байршуулан шилэн дансны цахим хуудсанд сар тутамд байршуулан 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 21 гүйлгээг холбогдох баримтын хамт байршуулсан.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
16.1.2	Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах хяналт шалгалт /хүн өдөр/	32780	3278	85.5	85.5	НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2009 оны 64/200 дугаар шийдвэрийн хүрээнд "Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр"-ийг НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас 2021 онд дэвшүүлсэн "Зөвхөн хамтдаа. Бид эх дэлхийгээ аварч чадна" уриатай уялдуулж Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, тогтоомж сурталчлах өдөрлөг, нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд нийт 43 удаа зохион байгуулж, 28,150 иргэн, 870 оюутан, сурагчдыг хамруулсан байна. Коронавируст халдвараас сэргийлэх зорилгоор "Ойлгоё, хайрлая" цахим аян, "Үер, уснаас үрсээ хамгаалъя" аяны удирдамж, төлөвлөгөө, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх "Алдвал галдана" аян, ахуйн гал түймэр, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх "Мартаж болохгүй" аян, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөрлөг"-ийг зохион байгуулж ногоон түвшинд байгаа аймгуудад гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, аюулгүйн талбайд цугларах, нүүлгэн шилжүүлэх дадлага сургуулийг зохион байгуулж нийт 42,234 албан хаагч, иргэдийг хамруулсан байна. "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх нь" сэдэвт шинжлэх ухаан, танин мэдэхүйн цахим сургалтыг улсын хэмжээнд 2021 оны 3 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 824,000 иргэнийг хамруулан, гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг Өвөрхангай аймагт зохион байгуулж нийт 492 хүнийг цахимаар болон танхимаар хамруулан зохион байгуулсан. Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2021 онд зохион байгуулах "Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ", "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөрлөг", "Олон улсын Иргэний хамгаалалтын өдөрлөг", "Шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ", "Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ", "Эрчим хүч, ус дулаан хангамжийн салбарын тогтвортой ажиллагаа, аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийн гал түймрийн аюулгүй байдлыг хангуулах нэгдсэн арга хэмжээ", "Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдөрлөг" зэрэг нийт 7 төрлийн нэгдсэн арга хэмжээний удирдамжийг боловсруулан ажилласан.
16.1.3	Гамшгийн хор уршгийг арилгах аврах ажлын зориулалттай тусгай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах /хувиар/	60	60	43.0	43.0	Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж байгаа "Онцгой байдлын албаны гамшигтай тэмцэх техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах" төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 оны 9 дүгээр сарын 06-21-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Франц Улсын "Десотел" компанид албан томилолтоор ажиллав.Төслийн хүрээнд эхний ээлжид нийлүүлэгдсэн гал түймэр унтраах үндсэн албаны 21 автомашины дадлага, сургалтыг 2021 оны 9 дүгээр сарын 24-29-ний өдрийн хооронд зохион байгуулж, төв, орон нутгийн салбар нэгжүүдэд хүлээлгэн өгөв. Төслийн хоёрдугаар ээлжид нийлүүлэгдсэн үндсэн албаны 14, штабын 1, автомеханик шатны 3, нийт 18 ширхэг автомашины сургалт, дадлагыг 2021 оны 12 дугаар сарын 03-08-ний өдрүүдэд зохион байгуулав. Мөн төслийн багаас Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын тандалтын системийг боловсруулж, Эрүүл мэндийг яаманд хүлээлгэн өгөв. Азийн хөгжлийн банкны "Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх" техникийн туслалцааны төслийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх эцсийн шатны үйл ажиллагааг 2021 оны 12 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд цахим хэлбэрээр тус тус зохион байгуулав. Агаараас эрэн хайх 111-р ангийн бүтэц, орон тоог батлуулж, БНФУ-ын Хэл-Юнион компанийн сургагч багш бэлтгэх сургалтад 24 алба хаагчийг хамруулав. Төслийн хүрээнд эхний ээлжид нийлүүлэгдсэн 2 нэгж Иси-145 загварын нисдэг тэргийг 2021 оны 4 дүгээр сард, сургалтын Кабри загварын 1 нисдэг тэргэний 2021 оны 6 дугаар сард тус тус хүлээн авав. Онцгой байдлын байгууллагын аврах ажиллагааны чадавхыг сайжруулах, албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангах төсвийн урсгал зардлаар худалдан авах нэн шаардлагатай аврах ажиллагааны зориулалттай тусгай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалтын дагуу аврах ажиллагааны тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, "Авгаз ЛЛ-100" буюу аврах ажиллагааны нисдэг тэргэний түлш, тусгай зориулалтын болон туулах чадвар сайтай тээврийн хэрэгсэл зэргийн худалдан авахад нийт 7.45 тэрбум төгрөгийг холбогдох хууль, тушаал шийдвэрийн дагуу захиран зарцуулсан.
16.1.4	Цацраг идэвхт, химийн хорт бодисын болон тэсэрч дэлбэрэх бодисын аюулаас хамгаалах, хүн, мал, амьтны гоц халдварт, халдварт өвчин, ой хээр, объектын гал түймэртэй тэмцэх /хувиар/	90	90	-	-	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/150 дугаар тушаалаар "Тэсэрч, дэлбэрэх бодисоос үүдэлтэй ослын үед ажиллах заавар"-ыг батлуулан Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албатай хамтран ажиллах төлөвлөгөөний төслийг Экологийн цагдаагийн албатай хамтран боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албатай 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хамтран ажиллах төлөвлөгөөг баталгаажуулав. Хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу улсын хэмжээнд гарсан ой, хээрийн гал түймрийн мэдээллийг хүргүүлж, шалтгаан нөхцөл, эзэн холбогдогчийг тогтоосон талаарх мэдээлэл ирүүлэх тухай Онцгой байдлын ерөнхий газрын 2021 оны 7/2265 дугаар албан бичгийг Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албанд хүргүүлж хамтран ажиллав.
16.2	Мэргэжлийн хяналт			44,435.2	42,381.4	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	16.2.1	Хяналт шалгалтын үр дүнгээр шалгалтад хамрагдсан объектод их, дунд эрсдэлтэй объектын эзлэх хувь	60	48.7	741.2	646.3	Тайлант хугацаанд 11477 объектод хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 15730 шалгалт хийж, хяналтын хуудсаар үнэлэхэд эрсдэл ихтэй 1911 /12.1%/, эрсдэл дунд /36.6%/, эрсдэл бага 8051 /51.3%/ объект үнэлэгдсэн байна.
	16.2.2	Хууль сахин мөрдөлтийн төвшин /хувь/	75	76.6	40,824.2	38,917.0	2021 онд төлөвлөгөөт шалгалтад 6319, зөвхөн туслах үйлчилгээнд 5158 объект, нийт хамрагдсан 11477 объектын хяналтын хуудасны үнэлгээгээр хууль сахин мөрдөлтийн хүрсэн түвшин 76.6% байна.
	16.2.3	Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн /акт, нөхөн төлбөр /биелэлт /хувиар/	74	66.9	139.6	98.6	2021 онд улсын байцаагчийн гаргасан шийдвэрүүдийн биелэлтийн дундаж 66.87% байна. үүнийг задлан харуулбал: Тайлант хугацаанд улсын байцаагчийн 50728 заалттай 5452 албан шаардлага хүргүүлсний 39.9% биелэгдсэн. Зөвлөх үйлчилгээг 4252 объектод үзүүлж, хууль стандарт зөрчсөн нөхцөл байдлыг арилгуулах талаар улсын байцаагчийн 41927 заалттай зөвлөмж өгч, үүний 61.3% биелэгдсэн байна. Шалгалтын явцад 178 объектод 1,324.5 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож 78.98%-ийг, 1807 объектод 1,796.8 сая төгрөгийн торгууль ногдуулж 88.29%-ийг барагдуулсан байна. Ногдуулсан торгуулийн хэмжээ нь өмнөх оноос 16.4%-иар буурсан, барагдуулалт 5.55%-иар өссөн бол нөхөн төлбөрийн барагдуулалт 9.88-иар мөн өссөн байна.
	16.2.4	Лабораторийн шинжилгээний итгэмжлэгдсэн үзүүлэлтийн өсөлт	1240	1292	2,730.3	2,719.4	ХАБҮЛЛ нь Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн А/235 тоот тушаалаар 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл итгэмжлэгдсэн. Үүнд Эмийн 298 үзүүлэлт, хими, хор судлалын 915 үзүүлэлт, нян судлалын 270 үзүүлэлт, ургамал, хорио цээрийн 44 үзүүлэлт, цацрагийн 63 үзүүлэлт нийт давхардсан тоогоор 1590 үзүүлэлтийг итгэмжлүүлсэн. Эмийн хяналтын лаборатори нь Эмийн хяналтын агентлагийн бүтэц орон тоонд орж шилжсэн тул эмийн хяналтын 298 итгэмжлэгдсэн үзүүлэлтийг хасаж тоог нэгтгэсэн болно. Хяналтын итгэмжлэгдсэн сүлжээ лабораториудын үндэсний итгэмжлэлийн хүрээний тодорхойлолт 1292 (давхардсан тоогоор)-д хүрсэн байна. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн хувьд Америкийн нэгдсэн улсын Олон Улсын итгэмжлэлийн байгууллага болох "ANAB"-аар хими, хор судлалын 5 үзүүлэлтээр өргөтгөж 85, нян судлалын 12 үзүүлэлтээр итгэмжлүүлсэн.
	16.3	Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчийн эрхийг хамгаалах			52,521.0	50,386.9	
	16.3.1	Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт хийх тоо	40	40	20,218.0	20,218.0	Өрсөлдөөний асуудлаар аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн 133 гомдол, тендерийн баримт бичигтэй холбоотой 260 гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн. Өрсөлдөөний хуулийн хүрээнд 57, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хүрээнд 82, Зар сурталчилгааны хуулийн хүрээнд 4, Монгол хэлний тухай хуулийн хүрээнд 1 хяналт шалгалтыг тус тус хийж нийт 83 зөрчлийн хэрэгт 10,185.6 сая төгрөгийн торгууль оногдуулсан. Тайлант хугацаанд нийт 83 зөрчлийн шинжтэй гомдол ирүүлснээс 31 гомдолд зөрчлийн хэрэг нээн шалгаж, 43 хэргийг хялбаршуулсан журмаар шийдэж, 6 хэргийг хүлээн авахаас татгалзаж, 3 хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн байна."Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хууль, Монгол Улсын Засгийн газрын 78 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд өргөн хэрэглээний хүнсний барааны нийлүүлэлт, үнийг тогтвортой байлгах, зохиомол хомсдол үүсгэхээс сэргийлж БГД, БЗД, ЧД, ХУД, СБД, СХД зэрэг 6 дүүрэгт байрлах зах, худалдааны төв, махны төрөлжсөн дэлгүүрүүдэд худалдаалагдаж буй мах болон өргөн хэрэглээний хүнсний барааны хангамж, үнийн талаар судалгаа хяналт шалгалтыг 3500 гаруй байгууллагад хийж, 196 зөрчлийг арилгуулж, 143 сая төгрөгийн торгууль оногдуулсан.
	16.3.2	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт /хувиар/	100	100	12,540.0	12,539.1	Нийт аж ахуйн нэгж иргэдээс 13388 гомдол ирүүлснээс Хэрэглэгчийн эрхийн асуудлаар бичгээр ирүүлсэн гомдол 298, Өрсөлдөөний асуудлаар аж ахуйн нэгжээс ирүүлсэн гомдол 93, Тендерийн гомдол 260, Засгийн газрын 11-11 төвөөс ирүүлсэн өргөдөл гомдол 31, "Хэрэглэгчийн мэдээллийн 115 төв"-д нийт 12,626 иргэн хандсанаас 115 утсанд 8450, чатботод 2646, и-баримт аппликешнд 831 гомдол мэдээлэл ирсэн бөгөөд 9665 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 681 иргэний асуудлыг эцэслэн шийдвэрлэж, 141 гомдол мэдээллийг өргөдлөөр шилжүүлж, 854 гомдлыг хариуцах салбарт шилжүүлж, 579 иргэний гомдол чанаргүй байдлаар бүртгэгдэж, 7 иргэний гомдол, мэдээллийг судалж байна. Үүнээс 231 иргэний 476,145,547 төгрөгийн мөнгөн хохирол барагдуулж мөн 450 иргэний барааг шинээр сольж өгөх, засвар үйлчилгээ үзүүлэх, болон бусад байдлаар ирүүлсэн гомдлыг шуурхай шийдвэрлэж ажилласан.
	16.3.3	Зүй ёсны монопол болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох судалгааг хийж, хуралдаанаар шийдвэрлүүлэх	Тухай бүр	Тухай бүр	19,103.0	16,969.9	Тайлант хугацаанд ШӨХТГ-ын Хуралдаан 8 удаа хуралдаж, 6 аж ахуйн нэгжийг давамгай байдалтай аж ахуйн нэгжээр тогтоох судалгаа, 4 бодлогын судалгаа, монопол аж ахуйн нэгжийг тогтоох 1 судалгаа хийсэн. Үүнээс 29 аж ахуйн эрхлэгч давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр, 1 зүй ёсны монопол байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоосон.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
16.3.4	Нийгэм, эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлдэг салбараас сонгон авч зах зээлийн өрсөлдөөний төлөв байдлын судалгаа хийж, өрсөлдөөний хэв шинж, хэлбэрийг тодорхойлох судалгааг хийх	2-оос доошгүй удаа	15			Иргэд хэрэглэгчдэд өдөр тутамд тулгардаг асуудлаар олон нийтийн дунд санал асуулга явуулж, тулгамдаж буй 76 асуудлыг боловсруулж, тайлант хугацаанд өрсөлдөөний чиглэлээр 4 бодлогын судалгааг хийж холбогдох төрийн байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн. Үүнд: 1. Ноос, ноолуурын зах зээлийн бодлогын судалгааг хийж, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд зөвлөмж хүргүүлсэн. 2. Цахилгаан тамхины зах зээлийн бодлогын судалгаа хийж, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж цахилгаан тамхины хяналт зохицуулалттай болгох, цахилгаан тамхины импортын тусгай зөвшөөрөлтэй болгох, худалдан борлуулах үйл ажиллагааг нэгдсэн бүртгэлтэй болгох, импортлогч иргэд, аж ахуй эрхлэгчдэд ижил байдлаар татвар ногдуулах тогтолцоо бий болгох гэсэн зөвлөмж хүргүүлсэн. 3. Монгол Улсын хот хоорондын шуудан үйлчилгээний /дайвар ачаа/ зах зээлийн бодлогын судалгаа хийж, Зам тээврийн хөгжлийн яам, Харилцаа холбооны зохицуулах хороонд тус тус шуудангийн захиалгат болон нэмэлт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу дайвар ачаа хүргэлтийн үйлчилгээг 21 аймагт нэвтрүүлэх талаар зөвлөмж хүргүүлсэн. 4. Газрын тосны бүтээгдэхүүний зах зээлд бодлогын судалгаа хийж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны импорт, хэрэглээг үе шаттай нэмэгдүүлэх, цаашид 2, 3 дахь эх үүсвэрээс импортлох, үйлдвэрийн тусгай зөвшөөрөл авсан хэдий ч үйлдвэрийн байргүй, стандартын бус орчинд шатахуун үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байгаа асуудлыг шийдвэрлэх, газрын тосны завсрын бүтээгдэхүүнийг онцгой албан татвартай болгох талаар зөвлөмж хүргүүлсэн.
16.3.5	Холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах	15	15	660.0	660.0	Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтэд сурталчлах 3 удаагийн цуврал комикс номын эх бэлтгэл, зохиол дээр нь ажиллан 3 ном бэлэн болсон. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2021.01.15-ны өдөр хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд болон иргэд, олон нийтэд, 2021.01.22-ны өдөр хууль, эдийн засгийн чиглэлийн эрдэмтэн, судлаач багш нарын хүрээнд, 2021.01.29-ний өдөр Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбоо ТББ (MORA) түүний гишүүдийн хүрээнд тус тус 10 удаагийн онлайн хэлэлцүүлсэн. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн онлайн хэлэлцүүлгийг хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, олон нийт, эрдэмтэн судлаачид, Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбоо ТББ түүний гишүүдийн хүрээнд тус тус зохион байгуулсан. Тайлант хугацаанд 61 сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж 498 иргэн хамрагдсан. Байгууллагын фейсбүүк хуудсанд цаг үеийн шинжтэй 574 мэдээ мэдээлэл, байгууллагын веб сайтад 115, Засаг.мн 65, Шадар сайд аппликейшн 60 мэдээ, мэдээллийг байршуулж сэтгэгдэл бичсэн иргэдэд тухай бүр хариу өгч, агентлагийн пэйж хуудсанд чатаар мэдээллээр ханган ажиллаж байна.
16.4	Стандартчилал, хэмжил зүй			2,078.9	3,121.2	
16.4.1	Шалгалт тохируулга /калибровка/-д хамруулах хэмжих хэрэгслийн тоо /мянган нэгж/	7.6	8.1	108.5	171.5	Тайлангийн хугацаанд 8122 ш өндөр нарийвчлалтай эталон болон хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийсэн. Үүнд: Цахилгаан, масс, эзлэхүүн, урт, цаг давтамж, температур, нягт, даралтын төрлийн хэмжих хэрэгслийн хэрэгсэлд шалгалт тохируулга хийсэн байна.
16.4.2	Загварын туршилтад хамруулан улсын бүртгэлд бүртгэх хэмжих хэрэгслийн тоо	43	63	12.0	20.2	Тайлангийн хугацаанд нийт 52 аж ахуйн нэгж, байгууллагын 63 хэмжих хэрэгслийн загварын туршилтын үр дүнг хүлээн зөвшөөрөх, загварын баталгааны гэрчилгээг сунгах, загварыг турших ажлыг зохион байгуулсан. Үүнд: - OIML-CS хүлээн зөвшөөрсөн 7 загвар; - Загварын баталгааны гэрчилгээний хугацаа сунгасан 10; - Шинээр загвар нь батлагдсан 40.
16.4.3	Ээлжит баталгаажуулалтад заавал хамруулах хэмжих хэрэгслийн тоо /мянган нэгж/	200	330.4	1,753.3	2,556.4	Баталгаажуулсан хэмжих хэрэгслийг лаборатори тус бүрээр харуулбал: - Цахилгааны хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын лаборатори 238,579; - Эзлэхүүн зарцуулалтын хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын лаборатори 56,412; - Дулаан, даралтын хэмжих хэрэгслийн лаборатори 10,7; - Массын хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын лаборатори 24,7.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/	
	16.4.4	Чанарын удирдлагын тогтолцооны баталгаажуулалтад хамруулах байгууллага, аж ахуйн нэгжийн тоо	101	203	40.0	121.1	Тайлант онд 73 байгууллага, аж ахуйн нэгжид Менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлснийг баталж, гэрчилгээжүүлсэн. Тухайлбал: - Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 стандартыг хэрэгжүүлсэн 54; - Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 45001 стандартыг хэрэгжүүлсэн 4; - Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 22000 стандартыг хэрэгжүүлсэн 8; - Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001 стандартыг хэрэгжүүлсэн 2; - НАССР тогтолцоог хэрэгжүүлсэн 5;
	16.4.5	Итгэмжлэлд хамруулах сорилтын лабораторийн тоо	0	0	-	-	
	16.4.6	Үндэсний стандартад олон улс, бус нутгийн дэвшилтэт стандартын эзлэх хувь	34	41.5	165.1	252.0	Олон улсын дэвшилтэт стандартын түвшинд нийцүүлэн 45 стандартыг шинээр, 13 стандартыг дахин хянаж, 59 стандартыг нэгийг харьцах нь нэгээр орчуулан нийт 117 стандартыг баталсан. Үүнд: - ISO-36; - IEC-7; - ITU-1; - EN-11; - AASHTO-4; -OIML-2; - FOST-4; - ASTM-4; - MNS-48; Мөн шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ, дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогоор байнгын дэмжлэг тусалцаа үзүүлж нийт 13-н ААН, байгууллагын 31 олон улс, бус нутаг, гадаад орны стандартыг бүртгэсэн байна.
17	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА			95,553.3	70,930.0		
	17.1	Гүйцэтгэх засаглалын удирдлага, түүний ажлын алба		63,645.5	44,090.7		
	17.1.1	Засгийн газрын бодлого, шийдвэрийг боловсруулах, хуралдаанд бэлтгэх болон яам, агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ чиглэлээр цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх	Хууль тогтоомжид нийцсэн байх	Хууль тогтоомжид нийцүүлэн, дэмжлэг үзүүлж ажилласан		Яамд, Засгийн газрын агентлагийн чиглэлээр Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр ирүүлсэн асуудлыг хүлээн авч, эрх зүйн үндэслэл, найруулга, ач холбогдлыг нь үнэлж, шалган ажилласан ба Засгийн газрын хуралдаанд 997 асуудал боловсруулж хэлэлцүүлэх, танилцуулахад бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажилласан.	
	17.1.2	Ерөнхий сайд, Засгийн газрын танхим, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргыг нутгийн удирдлагын чиглэлээр мэргэжлийн өндөр, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэгээр шуурхай хангах, тэдгээрийн үйл ажиллагааны үр нөлөөтэй, хэвийн жигд ажиллагааны эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	Мэдээллээр хангасан байх	мэдээллээр хангаж ажилласан	63,645.5	44,090.7	Хөтөлбөрийн хүрээнд хуулиар хүлээсэн үүрэг зорилтыг хэрэгжүүлэх, "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, үндсэн чиглэлд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх болон Ерөнхий сайд, Засгийн газрын танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх талаар бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажилласан. Засгийн газрын 66 удаагийн хуралдааныг зохион байгуулж, Засгийн газрын тогтоол 384, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 597 гаргасан байна.
	17.1.3	Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн мэдээллийг 3, 9 дүгээр сард, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 3, 9 дүгээр сард, хөтөлбөр, төслийн мэдээллийг 5 дугаар сард, үйл ажиллагааны үр дүнгийн мэдээллийг улирал тутам хийсэн байх	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	Мэдээллүүд хууль тогтоомжид заасны дагуу улирал тутамд бүрэн гарч хэрэгжсэн.			Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2021 оны эхний хагас жилийн дүнг Засгийн газрын 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанд, "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх хэрэгжилтийн талаар Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанд тус тус танилцуулсан. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн 2020 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2020 оны хэрэгжилтийг Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанд тус тус танилцуулсан. Үндэсний хөтөлбөрүүдийн 2020 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.
	17.2	Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц хөтөлбөр		21,656.5	16,801.4		
	17.2.1	Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтөлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох /төрийн албан хаагчийн тоо, мянгаар/	3.0	3		Төрийн байгууллагын дотоод удирдлагын eр.e-mongolia.mn системийн хөгжүүлэлт хийгдсэн. Нийслэлийн төр захиргааны байгууллагын төрийн албан хаагчдын 70 хувь нь албан хэрэг хөтөлөлтийн системүүдтэй цахим гарын үсгээр холбогдоод байна.	
	17.2.2	Монгол Улсын иргэн бүрд цахим гарын үсэг олгох /иргэний тоо мянгаар/	20.0	60.8	11,319.3	9,265.7	Дундын мэдээллийн санд бүртгэлтэй тоон гарын үсгийн тоо 60,798 байна.
	17.2.3	Төрөөс цахим хэлбэрээр шинээр хүргэх үйлчилгээний тоо	200	657			e-Mongolia нэгдсэн портал системд төрийн 657 үйлчилгээ нэгтгэгдсэн.
	17.2.4	ХУР системд холбогдох төрийн байгууллагын тоо	60	80			ХУР системд 2021.12.31-ний байдлаар нийт 80 төрийн байгууллага холбогдоод байна.
	17.2.5	ХУР системийг ашиглах байгууллагын тоо	140	317	6,405.1	4,390.7	ХУР Төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан 2021 онд төр болон хувийн хэвшлийн нийт 317 байгууллага холбогдоод байна.
	17.2.6	Хөдөө орон нутгийн аслгагдсан сум, суурин газарт шилэн кабелийн сүлжээнд холбох сумын тоо	9	4			Архангай аймгийн Хашаат сум, Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгон, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Гурванбаян баг, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-улаан багуудыг өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбосон бөгөөд иргэдийг төрийн үйлчилгээг авах боломжийг бий болгосон.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
17.3	17.2.7	Алслагдсан бүс нутагт хөдөлгөөнт холбооны үйлчилгээ хүргэх багийн тоо	25	20	3,932.1	3,145.0	Архангай аймгийн Их тамир сум, Хан-Өндөр баг, Баян-өлгий аймаг, Цэнгэл сумын Загастнуур баг, Говь-Алтай аймгийн Чандмань, Бигэр, Эрдэнэ сумын зааг, Дарви сумын Хужирт баг, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Хилийн 0168 дугаар анги, Завхан аймгийн Алдархаан сумын Загастайн даваа, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын Бурхант баг, Хужирт сумны Дулаан баг, Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1-р баг, Булган аймгийн Хишиг-Өндөр сумын Хүрэмт баг, Орхон Бүрэгхангайн зааг Шувуут, Дашинчилэн сумын Лах баг, Сүхбаатар сумын Түвшинширээ сумын Өлзийт баг, Хөвсгөл аймгийн Түнэл сумын Навчилтай, Шинэ-Идэр сумын 3-р баг, Увс аймгийн Тариалан сумын Мянгат баг, Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат, Өмнөдэлгэр сумын Баянзүрх, Балдан Врайбун хийд, Төв аймгийн Баяндэлгэр сумын Байдлаг багуудад хөдөлгөөнт холбооны үйлчилгээ хүргэсэн.
	17.2.8	Алслагдсан сум, суурин газарт утасгүй болон суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернэтийн үйлчилгээ хүргэх сумын тоо	10	2			Нийслэлийн СХД, БЗД-ийн гэр хорооллын 2,000 өрх интернэт үйлчилгээ хүлээн авах боломжтой болсон.
	Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт				1,402.0	1,341.5	
	17.3.1	Монгол Улсын нийгэм, эдийн засаг, санхүүгийн төлөв байдлын талаарх лавлагаа бэлтгэн, зөвлөмж боловсруулж, Ерөнхий сайдыг шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангаж ажиллах	Тухай бүрд	Тухай бүр мэдээллээр хангаж ажилласан.			Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлт боловсруулсан. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нийт 566 бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн Улсын Их Хурлаас батлан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 53 баримт бичиг, Монгол Улсын Засгийн газар, түүний гишүүн, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас батлан гаргасан 513 баримт бичиг байна. Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийг хуульд нийцүүлэх талаарх дүн шинжилгээний танилцуулга, Засгийн газрын шийдвэрийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн газар, түүний гишүүн, төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтан, нийслэл болон аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчид, аймгийн Засаг даргын шийдвэрээр баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хуульд нийцүүлэх талаарх дүн шинжилгээний танилцуулга, Засгийн газрын шийдвэрийн төслийг боловсруулж, мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.
	17.3.2	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нэгдсэн сан үүсгэж, эрхлэн хөтлөх /хувиар/	100	100			Яамд, төрийн байгууллагуудын хариуцан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийг тухай бүрд шинэчилж, мэдээллийн санг хөгжүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар Хөрөнгө оруулалтын төслийн мэдээллийн системд нийт 585 гаруй төслийн танилцуулга, мэдээлэл бүртгэгдсэн. Мөн http://project.zasag.mn -ний англи хувилбарыг туршин нэмэлт хөгжүүлэлт хийж байна. "ЖАЙКА"-ийн Улсын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн чадавч бэхжүүлэх төсөлтэй хамтран Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, хөтөлбөрийг үнэлэх эрэмбэлэх аргачлалыг цахим болгох ажлын даалгаврыг боловсруулсан ба 2022 оны 1 дүгээр сараас ажил эхэлнэ.
	17.3.3	Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах /богино болон дунд хугацааны/	7	2	1,402.0	1,341.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.4.2-т заасны дагуу "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулсан ба Улсын Их Хурлын 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 56 дугаар тогтоолоор "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө" батлагдсан байна. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар тушаалаар Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг болон Ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулсан ба Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулах, Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулах хүрээнд 2021 оны 12 дугаар сарын 11-ний байдлаар нөхцөл байдлын дүн шинжилгээний төслийн хувилбарыг боловсруулсан болно.
	17.3.4	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн цахим мэдээллийн нэгдсэн сан, аж үйлдвэрийн мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх, эрхлэн хөтлөх /хувиар/	100	100			Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх ажлын хүрээнд газарзүйн мэдээллийн системд суурилсан Төслүүдийн төлөвлөлт, удирдлага, мониторингийн нэгдсэн дашбоард, Орон зайн төлөвлөлт /Монгол улсын эдийн засгийн макро, мезо, микро бүсчлэл, шинээр боловсруулсан/-ийн нэгдсэн дашбоард, Соёлын салбарт хэрэгжиж буй төслүүдийн дашбоард зэрэг цахим вебийг хийж, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем, Орон нутгийн хөгжлийн индекс, Аж үйлдвэрийн мэдээллийн систем зэрэг цахим мэдээллийн системүүдийг нэгтгэсэн "Хөгжлийн төлөвлөлт, гүйцэтгэл, удирдлага, мониторингийн нэгдсэн цахим платформ"-ыг хөгжүүлсэн.
17.3.5	Хөгжлийн томоохон төслүүдийн судалгааг зохион байгуулах, дүн шинжилгээ хийх /хувиар/	100	100			Эдийн засгийн ач холбогдол бүхий 177 төслөөс эдийн засгийн өндөр ач холбогдолтой 100 төсөл, арга хэмжээний төслүүдийг эрэмбэлэн боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Мөн эдийн засгийн өндөр ач холбогдолтой 61 төслийн эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг тооцоход шаардлагатай мэдээллийг боловсруулан бэлтгэж холбогдох яаманд хүргүүлсэн болно.	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	17.3.6	Хөрөнгө оруулалт бизнес форум зохион байгуулах /тоогоор/	3-5	3			2021 оны 3 дугаар сарын 2-ны өдөр "Гадаад худалдаа болон хөрөнгө оруулалтын боломжууд" сэдэвт Монгол-Туркийн бизнес уулзалтыг МХАҮТ, Турк улсын Гадаад эдийн засгийн хамтын харилцааны байгууллага /DEIK/-тэй хамтран цахимаар зохион байгуулсан. Үндэсний хөгжлийн газар нь Монгол Улсын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, сурталчилгааг хариуцах чиг үүргийнхээ хүрээнд Японы Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын байгууллага /JETRO/, Монгол Улсаас Япон улсад суугаа ЭСЯ, Олон Улсын Санхүүгийн Корпорац (IFC), Ирбис Венчурс компанитай хамтран "Invest in Mongolia - Tokyo 2021" Монгол-Японы бизнес форумыг 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдөр цахимаар, амжилттай зохион байгуулсан. Мөн 2021 оны 6 дугаар сарын 23-нд "Invest in Mongolia-Seoul 2021" Монгол, Солонгосын бизнес цахим форумыг тус тус зохион байгуулсан.
17.4	Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа				1,756.9	1,664.0	
	17.4.1	Дотоод үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах /ширхгээр/	240,400	230,820			Монгол Улсын төр, засгийн удирдлага ба төв байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, олон нийтийг улс орны дотоод амьдралын шуурхай мэдээллээр хангах зорилтын хүрээнд санхүү, хүний нөөц, техник тоног төхөөрөмжийн хангамжийн бодлогыг оновчтой тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан. Мэдээллийг шуурхай хэрэглэгчдэд хүргэх зорилгоор дотоод мэдээний редакцын сэтгүүлчдийг чадавжуулах, нийгмийн сүлжээний мэргэшсэн ажилтнуудаар бэхжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэв. Мэдээллийн шуурхай байдлыг хангаж, вэбсайтын өнгө төрх дизайны, хүчин чадал, хэрэглээний боломжийг нэмэгдүүлж ажилласан болно.
	17.4.2	Гадаад үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах /ширхгээр/	209,370	189,500	1,756.9	1,664.0	Дэлхий дахинаа болж буй олон улсын чанартай үйл явдлын тухай мэдээ, мэдээллийг Москва, Бээжин зэрэг хотуудад суугаа өөрийн байнгын сурвалжлагчдын болон ТАСС, Риа-Новости, VOA, Синьхуа, Anadolu, KCNA, BMA, Киодо, Ёнхап, ПТИ зэрэг хамтын ажиллагаатай гадаадын улсуудын мэдээллийн агентлагуудын мэдээлэл, ОАНА, НАНАП зэрэг бус нутгийн байгууллагуудын сүлжээнээс сонгон авч, орчуулан бэлтгэн нийлүүлж байна. Мөн мэдээллийн баталгаат эх үүсвэрийг хангах үүднээс Ройтерс, Тасс зэрэг мэдээллийн агентлагуудтай албан ёсны гэрээ байгуулан баталгаат эх сурвалжаас мэдээллийг хүргэж ажилласан.
	17.4.3	Хэвлэмэл бүтээгдэхүүний орлогыг нэмэгдүүлэх /хувиар/	3	2.5			Сүүлийн жилүүдэд хэвлэмэл бүтээгдэхүүн хэрэглэгчдийн хандлага өөрчлөгдсөн, нөгөө талаар дэлхий дахинд тархсан цар тахлаас шалтгаалан мэдээллийн цахим хэлбэрийг түлхүү сонирхох болсон хэдий ч цахим сурталчилгаа хийх замаар хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх, захиалгат ном сонин хэвлэх, хэвлэмэл бүтээгдэхүүний хэмжээг бууруулахгүй байх арга хэмжээг авч ажиллаж байна.
	17.4.4	Хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх /хувиар/	5	5			Агентлагийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд тогтмол сурталчлан таниулах, үзэсгэлэн яармагт оролцох, байгууллага иргэдэд хамтран ажиллах санал хүргүүлэх зэргээр хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан ба мөн мэдээллийн шуурхай, үнэн бодит байдлыг тогтмол ханган ажиллаж ирсний үр дүнд 2020 онд агентлагийн цахим хуудсанд дунджаар 998,000 хэрэглэгч хандаж байсан бол 2021 оны байдлаар хэрэглэгчдийн тоо 2 саяд хүрээд байна.
17.5	Төр, засгийн үйлчилгээ				7,092.4	7,032.4	
	17.5.1	Төр, засгийн авто баазын үйлчилгээний стандартыг хангах	CS11-0120:2010 стандартыг ханган биелүүлсэн байх	CS11-0120:2010 стандартыг ханган ажилласан.	2,995.3	2,995.3	Төр, засгийн авто тээврийн үйлчилгээнд CS11-0120:2010 стандартыг ханган ажилласан.
	17.5.2	Төр, засгийн төв байгууллага болон хэрэглэгчийн хэвийн үйл ажиллагааг хангуулах	MNS-ISO 9001:2010 стандартыг ханган биелүүлсэн байх	MNS-ISO 9001:2016 стандартыг ханган ажилласан.	4,097.1	4,037.1	Төр, засгийн төв байгууллагуудын нийтлэг үйлчилгээнд MNS-ISO стандартыг ханган ажилласан ба MNS-ISO 9001:2016 стандартын биелэлтэд Стандарт, хэмжил зүйн газрын Магадлангийн аудит хийгдэж "Ул тохиролгүй" гэрчилгээ олгогдсон болно.
18	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД				153,847.7	148,452.6	
	18.1	Ойжуулалт			1,791.1	1,258.6	
	18.1.1	Ойжуулах, ойг нөхөн сэргээх /мянган га/	6	1.06	562.60	418.70	БОАЖС-ын 2021.03.12-ны өдрийн А/78 дугаар тушаалын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр Ойт хээрийн бүсэд экологийн ач холбогдол бүхий газрыг шилмүүст, навчит модоор ойжуулах ажлыг 96 га талбайд, Байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 940 га талбайд, Мод тарих, ойжуулах ажлыг 3 аймгийн 20 га талбайд гүйцэтгэсэн.
	18.1.2	Ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажил хийх /мянган га/	50	33.9	960.00	729.30	БОАЖС-ын 2021.03.12-ны өдрийн А/78 дугаар тушаалын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тогтоох тоймчилсон судалгааны ажлыг 11 аймгийн 87 сумыг хамруулан явуулж 1.68 сая га талбайг тодорхойлсон. Ойн хөнөөлт шавжтай авиа микробиологийн аргаар 16663 га талбайд, гэрлэн урхи тавих аргаар 17272 га талбайд тэмцлийн ажлыг зохион байгуулсан. Тэмцлийн ажилд шаардлагатай 49989 литр бэлдмэлийг худалдан авсан.
	18.1.3	Ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх /мянган га/	30	30.1	268.50	110.60	БОАЖС-ын 2021.03.12-ны өдрийн А/78 дугаар тушаалын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 5 аймгийн 7 суманд 533 га талбайд ойн цэвэрлэгээ, 1 аймгийн 1 сумын 60 га талбайд ойн арчилгаа хийсэн. БОАЖС-ын 2020.09.28-ны өдрийн А/599 дүгээр тушаалын хүрээнд 13 аймаг, нийслэлийн болон 20 УТХГ-ын нутаг дэвсгэрт 30.1 мянган га талбай ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалсан.
18.2	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент				325.7	322.7	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	18.7.2	Ховор, нэн ховор болон ашиглалтад өртөмхий амьтан, ургамлын нөөц, тоо толгой, тархцын судалгаа хийх /зүйлийн тоо/	2	2	45,115.16	43,551.9	БОАЖЯ, Шинжлэх ухаан технологийн сантай хамтран халиун бугын тархац нутгийг бүрэн хамарсан тоо толгойн судалгааг хийв. Судалгааны үр дүнд Монгол орны халиун бугын биологийн болон агнуурын нийт тархац нутгийн хэмжээ, популяцийн нөөцийг тогтоож, байрлал зүйн зураглал, коридор нутгийн зураглал, Монгол орны халиун бугын тархац, нөөц, сургийн бүтцийн тухай мэдээлэл бүхий мэдээллийн санг бүрдүүлж, хамгааллын статусыг тодорхойлов. Халиун бугын тархац, нөөц, зохистой ашиглах хэмжээг тогтоох, хамгааллын статусыг тодорхойлох ажлыг МУИС-ийн Биологийн тэнхимийн судлаачидтай хамтран хийлээ. Даян дэлхийн байгаль орчны сангийн санхүүжилтээр Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь" төслийн санхүүжилтээр гүйцэтгэсэн. Хангайн уулын ойт хээрийн тойргийн судалгаагаар Архангай аймгийн 19 сум, Булган аймгийн 16 сум, Сэлэнгэ аймгийн 3, Өвөрхангай аймгийн 5 сум, Баянхонгор аймгийн 9 сум, Завхан аймгийн 19 сум, Хөвсгөл аймгийн 18 сумууд, Говь-Алтай аймгийн Тайшир сумын хойд хэсэг нийт 8 аймгийн 90 сумыг хамруулсан. Уг судалгааны дүнд Хангайн уулын ойт хээрийн тойрогт өмнө тэмдэглэгдээгүй нийт 35 зүйл гуурст дээд ургамлыг шинээр илрүүлэн, уг тойрогт нийт 94 овгийн 419 төрөлд хамаарах 1667 зүйл гуурст дээд ургамлыг бүртгэн, овог, төрөл, зүйлийн латин болон монгол нэр, бүтээлийн эх сурвалж бүхий жагсаалтыг гаргалаа. Мөн нэн ховор 16 зүйл ургамлын 307, ховор 55 зүйл ургамлын 1495 цэгийг шинээр тэмдэглэж, эмийн, хүнсний, ашиглалтад өртөмтгий 178 зүйл ургамлын 10685 тархцын цэгийг тэмдэглэн 161 зүйл ургамлын биологийн нөөцийг, 133 зүйл ургамлын ашиглалтын нөөцийг хуурай нойтон жингээр тооцож, аймаг, сум тус бүрээр нь гаргаж, тархац нөөцийн зургуудыг зохион ажилласан.
	18.8	Аялал жуулчлал			-	-	
	18.8.1	Аялал жуулчлалын салбарын орлого /сая ам.доллар/	400	21,623,163 ам доллар			"Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн Монгол Улсын үндсэн чиглэлд тусгаж шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжид хамруулан ажилласан. 2021 онд 88 арга хэмжээг төлөвлөн, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 10 тэрбум 895 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, Аялал жуулчлалын хөтөлбөрөөс 3 тэрбум 162 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээг санхүүжүүлж, 86.3 хувийн биелэлттэй төр хувийн хэвшлийн түншлэл, мэтгэжлийн холбоод, Аялал жуулчлалын хөгжлийн төвтэй хамтран төлөвлөсөн арга хэмжээг гүйцэтгэсэн байна.
19	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД				100,950.2	84,306.1	
	19.1	Гадаад харилцааны бодлого, удирдлага			12,745.4	8,002.2	
	19.1.1	Гадаад харилцааны бодлого, удирдлагын чиглэлээр сургалт, семинар зохион байгуулах /тоогоор/	5	5	5.00	3.5	Монгол Улс нь дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байж, улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, хөгжил дэвшлийг хурдасгах замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах явдал бөгөөд манай улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг явуулах зорилго дэвшүүлэн ажилладаг. Монгол Улсын гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах, төрийн захиргааны төв болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад харилцааг уялдуулан зохицуулах, хяналт тавих үүргийнхээ дагуу гадаад харилцааны бодлого, удирдлагын чиглэлээр сургалт, семинар зохион байгуулах ажлын хүрээнд "Гадаад бодлогын хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангах" сэдвээр Нийслэлийн ЗДТГ, ЦЕГ-ын удирдах албан тушаалтнууд, албан хаагчдад зориулсан сургалт, Монгол Улсаас гадаадын 23 улсад суух элчин сайд нарт зориулсан сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. ГХЯ-ны ТНБД-аар батлууланТүүнчлэн консулын асуудал хариуцан ажиллах ажилтнуудад зориулсан сургалтын төлөвлөгөөг ГХЯ-ны ТНБД-аар батлуулсан сургалтын төлөвлөгөөний дагуу консулын асуудлаар ДТГ-уудад тогтмол сургалт зохион байгуулан, хууль, тогтоомжоор хүлээсэн үүрэг, тогтоосон хориглолт, хязгаарлалтыг чанд мөрдөж, хэрэг эерчилд холбогдохгүй байхыг нийт албан хаагчдад анхааруулсан чиглэл хүргүүлж, яамны 2021 оны сургалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу сургалтад давхардсан тоогоор яамны 120 албан хаагчийг хамруулан ажилласан.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	19.1.2 Засгийн газар хоорондын хамтарсан хэлэлцээр байгуулалт /тоогоор/	20	6	291.80	26.70	хамтран хэрэгжүүлэх, шинэ техник технологи, ноу хау нэвтрүүлэх, эдийн засаг, техник технологи, соёлын зэрэг гол гол салбаруудад тухайн улстай харилцаа, хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд ЗГХК-ын механизмууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, гадаад улсын Засгийн газрын хооронд байгуулсан худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны ЗГХК-ын Монголын хэсгийн удирдах бүрэлдэхүүнийг томилж асуудлаар санал боловсруулж, Засгийн газрын 6 дугаар сарын 16-ны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Манай улс ЗГХК-ын хамтын ажиллагааны 34 механизмтай бөгөөд үүнд хөрш хоёр улстай 4, Азийн улсуудтай 10, Европын улсуудтай 14, Америк, Ойрх Дорнодын улсуудтай 5 болон Евразийн эдийн засгийн комисстой байгуулсан механизмууд багтаж байна. Шадар сайд С.Амарсайхан, ОХУ-ын Засгийн газрын орлогч дарга В.В.Абрамченко нарын тэргүүлсэн Монгол, Оросын ЗГХК-ын Үндэсний хэсгийн дарга нарын цахим уулзалтыг 3 дугаар сарын 17-нд, Монгол, Беларусийн ЗГХК-ын Монголын хэсгийн дарга, ХХААХҮ-ийн сайд З.Мэндсайхан, Беларусийн хэсгийн дарга, Аж үйлдвэрийн сайд П.А.Пархомчик нар 2 дугаар сарын 23-нд, эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны Монгол, Италийн ЗГХК-ын III хуралдааныг 6 дугаар сарын 22-нд цахимаар зохион байгуулж, мөн эдийн засаг, худалдааны Монгол, Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны IX хуралдаан 11 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд Анкара хотноо болж, цар тахлын улмаас саарсан худалдаа, эдийн засгийн харилцааг сэргээх чиглэлээр 20 гаруй салбарыг хамарсан өргөн хүрээтэй асуудлыг хэлэлцэж, протокол болон хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөө батлаад байна. ОХУ-ын Засгийн газрын орлогч дарга А.Л.Оверчук 10 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд Монгол Улсад ажлын айлчлал хийж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарт бараалхаж, Шадар сайд С.Амарсайхантай уулзалт хийж, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэн, Монгол, Оросын ЗГХК-ын ээлжит 23 дугаар хуралдааныг 11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулж, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тулгамдсан асуудлуудаар санал солилцон хуралдааны дүнгээр Протокол байгуулж ажилласан. Дэлхий нийтийг хамарсан "Ковид-19" цар тахлын нөхцөл байдлын улмаас төлөвлөгдсөн зарим арга хэмжээ хойшилсон ба улмаар тулгарч буй хүндрэлийг даван туулахад ялангуяа хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг хэвийн хэмжээнд явуулахад анхаарч ажиллан 2022 онд Европын чиглэлээр ЗГХК-ын 11 хуралдаан зохион байгуулахаар ажиллаж байна.
	19.1.3 Зөвлөлдөх уулзалт, дугуй ширээний уулзалт /тоогоор/	17	10	236.50	-	"Ковид-19" цар тахалтай холбоотой халдвар хамгааллын дэглэм, хориг хязгаарлалтууд 2021 онд хэвээр байсан тул тавьсан зорилт, төлөвлөгөөт ажлуудаа бүрэн хэрэгжүүлэхэд анхааран хоёр болон олон талт шугамаар идэвхтэй үйл ажиллагааг идэвхтэй явуулсны үр дүнд гадаадын улс орнуудтай улс төрийн харилцаагаа бэхжүүлэх, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг сэргээхэд эерэг уур амьсгал бүрдүүлэн ажилласан. Монгол Улс, БНХАУ-ын ГХЯ хоорондын Бодлогын зөвлөлдөх хоёрдугаар уулзалтыг 6 дугаар сарын 15-нд цахимаар хийсэн. Монгол Улс, АНУ, Япон Улсын гурван талт уулзалт 2021 онд Улаанбаатарт болох ээлжтэй байсан боловч цар тахлаас шалтгаалан хэрэгжүүлэх боломжгүй болсон боловч ГХЯ хоорондын зөвлөлдөх уулзалтыг Итали, Азербайжан, Герман болон Эстони улстай хийн ажилласан. Мөн хөрш орнууд болон гуравдагч хөрш улсуудтай тогтоосон харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, хамтын ажиллагааны эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх үндсэн зорилт тавьж, гадаад харилцааны яамд хоорондын зөвлөлдөх болон дугуй ширээний уулзалтуудыг цахимаар зохион байгуулж, Европын улс орнуудтай харилцаа, хамтын ажиллагааг цар тахлын нөхцөл байдал нийцүүлэн хэвийн өрнүүлэх, харилцааны цар хүрээг сааруулахгүй байхад анхааран ажилласнаар Европын Холбооны 2021-2027 оны Олон жилийн баримжаат хөтөлбөрийн хөгжлийн тусламжийн тэргүүлэх чиглэлийг тогтвортой ногоон хөгжил, ардчилал, эдийн засгийн хөгжил гэж тодорхойлсон нь Европын Холбоотой уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлж ажилласан.
	19.1.4 Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг хэвлэн нийтлэх тоо	400	132	0.50	0.49	Коронавируст халдвар "КОВИД-19"-ын шинэ хувилбар болон цар тахлын нөхцөл байдлын улмаас өндөр дээд хэмжээний харилцан айлчлалын тоо буурсантай холбогдуулан Засгийн газар хоорондын 10 гэрээг (132 хуудас бүхий), олон талт олон улсын гэрээний 6 батламж жуух бичгийг хэвлэсэн байна. Олон талт 6 гэрээнд нэгдэн орох дотоодын процессууд хамаарж, 2 гэрээг хүчин төгөлдөр болгон, Засгийн газар хоорондын 10 гэрээ байгуулснаас 7 гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ба өмнөх онд байгуулсан 11 гэрээг хүчин төгөлдөр болгон ажиллалаа. ГХЯ нь байгууллага хоорондын 20 гэрээ байгуулж бүртгэсэн бол гэрээний төсөлд санал өгөх, орчуулгыг хянах зэрэг байгууллага хоорондын нийт 96 гэрээ байгуулахтай холбоотой үйл явцад оролцон, 2021 онд хууль тогтоомжийн 1 төсөл боловсруулсан, хууль болон бусад холбогдох 102 шийдвэрийн төсөлд санал өгч ажилласан байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	19.1.5	Өндөр, дээд түвшний айлчлал зохион байгуулах	Хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа өргөжихийн хирээр айлчлал арга хэмжээний давтамжийг нэмэгдүүлнэ.	15	963.20	463.40	Дэлхий нийтийг хамарсан "Ковид-19" цар тахлын нөхцөл байдлын улмаас төлөвлөгдсөн зарим арга хэмжээнүүд цуцлагдсан тул хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг хэвийн хэмжээнд явуулах, "Ковид-19" цар тахлын эсрэг гадаадаас вакцин худалдан авах, тээвэрлэх асуудалд болон Монгол Улсын иргэдээ татан авах чиглэлээр идэвхтэй ажилласан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн олон улсын 2 арга хэмжээ, УИХ-ын даргын 3 айлчлал, Ерөнхий сайдын оролцсон Зуны олимпын нээлт, Шадар сайдын оролцсон олон улсын арга хэмжээнүүд, Гадаад харилцааны сайдын 5 удаагийн айлчлал, Гадаад харилцааны дэд сайдын 3 удаагийн айлчлалыг хэрэгжүүлэн эдгээр айлчлалын хүрээнд хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг урагшлуулах асуудлаар, ялангуяа худалдаа, хөрөнгө оруулалт, зам тээвэр, дэд бүтэц, эрчим хүч, уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, хүмүүнлэг, соёл, боловсрол, шинжлэх ухаан зэрэг салбарын харилцааг гүнзгийрүүлэх чиглэлээр санал солилцож, харилцан тохиролцоонд хүрсэн байна.
	19.2	Гадаад улс дахь дипломат үйл ажиллагаа			88,204.8	76,303.9	
	19.2.1	Хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газраас төлөөлөн суугаа буюу хавсран суугаа улс, олон улсын байгууллагатай гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ авах	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	Төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлсэн	88,010.7	76,115.0	Монгол Улсын гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлж, түүний үр өгөөжийг улам нэмэгдүүлэх шаардлага тулгарч байгаа өнөө үед гадаад харилцааг хөгжүүлэх, хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын болон бүс нутгийн арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцож, олон улсын тавцанд улс орны нэр хүндийг өсгөх, одоо байгаа харилцааныхаа түвшинг ахиулах, харилцан хамтын ажиллагааг бэхжүүлэх, харилцан айлчлалын давтамжийг хадгалах, олон улсын арга хэмжээнүүд, өндөр дээд түвшний айлчлал, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэхэд үйл ажиллагаанд онцгой анхаарч ажилласан. Ковид-19 цар тахлын гарцаагүй байдлаас шалтгаалан гадаад бодлого, дипломат үйл ажиллагаа маань вакцины татан авалтыг хурдан шуурхай хийх, гадаадад гацсан иргэдээ татан авах, гадаад худалдааны урсгалыг чөлөөтэй явуулж, нэн чухал хэрэгцээт барааны импортыг тасалдуулахгүй байх, хилийн боомтуудын үйл ажиллагааг сайжруулах, иргэдийн гадаадад зорчих эрхийг сэргээх зэрэг асуудалд нилээд хүч чармайлт гарган ажиллаж түүний зэрэгцээ Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх зорилтуудаа үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хоёр хөрш болон гуравдагч хөрш орнуудтайгаа харилцаагаа бэхжүүлж, олон улс, бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцохыг зорин ажиллалаа.
	19.2.2	Гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх хувь	100	100	194.12	188.86	Иргэдэд туслах сангаас 2021 онд хилийн чанадад нас барсан, гэнэтийн осол аваар, эмчилгээ, гэмт хэргийн улмаас хохирч хуулийн өмгөөллийн зардал хүссэн нийт 56 иргэн, мөн хилийн чанадад хоригдож буй 54 хоригдлыг ДТТ-аас эргэж урлах, дэмжлэг үзүүлэхэд нийт 188.8 сая төгрөгийн тусламж үзүүлэн гадаад улсад суугаа Монгол улсын иргэдийн гаргасан өргөдөл хүсэлтийг иргэдэд туслах сангаас 100 хувь шийдвэрлэн ажилласан.
	19.2.3	Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн дагуу дипломат аргаар хамгаалах	Тусламж шаардлагатай тухай бүрд				Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн дагуу дипломат аргаар хамгаалах үйл ажиллагааны хүрээнд шаардлагатай тусламж үйлчилгээг тухай бүрд шуурхай үзүүлж ажиллалаа. "Ковид-19" цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан хилийн чанадаас нутаг буцах хүсэлтэй иргэдийн татан авалтын нислэгийн давтамжийг эрс нэмэгдүүлэх, тусгаарлалтын хоногийг 21-ээс 7 хоног болгон бууруулах, тусгай үүргийн нислэгийн тийзийн үнийг 15 хувиар бууруулах зэрэг шийдвэрүүд гарсны үр дүнд иргэдээ 2021.05.01-ний өдөр гэхэд бүрэн татан авч дуусгасан. "Ковид-19" цар тахлаас үүдэн тогтмол нислэгүүд зогссон хугацаанд гадаадын 93 улсаас 46,000 орчим Монгол Улсын иргэнийг эх оронд буцаан авчирч Засгийн газраас өгсөн үүрэг чиглэл, холбогдох шийдвэрийн дагуу агаарын хилийг үе шаттай нээлгэн, 2021 оны 6 дугаар сараас тусгай үүргийн нислэгүүдийг тогтмол хуваарьт бүрэн шилжүүлж, энгийн горимд оруулан ажилласан. ОХУ, БНХАУ, БНСУ, Япон, Болгар, Унгар, Чех зэрэг улсуудад суралцагч оюутнууд болон зайлшгүй шаардлагаар зорчих иргэдийг хил нэвтрүүлэх чиглэлээр яриа хэлэлцээг тогтмол хийж, БНХАУ-аас бусад улсад зорчих нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.
	19.2.4	Төсвийн орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх	Орлогыг бүрэн төвлөрүүлсэн байх	бүрэн төвлөрүүлж ажилласан			Төсвийн тухай хуулиар батлагдсан улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг батлагдсан хуваарийн дагуу бүрэн төвлөрүүлсэн ажилласан.
20	САНГИЙН САЙД				2,659,625.9	2,590,506.7	
	20.1	Санхүү, төсвийн нэгдсэн удирдлага			2,548,583.4	2,498,012.7	
	20.1.1	Монгол Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх	Хуульд заасан хугацаанд хийгдсэн байх	Нийцсэн	2,548,583.4	2,498,012.7	Монгол Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөв болон Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн төслийг боловсруулж хуульд заасан хугацаанд буюу 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Монгол Улсын Их Хурлаар Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийг 2020 оны 13-ны өдөр баталсан.
	20.2	Татвар хураалт, орлого бүрдүүлэлт			111,042.5	92,494.0	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
20.2.1	Улс, орон нутгийн төсөвт орох татварын орлогын төлөвлөгөөний биелэлт /хувиар/	100.0	100			Экспортын гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын хэмжээ зэс 22.5 мянган тонноор, нүүрс 13.6 сая тонноор, цайр 56.5 мянган тонноор тус тус буурснаас ашигт малтмалын ноёд ашигласны төлбөрийн 1,795.0 тэрбум төгрөг төлөвлөгөө 208.6 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн. Улс, орон нутгийн төсвийн татварын орлогын гүйцэтгэлд "Оюу толгой" ХХК-д нөхөн ногдуулалтын актаар ногдуулсан 1.0 их наяд төгрөгийг төвлөрүүлсэн гүйцэтгэлд эерэг нөлөөлсөн.
20.2.2	Өмнөх онуудын тайлангаар ногдуулсан татварын өр барагдуулалт /хувиар/	75.0	57.7			Татварын өр барагдуулалт зорилтот түвшиндээ хүрээгүй нь хэд хэдэн гадаад хүчин нөлөөлсөн. Үүнд: 1. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас Засгийн газраас өндөржүүлсэн болон бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, мөн хилийн хязгаарлалттай холбоотой гадаад худалдаа, барилга, тээврийн салбар, уул уурхай тэр дундаа нүүрсний экспортын хэмжээ буурсан зэргээс бизнесийн идэвхжил саарч татвар төлөгчдийн төлбөрийн чадвар буурсан. 2. УИХ-аас баталсан "Татварын алданги, торгуулиас чөлөөлөх" тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр дахин сунгаж "2020 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд албан татвар төлөгчийн хуулийн дагуу ногдуулан тайлагнасан төлбөл зохих татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд уг хугацаанд ногдуулах татварын алданги, торгуулиас тухайн албан татвар төлөгчийг нэг удаа чөлөөлсүгэй" гэсэн хуулийн зохицуулалт үйлчилсэн нь татварын өр төлөлт хойшлоход нөлөөлсөн. 3. Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 13, 2021 оны 05 дугаар сарын 19-ний хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу татварын өртэй татвар төлөгчдийн арилжааны банкинд дахь битүүмжилсэн дансыг нээх шийдвэр гарч 5130 татвар төлөгчийн 31630 дансны битүүмжлэлийг цуцалж, ТЭХ-д заасан хугацаа хэтэрсэн өр хураах албадлагын арга хэмжээг авах үйл ажиллагааг хязгаарласан зэрэг нь өр хуримтлагдах, өрийн барагдуулалт удаашрах, зорилтот түвшинд хүрэхгүй байх нөхцөл болсон.
20.2.3	Өмнөх онуудын хяналт шалгалтаар ногдуулсан өр барагдуулалт /хувиар/	75.0	64.5			
20.2.4	Тайлант хугацааны татварын тайлангийн ногдол, өр барагдуулалт /хувиар/	90.0	80.5			
20.2.5	Тайлант хугацааны хяналт шалгалтын ногдол, өр барагдуулалт /хувиар/	80.0	32.7			
20.2.6	Татварын цахим тайлан авалт /хувиар/	89.5	79.63	49,818.9	46,474.7	1. ААНОАТ-ын тайланг 2021 онд 208677 ирүүлэхээс 139929 тайлан ирүүлж 67.0 хувьтай. Мөн 8 улирал дараалан үйл ажиллагаа явуулаагүй татварын тайлан ирүүлээгүй 58282 татвар төлөгчийг хасуулах саналыг СЯ-нд 2021.10.26-ны өдрийн 01/2314 тоот бичгээр хүргүүлсэн. Тухайн татвар төлөгчийг хасаж тооцвол тайлангийн ирц 93.0 хувь, хүрсэн түвшин 86.2 хувьтай гарахаар байна. 2. 2021 онд ТТ-11 тайлангаар 206367 тайлан ирүүлэхээс 138470 тайлан ирүүлж 67.1 хувьтай байна. 3. АМНАТ тайланг 2021 оны 04-р улиралд 1280 тайлан ирүүлэхээс 1173 тайлан ирүүлж тайлангийн ирц 91.6 хувьтай байна. 4. ОАТ-ын тайланг 2021 онд 61 тайлан ирүүлэхээс 57 тайлан ирүүлж 93.4 хувьтай байна.
20.2.7	Татварын зөрчлийн бууралт /хувиар/	6.3	26.2			2020 онд Оюутолгой ХХК-г ХШ-танд хамруулснаар зөрчлийн дүн өссөн. 2020 онд 10,764,971.0 сая төгрөгийн, 2021 онд 8,849,692.8 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн. 2021 онд зөрчлийн дүн 17,8 хувиар буурсан.
20.2.8	Алдагдалтай буюу "Х" тайлан тушаалтын бууралт /хувиар/	0.6-1.0	5.5			2020 онд ирүүлсэн 132562 татвар төлөгчөөс 67719 татвар төлөгч Х болон алдагдалтай тайлан ирүүлсэн нь Х болон алдагдалтай тайлангийн эзлэх хувь 51.1 хувь, 2021 онд 139929 тайлан ирүүлснээс 70037 татвар төлөгч Х болон алдагдалтай тайлан ирүүлсэн тайланд эзлэх хувь 50.1 хувьтай байна. Дээрх тоон үзүүлэлтээс харахад Х болон алдагдалтай тайлангийн эзлэх хувь өмнөх оноос 1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
20.2.9	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгчийн баазыг нэмэгдүүлэх /хувиар/	2.5	7.8			УБЕГ-ын хуулийн этгээдийн бүртгэлийн газраас хуулийн этгээд бүртгэлийг хүлээн авч бүртгэлжүүлэн, татварын төрлийн үндсэн бүртгэл болон ААНОАТ, Суутган татварын төрлөөр автоматаар бүртгэн татвар төлөгчид мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна. Татварын албанд ААНОАТ-ын төрлөөр 2020 онд 196.2 мянган татвар төлөгч аж ахуйн нэгж бүртгэлтэй байсныг 2021 онд 210.4 мянга буюу 107.2 хувиар нэмэгдүүлж ажилласан.
20.2.10	Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн баазыг нэмэгдүүлэх /хувиар/	8.0	1.6			Татварын албанд 2020 оны жилийн эцэст 40263 татвар төлөгч НӨАТ суутган төлөгчөөр бүртгэлтэй байснаас 2021 онд 9936 татвар төлөгчийг бүртгэж, 988 татвар төлөгчийг хасаж 49211 буюу 122.2 хувиар нэмэгдүүлж бүртгэж ажилласан. Үүнд: Үйл ажиллагаа явуулдаггүй, татварын төлөлт хийгддэггүй, чанаргүй татвар төлөгчдийг бууруулах зорилгоор ТЕГ-ын ЭУГ-аас ирүүлсэн жагсаалтын дагуу тухай бүр хасалтыг хийн, татварын албадад чиглэл хүргүүлэн, 988 суутган төлөгчийг хасаж, НӨАТ суутган төлөгчөөр бүртгэгдвэл зохих татвар төлөгчийн судалгааг улирал бүр хүргүүлэн, нийт 9936 татвар төлөгчийг НӨАТ суутган төлөгчөөр бүртгэсэн. 2. Цахим төлбөрийн баримтын систем дэх борлуулалтын орлогын хэмжээ 50 сая болон түүнээс дээш хүрсэн татвар төлөгч нарт цахим шуудан болон бүртгэлтэй гар утсаар бүртгүүлэх анхааруулгыг тогтмол хүргүүлсэн. 3. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн жижиг, дунд бизнесийг дэмжих 3 хувийн зээлтэй холбогдуулан НӨАТСТ-өөр сайн дураараа бүртгүүлэх татвар төлөгчийн тоо өмнөх оноос 22.2 хувиар нэмэгдсэн байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	20.2.11	Бусад төрлийн татвар төлөгчийн баазыг нэмэгдүүлэх /хувиар/	2.5	6.04			Татварын албанд 2020 онд 1430.6 мянган бусад төрлөөр бүртгэгдсэн байна. Коронавируст цар тахлын улмаас 2021 онд 273.4 буюу 19.1 хувиар татварын төрлийг шинээр бүртгэж ажилласан. Бусад татварын төрөл буюу хөрөнгийн татварын төрөл, суутган-1, суутгуулсан татварын төрүүдэд голлон нэмэгдсэн татварын төрөл нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтээр 221.0 татварын төрөл нэмэгдсэн байна.
	20.2.12	Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааны хэрэгжилт /хувиар/	58.5	41.0			Гаалийн байгууллагад бүртгэгдсэн нийт бүрдүүлэлтийн тоо 523134 бөгөөд үүнээс 261723 импорт, 261411 экспортын бүрдүүлэлт бүртгэгдсэн байна. Коронавируст цар тахлын улмаас 2021 оны гаалийн бүрдүүлэлтийн тоо өмнөх оны мөн үеэс 19.5%-иар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын аргачлалаар зорилтоо бүрэн хүрээгүй буюу 70 оноог хувиан үзвэл 40.95 хувьтай байна.
	20.2.13	Худалдааг хөнгөвчилж, гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг бууруулах /хувиар/	2.0	1.4	61,223.6	46,019.3	2019 онд Дэлхийн гаалийн байгууллагаас Монгол Улсын гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааг хийсэн бөгөөд дараагийн судалгааг 2023 онд хийхээр төлөвлөн ажиллаж байна. Тайлант хугацаанд Худалдааг хөнгөвчилж, гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг бууруулах зорилгоор хэд хэдэн ажлыг хэрэгжүүлсэн. Уг хэрэгжүүлсэн ажлуудын үр дүн гарч байгаа тул Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын аргачлалаар тодорхой үр дүн гарч байгаа 85 оноог хувиан үзвэл 1.4 хувьтай байна.
	20.2.14	Гаалийн хууль тогтоомжийн зөрчил илрүүлэлтийг нэмэгдүүлэх /хувиар/	2.0	(1.5)			Гаалийн хууль тогтоомжийн зөрчил илрүүлэлтийн тоо 1.5 хувиар буурсан тухай ТАЙЛБАР: Гаалийн байгууллага 2020 онд нийт 944 зөрчил илрүүлж 1 тэрбум 408.4 сая төгрөгийн торгууль ногдуулж, 1 тэрбум 989.3 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн ба 2021 онд нийт 933 удаагийн зөрчлийг илрүүлж, 1 тэр бум 616.7 сая төгрөгийн торгууль ногдуулж, 2 тэр бум 771.8 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн байна. Өмнөх оноос зөрчлийн тоо 1.5 хувиар буурсан хэдий ч торгуулийн дүн 7.4 хувиар, нөхөн төлүүлсэн татварын дүн 31.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зөрчил илрүүлэлтийн тоо буурсан нь коронавирус /COVID-19/-ын цар тахлын халдварын улмаас хилийн боомтууд түр хугацаагаар хаагдаж, зорчигч, тээвэр, бараа эргэлтний тоо өөрчлөгдсөн шүүд хамааралтай юм.
21	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД				604,610.4	619,864.3	
	21.1	Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын удирдлага зохицуулалт			8,905.1	8,882.1	
	21.1.1	Боловсруулах баримт бичиг, хуулийн төслийн тоо	35	68	4,427.3	4,407.9	УИХ-д өргөн мэдүүлж батлуулсан хууль 14, үүнд шинэчилсэн найруулгыг батлуулсан хууль 6 (Шүүхийн тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, Патентын тухай хууль, Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний үсвийн мэдээлэл хамгаалах тухай хууль), нэмэлт өөрчлөлт оруулж батлуулсан хууль 5 (Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Шүүхийн тухай шинэчилсэн найруулгын дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль), шинээр батлуулсан хууль 3 (Өршөөлийн тухай хууль, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль), "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай" Монгол Улсын Их хурлын тогтоол батлуулсан. Боловсруулалтын шатанд байгаа хууль 16, үүнд УИХ-д өргөн мэдүүлсэн хууль 9, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн хууль 3, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан хууль 4, Боловсруулж буй хууль тогтоомжийн төсөл 38 байна. Биелэлт 194.2 хувь
	21.1.2	Хянах эрх зүйн актын тоо	1000	999			Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2021 онд 685 эрх зүйн акт хянаж бүртгэсэн байна. Нийт 193 актад дүгнэлт хүргүүлж, 49 актыг захиргааны хэм хэмжээний актад хамаарахгүй үндэслэлээр бүртгэх шаардлагагүй тул буцаан хүргүүлж, нэмэлт өөрчлөлт оруулсан 63 акт, хүчингүй болсон 9 актыг Улсын нэгдсэн санд хүлээн авч холбогдох өөрчлөлт хөдөлгөөнийг хийсэн байна. Биелэлт 100 хувь
	21.1.3	Сэтгэл зүйн анхан шатны болон мэргэжлийн сургалтад хамрагдан архины хамаарлаас гарах иргэний тоо	2000	2340	2,558.5	2,558.5	Зөрчлийн тухай хуулийн 14.7.5 дахь заалтын дагуу албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулсан 1056 иргэнд 446 удаагийн 1784 цагийн сургалтыг танхимаар, 2819 удаагийн 5556 цагийн сургалтыг ганцаарчилсан хэлбэрээр, 46 удаагийн 184 цагийн сургалтыг бие даалтын хэлбэрээр ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвд, 892 иргэнийг Баривчлах байранд сургаалтанд хамруулсан. Үүнээс 149 иргэнд 34 хоног, 80 цагийн сургалтыг Наркологийн төвтэй хамтарч зохион байгуулсан. Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн дагуу ШШГЕГ-ын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт 392 хүнийг 3-6 сарын хугацаатай хүмүүжүүлж 7 хоногт 2 удаагийн давтамжаар нийт 126 удаагийн бүлгийн болон ганцаарчилсан архинаас гарах албадан сургалтад хамруулсан байна.
	21.1.4	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй тэмцэх хүрээнд :			700.4	700.4	
	21.1.4.1	Тусламж үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдах хүний тоо	150	69			Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 2021 оны байдлаар хэвтэн эмчлүүлсэн болон амбулаторийн үйлчилгээ авсан, мөн 1800-2000 дугаар тусгай дугаарын утсаар донтох эмгэгийн чиглэлээр 69 иргэн үйлчлүүлсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	21.1.4.2	Сургалт, семинарт оролцох хүний тоо	150	245	700.4	700.4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 45, хэв журмын цагдаагийн 200 алба хаагчид нийт 245 хүн мэргэшүүлэх сургалт зохион байгуулсан Эрсдэл ихтэй Сэлэнгэ аймгийн Алтанбулаг болон Орхон аймгийн Баян-Өндөр суманд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн байгууллагын албан хаагч нийт 135 гаруй хүнд сургалт зохион байгуулсан.
	21.1.4.3	Сурталчилгаа хүрэх хүний тоо /мянгаар/	110	135			
	21.1.5	Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд:			216.5	216.5	
	21.1.5.1	Тусламж үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдах хүний тоо	1000	40	216.5	216.5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас "Хүйсийн тэгш эрхийн төв" төрийн бус байгууллагад "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх" зорилгоор 30 сая төгрөгийн санхүүжилт үзүүлэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг санхүүжүүлэн 40 хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэн ажиллалаа. Охид, эмэгтэйчүүдийг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий "Мөрөөдлийн шүхэр" мэдээллийн аяныг 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 21 хоногийн хугацаанд зохион байгууллаа. Мэдээллийн аяны турш иргэд, олон нийтэд хүргэсэн урьдчилан сэргийлэх агуулга бүхий сэрэмжлүүлэг нь давхардсан тоогоор иргэдэд нийт 26 сая хүнд хүрсэн бөгөөд мэдээллийн аяны дараа үр дүнгийн үнэлгээг "КАР: Knowledge, Attitude, Practice" аргачлалаар хийж иргэд, олон нийтийн мэдлэг, хандлага, ойлголтын өөрчлөлтийг үнэлсэн. Энэхүү үнэлгээгээр иргэд, олон нийтийн ойлголт, хандлага 5 хувийн өсөлттэй гэж дүгнэгдсэн болно.
	21.1.5.2	Сургалт, семинарт оролцох хүний тоо	100	663			
	21.1.5.3	Сурталчилгаа хүрэх хүний тоо /мянгаар/	40	26000			
	21.1.6	Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:			260.7	260.7	
	21.1.6.1	Сургалт, семинарт оролцох хүний тоо	400	500	260.7	260.7	Мал эмнэлгийн ерөнхий газар нь Цагдаагийн ерөнхий газартай хамтран "Мал эмнэлгийн нэгдсэн систем"-ийн талаар 21 аймаг, нийслэлийн МЭГ, ЦХ, 330 сумын МЭ-ийн тасаг, сумын цагдаагийн албан хаагчид нийт 513 хүнийг хамруулан цахим сургалтыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн. "Монголын нутгийн удирдлагын холбоо" ТББ-аас Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 80 орчим төлөөлөгч нарт коронавирусын цар тахлын халдвар хамгааллын дэглэмийг сахин батлагдсан хуваарийн дагуу сургалтыг зохион байгуулсан. "Eagle news" телевизийн 2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 21 цагийн мэдээллийн хөтөлбөрт ЭЦА-ны ХГХТХ-ийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Мягмаррагчаа оролцон, ярилцлага өгсөн. Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Хулгайлах гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэстэй хамтран "Хулгайлах гэмт хэрэг мөрдөн шалгах болон энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим асуудал" сэдэвт гарын авлага боловсруулан гаргаж, мөрдөн шалгах эрх бүхий 500 алба хаагч нарт хүргүүлсэн.
	21.1.6.2	Сурталчилгаа хүрэх хүний тоо /мянгаар/	20	20			
	21.1.6.2	Сурталчилгаа хүрэх хүний тоо /мянгаар/	20	20			
	21.1.7	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:			216.5	216.5	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	21.1.7.1	Сургалт, семинарт оролцох хүний тоо	700	2522	216.5	216.5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/50, А/12 тоот хамтарсан тушаалаар байгуулсан "Хамтарсан багийн үйл ажиллагааны чадавхыг үнэлж, гишүүдийг ажлын байран дээр мэргэшүүлэх замаар хууль, тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах" үүрэг бүхий Ажлын хэсгийн байгуулан "Хүчирхийллийн эсрэг үндэсний төв" төрийн бус байгууллагын сургагч багш нартай хамтран хамтарсан багийн гишүүдийг ажлын байран дээр сургах сургагч бэлтгэх сургалтыг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагын 80 ажилтныг сургаж, сургагч багшаар бэлтгэсэн. Хамтарсан багийн гишүүдийг ажлын байранд сургах сургалтыг үе шаттай зохион байгуулж эхлээд байгаа бөгөөд Баянгол дүүрэг, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн 78 хорооны хамтарсан баг сургалтад хамрагдаж байна. Мөн Сонгинохайрхан дүүргийн 43 хорооны засаг дарга буюу хамтарсан багийн ахлагчдыг кейс шийдвэрлэх арга зүйг сургалаа. Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс 2021 онд цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 31 удаагийн сургалтыг Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв, төв орон нутгийн цагдаагийн газар, хэлтэстэй хамтран зохион байгуулж нийт 2321 алба хаагчийг хамруулсан.
	21.1.7.2	Сурталчилгаа хүрэх хүний тоо /мянгаар/	40	180.6			"Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-ыг "Хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай" уриан доор зохион байгуулж, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хууль сурталчлах нэгдсэн арга хэмжээ зохион байгууллаа. Энэ аяныг угтаж Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны санаачилгаар НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр "Нарны сүүдэр" уран сайхны киног бүтээлгэж, 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн иргэд, олон нийтэд 29 телевизийн сувгаар түгээж байна. Өнөөдрийн байдлаар "Нарны сүүдэр" уран сайхны киног нийт 180,600 хүн үзэж, 1007 сэтгэгдэл бичиж, 6000 гаруй бусадтай хуваалцсан байна.
	21.1.8	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:			510.7	510.7	
	21.1.8.1	Сургалт, семинарт оролцох хүний тоо	500	311			Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Дотоод хэргийн их сургуультай хамтран "Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн нэгдмэл байдал, уялдааг хангах боломж" сэдэвт судалгааны ажлын хэлэлцүүлгийг 2021 оны 5 дугаар сарын 19-ний цахим хэлбэрээр зохион байгуулсан. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Экологийн цагдаагийн алба хамтран 2021 оны 11 дүгээр сарын 29-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ны өдрүүдэд Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборт экологийн цагдаагийн 137 алба хаагчдад "Хууль бусаар мод, байгалийн ургамал түүж бэлтгэх, худалдаалах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд" болон "Монгол орны нэн ховор, ховор амьтад, тэдгээрийн эд эрхтэн бүтээгдэхүүний хэрэглээ, худалдаа ба хуулийн хариуцлага" сэдвээр сургалт зохион байгуулсан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газар хамтран "Зэрлэг амьтад, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүний хил дамнанасан хууль бус худалдааг бууруулах боломж" сэдэвт цахим сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгууллаа. Улсын ерөнхий прокурорын газар, Экологийн цагдаагийн алба, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран "Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд учирч буй хүндрэл бэрхшээл, гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг сайжруулах нь" сэдэвт судалгааны тайлангийн хэлэлцүүлгийг 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдөр цахимаар зохион байгуулсан.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/	
	21.1.8.2	Сурталчилгаа хүрэх хүний тоо /мянгаар/	50	10701.2	510.7	510.7	Хүрээнд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Байгалиа хамгаалъя" нэгдсэн арга хэмжээг "Ногоон дуу хоолой" нэрийн доор "Таны дуу хоолой байгалийг хамгаалж чадна" уриатайгаар төлөвлөгөөг 4 бүлэг, 18 заалттайгаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зорилтот видео шторк 4, бүтээлч постер 15 нийт 19 контент, хүрээлэн байгаа орчноо хайрлан хамгаалах уламжлалт зан заншил, орчин үеийн хандлага, иргэний оролцоог таниулсан агуулгатай бичлэг 32, зурагт сурталчилгаа 43, нийт 94 мэдээ, мэдээллийг нийтийн цахим сүлжээнд байршуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ярилцлага 6, нэвтрүүлэг 3, сонин сайтын мэдээ, ярилцлага 16 өгсөн. Цахим орчинд иргэд, олон нийтэд хүргэсэн мэдээ, мэдээлэл давхардсан тоогоор 10.701.229 хүнд хүрсэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба нь "Эн Ти Ви Бродкастинг" ХХК-тай хамтран Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга бүхий "Эко-сэргийлэгч" захиалгат 5 нэвтрүүлгийг бэлтгэн, NTV телевизээр хуваарийн 12 удаа цацаж, 600,000 орчим иргэдэд хүргэсэн. "Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн ойлголт, ял шийтгэл, хор уршиг, энэ төрлийн гэмт хэргэтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ" нэвтрүүлгийг бэлтгэн, МҮОНРТ-ийн 2 сувгаар цацаж, 100,000 орчим иргэнд хүргэсэн. Мөн тус Ажлын албанаас "Энх-Арслан" ХХК-тай гэрээ байгуулан "Эко-сэргийлэгч" булан ажиллуулж, 4 видео шторк, 10 ширхэг постер, 9 ширхэг постер, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн 5 ширхэг инфографик бэлтгэн олон нийтэд хүргэлээ. "Eagle" телевизтэй хамтран Сэргийлэгч цуврал нэвтрүүлгээр "Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах уламжлал, соёл, хууль эрх зүйн орчин" сэдэвт нэвтрүүлгийг бэлтгэн 2021.05.03-ны өдөр иргэд, олон нийтэд хүргэсэн.
	21.1.9	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:			14.5	10.9	
	21.1.9.1	Боловсруулах баримт бичиг, стандарт, хөтөлбөрийн тоо	2	1			Хүүхдийн цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор facebook нийгмийн сүлжээнд "Цахим орчны хүүхэд хамгаалал" нэртэй мэдээллийн хуудас боловсруулан эцэг эх, хүүхэд багачуудад хандсан мэдээллийг тогтмол бэлтгэн хүргэж байна. https://www.facebook.com/ekids.mn/following
	21.1.9.2	Сургалт, семинарт оролцох хүний тоо	100	40	14.5	10.9	НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран АНУ-д төвтэй сураггүй алга болсон болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд туслах олон улсын төв (ICMEC)-ийн сургагч багш нараар "Цахим орчинд үйлдэгддэг хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх нь" сургалтыг 2022 оны 01 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд цагдаа, прокурор, шүүхийн байгууллага, харилцаа холбооны зохицуулах хороо, үүрэн телефоны оператор компаниудын нийт 40 төлөөлөлд, "Цахим орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх нь" дугуй ширээний ярилцлагыг 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгууллаа.
	21.1.9.3	Сурталчилгаа хүрэх хүний тоо /мянгаар/	80	120			Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба үзүүлж байна "Сэргийлэгч" нэвтрүүлгийн дугаараар цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулгатай 1 нэвтрүүлэг бэлтгэн 2 удаагийн давталтаар нийтэд хүргэсэн ба сэргийлэгч нэвтрүүлэг нь 120 мянган хүний хандалттай.
21.2	Цагдаа				246,477.6	246,468.2	
	21.2.1	Хэргийг хэрэг бүртгэлт явуулж эхэлснээс хойш хуулийн хугацаанд шийдвэрлэх хувь	80	85.6			Цагдаагийн байгууллагад 2021 онд нийт 26015 хэрэгт хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулснаас 10253 хэргийг шийдвэрлэсэн. Үүнээс 8778 хэрэг буюу 85.6 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, прокурорын байгууллагад хүргүүлжээ.
	21.2.2	Эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн илрүүлэлт /хувиар/	50	77.5			Эрэн сурвалжлах АСАП санд 2021 онд хүн, мал амьтан, эд зүйлийн 26605 мэдээллийг бүртгэн зарлан мэдээлснээс 20637 хүн, мал амьтан, эд зүйлийг олж тогтоон, үлдэгдэл 5968, илрүүлэлт 77.5 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.9 хувиар өссөн. Үүнээс шүүхээс даалгасан нийт 4929 хүний мэдээллийг бүртгэж зарласнаас 3716 хүнийг олж тогтоон, эрэн сурвалжлалтыг зогсоож, илрүүлэлт 75.3 хувьтай байна.
	21.2.3	Хэрэг илрүүлэлт /хувиар/	50	52.7	237,347.0	237,347.0	2021 оны байдлаар цагдаагийн байгууллагад нийт 267221 гомдол, мэдээлэл бүртгэгдэн шалгагдсаны 71495 буюу 26.8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 195726 буюу 73.2 хувь нь зөрчлийн шинжтэй байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 6864 буюу 2.6, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 3948 буюу 5.8, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 2916 буюу 1.5 хувиар тус тус өссөн. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 23139 буюу 32.4 хувьд нь хэрэг бүртгэлийн хэрэг нээж, 44165 буюу 61.8 хувьд нь хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзан, 752 буюу 1.1 хувийг нь харьяаллын дагуу шилжүүлсэн. Шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 10757 буюу 15.8 хувийг 5 хоногт, 55997 буюу 82.3 хувийг 6-19 хоногт шийдвэрлэсэн. Улсын хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 52.7, нийслэлд 50.3, орон нутагт 58.9 хувь байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 0.8, нийслэл хотод 2.0 нэгжээр тус тус өсөж, орон нутагт 0.3 нэгжээр буурчээ.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/	
	21.2.4	Гэмт хэрэг, захиргааны зөрчил, гал түймэр, гамшиг, осол, эмнэлгийн яаралтай тусламжийн талаар хангасан бодит мэдээллийн хувь	90	100	3,634.1	3,624.7	2021 онд гэмт хэрэг, зөрчлийн 503671, гал түймэр, гамшиг ослын 3719, эмнэлгийн 313901 нийт 821291 дуудлага, мэдээллийг хүлээн авч, холбогдох нэгж, байгууллагад 100 хувь дамжуулж, яаралтай тусламж үзүүлжээ.
	21.2.5	Гэрч, хохирогчийн хамгаалалт /хүний тоо/	70	234			Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу 234 гэрч, хохирогч хамгаалсан байна.
	21.2.6	Шүүхийн байрын хамгаалалт /хувиар/	100	100			Нийслэлийн хэмжээнд Эрүүгийн хэргийн 12027, Иргэний хэргийн 26022, Захиргааны хэргийн 4758, гэр бүлийн 4, зөрчлийн 4681, нийт 47492 шүүх хуралдаан явагдсаныг нийт 43 алба хаагч 56586 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж хамгаалсан. Эрүүгийн анхан шатны шүүхэд цагдан хорих ангиас 2205 шүүгдэгчийг шүүхийн саатуулах байранд хүлээн авч, цагдан хорих 461 дүгээр ангид хуяглан хүргүүлэхээр 2872 шүүгдэгчийг хүлээн өгч, өмгөөлөгч 411, ар гэрийн 226 гишүүд саатуулах байранд шүүгдэгч нартай уулзахад хяналт тавьж, шүүхийн байранд шалган нэвтэрсэн 185081 иргэдийн хөдөлгөөнд хяналт тавь ажилласан. Олны анхаарал татсан шүүх хурлын хамгаалалтад нийт 179 удаагийн олны анхаарал татсан шүүх хурлын хамгаалалтад давхардсан тоогоор 438 офицер, 1120 цагдаа, нийт 1558 алба хаагч 6152 хүн/цаг үүрэг гүйцэтгэсэн.
	21.2.7	Шүүх хурлын танхимын хамгаалалт /хувиар/	100	100	5,496.5	5,496.5	
	21.2.8	Шүүгчийн хамгаалалт /хувиар/	100	100			
	21.2.9	Шүүгчийн захирамжаар албадан авчрах /хувиар/	85	91.1			
	21.3	Хил хамгаалалт			158,406.3	158,406.3	
	21.3.1	Улсын хил хамгаалалтын нэгдмэл тогтолцоог хангаж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улс, Олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хил хамгаалалтад орчин үеийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн ололтыг нэвтрүүлэх /хувиар/	25	17.5			Монгол Улсын хил хамгаалалтын удирдлагын төвийг шинээр барих төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд болон УИХ-ын гишүүдэд танилцуулж, техник технологийн шинэчлэлийн судалгааг хийж санхүүжилтийг 2022 оны улсын төстийн хөрөнгө оруулалтад тусгасан. Хилийн 0131, 0108 дугаар ангид хил хамгаалалтын удирдлагын төвийг шинэчлэн байгуулж хил хамгаалалтад ашиглаж байна. ОХУ-д "Нисгэгчгүй нисэх хэрэгслийг ашиглах" сургалтад алба хаагчдыг хамруулж, техник хэрэгслийг хил хамгаалалтад туршиж байна.
	21.3.2	Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн торон саадыг шинэчлэх /хувиар/	10.3	7.2			ХХЕГ, хилийн цэргийн 0119 дүгээр анги (ТӨААТҮГ)-тай 2021 онд н/15-н/04 тоот "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулж, "ХӨҮМГРОВН" ХХК-иас спираль торон саадын материал шон 6500 ш, 5 тн ган утас, 20 тн цемент хүлээн авч, хилийн 0275 дугаар ангийн 0207 дугаар салбар /Ульхан/-т 3200 шон, 5 тн ган утас, 10 тн цемент хүргэж, 11,2 км спираль торон саад байгуулсан -Хилийн 0245 дугаар ангийн 0308 дугаар салбар (Хайрхан)-т 3300 шон, 10 тн цемент тус тус хүргэсэн. Хилийн 0130, 0214, 0285, 0101, 0275, 0132 дугаар ангийн хариуцсан хэсэгт 40 км өргөст торон саад байгуулсан
	21.3.3	Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж, барилга, дэд бүтцийн 50-аас доошгүй хувийг шинэчлэх /хувиар/	10	10	158,406.3	158,406.3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Дорнод аймгийн Чулуун хороот сум дахь хилийн 0275 дугаар ангийн Эрээнцав шалган нэвтрүүлэх салбарыг өргөтгөх ажлыг эхлүүлсэн. Хилийн 0198 дугаар ангийн 0188 дугаар салбар (Задгайт), Хилийн 0287 дугаар ангийн 0279 дүгээр салбар (Онон)-ын барилга байгууламжид их засвар хийсэн. Хилийн 0245 дугаар ангийн соёлын төвийн барилгын өргөтгөл, алба хаагчдын 4 айлын орон сууцны барилгад засвар хийсэн. Хилийн 6 ангийн хариуцсан хэсэгт 40 км өргөст торон саад байгуулсан. Дорнод, Сүхбаатар аймаг дахь хилийн 2 ангид 5 хянах цамхгийг засварлаж, Дорноговь аймаг дахь хилийн 1 ангид 1 хянах цамхаг шинээр байгуулсан. Дорнод, Хэнтий, Увс аймаг дахь хилийн 3 ангид 6 барилга байгууламжид засвар хийж ашиглалтад оруулсан. Хилийн 5 ангийн төвд 40 айлын орон сууц, 4 ангийн 11 салбарт 48 айлын орон сууц, 3 ангийн 4 салбарын албаны нэгдсэн байр тус тус засварласан. Дорнод аймаг дахь хилийн 0275 дугаар ангид 1, 0132 дугаар ангид 2, Сүхбаатар аймаг дахь хилийн 0184 дүгээр ангид 2 хянах цамхгийг тус тус засварлаж, Дорноговь аймаг дахь хилийн 0129 дүгээр ангид 1 хянах цамхгийг шинээр байгуулан хил хамгаалалтад ашиглаж байна.
	21.3.4	Хилийн салбаруудыг байнгын цахилгааны эх үүсвэрт холбох ажлыг үргэлжлүүлэх /салбарын тоогоор/	15	3			Баян-Өлгий аймаг дахь хилийн 0285 дугаар ангийн 0289 дүгээр салбар (Холбоо нуур)-ыг төвлөрсөн эрчим хүчинд холбож, Сүхбаатар аймаг дахь хилийн 0146 дугаар ангийн 0176 дугаар салбар (Холбоо залаа)-ын өндөр хүчдэлийн шугам, дэд станцыг Улсын комисст хүлээлгэн өгч, 0245 дугаар ангийн 0246 дугаар салбар (Давст)-ын 18 км өндөр хүчдэлийн шугамын тулгуурыг босгож, дэд станцыг угсарсан
	21.3.5	Хилийн боомтуудыг "Дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем"-ээр төхөөрөмжилж, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд "Ухаалаг цахим" технологийг нэвтрүүлж, орчин үеийн хяналт шалгалтын техник хэрэгслээр хангах /боомтын тоогоор/	4	4			Шилэн кабелийн холболтоор 17 хилийн боомт холбогдсон. "Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн систем"-ийн программын шинэчлэлийг "Гэрэгэ систем" ХХК-тай хамтран хийж байна. Шалган нэвтрүүлэх албанд хүний биеийн давхцахгүй өгөгдөлд суурилсан технологи нэвтрүүлэх арга хэмжээний хүрээнд БСШУЯ-ны судалгаа, туршилтын "Шинжлэх ухаан технологийн төсөл"-өөс 30.5 сая төгрөг (31 нэр төрлийн 1332 ширхэг), ХЗДХЯ-тай хамтарсан ажлын хэсэг 4.7 тэрбум төгрөг (24 нэр төрлийн 2369), Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтээр 40.0 сая төгрөг (зөөврийн тусгаарлах хашаа), нийт 5.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр (56 төрлийн 4001 ширхэг техник хэрэгсэл) шийдвэрлүүлж, хилийн боомтуудын шалгалтын кабин, шалгалтын техник хэрэгслийг шинэчилсэн.
21.4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл				70,552.6	70,545.3	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	21.4.1	Хоригдлын хөдөлмөр эрхлэлт /хувиар/	59	65			Тайлант хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд блок, тоосго, хавтан үйлдвэрлэл 8, шохой, замаск, эрдэс нунтаг, цавуу үйлдвэрлэл 10, хувцас, гутал, нэхмэл, эсгий, оёдлын бүтээгдэхүүн, хэрэглэл 217, тавилга болон бусад мод бэлтгэл, модон эдлэл 88, гэр, гэрийн мод 21, төмөр хийцийн бүтээгдэхүүн 5, чулуу бэлтгэл, чулуун бүтээгдэхүүн 14, газар тариалан 28, мал, аж ахуй 48, гар урлалын бусад бүтээгдэхүүн 154, барилга, орон сууц 68, авто засвар, усчин зэрэг бусад үйлчилгээний ажилд 64, гэрээгээр 142, аж ахуйн үйлчилгээнд 1484 нийт 2351 хоригдлыг хөдөлмөрөөр ханган ажилласан. Хоригдлын хөдөлмөр хангалт 77.2 хувьтай ба 993,2 сая төгрөгийн цалин бодогдож, гэм хорын төлбөрт 187.0 сая төгрөг, үлдсэн 806.2 сая төгрөгийг тухайн хоригдлын нэрийн дансанд байршуулсан.
	21.4.2	Мэргэжлийн сургалтад хамрагдах хоригдлын тоо	350	285	66,639.2	66,631.9	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2021 онд 405, 407, 417, 421, 427, 429, 441 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангиудад барилгын засал чимэглэлчин, цахилгаанчин, гагнуурчин, өрөг угсрагч, тогооч, мужаан, сантехникч, бетон арматурчин мэргэжлээр мэргэжлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж, амжилттай үнэлэгдсэн 285 хоригдолд "Мэргэжлийн үнэмлэх" олгосон. 2021 оны хичээлийн жилийн хуваарийн дагуу 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хугацаанд 407, 417, 421, 427, 429, 441 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангиудад барилгын засал чимэглэлчин, цахилгаанчин, өрөг угсрагч, сантехникч мэргэжлээр мэргэжлийн боловсрол олгох сургалтыг 167 хоригдолд зохион байгуулж байна. Сургалтад хамрагдсан суралцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 10.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
	21.4.3	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувь /хоёр төрлийн гүйцэтгэлийн дунджаар/	49	52			2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 36321 гүйцэтгэх баримт бичгийн 1.8 их наяд төгрөгийг биелүүлэхээс 19693 гүйцэтгэх баримт бичгийн 339.0 тэрбум төгрөгийг биелүүлж, 16628 гүйцэтгэх баримт бичгийн 1.4 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийн улсын дундаж үзүүлэлт 54.2 хувь, мөнгөн дүн 18.9 хувьтай ажилласан ба өмнөх оны мөн үеэс гүйцэтгэх баримт бичгийн статистик үзүүлэлт 2.5 хувиар өссөн, мөнгөн дүн 3.6 хувиар буурсан үзүүлэлттэй ажиллалаа. Хүүхдийн тэтгэлгийн биелүүлбэл зохих 12724 гүйцэтгэх баримт бичгийн 70.4 тэрбум төгрөгөөс 1444 гүйцэтгэх баримт бичгийн 36.4 тэрбум төгрөгийг бодитой биелүүлсэнээс 30.3 тэрбум төгрөгийг хэсэгчлэн төлүүлжээ. Гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 11.3 хувийн үзүүлэлттэй, 11280 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байна.
	21.4.4	Яллагдагч, хоригдлыг хуяглан хүргэх, хуяглан харгалзах /хүнээр/	5600	7308	1,710.9	1,710.9	Тайлангийн хугацаанд нийт хорих анги, байгууллагаас 5820 алба хаагчийн хүчээр 7308 хоригдогсдыг 1915 удаагийн тээвэрлэлтээр 195537 км зам туулсан хуяглан хүргэх ажиллагаанд байршил тогтоогч төхөөрөмж ашиглан хяналт тавьж ажилласан.
	21.4.5	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны бодит биелэлт /хувиар/	80	100	749.9	749.9	Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн 12589 ялтнаас 8972 ялтны ялыг бүрэн эдлүүлж, 2021 оны жилийн эцсийн байдлаар 3617 ялтан бүртгэл хяналтад байна. Тайлант хугацаанд торгох ялаар шийтгүүлсэн 71, нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн 171, зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн 149, нийт 391 ялтны ялыг хорих ялаар сольж шийдвэрлэсэн. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 154 дүгээр зүйлд заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн 264 /торгох 161, нийтэд тустай ажил хийлгэх 64, зорчих эрхийг хязгаарлах 39/ ялтнаас 239 /торгох 163, нийтэд тустай ажил хийлгэх 71, зорчих эрхийг хязгаарлах 5/ ялтанд холбогдох эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээсэн. "Цахим бүртгэл, хяналтын систем"-д хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ажиллагаатай 2442, хасагдсан 1245, дуусгавар болгосон 31644, нийт 35331 ялтанд холбогдох мэдээлэл бүртгэгдсэн. Улсын хэмжээнд 2021 онд нийт 5.4 тэрбум төгрөгийн 2589 гүйцэтгэх баримт бичигт зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж 3.0 тэрбум төгрөгөөр ангид 2 хянах цахмгийг тус тус засварлаж, Дорноговь аймаг дахь хилийн 0129 дүгээр ангид 1 хянах цахмгийг шинээр байгуулан хил хамгаалалтад ашиглаж байна. гэмт хэргийн ойлголт, ял шийтгэл, хор уршиг, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ" нэвтрүүлгийг бэлтгэн, МҮОНРТ-ийн 2 сувгаар цацаж, 100,000 орчим иргэнд хүргэсэн. Мөн
	21.4.6	Хорих ял эдлэгсэд болон сэжигтний амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	43	0.597	1,452.6	1,452.6	2021 онд 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг нь хуваарийн дагуу төв орон нутгийн 7 хорих анги, байгууллагад нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулж ажилласан ба давхардсан тоогоор 1986 хоригдол үзлэгт хамрагдсан бөгөөд үүнээс 1186 хоригдол буюу 59.7% хувьд нь өвчлөл илэрсэн бөгөөд 13А маягтаар 52 хоригдлыг хэвтэн эмчлүүлэхээр шийдвэрлэсэн.
21.5	Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын судалгаа, шинжилгээ				1,085.5	1,085.5	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	21.5.1	Сургалт, сурталчилгааны тоо	200	4017	1,085.5	1,085.5	2021 оны жилийн байдлаар эрх зүйн албан бус сургалт 31 удаа зохион байгуулсан. Эдгээр сургалтыг эрх зүйн хөтчийг чадавхжуулах, хууль сахиулах алба хаагчдад хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх чиглэлээр хийсэн. Мөн тайлант хугацаанд 3982 ширхэг сурталчилгааны зурагт хуудас, видео шторк, цахим контент гаргаж, олон нийтэд түгээсэн байна. Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн агуулгаар шинээр батлагдсан хууль тогтоомж, нийтлэг асуудлаар эрх зүйн зөвлөгөө, мэдээллийг энгийн ойлгомжтой хэлбэрээр хүргэсэн байна.
	21.5.2	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тоо	30	55			Цаг үеийн шинжтэй, захиалгат судалгааг нэмэлтээр хийж гүйцэтгэсэн болно.
21.6	Шүүхийн шинжилгээ				13,220.2	13,220.2	
27.1.4	Цалинтай ээж хөтөлбөр буюу 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж /хувь/	96	97	104,924.0	89,659.6	"Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн хүрээнд олгож байгаа 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 2021 онд өссөн дүнгээр 199,139 иргэнийг хамруулж, 90,492,992,260 төгрөгийг 2021 онд өссөн дүнгээр 206,208 иргэнийг хамруулж, 89,659,633.00 төгрөгийг тус тус зарцуулсан байна. Хуульд заасан "Төрүүлсэн 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх сар бүр хүүхэд асарсны тэтгэмж авах эрхтэй" гэсэн нь Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтээр Үндсэн хууль зөрчсөн байна гэснийг Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 20 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрч, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарч байгаа эх ажилдаа орсон тохиолдолд тэтгэмжийг хүүхдээ асарч байгаа, ажил эрхлээгүй эцэгт үргэлжлүүлэн олгохоор шийдвэрлэсэн болно. Хуулийг 2021 оны 07 дугаар сараас эхлэн дагаж мөрдөж байгаа бөгөөд 3000 гаруй эцэг тус тэтгэмжид хамрагдаж байна. 2021 онд тэтгэмжид хамрагдсан хүний тоо 2020 онтой харьцуулахад 7069-өөр өссөн ч зарцуулсан хөрөнгийн хэмжээ 0,8 тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэ нь тэтгэмж авсан хүний тоо хэдийгээр олон ч тэтгэмжид хамрагдсан сар нь бага байгаа тул зарцуулсан хөрөнгийн хэмжээ өмнөх оныхоос бага байх шалтгаан юм.
27.2	Нийгмийн даатгал			602,119.8	596,479.4	
27.2.1	Нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тооны өсөлт /өмнөх жилд харьцуулсан хувиар/	5	6.3			Нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тоо 2020 онд 49 284 байсан бол 2021 онд 52 388 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.3 хувиар өссөн байна

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	27.2.2	Нийгмийн даатгалд даатгуулсан даатгуулагчийн тооны өсөлт /өмнөх жилд харьцуулсан хувиар/	2	3.0	602,119.8	596,479.4	Нийгмийн даатгалд даатгуулсан даатгуулагчийн тоо 2020 онд 1 146 499 байсан бол 2021 онд 1 181 282 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 хувиар өссөн байна
	27.2.3	Нийгмийн даатгалын үйлчилгээ авсан хүний тоо /давхардсан тоогоор мянган хүн/	749.5	749.0			Нийгмийн даатгалд даатгуулсан даатгуулагчийн тоо 2020 онд 1 146 499 байсан бол 2021 онд 1 181 282 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 хувиар өссөн байна
	27.3	Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр			46,717.3	41,689.8	
	27.3.1	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд урьдчилан сэргийлэх болон хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн хувь	95	80.5	1,358.2	1,108.7	2021 онд 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс/газар, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Халамж асрамжийн төв, Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүд Хамтарсан багаас эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд урьдчилан сэргийлэх болон хамгааллын хариу үйлчилгээг давхардсан тоогоор нийт 34995 хүүхдэд үзүүлсэн.
	27.3.2	Хүүхдээс хүлээн авсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт /хувь/	99	95	145.3	129.0	Аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар/хэлтэст 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 1051 өргөдөл гомдол бүртгэгдсэнээс 998 нь шийдвэрлэж, 53 нь хугацаа сунгасан. Үүнийг хандалтаар ангилж үзвэл: утсаар 120, бичгээр 527, биечлэн 313, бусад 20, цахим 71 өргөдөл бүртгэгдсэн.
	27.3.3	Хүүхдийн зусланд хамрагдсан хүүхдийн тоо /мянган хүн/	70	0	93.8	62.8	Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор хүүхдийн зуслан ажиллаагүй. Харин байнгын асаргаатай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний гэр бүлийг дэмжих зорилгоор Олон улсын хүүхдийн "Найрамдал" зусланд 50 хүүхдийн тусгай ээлж ажиллуулсан.
	27.3.4	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн хүний тоо /хувиар/	32	33.9	607.9	542.0	Гэр бүлийн боловсрол олгох 164 удаагийн танхимын болон цахим сургалтад 29960 хүн /хандалт 168503/, угийн бичгийн сургалтад 7343 иргэн /хандалт 102568/ хамруулсан нь нийт 308374 хүнд буюу нийт гэр бүлийн 33.9%-д хүрсэн.
	27.3.5	Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн хүний тоо /хувиар/	40	42	451.1	391.0	21 аймаг, 9 дүүрэг, 5 суманд Залуучуудын хөгжлийн нийт 35 төв үйл ажиллагаа явуулж 2021 онд нийт залуучуудын 42.0 хувь буюу 427290 залуучуудыг амьдрах ухааны сургалт, нөлөөллийн, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, холбон зуулах үйл ажиллагаа, гэр бүлийн боловсрол олгох, хөдөлмөр эрхлэлтийн ганцаарчилсан/бүлгийн зөвлөгөө, сэтгэл зүйн ганцаарчилсан/бүлгийн зөвлөгөө, 217 төрлийн клуб, дугуйлан, улсын хэмжээнд сайн дурын үйл ажиллагаа, залуучуудын хөгжлийг дэмжих сургалт, нөлөөллийн, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгаанд тус тус хамруулсан.
	27.3.6	Ахмадын ордон, өргөө, танхим, төвөөр үйлчлүүлсэн болон зөвлөгөө мэдээлэл авсан ахмад настны хувь	90.5	90	148.6	-	Улсын хэмжээнд нийт 456 ахмадын ордон, өргөө, танхим, төв ахмад настанд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ахмадын хөгжил, оролцоонд чиглэсэн үйлчилгээ болон ахмадын сан байгуулах, тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр зэрэг төрөөс хэрэгжүүлэх бодлого үйл ажиллагааны хэрэгжилтийг төр, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажиллав. 2021 оны байдлаар 344,6 мянган ахмад байгаагийн 90 гаруй хувьд дээрх ордон, өргөө, төвүүдээр дамжуулан үйлчилгээ үзүүлсэн байна.
	27.3.7	Сэргээн засах үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь	15.7	11.3	8,628.1	7,047.9	2021 онд: 2020 оны хагас жилд ХБХХЕГ нь Сэргээн засах үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувийг 2020-2023 онд хэрхэн үе шаттай нэмэгдүүлэх талаар тооцоолол хийсэн. 2021 онд 2020 оны нөхцөл байдлыг харгалзан зорилтот бүлгийн хүн амд үзүүлэх сэргээн засах тусламж үйлчилгээ "Цахим эмнэлэг" болсноор 2.8 хувиар өсөж 15.7% хувь (17178) болгоно гэсэн төлөвлөлттэй байсан. 2021 оны зорилтот түвшинд хүрэхэд томоохон саад бэрхшээлүүд гарсан нь 2021 оны эхний 2 улирлыг дамнасан КОВИД-19 цар тахлын улмаас тогтоосон хөл хорионоос шалтгаалж салбарын үйл ажиллагаа тодорхой хугацаанд зогсож, иргэдэд хүргэх үйлчилгээний тоо хэмжээнд нөлөөлсөн. Мөн ХБХХЕГ-ын харьяа Сэргээн засах төв (4-5 сар, 9-11 сар), Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвүүд (3-7 сар) нь улаан бус болж, КОВИД-19 цар тахлын эсэргүүцэх арга хэмжээнд хамрагдсаны улмаас зөвхөн халдвар авсан иргэдэд үйлчилгээ хүргэж ажилласан байна. 2020 оны эхний хагас жилд нийт 7274 иргэн буюу зорилтот бүлгийн 6.7 хувьд нь хүрч үйлчилж байсан бол 2021 оны эхний хагас жилд /3845/ 3.5 хувьд нь тусламж үйлчилгээг хүргэсэн. 2021 оны жилийн эцсийн байдлаар зорилтот бүлгийн 11.3 хувьд (12255) хүрч үйлчилсэн. 2021 оны 8 дугаар сард хийсэн таамаглалаас 0.5 хувиар зөрүүтэй гарсан байна
	27.4	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, удирдлага			14,098.3	13,454.9	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	27.4.1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бодлого, стратеги, хууль тогтоомж, тогтолцоог боловсронгуй болгож, үр дүнтэй хэрэгжүүлэх	Салбарын үйл ажиллагааны хэрэгжилтээр				Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн батлуулав. Сайдын 2020 оны А/167 дугаар тушаалаар баталсан нийгмийн даатгалын дэвтрийг цахимжуулах санал боловсруулах, ажлыг хэрэгжүүлэх хүрээнд нийгмийн даатгалын дэвтэр цахим хэлбэрт шилжиж үйлчилгээнд нэвтрүүлэв. Нийгмийн халамжийн цахимжуулсан үйлчилгээ 2021 оны байдлаар нийт 26 төрлийн халамжийн үйлчилгээг цахим системээр дамжуулан олгож эхлэв. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээ, Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэн цахимжуулж ezuvshuurl.mn Цахим хаягт байршуулав. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа "Цахим Монгол" арга хэмжээ, цар тахлын өнөө үед төрийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон хөдөлмөрийн хувийн биржүүд хөдөлмөр зуучлалын үйлчилгээг www.ejob.gov.mn вэбсайтаар дамжуулан иргэдэд хүргэж байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулж 12 дугаар сарын 3-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хамтран батлуулав. Нийгмийн ажлын нийтлэг стандарт", "Гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага" стандарт болон "Хүүхэд, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг стандарт"-ыг Стандарт, хэмжил зүйн газраар батлуулав. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад нийт 12 төвийн санхүүжилтийн асуудлыг тусгуулан шийдвэрлүүлэв.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ажилтныг ажлын бүтэн бус цагаар ажиллуулах, гэрээсээ ажиллах, зайнаас ажиллах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн онцлог харилцааг зохицуулсан заалтуудыг тусган, УИХ-ын 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар батлуулав.
	27.4.2	Салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх	Салбарын үйл ажиллагааны хэрэгжилтээр		14,098.3	13,454.9	Монгол Улс, гадаад улс хоорондын хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр хэлэлцээр болон санамж бичиг байгуулахад хүрээнд: Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэх, Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын Тэтгэврийн тухай хэлэлцээрийг байгуулах, "Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын хэлэлцээр"-ийн 3 дахь шатны хэлэлцээ хийх, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамтай байгуулах "Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу ажилтан илгээх болон хүлээн авах тухай санамж бичиг"-ийг шинэчлэн байгуулах, "Монгол Улсын Хөдөлмөр эрхлэх үйлчилгээний цахим систем хөгжүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээний протоколыг Монгол Улсын Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хооронд байгуулах хүрээнд Хэлэлцээний протоколын төслийг зохих журмын дагуу Гадаад харилцааны яамтай хамтран эцэслэв. "Олон улсын байгууллагууд, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх санал тавих, төслүүдийн хэрэгжилтийг зохицуулалтаар хангах" хүрээнд: АХБ-ны буцалтгүй тусламжаар "Ахмад настнуудад үзүүлэх урт хугацааны тусламж" төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил, төслийн удирдах зөвлөл байгуулах болон хэрэгжүүлэх байгууллагуудыг тодорхойлох зэрэг асуудлаар АХБ-ны холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулав. МУ-ын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хооронд "Хөгжлийн дэлхий дахинд" Сайн дурын хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай Хамтарсан мэдэгдэл байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллав. Хамтарсан мэдэгдлийг ЗГ-ын хуралдаанд танилцуулав. Европын Холбооноос МУ-д үзүүлэх тусламжийн хүрээнд "Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлд зориулсан төсвийн дэмжлэг" төслийг 2020-2024 онд хэрэгжүүлэхээр болов. Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд үндсэн зорилго оршино. Олон улсын байгууллага, гадаад улсын Засгийн газруудын буцалтгүй тусламж болон хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хэрэгжиж буй нийт төслүүдийн агуулга, чиглэлийн уялдааг сайжруулах зорилгоор нэгдсэн танилцуулгыг 2021.04.20-23-ны өдрүүдэд зохион байгуулав. Салбарын хэмжээнд нийт 20 төсөл хэрэгжиж байна.
27.5	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих				99,604.2	87,232.2	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	27.5.1	Ажилгүйдлийн түвшин /хувиар/	9.5	8.1			Ажилгүйдлийн түвшин 9.5 байхаар тооцоолсон нь тухайн үед коронавирусын тархалтын зогсох хугацаа болон эдийн засагт учирч болох хохирлыг тооцоход төвөгтэй, цаашид хэр удаан үргэлжлэх, эдийн засагт ямар хэмжээний хохирол үзүүлэхийг тодорхойлох боломжгүй байсан учир хамгийн доод хувилбараар авч үзсэн болно. Монгол Улсын ажиллах хүчний оролцооны түвшин 2019 онд 60.5%, 2020 онд 58.8%, 2021 оны 3 дугаар улирлын байдлаар 57.9%, 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар 58.3 хувь байна. Ажилгүй хүний тоо 2020 онд 87.7 мянга, 2021 оны 1 дүгээр улиралд 101.1 мянга, 2021 оны 2 дугаар улирлын байдлаар 101.2 мянга болж нэмэгдсэн. Ковидын нөхцөл байдлаас шалтгаалж эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн бага буюу 2021 оны 1 дүгээр улиралд 48%, 2 дугаар улиралд 49% болж буурсан. Гэвч сүүлийн улирлуудад хөл хориог цуцалж, агаарын хилийг нээснээр иргэн, аж ахуй нэгж байгууллага, бизнесүүд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэнтэй холбоотойгоор хөдөлмөрийн зах зээл сэргэх хандлага ажиглагдаж байна.
	27.5.2	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин /хувиар/	56.6	53.6	99,604.2	87,232.2	Хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг тооцохдоо ажиллагчдын тоог/хөдөлмөрийн насны хүн амд харьцуулдаг. Хөдөлмөрийн насны хүн ам нь ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын нийлбэр юм. Ажиллах хүчний тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.8 мянгаар нэмэгдэж, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 39.9 мянгаар буурсан үзүүлэлттэй байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 53.6% болж буурахад ажиллах хүчнээс гадуурх хүн ам 39.9 мянга буюу 4.3 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.
	27.5.3	Шинээр бий болсон ажлын байрны тоо /мянган хүн/	30	28.3			Улсын хэмжээнд 2021 оны 12 сард нийт 28390 ажлын шинэ байр бий болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3410 хүнээр буюу 10.7 хувиар, 2019 онтой харьцуулахад 5935 хүнээр буюу 15 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Учир нь Дэлхийн бүхий л бүс нутгийг хамарсан Коронавирус халдварын нөлөөгөөр уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилга, тээвэр ба агуулах, аялал жуулчлал, үйлчилгээ зэрэг бүхий л салбарууд зогсонги нөхцөл байдалд орж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаа түр хугацаагаар зогсон нь нөлөөлсөн.
	27.5.4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авсан иргэний тоо /мянган хүн/	5.6	5.2			2021 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож буй жижиг зээл, санхүүгийн дэмжлэгт 5260 хүн хамрагдсан байна. Үүнээс санхүүгийн дэмжлэгт 4923 иргэн, аж ахуйн нэгж, жижиг зээлд 337 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан байна. Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө-нд тусгасан ажлын байрыг дэмжих зорилтын хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 2.0 их наяд төгрөгийн зээлийг банкуудын чөлөөт эх үүсвэрээр олгож эхэлсэнтэй холбоотой ХЭДС-аас олгож буй жижиг зээлд хамрагдах иргэдийн тоо буурсан байна.
27.6	Мэргэжлийн боловсрол				78,334.8	75,996.7	
	27.6.1	Мэргэжлийн боловсрол эзэмшсэн төгсөгчийг ажлын байраар хангах /хувиар/	67.5	51.7	75,900.8	73,563.4	Үндэсний статистикийн хороонд хүргүүлдэг маягтын дагуу төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 2018-2019 оны хичээлийн жилд 58.1 хувь, 2019-2020 онд 51.5 хувь, 2020-2021 онд 51.7 хувь байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэхгүй буурсан нь Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоосон, аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаа доголдсон, эдийн засгийн үйл ажиллагаа хумигдсан гэх зэрэг олон шалтгааныг дурдахаар байгаа боловч салбар төгсөгчдөө тухайн хичээлийн жилд шууд төгсөнгүүт нь статистик мэдээгээр нь хөдөлмөр эрхлэлтийн хувийг тодорхойлж мэдээлж байгаа нь учир дутагдалтай байна. Цаашдаа төгсөгчдийн шууд хөдөлмөр эрхлэлтийн хувийг нэмэгдүүлэхэд мөшгөх судалгаа болон дагах судалгааг 9, 12 сард хийх шаардлагатай байна.
	27.6.2	Мэргэжлийн боловсролын байгууллагын дадлагын болон сургалтын баазыг шинэчлэх /тоогоор/	5	7	2,434.0	2,433.3	Улмын төсвийн хөрөнгөөр 1. Оюутны дотуур байрын барилга, 300 ор /Увс, Улаангом сум, Политехник коллеж/, 2. Хөгжил политехник коллежийн барилга /Ховд, Жаргалант сум/, 3. Хөдөө аж ахуйн их сургуулийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон, Баян-Өндөр сум/, 4. Хөгжил политехник коллежийн барилга /Ховд, Жаргалант сум/, 5. МСҮТ-ийн байрны засвар /Хэнтий аймаг, Бор-Өндөр сум/, 6. Монгол-Солонгосын политехник коллежийн барилга засвар /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг/, 7. Политехник коллежийн барилга засвар /Завхан аймаг, Улиастай сум/ 2021 онд барилга болон их засварын ажил хийгдсэн.
27.7	Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах				2,150.9	1,739.1	
	27.7.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр шинэчлэн боловсруулах дүрэм, журам, стандарт	3	3			Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын Үндэсний холбоотой хамтран 3 стандартын төслийг шинэчлэн боловсруулав. Үүнд: • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага. MNS 4990:2015 стандарт, • Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ 5080:2001 стандарт, • Ажлын байрны агаар. Ажлын байрны агаарын температур, чийгийг хэмжих арга 5387:2004 стандарт.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	27.7.2	Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн ажлын байрны тоо	2200	1036	2,150.9	1,739.1	2021 оны жилийн эцсийн дүнгээр итгэмжлэл бүхий 4 байгууллагын 1036 ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийсэн. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх ажил нь 2021 оны эхний хагас жилд коронавируст халдварын /Ковид - 19/ цар тахлын үед улсын хэмжээнд 3 удаа буюу нийт 50 өдрийн хатуу хөл хорио тогтоосон ба үүнээс гадна хэсэгчилсэн хөл хорио тогтоон ажлын цагийг онлайн горимд шилжүүлсэнтэй холбогдуулан хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг ажлын байранд нь хийх, орон нутаг руу томилолтоор явж ажиллах боломжгүй байсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулсан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөдөлмөрийн хүнд нөхцөлийг үе шаттайгаар бууруулах, арилгах чиглэлээр тусгагдсан. Үүний дагуу хөдөлмөрийн хэвийн бусаар үнэлэгдсэн ажлын байрны нөхцөлийг сайжруулан хөдөлмөрийн хэвийн нөхцөлд шилжихэд түлхүү анхаарч ажиллах шаардлага үүсэж байна. Тиймээс хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тоонд бус ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлсийг бууруулах, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх өндөр ач холбогдолтой.
	27.8	Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, шинжилгээ			726.5	716.3	
	27.8.1	Хөдөлмөрийн салбарын хүрээнд хийсэн судалгааны тоо	4	5	726.5	716.3	Тус яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй холбоотой дараах судалгааг хийж гүйцэтгэв. Судалгааны үр дүнг http://www.nlsp.gov.mn сайтаас харах боломжтой. Үүнд: • Хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа • Цалин хөлсний бүтцийн судалгаа • Албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын судалгаа • "Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хэрэгжилт болон хүнсний эрхийн бичиг олгох журамд заасан хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийн хэрэгжилт, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих үйл ажиллагааны талаарх судалгаа • Нийгмийн халамжийн хөтөлбөрийн хэрэгжилтэд үзүүлэх Ковид-19 цар тахлын нөлөөллийн шинжилгээ
28	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД				193,833.0	182,574.7	
	28.1	Мал аж ахуй			29,771.2	28,042.0	
	28.1.1	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ /сая толгой, давхардсан тоогоор/	58.7	63.7	29,771.2	26,541.0	Малын халдварт болон архаг халдварт брүцеллээ өвчинтэй тэмцэхэд 8 нэр төрлийн 8,723.9 литр шингэн, 20.78 сая тун хатаасан вакциныг давхардсан тоогоор 25.7 гаруй сая толгой малыг хамруулсан. Орон нутгийн санхүүжилтээр урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд 9 нэрийн өвчний вакцин 11.6 сая толгой мал, амьтныг хамруулж ажиллаа. Шүлхий өвчний гаралт 20 аймгийн 170 сумын 301 голомт бүртгэгдсэнээс давхардсан тоогоор 21 аймгийн 234 сумын нийт 23.3 сая толгой, бог малын мялзан өвчин 6 аймгийн 18 сумын 36 голомт бүртгэгдсэнд 4 аймгийн 18 сумын 1.9 сая толгой, хонины цэцэг өвчний гаралт 3 аймгийн 4 сумын 4 голомт бүртгэгдсэнд 3 аймгийн 7 сумын нийт 1.0 сая толгой хонин сүргийг дархлаажуулалтад хамруулсан байна. Мөн малын гоц халдварт үхрийн арьс товруутах өвчнөөс сэргийлэх вакциныг 180.0 мянган үхэрт хонины тунгаар 10 дахин их буюу 1.8 сая цэцгийн вакцин тарьсан байна.
	28.1.2	Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх /өссөн хувиар/	3	20		2021 оны жилийн эцсийн байдлаар эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр 3035 өрх, аж ахуйн нэгж сүүний үхрийн 98,025 үнээ, 341 аж ахуйн нэгж 34,963 махны үхэр, 28 аж ахуйн нэгж, 1,190 өрх 1 сая 60 мянган шувуу, 15 аж ахуйн нэгж, 446 өрх 21,652 гахай, 35 аж ахуйн нэгж, 680 өрхөд 13770 бүл зөгий үржүүлгийн үйл ажиллагаа явуулж байна.	
	28.1.3	Бэлчээрийн ургамал хамгаалал /мянган га/	1066	396.6		1,501.0	Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготнотой микробиологийн болон энгийн механик, биологийн аргаар улсын төсвийн санхүүжилтээр 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн. Энэ ажилд нийт 9 аймгийн 114 сум, 4 аймаг дундын отрын бус нутгийн 396.6 мянган га бэлчээрийн талбай хамрагдаж үлийн цагаан оготнын хөнөөлөөс хамгаалж мал аж ахуйн үйлдвэрлэлд ашиглах боломжийг бүрдүүлж ажилласан. Орон нутгийн төсвөөс 250 сая төгрөгийг зарцуулсан байна. "Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль"-иар төсөв хасагдаж батлагдсан.
	28.2	Газар тариалан			26,527.4	24,986.6	
	28.2.1	Буудайн үйлдвэрлэлийг дэмжих /мянган тонн/	480	567	26,527.4	22,717.1	2021 онд дотоодын гурилын үйлдвэр, улсын нөөцийн газар болон ХААДСанд 13 аймгийн 776 иргэн, аж ахуйн нэгжийн 255.8.0 мянган тонн тушаасан улаанбуудайнд 22.7 тэрбум төгрөгийн урамшуулал олгож ажилласан.
	28.2.2	Төмс, хүнсний ногоо /мянган тонн/	290	300.1		2,269.6	2021 оны төмс 181.5 мянган тонн, хүнсний ногоо 118.6 мянган тоннж хураан авсан. Улсын төсвийн санхүүжилтээр хүнсний ногооны үрийн нөөц бүрдүүлэхэд 2.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гаргаж ажилласан.
	28.3	Хүнсний үйлдвэрлэл			12,553.1	11,824.0	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	28.3.1	Хүн амын сүүний хэрэглээг үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүүгээр хангах /сая литр/	170	205.4	12,553.1	4,188.6	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ 2021 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 205.4 сая.литр сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийн аргаар боловсруулаад байна. Сүү боловсруулах 12 үйлдвэрт 8.4 сая литр сүү бэлтгэн нийлүүлсэн 9016 малчин, эрчимжсэн мал аж эрхлэгчдэд 4.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож ажилласан.
	28.3.2	Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны хэрэглээг нэмэгдүүлэх /мянган тонн/	50	26		7,635.3	Монгол улсын Засгийн газрын 2021 оны 72 дугаар тогтоолын дагуу нийслэлийн хүн амын хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан арилжааны 5 банкны 67.3 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрээр 16 аж ахуйн нэгжийн бэлтгэсэн 11.0 мянган тонн маханд үнийн зөрүү 3.0 тэрбум төгрөг, тус зээлийн хүүгийн 4.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг олгож ажилласан.
28.4	Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого, удирдлага				114,526.0	107,874.0	
	28.4.1	Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан шийдвэр, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх /тоогоор/	4	12	114,526.0	107,874.0	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Улсын Их Хурлаар батлагдсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, УИХ, Засгийн газраас батлагдсан Монгол мал, Сав баглаа боодол, Хүнсний ногоо, Жимс, жимсгэнэ, Малын эрүүл мэнд, Үйлдвэржилт 21:100, Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, Ноолуур хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж ЗГЖЭГазарт хүргүүлж ажилласан.
28.5	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх, ажлын байр олгох				10,455.3	9,848.0	
	28.5.1	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн тоо	450	12	10,455.3	9,848.0	2021 онд ЖДҮХөгжүүлэх сан өөрийн эх үүсвэрээс зээл гаргаагүй бөгөөд засгийн газрын бондод 29.0 тэрбум төгрөг төлж барагдуулсан. "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл", Сангийн яамтай хамтран хоршоодыг дэмжих зорилгоор 12 хоршоонд 810 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн хүрээнд 2 төсөлд 9.0 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Засгийн газрын "Эдийн засгийг сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө" хөтөлбөрийн хүрээнд ажлын байрыг дэмжих зорилгоор 2021 онд жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 1,823.6 тэрбум төгрөгийн зээлийг 18,000 иргэн, 5000 гаруй аж ахуйн нэгжид олгожээ. Тухайн зээлээр 125 мянган ажлын байр хадгалагдан үлдсэн байна. Цар тахлын улмаас ажлын байргүй болох эрсдэлтэй ААН-үүдийг дэмжиж ирсэн жилийн 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээл бизнес эрхлэгч нарт дэмжлэг хөшүүрэг, давуу тал болсон. Өнгөрсөн онд нийт зээлийн 62 хувь нь нийслэлд, 37 хувийг аймаг, орон нутагт олгож, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймаг олгосон зээлийн хэмжээгээр тэргүүлсэн.
	28.5.2	Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх /зээлдэгчийн тоо/	100-150	1334			2021 онд нийт 1082 зээлдэгчдэд 299.5 тэрбум төгрөгийн зээлд 146.2 тэрбум төгрөгийг зээлийн батлан даалтын сангаас гаргасан байна. /Зээлийн батлан даалтын сангаас өгсөн мэдээлэл/. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн дэд төслийн хүрээнд 1337 иргэний 9.9 тэрбум төгрөгийн зээлд 5.4 тэрбум төгрөг, 252 аж ахуйн нэгж, хоршоодын 6.4 тэрбум төгрөгийн зээлд 2.5 тэрбум төгрөгийн зээлийн батлан даалтыг гаргаж ажилласан.
29	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД				1,079,237.3	1,061,300.5	
	29.1	Эмнэлгийн тусламж үйлчилгээ			490,978.9	478,612.9	
	29.1.1	Эхийн эндэгдлийн харьцаа /100000 амьд төрөлтөд/	21.4	94.9			2021 онд эхийн эндэгдлийн 68 тохиолдол бүртгэгдсэн. Үүний 46 тохиолдол нь коронавируст халдварын шалтгаант нас баралт байгаа нь эхийн эндэгдлийн харьцаа нэмэгдэх шалтгаан болсон.
	29.1.2	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	15.1	11.6			Зорилтот түвшиндээ хүрсэн бөгөөд нялхсын эндэгдэл өмнөх оноос 49 тохиолдлоор буурсан. Гэвч 1000 амьд төрөлтөд ногдох эндэгдэл өмнөх оноос 0.1 промилээр өссөн нь 2021 онд төрөлтийн тоо буурсантай холбоотой.
	29.1.3	Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	12.3	13.9	490,978.87	478,612.89	Зорилтот түвшиндээ хүрсэн.
	29.1.4	30-70 насны хүн амын зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын түвшин /10000 хүн амд ногдох/	16.7	21.0			Өмнөх оноос нас баралтын тоо 331 хүнээр нэмэгдсэн. Зорилтот түвшиндээ хүрээгүй.
	29.1.5	Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	88.7-ээс доошгүй	90.6			Жирэмсний эрт үеийн хяналтын хувь зорилтот түвшингээс давуулан хэрэгжүүлсэн.
	29.1.6	Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь /ерх, сумын эрүүл мэндийн төвийн түвшин/	30.0-аас доошгүй	45.5			Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь зорилтот түвшингээс давуулан хэрэгжүүлсэн.
	29.2	Нийгмийн эрүүл мэнд			25,911.8	24,268.0	
	29.2.1	Тавт вакцины 3 дахь тунгийн хамралтын хувь	98.1-ээс доошгүй	95.3			Ковидоор өвдсөн хүүхдүүд товлолт дархлаажуулалтаас хоцрогдсон. Мөн цар тахал коронавируст халдварын үеийн хязгаарлалт нөлөөлсөн.
	29.2.2	Улаанбурухан-Гахайн хавдар-Улаануудын (УГУ) эсрэг вакцины 2 дахь тунгийн хамралтын хувь	98.5-ээс доошгүй	93.7			Цар тахал коронавируст халдварын үеийн хязгаарлалтаас шалтгаалж, товлолт дархлаажуулалтын хамрагдалт буурсан.
	29.2.3	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	80.6	46.6	25,911.77	24,268.03	Цар тахал коронавируст халдварын үеийн хязгаарлалтаас шалтгаалж, иргэдийн эрт илрүүлэгт хамрагдалт буурсан.
	29.2.4	Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	77.9	82.4			Эрт илрүүлэгт хамрагдах нас нь 40-өөс дээш болж өөрчлөгдсөн бөгөөд зорилтот түвшинд хүрсэн.
	29.2.5	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	41.6	29.7			Цар тахал коронавируст халдварын үеийн хязгаарлалтаас шалтгаалж, иргэдийн эрт илрүүлэгт хамрагдалт буурсан.
29.3	Эрүүл мэндийн бодлого, удирдлага				65,881.5	62,071.5	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	29.3.1	Эмч, сувилагчийн харьцаа	1:1.3	1.0:1.0	65,881.50	62,071.51	Сувилагчийн хомсдолтой холбоотой эмч, сувилагчийн харьцаа үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй.
	29.3.2	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтний тоо	4716	3055			Үндсэн мэргэшлийн сургалтад-787, төрөлжсөн мэргэшлийн сургалтад-2268 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Цар тахал коронавируст халдварын улмаас ажлын байран дээр зайлшгүй байх, хүний нөөцийн дутагдлаас шалтгаалан төгсөлтийн дараах эмнэлгийн сургалтуудад бүрэн хамрагдаж чадаагүй.
	29.3.3	Гадаадад мэргэжил дээшлүүлсэн эмнэлгийн мэргэжилтний тоо	30	Ажлын байр-253 Цахим сургалт-465			Цар тахал коронавируст халдвараас шалтгаалж гадаадад эмнэлгийн мэргэжилтэн дээшлүүлэх сургалт зохион байгуулагдаагүй. Гадаад улс орноос зочин профессорын баг урьж, ажлын байр болон цахим сургалтуудыг зохион байгуулсан.
	29.4 Эрүүл мэндийн даатгал				496,465.2	496,348.1	
	29.4.1	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	91.2	96.8	496,465.20	496,348.07	Зорилтот түвшиндээ хүрсэн. Эрүүл мэндийн албан журмын даатгалын хэрэгжилтийг хангах зорилгоор иргэд 2016 оноос хойш эрүүл мэндийн даатгалаа бүрэн төлж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах шаардлагыг ЭМДЕГ-аас тавьсан тул даатгалд хамрагдалт нэмэгдсэн.
	29.4.2	Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ авсан хүний тоо /давхардсан тоогоор сая хүн/	7.8	5.5			Зорилтот түвшиндээ хүрээгүй. Цар тахал коронавируст халдварын үеийн хязгаарлалтаас шалтгаалж, эмнэлгээр үйлчлүүлэх тоо багассан.
30	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД				67,693.7	65,975.8	
	30.1 Дулаан хангамжийн өргөтгөл, шинэчлэлт				14,418.0	14,418.0	
	30.1.1	Дулаан, цахилгааны эх үүсвэр /шинээр хийгдэх ажлын тоо, хүчин чадал МВт/	71 МВт	71 МВт	6,000.00	6,000.00	Дулааны цахилгаан станцын өргөтгөл /Дорнод, Хэрлэн сум/
	30.1.2	Дулааны шугам сүлжээний өргөтгөл /шинээр хийгдэх ажлын тоо, хүчин чадал км/	5.6 км	5.6 км	5,118.00	5,118.00	Дулаан хангамжийн шугам сүлжээ, дулаан дамжуулах төв /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/ 12 а магистраллийн ТК-1211 цэгээс урагш гарсан 2 Ø 400 мм голчтой шугамыг 2 Ø 500 мм болгон өргөтгөх, 3х500х70 хүчин чадалтай шинээр даралт өргөх насос станц барих, зургийн хамт /Улаанбаатар/. Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээний үргэлжлэл /Хэнтий, Хэрлэн сум/. Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам засвар, шинэчлэл-3 дугаар ээлж /Хэнтий, Хэрлэн сум/
	30.1.3	Халаалтын зуухыг буулгаж төвлөрсөн дулаан хангамжид холбох /шинээр хийгдэх ажлын тоо, төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох техникийн нөхцөл бүрдүүлэх/	70	70	3,300.00	3,300.00	Халаалтын зуухнуудын төвлөрсөн дулааны холболт /Улаанбаатар/ төсөл, арга хэмжээний хүрээнд "Нэгдсэн халаалтын шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум, Тахилгат тосгон/
	30.2 Цахилгаан эрчим хүчний хангамж				53,275.7	51,557.8	
	30.2.1	Улаанбаатар хотын цахилгаан хангамжийн дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлт /цахилгаантай болох айл, өрхийн тоо/	6662	6662	1,500.00	1,500.00	"Гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах шугам, дэд станц /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 8, 13, 16 дугаар хороо/" төсөл, арга хэмжээний хүрээнд Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны Цайзын 16-18, Монелийн 17-19, Цэргийн хотхон Нарангийн 5, 7 дугаар гудамж, 5 дугаар хорооны Монелийн 30-33, 36-39, 50-52 дугаар гудамж, 8 дугаар хорооны, 13 дугаар хорооны 1 дүгээр хэсэг, 16 дугаар хорооны Газарчин, Хөшөөт фидер орчмын гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй болон хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж сайжирсан.
	30.2.2	Орон нутгийн цахилгаан хангамжийн дамжуулах түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлт /шинээр хамрагдах сумын тоо/	20	20	28,193.90	26,476.00	2021 онд нийт 13 аймгийн 20 сумын цахилгаан хангамжийн дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Дундговь: Аймгийн төвийн 220/110/35 кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажил /Дундговь, Сайнцагаан сум/; Төв: Сумын төвийн 0.4 кВ-ын шугамын шинэчлэлт /Төв, Баянцагаан сум/; Завхан: Цахилгаан дамжуулах агаарын шугам /Завхан, Улиастай сум, 21 дүгээр зуун хороолол/; Увс: Сумын төвийн цахилгааны шугамыг СИП кабелиар солих /Увс, Баруунтуруун сум/; 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл /Увс, Улаангом сум, 12 дугаар баг/; Хөвсгөл: Төмс, хүнсний ногоо тариалдаг хөдөөгийн багуудыг эрчим хүчинд холбох /Хөвсгөл, Бүрэнтогтох сум, Их-Уул, Эрчим баг/; Багийн төвийг эрчим хүчээр холбох /Хөвсгөл, Их-Уул сум, Мандал, Сараалж баг/; Багийн сэргээгдэх эрчим хүчний холболт /Хөвсгөл, Төмөрбулаг сум/; Өвөрхангай: Сумын төвийн 10 кВ-ын шугам /Өвөрхангай, Бүрд сум/; Есөнзүйл сумын төвөөс орон нутгийн А-0301 Засмал зам хүртэлх 10.0 км цахилгаан дамжуулах агаарын шугам /Өвөрхангай, Есөнзүйл сум/; Булган: Цахилгаан эрчим хүчинд холбох /Булган, Бугат сум, Ханжаргалант баг/; Сайхан, Хутаг-Өндөрийн сумын заагт орших "Дондогийн булаг" орчмыг цахилгаан эрчим хүчний системд холбох /Булган, Сайхан сум/; Сэлэнгэ: Шинэ суурьшлын бүсийн цахилгаан дамжуулах агаарын шугам, 250кВТ АТП /Сэлэнгэ, Мандал сум/; Хэнтий: Цахилгааны шугам сүлжээ /Хэнтий, Өмнөдөнгэр сум/; Баян-Өлгий: Цахилгаан дамжуулах агаарын шугам, 0.4 кВТ /Баян-Өлгий, Толбо сум/; Ховд: Хөшөөтийн уурхайгаас Ховд аймгийн Үенч сум хүртэл 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Үенч дэд станцын өргөтгөл /Ховд, Үенч сум/; Баянбулаг хүүхдийн зусланг өндөр хүчдэлийн ЦДАШ-тай холбох /Ховд, Жаргалант сум/; Говь-Алтай: Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/; Говьсүмбэр: Сумын өмчлөлд олгох 6 кВ-ын шугам, КТПН байгуулж, цахилгааны эх үүсвэр /Говьсүмбэр, Сүмбэр сум/.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	30.2.3	Гэр хорооллын айл өрхүүдэд олгох цахилгааны хөнгөлөлт /хамрагдах айл өрхийн тоо/	189467	155861	23,581.80	23,581.80	Монгол Улсын 2017 оны Засгийн газрын 199 дүгээр тогтоолоор баталсан "Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам"-ын дагуу нийслэл хот, аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын өрхийн аж ахуйн хэрэглээ болон халаалтын зориулалтаар хүйтний улиралд орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг 100 хувь чөлөөлсөн. 2021 онд шөнийн тарифын хөнгөлөлтөд Улаанбаатар хотод 120,915 хэрэглэгч, орон нутагт 34,946 хэрэглэгч хамрагдаж, 23,581.8 сая төгрөгийг зарцуулсан. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Эрчим хүчний төсөл-2"-ын хүрээнд "Багануур зүүн Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК, "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д хийгдэх ухаалаг тоолуур суурилуулах ажилтай холбоотой хэрэглэгчийн тоо буурсан.
31	ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА				5,386.0	5,385.7	
	31.1	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах үйл ажиллагаа			5,386.0	5,385.7	
	31.1.1	Нийслэл, аймаг, дүүргийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Салбар комиссыг бодлогын нэгдсэн удирдлагаар хангах	Байнга	байнга	386.0	385.7	Аймаг, нийслэлийн салбар комиссуудаас 2021 онд хийсэн ажлын дүн мэдээг нэгтгэн улсын комиссын гишүүдэд танилцуулж, комиссын даргын захирамжаар томилогдох ажлын хэсгийн боловсруулсан Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөж олговор олгох тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахаар ...хэлмэгдэгчийн материалыг хүлээн авч 2021 онд нөхөж олговор олгохоор нотлох баримтын бүрдүүлбэрийг хийж ажилласан . Салбар комиссын ажилтнуудад хуулийн нэмэлт өөрчлөлтийг таниулан сурталчлах, зөвлөгөө өгөх, тэдэнд тулгамдаж байгаа асуудлын талаарх санал бодлыг сонсох, бололцоотой асуудлыг газар дээр нь хуулийн хүрээнд шийдвэрлэх, тэдэнд бодлогын зөвлөгөө өгөх сургалт семинарыг 2 удаа хийсэн.
	31.1.2	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь олдохгүй байгаа аймгийн архивын 322, Тагнуулын ерөнхий газрын архивын 1953 хэргийг шалгаж дуусгах	980	820	5,000.0	5,000.0	980 хэрэг шалгах төлөвлөгөөтэй байснаас 820 хэргийг шалгасан үлдсэн нь Прокурорын ерөнхий газарт шалгагдаж байна. Мөн цагаатгагдаагүй хүний холбогдолтой эрүүгийн хэрэг, баримт нотолгоог олох чиглэлээр аргачилсан удирдамж гаргаж, зөвлөмж, эрх зүйн туслалцаа үзүүлэн ажиллаж, үлдсэн хэрэг материалыг аймгуудаас татан авчирч Тагнуулын ерөнхий газарт хүргүүлсэн.
	31.2	Хэлмэгдэгчдийн талаар хийх судалгаа шинжилгээ					
	31.1.3	Хөдөө орон нутагт байгаа хэлмэгдүүлэлттэй холбоотой түүх соёлын дурсгалт зүйлсийг сэргээн засварлах	8 аймаг, дүүрэгт	8 аймаг, дүүрэгт			Хөдөө орон нутагт байгаа хэлмэгдүүлэлттэй холбоотой түүх соёлын дурсгалт зүйлсийг сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн.
	31.1.4	Хэлмэгдэгчдийн дурсгалд зориулсан үзэсгэлэн, номын сан зохион байгуулах	Нийслэлд 1	Нийслэлд 1			Хэлмэгдэгчдийн дурсгалд зориулсан үзэсгэлэн, номын сан зохион байгуулах судалгаа хийсэн.
	31.1.5	Хөдөө орон нутгийн салбар музейд байгаа улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд хамаарах үзмэр, сан хөмрөг, тайз дэлгэцийн уран бүтээлийн судалгаа хийх	Хөдөө орон нутагт 22 газар	Хөдөө орон нутагт 22 газар			Хөдөө орон нутгийн салбар музейд байгаа улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд хамаарах үзмэр, сан хөмрөг, тайз дэлгэцийн уран бүтээлийн судалгаа хийсэн.
32	СОЁЛЫН САЙД				138,088.9	131,555.2	
	32.1	Соёл урлаг			138,088.9	131,555.2	
	32.1.1	Соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн тоо /хүн амд эзлэх хувиар/	75%	116.4%			Соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн нийт тоо 3,821,938 (үүнд урлагийн тоглолт үзэгчийн тоо 1,301,574; музейн үзэгчийн тоо 267,730; номын сангийн байнгын уншигчийн тоо 191,348; соёлын төв, соёлын ордноор үйлчлүүлэгчдийн тоо 1,675,800, кино үзвэр үзэгчийн тоо 385,486) байгаа нь Монгол Улсын хүн амын нэг хүнд ногдох соёл, урлагийн байгууллагын үйлчилгээ 1.2 дахин буюу нэг хүн давхардсан тоогоор 1.2 удаа соёл, урлагийн үзвэр, үйлчилгээ авсан гэсэн үзүүлэлт юм. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх хугацаа тогтоох болон сунгах тухай Засгийн газрын шийдвэр, холбогдох журам, хариуцлагын гэрээг баримтлан, вакцины зохих тунд хамрагдалтыг харгалзаж соёлын байгууллагууд үйлчилгээгээ 30%-50% танхимаар үзүүлэн ажилласан бөгөөд 2021 оны хувьд 2-3 сарын үйлчилгээ танхимаар, бусад тохиолдолд цахимаар үйлчилсэн байна. Үүнтэй холбоотойгоор үйлчлүүлэгчийн тоо 2020 оны тоо хэмжээнээс 44% буурсан үзүүлэлттэй гарсан.
	32.1.2	Нийтийн номын сангийн байнгын уншигч /хүн амд эзлэх хувиар/	15%	6.5%			Улсын хэмжээний байнгын уншигчийн тоо 191,348 байгаа хүн амд эзлэх хувиар тооцоход 6.5% байна. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх хугацаа тогтоох болон сунгах тухай Засгийн газрын шийдвэр, холбогдох журам, хариуцлагын гэрээг баримтлан, вакцины зохих тунд хамрагдалтыг харгалзаж соёлын байгууллагууд үйлчилгээгээ 30%-50% танхимаар үзүүлэн ажилласан бөгөөд 2021 оны хувьд 2-3 сарын үйлчилгээ танхимаар, бусад тохиолдолд цахимаар үйлчилсэн байна. Үүнтэй холбоотойгоор /уншигчийн карт сунгуулаагүй, шинэ уншигч нэмэгдээгүй зэрэг шалтгаанаар/ байнгын уншигчийн тоо буурсан үзүүлэлттэй гарсан.
	32.1.3	Музейн үзэгчийн тоо /хүн амд эзлэх хувиар/	21	9.1%			Музейн үзэгчийн тоо 267,730 байгаа хүн амд эзлэх хувиар тооцоход 9.1% байна. Музейн үзэгчийн тоо 2020 онд 336,872 байсан бөгөөд 2021 онд энэхүү үзүүлэлт 20%-иар буурсан. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх хугацаа тогтоох болон сунгах тухай Засгийн газрын шийдвэр, холбогдох журам, хариуцлагын гэрээг баримтлан, вакцины зохих тунд хамрагдалтыг харгалзаж соёлын байгууллагууд үйлчилгээгээ 30%-50% танхимаар үзүүлэн ажилласан бөгөөд 2021 оны хувьд 2-3 сарын үйлчилгээ танхимаар, бусад тохиолдолд цахимаар үйлчилсэн байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2021 оны зорилтот түвшин	2021 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	32.1.4	Жилийн эцэст хүрсэн байх музейн үзмэрийн тоо /мянгаар/	245	243.1	138,088.9	131,555.2	2021 оны тайлан, мэдээгээр музейн үзмэрийн тоо 243,102 ширхэг байгаа нь Үндэсний статистикийн хорооноос зарласан 2020 оны тайлан, мэдээгээр 246,971 ширхэг үзмэр байсантай харьцуулахад 3,869 ширхэгээр буурсан. 2021 онд батлагдан хэрэгжиж буй Музейн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.3 дахь заалтын дагуу музейн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээдийг мэдээ, тайланд хамруулсан тул статистикийн 2020 оны мэдээ, тайланд орсон байгууллагын дэргэдэх 2 музей хасагдсанаар үзмэрийн тоо мөн хасагдаж тооцсон болно.
	32.1.5	10000 хүнд ногдох номын тоо /мянган ширхэг/	28	19			Улсын хэмжээний номын сангийн сан хөмрөгт нийт 6,245,068 ном байгааг 10 мянган хүнд ногдохоор тооцоход 19,024 ном байна. Энэ нь 2020 оны үзүүлэлт 19,290 байгаагаас 266-аар буурсан үзүүлэлт. Номын сангийн сан хөмрөг 2020 онтой харьцуулахад 2021 онд 0.5% буурсан бөгөөд сан хөмрөгөөс 40.4 мянган ном хасагдаж, актлагдан, 38.0 мянган номоор баяжилт хийгдсэний зөрүүтэй холбоотой.
	32.1.6	10000 хүнд ногдох соёлын төвийн суудлын тоо	300	279			Нийт соёлын төв, соёлын ордны суудлын тоо 91,466 бөгөөд 10,000 хүн тутамд 279 суудал ногдож байна. 2020 онд соёлын төв, соёлын ордны суудлын тоо 90,538 байсан бөгөөд 10,000 хүн тутамд 278 суудал ногдож байсантай харьцуулахад 2021 онд 1 пунктээр өссөн байна. 2021 онд соёлын төвийн суудлын тоо 928-аар өссөн нь Орхон, Төв, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд, Хэнтий аймгуудад суудал нэмэгдсэнтэй холбоотой.
	32.1.7	Улсын хэмжээнд хэрэгжүүлсэн үндэсний хөтөлбөрийн тоо	3-аас доошгүй	хэрэгжүүлж ажилласан			2021 онд дараах 5 үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Үүнд: 1. Соёлын баримтат өвийг хамгаалах; 2. Монгол уран бүтээл; 3. Сонгодог урлаг-III; 4. Чулуун соёлын өв; 5. Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр. /Эдгээр үндэсний хөтөлбөрүүд нь Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсон/
	32.1.8	Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчдийн тоо /давхардсан тоогоор, сая хүн/	3.6	1.3			Урлагийн байгууллагын тоглолт үзэгчийн тоо 2020 онд 2,702,866 байсан бол 2021 онд 1,301,574 болж 52%-иар буурсан. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх хугацаа тогтоох болон сунгах тухай Засгийн газрын шийдвэр, холбогдох журам, хариуцлагын гэрээг баримтлан, вакцины зохих тунд хамрагдалтыг харгалзаж соёлын байгууллагууд үйлчилгээгээ 30%-50% танхимаар үзүүлэн ажилласан бөгөөд 2021 оны хувьд 2-3 сарын үйлчилгээ танхимаар, бусад тохиолдолд цахимаар үйлчилсэн байна.